

Төслийн баримт бичиг

Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ)

Үе шат 3, 2011 - 2014



Төслийн дугаар: 7F-04344.03

Хугацаа: 2011 оны 1-р сарын 1-ээс 2014 оны 12-р сарын 31 хүртэл
Монгол Улс

2011 оны 12-р сар



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

**Swiss Agency for Development
and Cooperation SDC**



**Монгол Улсын Эрдэс Баялаг
Эрчим Хүчний Яам**

**Ministry of Mineral Resources and Energy
of Mongolia**

Агуулга

1.	Өмнөх үг	Error! Bookmark not defined.
2.	Нэгдсэн хураангуй	Error! Bookmark not defined.
3.	Нөхцөл байдал.....	
3.1.	Хөгжлийн ерөнхий нөхцөл байдал	
3.2.	Монгол улсын ашигт малтмалын салбар болон бичил уурхайн өнөөгийн байдал	
3.3.	Өмнөх үе шатны үр дүн ба сургамж.....	
3.4.	Боломжууд болон хүндрэлтэй асуудлууд	
3.4.1.	Тулгамдсан асуудлууд	
3.4.2.	Бичил уурхайн боломжууд	
3.4.3.	Хүндрэлтэй асуудлууд	
3.5.	Хөгжлийн стратегитай уялдаа холбоотой байдал.....	
4.	Төслийн загвар ба стратегийн чиг хандлага	
4.1.	Төслийн ерөнхий стратеги.....	
4.1.1.	Хөгжлийн зорилго.....	
4.1.2.	Зохион байгуулалтын цар хүрээ: олон нийтэд тулгууралсан уурхай.....	
4.1.3.	Нийтлэг цар хүрээ	
4.1.4.	Үйл ажиллагааны таамаглал	
4.1.5.	Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд.....	
4.1.6.	Төслийн арга барил.....	
4.2.	Төслийн хэрэгжүүлэх стратеги	
4.2.1.	Хариуцлагатай бичил уурхайн талаар хамтрагч талуудын байр суурь..	
4.2.2.	Монгол улсад хариуцлагатай бичил уурхайн салбар хөгжүүлэхтэй холбоотой гол асуудлууд	
4.2.3.	Үйл ажиллагааны гол чиглэл болон нийтлэг сэдвүүд	
4.3.	Төслийн оролцооны стратегийн хэв загвар.....	
4.4.	Эрсдэл, таамаглал болон эрсдлийг бууруулах стратеги	
4.5.	Тогтвортой байдал ба төгсгөлийн стратеги	
5.	Дэвшүүлж байгаа үйл ажиллагааны хүрээ	
5.1.	Хөгжлийн зорилго	
5.2.	Үр дүн ба бүтээмж.....	
5.3.	Бүтээмж ба үйл ажиллагааны багц	
6.	Хамтрагч талууд, үр шимийг хүртэгчид ба түншүүд.....	
6.1.	Хамтрагч талуудын зураглал	
6.2.	Үр шимийг хүртэгчид.....	
6.3.	Дотоодын хамтрагч талууд.....	
6.4.	Түншүүд.....	
7.	Төслийн зохион байгуулалт ба мэнэжмент	
7.1.	Төслийн бүтэц	
7.2.	Төслийн зохион байгуулалт.....	
7.3.	Төслийн мэнэжментийн бүтэц.....	
7.4.	Ижил хүсэл зорилго бүхий байгууллагуудтай хамтын ажиллагаа	
8.	Мониторинг ба үнэлгээ.....	
9.	Төсөв ба эх үүсвэр.....	
9.1.	Швейцарийн оруулах хувь нэмэр.....	
9.2.	Монгол улсын оруулах хувь нэмэр.....	
	Хавсралтууд	
	Хавсралт 1: Точлсон үгсийн жагсаалт	
	Хавсралт 2: Үйлдвэрлэлийн уурхайн салбарын статистик	
	Хавсралт 3: “Бичил уурхайгаар шударгаар олборлосон алтны шудрага худалдаа”-ны тойм.....	
	Хавсралт 4: Хариуцлагатай бичил уурхайн зарчмууд	

Хавсралт 5: Livelihoods assets endowment as a monitoring tool.....	
Хавсралт 6: Үйл ажиллагааны багцууд.....	
Хавсралт 7: Ажилтангуудын ажил үүргийн тодорхойлолтын хураангуй	
Хавсралт 8: Тодорхой төсөв.....	
Хавсралт 9: Хамтрагч талуудын дүн үнжилгээ.....	
Хавсралт 10: Төлөвлөлтийн семинарын үр дүн	

Тайлбар зургууд

Зураг 1: Асуудлын мод	
Зураг 3: Эрхэд тулгууралсан арга барил ба эрх мэдэлжүүлэх арга барил.....	
Зураг 4: Тогтвортой амьжиргааны хүрээ	
Зураг 5: Стратегийн оролцооны хэв загвар.....	
Зураг 6: Хамтрагч талуудын төсөлд оруулах хувь нэмэрийн эрх хэмжээ.....	
Зураг 7: Хамтрагч талуудын map (товчилсон үгсүүдийг Хавсралт 9: Хамтрагч талуудын анализ-аас харна уу)	
Зураг 8: Бичил уурхайн пирамид	
Зураг 9: ТБУТ-ын байгууллагын болон мэнэжментийн бүтэц.....	

1. Өмнөх үг

Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) 2005 онд 8 жилийн төлөвлөгөөтэйгөөр үйл ажиллагаа явуулахаар эхэлсэн ба үүний дагуу эхний 1½ жилийг Бэлтгэл үе шат, 2007-2010 оны хоорондох дараагийн 4 жилийг Үндсэн үе шат, үүний дараа Төгсгөлийн үе шатны хэрэгжүүлэлт хийхээр төлөвлөсөн байсан.

Монгол улсын Засгийн газар болон Монголын бичил уурхайчдын хүсэлт, мөн 2009 онд хийсэн төслийн дунд шатны үнэлгээний багийн зөвлөмжид үндэслэн ШХА-аас уг төслийн үйл ажиллагааг 2011-2014 оны хооронд хоёр дахь үндсэн үе шатыг хэрэгжүүлэх замаар сунгах шийдвэр гаргасан.

2005 онд уг төслийг эхэлж байх үед Монголын бичил уурхайн асуудал маш их маргаантай сэдэв байсан. Байгалийн гамшигт малаа алдсан малчид, нийгэм эдийн засгийн шилжилтээс болж ажилгүйдэлд өртсөн хүн амыг орлого олох боломжоор хангаж байсан боловч албан бус үйл ажиллагаа гэдэг шалтгаанаар бичил уурхай эрхлэгчдийг хавчиж шахан хүний эрхийг нь хөсөрдүүлж байсан. Тухайн үед ШХА энэ салбарын асуудлыг хөндөж Монголын ашигт малтмалын салбарыг дэмжин эдгээр хүндрэлтэй асуудлуудыг сааруулах хүсэл зориг бүхий цорын ганц хөгжлийн агентлаг байсан юм.

Үүнээс хойш таван жил өнгөрөхөд бичил уурхайн хууль эрх зүйн орчин бий болсон ба төслийн үйл ажиллагаанаас сурсан сургамж цаашид хэрхэн яаж үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх замыг тодорхой болгож өгсөн. Ямартай ч Монгол Улсын бичил уурхайн салбар, үүний албан ёсны эдийн засгийн салбар (хөдөөгийн хөдөлмөрчдийн 20%-ийг ажлын байраар хангаж байгаа) болон шилжих үйл явц нь өөрийнхөө логикийн дагуу явагдах ёстой ба үүнд эхнээсээ төлөвлөж байсан 4 жилээс илүү хугацаа шаардагдана гэдэг дээр бүх хамтрагч талууд санал нэгтэй байгаа юм. ШХА Монгол Улс дахь энэ процессыг дэмжиж байгаа цорын ганц хөгжлийн байгууллага хэвээр байна.

3-р үе шатанд уг процесс болон төслийн үйл ажиллагаа нь дотоодын байгууллагуудын идэвхитэй оролцоотойгоор явагдсан тохиолдолд л тогтвортой байдлыг хангаж чадна гэдэг нь эхнээсээ л ойлгомжтой байсан. Энэ үе шатны үйл ажиллагааг төлөвлөх процесс нь хэдэн сарын турш холбогдох талуудыг оролцуулан ярилцлага, зөвлөгөөн, семинар, нөхцөл байдалтай газар дээр очиж танилцах томилолт, хэлэлцэх болон зөвшилцөх зэрэг оролцооны аргыг чухалчилж хийгдсэн. Төслийн төлөвлөгөө нь олон нийтэд тулгууралсан уурхайг хөгжүүлэхтэй холбоотой үндэсний болон олон улсын сүүлийн үеийн сайн туршлага, чиглэл хандлагыг тусгасан.

Төслийн төлөвлөгөө хэрэгжүүлэлтийн үр дүн нь тогтвортой байдалд хүрэх ил тод, илэн далангүй, эрсдэлийг багасгахуйц төслийн стратегиар чиглэл хийсэн зүй зохистой, мэдрэмжтэй мэнэжментийн зохицуулалт, уян хатан, тохиромжтой үйл ажиллагаа бүхий “хөнгөн” 3-р үе шат байх ёстой.

Одоо Монгол улсын бичил уурхайн салбарт ийм дэмжлэг хэзээ хэзээнээс илүү шаардлагатай байна. Дараагийн хэдэн жил хүлээн зөвшөөрөгдсөн, нийгэм болон байгаль орчны хариуцлагатай бичил уурхайн урт хугацааны ирээдүйн зүг чиглүүлж өгнө. Бичил уурхайчдын ашиг тусын төлөө ШХА болон Эрдэс баялаг, эрчим хүчний яам, хэрэгжүүлэгч агентлагуудын хамтаар төлөөлүүлсэн Монгол улсын Засгийн газар хоёр ТБУТ-ийг нягт холбоотойгоор хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2. Нэгдсэн хураангуй

Монгол Улс сүүлийн 20 жилийн хугацаанд захиран удирдах төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос олон намын ардчилсан тогтолцоо руу шилжих шилжилтийг хийж дуусгасан. Тус улсын арвин их байгалийн баялаг нь уул уурхайн салбарыг хөгжүүлэх боломжийг олгосон ба одоогийн байдлаар уг салбар улсын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 60%, экспортын орлогын 20%-ийг бүрдүүлж байна.

Гадаадын уул уурхайн компаниудын анхаарлыг ихээхэн хэмжээгээр татсан том уурхайнууд олон тоогоор бий болохын хажуугаар нийгмийн тогтолцооны шилжилтийн эхэн үед ажлын байрнаасаа хагацсан болон байгалийн гамшигаас шалтгаалж амьжиргааны эх үүсвэрээ алдсан хүн амд шинээр ажлын байртай болох боломжийг олгосон бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж эхэлсэн. 40.000-100.000 ажлын байр бий болгон улсын экспортын жилийн орлогод 100 сая долларын хувь нэмэр оруулдаг боловч бичил уурхайн үйл ажиллагааг зүй бусын үйл ажиллагаа гэж үзэхээс гадна бичил уурхай эрхлэгчид ялгаварлан гадуурхах, хүний эрхэнд халдах асуудлуудад байнга өртдөг байсан.

Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) 2005 онд 1½ жилийн хугацаатай бэлтгэл үе шат (1-р үе шат)-аар эхлэн бичил уурхайн үйл ажиллагаанд ШХА-ийн ажлын туршлагыг бий болгосон. 2009 оны 10-р сард хийгдсэн төслийн үндсэн үе шатны (2-р үе шат) ажлыг дүгнэх Дунд шатны үнэлгээгээр (ДШҮ) ТБУТ нь Монгол улсын хөгжил, ялангуяа уг салбарын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй хүмүүст чухал ач холбогдолтойгоос гадна эдгээр үйл ажиллагааг үргэлжлүүлэх зорилгоор санал болгож байгаа нэмэлт үндсэн үе шатанд (3-р үе шат) ДШҮ-ний багаас төслийг бүтэц зохион байгуулалтын хувьд Бичил уурхайн бодлогын бүрэлдэхүүн хэсэг ба Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсэг гэсэн хоорондоо харилцан холбоо бүхий 2 бүрэлдэхүүн хэсэгтэй ажиллуулахаар зөвлөсөн.

2-р үе шатны үйл ажиллагааны үед тодорхой ололт амжилтанд хүрсэн боловч Бичил уурхайн салбар ерөнхийдөө албан бус, зохион байгуулалт муутай байгаа учраас бичил уурхайчдын ажлын байр найдвартай биш, бичил уурхайгаас байгаль орчинд үзүүлэх нөлөө нь үндсэн асуудал болж үлдэж байгаагаас гадна орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр нь хязгаарлагдмал байна гэж дүгнэгдсэн. Хэдий тийм ч бичил уурхайн талаарх олон нийтийн ойлголт сайжирсан ба саяхан (2010 онд) олонхийн саналаар (Их хурлын гишүүдийн 80-аас дээш %) Ашигт малтмалын хуульд оруулсан бичил уурхайтай холбоотой өөрчлөлтийн хуулийг баталсан.

Төслийн 3-р үе шатны **хөгжлийн зорилго** нь “Бичил уурхайн үйл ажиллагааг Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, албан ёсны дэд салбар гэж хүлээн зөвшөөрдөг болгоход дэмжлэг үзүүлэх” юм. Төслийн үйл ажиллагаа нь Швейцарийн хамтын ажиллагааны стратегийн үр дүн 3 “Хөтөлбөрт хамрагдах бүс нутагт орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, малаас авах ашиг шимийг дээшлүүлснээр малчид, хөдөөгийн иргэдийн амьжиргааг сайжруулах”-д хүрэхэд шууд хувь нэмэр оруулна. Мөн үүнээс гадна Монгол Улсын үндэсний хөгжлийн бодлогын “...төрөөс зохицуулах зарчимтай, байгаль орчинд хал багатай, хүн амьтны амьдрах орчинд аюулгүй бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны хууль зүйн орчин бий болгох” гэсэн хэсэгтэй нэг чиг шугамаар явна.

Төслийн 3-р үе шатанд байнгын болон улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг бичил уурхайчидтай голчлон ажиллах ба төслийн үйл ажиллагаа тэдний тогтвортой амьжиргааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах юм. Төсөл **алтны** бичил уурхайчдыг хөгжүүлэх, технологийг сайжруулах ажиллагаагаа өргөсгөхөөс гадна **жонш** болон **нүүрс** олборлогч бичил уурхайчдын үйл ажиллагаа явуулдаг газруудад ижил төрлийн үйл ажиллагааг явуулж эхэлнэ. Бичил уурхайчдын үйл ажиллагаа 10 гаруй жилийн турш үл анхаарагдсан байдалд байсан ба зөвхөн сүүлийн үед олон нийтийн болон улс төрчдийн ойлголт эерэгээр өөрчлөгдөж эхэлсэн бөгөөд бичил уурхайн үйл ажиллагааг чухалчлан үзэх, шаардлагатай ажлын орон тоо бий болгож байгаа эдийн засгийн үйл ажиллагааны нэгэн хэлбэр юм гэж хүлээн зөвшөөрөгдөж эхэлж байна. Ийм нөхцөлд

хөгжлийн зорилгод хүрэх хамгийн тохиромжтой арга барил нь **эрхэд тулгуурлан чадваржуулах/эрх мэдэлжүүлэх** явдал юм.

Төслийн үйл ажиллагааг төлөвлөлтийг хийж байсан үеийн бичил уурхайн салбарыг тойрон хүрээлж байсан хүндрэлтэй асуудлуудын тойргийг эвдэн тус салбарын хөгжилд хувь нэмэр оруулахуйц таатай орчингоор хүрээлүүлэх болно гэж урьдчилсан байдлаар таамаглаж байгаа. Ингэж бий болгосон таатай нөхцөл нь уг салбарыг албан ёсны салбар болгож хөгжүүлэх, хариуцлагатайгаар үйл ажиллагааг явуулдаг болгоход гол хөшүүрэг болж өгөх юм. Одоогийн хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагаанууд нь бичил уурхайн үйл ажиллагааг цаашид хөгжүүлэх боломжийн талаар харилцагч талуудад итгэл найдварыг төрүүлэх болно. Эдгээр ажлуудыг хэргэжүүлэхийн тулд ТБУТ дараах **хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй** байх хэрэгтэй. Үүнд:

- **Бичил уурхайн бодлогын бүрэлдэхүүн хэсэг** нь бичил уурхайд чиглэсэн олон нийтийн таатай бодлогыг дэмжин албан ёсны хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх тохиромжтой хууль эрх зүйн орчин бий болгоход идэвхижүүлэгчээр ажиллах зорилготой,
- **Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсэг** нь орон нутгийн бичил уурхайчдыг аюул осолгүй, байгаль орчин болон нийгмийн хариуцлагатай, эдийн засгийн хувьд үр ашигтай үйл ажиллагааг өөрсдийнхөө орон нутагт явуулах чадавхийг бий болгох, бичил уурхайчдыг энэ зорилгод хүрэхийн тулд зохион байгуулалтад орж үйл ажиллагаагаа зохицуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилготой.

Төслийн 3-р үе шатны **хэрэгжүүлэлтийн стратеги** нь бүхэлдээ доороосоо дээш чиглэсэн оролцооны аргаар төлөвлөсөн ба энэ процессын үед Монголын хамтрагч талууд дараах **6 сэдвийг** өнгөрсөнд “нинжа”-гийн үйл ажиллагаа гэж нэрлэгддэг байсан үйл ажиллагааг хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагаа болгон өөрчлөхөд **гол үүрэг гүйцэтгэх асуудлууд** гэж чухалчилж үзсэн. Үүнд:

- Хууль эрх зүйн орчин ба албан ёсны болгох
- Бичил уурхайчдыг бүтэц зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх
- Нийгмийн хариуцлага, нийгмийн баталгаат байдал болон баталгаат ажлын байр бий болгох
- Байгал орчны хариуцлага ба экологийн талаар үр дүнтэй технологи нэвтрүүлэх
- ХАМО иргэдийн чадавхийг сайжруулах ба мэдээлэлд хүрэх арга замыг сайжруулах
- Орон нутгийн хөгжил ба орлогын эх үүсвэр бий болгох

“Шударга олборлолтоос зах зээлд хүрэх сүлжээ” болон “тогтвортой амьжиргаа” гэх мэт үйл ажиллагаануудыг нэгтгэхээс гадна хүйсийн тэгш байдлыг чухалчлан үзсэнээр төслийн стратегийн үр дүн нь хоорондоо бүрэн холбоотой 3 зонхилох чиг хандлага бүхий (эрх дээр тулгууралсан арга барил, эрх мэдэлжүүлэх/чадваржуулах арга барил, шударга худалдаа) хөгжлийн орчинг үүсгэх ба тогтвортой амьжиргааны хэтийн төлөвд үнэ цэнэтэй хувь нэмэр оруулах боломжтой юм. Эдгээр 6 сэдэв нь бүгдээрээ хөгжлийн 4 чиглэлтэй хамаатай юм.

Төслийн **логикийн цар хүрээ** (лог фрэйм) нь бүрэлдэхүүн хэсгүүдийн үйл ажиллагаанаас гарах **үр дүн** болон төслийн хэмжээний болон бүрэлдэхүүн хэсгүүдийн үйл ажиллагааны бүтээмжийг тодорхойлсон. **Бүрэлхүүн хэсгүүдийн** үйл ажиллагаанаас гарах **бүтээмжүүд** нь хоорондоо харилцан хамааралтай, бие биенийхээ үйл ажиллагааг баталгаажуулж өгдөг ба энэ нь 2 бүрэлдэхүүн хэсгийн хооронд нягт холбоотой ажиллах хэрэгцээ шаардлагыг бий болгосон. Үйл ажиллагааны **шалгуур үзүүлэлтүүд** нь төслийн бүрэлдэхүүн хэсгүүд нь харилцан дэвшил гаргаж байж л хөгжлийн зорилгод хувь нэмэр оруулж чадах учраас бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд бус харин төслийн хүрээнд тусгайлан боловсруулагдсан. Үйл ажиллагаа явуулах түвшинд төслийн мэнэжментэд зориулж маш тодорхой заавар бүхий **“багц ажлууд”**-ыг бэлтгэсэн. Эдгээр ажлууд нь тус төслийн боломжийг гаргаж тавих, үйл

ажиллагааг тухайн нөхцөлд тохируулан хэрэгжүүлэхэд төслийн мэнэжментэд дэмжлэг болох зорилготой. Ийм учраас үйл ажиллагааны ололт амжилт нь ямар нэгэн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэхээсээ илүүтэйгээр тохирсон үйл ажиллагаагаар гүйцэтгэгдэх харагдахуйц үр дүнд хүрэх чухал ач холбогдолтой **онцгой үйл явдлаар** дүгнэгдэх юм.

Төслийн үйл ажиллагаа нь Монгол Улсын хөгжлийн чухалчлах асуудлуудад хувь нэмэр оруулж байгаа болон ихээхэн уялдаа холбоотой учраас 3-р үе шатны үйл ажиллагааны **эрсдэл** бага байна гэж үзэж байна. Саяхан батлагдсан бичил уурхайтай холбоотой хуулийн өөрчлөлт нь олон нийтэд чиглэсэн тодорхой бодлого баримталж байгаа учраас нилээд **баталгаатай таамаглал** гаргаж болно. Бусад **эрсдэлүүдийн** хувьд тэднийг **бууруулах стратегийг** нарийвчлан боловсруулсан болно.

Тогтвортой байдал нь холбогдох эрх бүхий талууд болон үүрэг хүлээгч талуудыг тодотгон бичил уурхайчдыг тэдэнд олгогдсон эрхээ эдлэх боломжтой болгох зорилготой төслийн эрхэд тулгуурлан эрх мэдэлжүүлэх арга барилын салшгүй хэсэг юм. Бүх гол сэдвүүдийг хамруулсан чадвхижуулах ажлууд нь сонсогчдыг ерөнхийд нь чадавхижуулахад чиглэгдсэн ба урт хугацаанд “шудрага олборлолт, шудрага худалдааны” санаачлагад хамруулах замаар тухайн салбарын “манлайлагчид”-ыг бий болгох зорилготой. Хамтран хэрэгжүүлэгч талуудтай нягт холбоотойгоор тодорхойлсон ажил үүргийн хуваарь нь мөн тогтвортой байдалд хүргэх нэгэн хэлбэр болох юм.

Төслийн 3-р үе шат нь **Хаалтын үе шатыг** дөрвөн жилээр хойшлуулж байгаа ба ингэснээр Бичил уурхайтай холбоотой хуулийн өөрчлөлтийг баталснаас хойш төслийн гаргасан амжилтыг бататгаж зөв гольдиорлд нь оруулах юм. Чадавхижуулах чиглэлийн үйл ажлууд болон төслийн үйл ажиллагааны хугацаанд бий болсон туршлага, сурсан сургамжуудыг дотоодын хамтрагч талуудад хүлээлгэн өгөснөөр тэднийг төслийн үйл ажиллагаа дууссаны дараа цаашид уг салбарыг хөгжүүлэхэд илүү дөхөм болгох юм.

Төлөвлөгөөт ажлуудыг үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад гэрээгээр өгч хийлгэж байгаа нь (үндэсний хамтрагч талуудад хүлээлгэн өгөх) төслийн хаалтын үе шатны стратегийн нэгэн хэсэг болно. Харин төслийн хаалтын үе шат болох 2 жилийн хугацаанд бүх ажлыг хүлээлгэн өгөх юм.

Хамтрагч талуудын талаар хийсэн гүнзгийрүүлсэн **дүн шинжилгээ** нь хамтрагч талуудын талаар тодорхой зураглал гаргахад тус дөхөм болсон. Хөгжлийн зорилгод илэрхийлсэнчлэн төслийн ашиг шимийг хүртэгчид нь “хариуцлагатай бичил уурхайчид” юм. Харин бичил уурхайчдыг төслийн “үр шимийг хүртэгчид” гэхээсээ илүүтэйгээр “өөрчлөлт гаргагчид” буюу төслийн үйл ажиллагааны хамтрагчид/түншүүд гэх нь зүйтэй юм. Хамтрагч талуудын дүн шинжилгээгээр Монгол Улсын засгийн газрын уул уурхайн салбар, бүсийн болон орон нутгийн засаг захиргаа, мөн түүнчлэн хэд хэдэн ижил хүсэл зорилго бүхий олон улсын байгууллагуудыг төслийн **“гол хамтрагч талууд”** болохыг бататгасан. Үүнээс гадна төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийнхнийг хамарсан нилээд өргөн хүрээтэй **үндсэн хамтрагч талууд** байгааг тодотгосон. ТБУТ-ын хувьд эдгээр **хамтрагч талуудтай** ажиллах нь маш чухал юм. Төслийг хэрэгжүүлэх хугацаанд Төрийн байгууллагууд, орон нутгийн болон үндэсний хэмжээний ТББ, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудыг бичил уурхайн талаар чадавхижуулах, үндэсний хэмжээнд бичил уурхайн асуудлаар гаршиж чадваржуулах нь уг салбарыг урт хугацааны турш тогтвортой хөгжүүлэх үндэс баталгаа болно.

Төслийн **хамтран хэрэгжүүлэгч талууд** нь Монгол улсын засгийн газрыг төлөөлж Эрдэс баялаг, эрчим хүчний яам (ЭБЭХЯ), Швейцарийн Засгийн газрыг төлөөлж Швейцарийн элчин сайдын яамны дэргэдэх Швейцарийн хамтын ажиллагааны агентлаг (ШХА) юм.

Үйл ажиллагааны түвшинд ТБУТ нь уул уурхай, эрдэс баялагийн салбарын асуудлыг хариуцдаг Монгол Улсын засгийн газрын хэрэгжүүлэгч байгууллага болох Ашигт малтмалын газартай (АМГ) нягт холбоотой хамтран ажиллана. АМГ бичил уурхай хариуцсан тасаг дахин байгуулахаар төлөвлөж байна.

ТБУТ нь ШХА-ийн “төсөл хэрэгжүүлэгч нэгж” байна.

Иймээс **Төслийн бүтэц зохион байгуулалтын** хувьд ШХА-ын ТБУТ-ийн баг АМГ-ын бичил уурхайн тасагтай нягт холбоотойгоор ажиллан төслийг хэрэгжүүлэхээр сонгогдсон. ТБУТ-ийн **Удирдах хороо** нь стратегийн шийдвэр гаргах, төслийн төлөвлөгөө, тайланг батлах болон байгууллагуудын хоорондын зохицуулалтыг хариуцах зорилготой. Энэ бүтэц нь 2-р үе шатны бүтэц зохион байгуулалттай ижил төстэй учраас төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулахад тохиромжтойгоос гадна хэрэгжүүлэгч талууд болох ШХА ба АМГ-ын хоорондын нягт хамтын ажиллагааг чухалчилсан юм. Энэ хамтын ажиллагаа нь АМГ Бичил уурхайн тасаг байгуулсан цагт биелэлээ олох юм.

Төслийн **менежментийн бүтцийн** хувьд хамгийн тохиромжтой нь хэлбэр нь төслийг төлөөлөн гадаад түншүүдтэй харилцах, төсийн “олон нийтийн дундах нүүр царай” болохоос гадна олон нийт болон улс төрийн хувьд жинтэй байр суурь бүхий Төслийн үндэсний захиралаар (ТЗ) удирдуулах хэлбэр юм. ТЗ-ыг төслийн багийн үйл ажиллагааг удирдан, гадаад орнуудын туршлагыг нэвтрүүлж төслийн хэрэгжилт, захиргаа, болон төлөвлөлт, хяналтыг ерөнхийд нь хариуцаж ажиллах Төслийн олон улсын мэнэжер (ТМ) дэмжиж ажиллана. ТЗ болон ТМ “ТБУТ-ын мэнэжмент”-ийн зүгээс хамтарч болон бие дааж тус тусдаа төслийн үйл ажиллагааны талаар ШХА болон УХ-д тайлагнана. Төслийн багийн хувьд 2-3 ахлах мэргэжилтэн, 6 мэргэжилтэн (4 нь ШХА, 2 нь АМГ) болон бусад шаардлагатай захиргааны ажилтангуудаас бүрдэнэ. Үйл ажиллагааны хэрэгцээ шаардлага, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг мандатын гэрээгээр ажиллуулах, зөвлөхүүд болон өөрсдийгөө сургах зэрэг нөхцлүүдээс хамаарч цаашдын мэргэжилтэний асуудалд уян хатан байдлаар хандана. Үр дүнд чиглэсэн богино хугацааны гэрээт ажлууд нь үр дүнтэй, ашигтай байх шаардлагатай. Дотоодын болон гадаадын тусгай мэргэжилтэнгүүдийг богино хугацаатай гэрээгээр ажиллуулах болно.

ТБУТ нь Азийн сан (Байгаль орчныг хамгаалахад олон талын оролцоог хангах нь төсөл), Хариуцлагатай уул уурхайн холбоо ба Олон улсын шудрага худалдааны байгууллагатай бичил уурхайгаар олборлосон алтны шудрага олборлолт, шударга худалдааны нөхөрлөлийн шугамаар, мөн хувийн хэвшлийн үйлдвэрлэлийн газруудад бичил уурхайгаар олборлосон алтыг ёс суртахуунтай гоёл чимэглэл хийх зорилгоор нийлүүлэх гэх мэт **хамтын ажиллагаанаас** ашиг тус хүртэнэ. ШХА-ийн Мэргэжлийн сургалтын төсөлтэй тус салбарыг мэргэшүүлэх талаар **хамтран ажиллах** боломж байгаа.

Төслийн үйл ажиллагааны явцыг хагас жилийн болон үйл ажиллагааны үр дүн, бүтээгдэхүүнд төвлөрсөн жилийн тайлангаар бичиг баримтжуулагдана. Үйл ажиллагааны үр дүнд гарсан онцлог үйл явдлуудаар **мониторинг** хийх нь хамгийн амар буюу тодорхой хэлбэр болох “биелэсэн” ба “биелээгүй” гэсэн байдлаар дүгнэх боломжтой болгоно. Үйл ажиллагаанаас гарсан бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлтүүд нь дүгнэхэд амар ба ач холбогдолтой ойлголт өгөх зорилгоор зохиогдсон. Төслийн үйл ажиллагааны үр дүнгээр бичил уурхайчдын амьжиргааны байдалд гарсан мэдэгдэхүйц өөрчлөлтийг хэмжих зорилгоор төсөл хэрэгжиж буй сумдын үйл ажиллагааны мониторингийн үр дүнг үйл ажиллагаа болгож өгөх хэрэгтэй. Шудрага худалдааны гэрчилгээтэй холбоотой ажлуудыг тусад нь мониторинг хийнэ.

Төсөл хэрэгжүүлэлтийн 2 дахь жилийн эцсээр (2013 оны эцэс) **дотоодын дунд шатны үнэлгээг** хийж төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд шаардагдах өөрчлөлт тохируулгыг хийнэ. Гадны үнэлгээг төслийн хаалтын үе шатны үйл ажиллагааны төлөвлөлтийн болон 2014 оноос хойш төслийн үйл ажиллагааг хүлээлгэн өгөх төлөвлөгөөний нэг хэсэг болгон явуулах хэрэгтэй.

Тус төсөл нь Монгол болон Швейцарь улсын хоорондын хамтран хэрэгжүүлж байгаа төсөл учраас тус хоёр улсын хувь нэмэр оруулсан санхүүжилтаар хэрэгжүүлэгдэнэ. Швейцарь Улсаас оруулах хувь нэмэр нь 4 жилийн хугацаанд **4,500,000 Швейцарь Франк (CHF)** байх ба санхүүжилтийг ШХА-аас хийнэ. Монгол Улсаас оруулах нийт санхүүжилтийн хэмжээ нь **700,800 USD** болж байгаа ба үүнд хамтрагч талуудаас 200,000 USD-ыг бэлэн бусаар, 100,800 USD-ыг бүсийн болон орон нутгийн захиргааны зүгээс, ашиг тус хүртэгчдийн зүгээс тэдний зарцуулсан цаг хугацаа, замын зардал, харилцаа холбоо болон бусад зардлуудыг тусгасан 400,000 USD-ыг оруулах юм. Мөн

үүнээс гадна төсөл ашиг шим хүртэгчдэд Шудрага худалдааны нэмэгдэл шагналаас орж ирэх жилийн 1 сая USD-той тэнцэх орлогын урсгалыг нээж өгөх боломжтой ба энэ нь орон нутгийн хөгжилд зарцуулагдах ёстой юм. Хөрөнгө оруулж байгаа талууд өөрсдийнхөө захиран зарцуулах журмын дагуу оруулсан хөрөнгөө удирдан зохицуулна.

3. Нөхцөл байдал

3.1. Хөгжлийн ерөнхий нөхцөл байдал

Монгол Улс 1990-ээд оноос эхлэн захиран удирдах тогтолцооноос олон намын ардчилсан тогтолцоо руу, мөн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засаг руу шилжиж, улс орны нийгмийн харилцаа, сэтгэл санаа, хандлагыг өөрчлөхийн

тулд олон тооны сорилтыг давсан бөгөөд одоо шилжилтийн үе дуусах дөхөж байгаа ба улс орон эрчимтэй хөгжлийн шатандаа орж байна.

Мянганы хөгжлийн зорилтуудад тулгуурласан Монгол Улсын Үндэсний хөгжлийн иж бүрэн стратеги (ҮХС)-д хүмүүнлэг, ардчилсан, иргэний нийгэмд улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийг дэлхийн болон бүсийн хөгжилтэй нягт уялдуулан эдийн засгийн өсөлтийг хангах замаар Монголд хүний хөгжлийг дэмжих бодлогыг тодорхойлсон болно.”¹

3.2. Монгол Улсын ашигт малтмалын салбар болон бичил уурхайн өнөөгийн байдал

Монгол Улс ашигт малтмалаар баян бөгөөд 440 төрлийн эрдэс баялгийн 8000 гаруй орд газруудтай бөгөөд 600 орчим орд газар, илрэлийн хайгуул судалгаа үргэлжилж байна.

3.2.1. Үйлдвэрлэлийн уурхай

Үйлдвэрлэлийн уул уурхайн салбар Дотоодын нийт бүтээгдэхүүний 28.2 хувь (ҮСГ-ын 2008 оны мэдээ), түүнчлэн улс орны аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 59.7 хувь (ҮСГ-ын 2008 оны мэдээ), экспортын орлогын 18.4 хувийг (2009 он) тус тус бүрдүүлж байна. 2009 онд Монгол Улс 326 сая ам.доллартай тэнцэх 11.4 тонн алтыг боловсруулсан болон боловсруулаагүй хэлбэрээр экспортод гаргасан.

Өнөөдөр Монголын уул уурхайн салбарт 200 гаруй гадаадын болон хамтарсан компаниуд үйл ажиллагаа явуулж байна. Тус салбарт 46,500 хүн ажиллаж байгаа нь дэлхийд хамгийн бага хүн амын нягтралтай улс орны хувьд нийт аж үйлдвэрийн хүчний 37 гаруй хувьтай тэнцэж байна. Салбарын гол статистикийн талаар Хавсралт 2: Үйлдвэрлэлийн уурхайн салбарын статистик тоо баримт

-оос үзнэ үү.

3.2.2. Бичил уурхай (БУ)

Уул уурхайн салбарт албан бусаар хөдөлмөр эрхлэх явдал зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа Монголд гарч ирсэн. Шилжилтийн эхний жилүүдэд шинэчлэлийн үйл явцад ажилгүй болсон хүмүүс Налайх (улсын томоохон нүүрсний уурхай байгаад хаагдсан) зэрэг газар нүүрс малтаж эхэлснээр албан бус ажиллагаа эхэлсэн.

1998 оноос хойш албан бусаар алт олборлох бичил уурхайн ("нинжагийн уурхай") үйл ажиллагаа эхэлсэн. 1999-2002 онуудын хооронд болсон гурван удаагийн зудын² уршгаар нийтдээ 11 сая толгой мал алдсан явдал алт олборлох үйл ажиллагаа эхлэхэд анхны түлхэц болсон. Малаа алдсан хөдөө нутгийн малчдын хувьд бичил уурхай нь орлого олох, хөдөлмөр эрхлэх цорын ганц арга болж хувирсан. Алтны үнэ өсөх өнөөгийн хандлага анх 2003 онд гарч ирэхэд бичил уурхайд татагдах хүний тоо улам нэмэгдсэн.

Эхний үед бичил уурхайг удахгүй алга болох түр зуурын үзэгдэл хэмээн үзэж байсан. Гэвч бичил уурхайн хүрээ, нөлөө нэмэгдэн Засгийн газрын хяналтаас гадуур хөгжсөөр байсан тул бичил уурхай нь эдийн засгийн нэг чухал салбар, улс төрийн асуудал болж хувирсан. Байгаль орчинтой холбоотой хууль ёсны зовнил болон тодорхой сонирхолд хөтлөгдөн бичил уурхайг Монголын уул уурхайн салбарт тааламжгүй үзэгдэл гэсэн үзлийг олон нийтийн дунд бий болгох ажиллагаа явагдаж эхэлсэн бөгөөд бичил уурхайчдыг ялгаварлан гадуурхах, хүний эрхийг нь зөрчих явдал олонтаа гарч байсан. Үзэл баримтлалд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан хэдий ч ийм хандлага болон бичил уурхайг "түр зуурын" үзэгдэл гэсэн мөрөөдлийн бодол амь бөх байсаар л байна.

¹ 2008 оны 1 сарын 31 нд Парламентын шийдвэр No 12-р батлагдсан үндэсний стратегид тулгууралсан Мянганы хөгжлийн зорилт

² Хүнд хэцүү нөхцөлтэй өвөл

Одоо бичил уурхайчид зөвхөн алт, нүүрс төдийгүй хайлуур жонш болон бусад эрдэс олборлож байна. Статистикийн мэдээний дагуу өнөөдөр бичил уурхайчдын тоо 38,000 гэж байгаа боловч үүний зэрэгцээ албаны хүмүүс тооллого явуулах шаардлагатайг онцлон тэмдэглэж байна. Албан бус мэдээгээр 100,000 (1/3% нь эмэгтэй, 2/3% нь эрэгтэй) орчим бичил уурхайчид байгаа бөгөөд энэ нь хөдөөгийн ажиллах хүчний 20 орчим хувьтай³ тэнцэж байгаа ба улмаар 400,000 хүн энэхүү үйл ажиллагаанаас шууд бус хамааралтай байна. Бичил уурхайг байнга буюу улирлын чанартай эрхэлдэг, эсвэл зөвхөн олборлолт хариуцсан буюу үүнтэй холбоотой ажил (эрдэсийг ялгах, тээвэрлэх г.м) эрхэлж байгаа хүмүүсийг оролцуулан тоолсон эсэхээс шалтгаалан тоо ялгаатай гардаг.

Бичил уурхайчдын алтны үйлдвэрлэл багаар бодоход жилд 4 тонн, ахиуханаар бодоход 5-7 тоннтой тэнцэж байна. Иймд бичил уурхайчдын алт зараад олж буй жилийн орлого нь 100 сая ам. доллараас⁴ нэлээд давж байгаа гэж баттай тооцоолж болно. Алтны төлбөрийн хэрэгслийн де-факто чанартай үл нийцэх одоогийн татварын тогтолцоо (гэнэтийн орлогын татвар)-ны уршгаар бичил уурхайн алтны талаар худалдан авагчид ер тайлагнадаггүй бөгөөд албан бусаар экспортод гаргадаг. Тэгэвч, энэхүү 100 сая гаруй ам. долларыг Монголын экспортын де-факто нэмэлт орлого хэмээн тооцож болох юм.

Ашигт малтмалын газраас гаргасан судалгааны дагуу нийт бичил уурхайчдын 90.6 хувь нь алт, 4.2 хувь нь хайлуур жонш, 3.2 хувь нь нүүрс, 2 хувь нь бусад эрдэс олборлож байна. Хайлуур жоншны бичил уурхайн үйлдвэрлэл аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг ихээхэн нэмэгдүүлж байгаа ба Монгол Улсыг дэлхийн хэмжээнд гурав дахь том үйлдвэрлэгч болгож байна. Бичил уурхайн олборлосон нүүрсээр ядуу айл өрхөд хангалттай түлш нийлүүлж байгаа бөгөөд түлээний оронд түүнийг хэрэглэснээр хойд аймгуудад цөлжилттэй тэмцэхэд тус дэм болж байна.

Бичил уурхай нь хөдөө нутагт ажлын байр, орлогын эх үүсвэр бий болгох, үйлдвэрлэл, экспортын орлогыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой хэдий ч холбогдох эрх зүйн тааламжтай орчин бий болгох шаардлагатайг ойлгуулахын тулд арав гаруй жилийн хугацаа өнгөрлөө. Төслийн энэхүү баримт бичгийг боловсруулж байх үед Монголын Засгийн газар Монголын ашигт малтмалын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн эцсийн хувилбарыг Парламентад оруулсан. Саяхан буюу 2010 оны 7-р сарын 1нд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж баталсан.

3.3. Өмнөх үе шатны үр дүн ба сургамж

Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) нь 2005 онд эхэлсэн ба Латин Америкийн орнууд (Эквадор, Боливи, Перу)-д ШХА-ийн хэрэгжүүлсэн Бичил уурхайн төслүүдийн туршлагад үндэслэгдсэн болно. Эдгээр орнуудад ШХА нь Бичил уурхайн ажиллагааг хууль ёсны болгох, уул уурхайн захиргааны төвлөрлийг багасгах, харилцаа холбооны шинэ тогтолцоо бий болгох, хэрэгцээ хангахад чиглэсэн иж бүрэн (техникийн, байгаль орчны болон нийгмийн) үйлчилгээ үзүүлэх, бичил уурхайчдыг болон орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчдийг чадваржуулах явдлыг дэмжүүлэх чиглэлээр томоохон дэвшил гаргасан болно.

1,5 жилийн хугацаатай бэлтгэл үе шатыг оролцуулан 2005 оны 7 дугаар сараас 2010 оны 12 дугаар сар хүртэл үргэлжлэх төслийн үндсэн үе шат нь бичил уурхайн асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг зохион явуулах, холбогдох зохицуулалт, уялдаа холбоо, хамтын ажиллагааны бүтцийн боломжийг харуулах, уурхайчдыг хөгжүүлэн чадваржуулах асуудлуудад төвлөрсөн болно. Ингэснээр тус төсөл нь

³ Т. Навч, Ц.Болормаа, Б.Энхцэцэг, Д.Хүрэлмаа, Б.Мөнхжаргал: Монгол улсын албан бус алт олборлолт. ОУХБ 2006. (<http://www.unescap.org/stat/isie/reference-materials/Analysis-Country-Documents/Informal-gold-mining-MNG.pdf>)

⁴ Энэ нь хамгийн багаар бодсон тооцоо юм. 2010 оны 7-р сарын дунд үеийн байдлаар зах зээлийн үнэ нь 38,000 USD/kg (1,200 USD/oz) байгаа ба 4 тонн алт 150 сая USD болно.

- Бүхий л түвшинд үйл ажиллагаа явуулсан ба холбогдох журам боловсруулах, макро түвшний эрх зүйн хүрээний асуудлыг хэлэлцэх явдалд тус дэм болсон;
- Уурхайчдыг зохион байгуулалтад оруулахыг санаачлан хэрэгжүүлсэн ба уурхайчдын байгууллага болон төв, орон нутгийн захиргаа, хувийн компаниудын хооронд дунд түвшинд оновчтой харилцаа холбоо, хамтын ажиллагаа тогтооход дэмжлэг үзүүлсэн;
- Байгаль орчинд хал багатай, эдийн засгийн хувьд үр ашигтай технологи боловсруулж микро түвшинд нэвтрүүлэхэд тус дөхөм үзүүлсэн.

Үүний үр дүнд тус төсөл нь хамтрагч талуудын хооронд зөв зохистой шийдвэр гаргахад хувь нэмэр оруулсан ба албан бус “нинжа”-гийн уурхайн ажиллагааг албан ёсны бичил уурхай болгох чиглэлд анхны алхам хийхэд түлхэц өгсөн.

Бичил уурхайн төслийн нэгдүгээр үе шат нь “ бичил уурхайчдыг хөдөөгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах эдийн засгийн нэг гол дэд салбарын хүлээн зөвшөөрөгдсөн, хариуцлагатай гишүүн болох явдлыг хангах замаар Монгол Улсад хариуцлагатай уул уурхай хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх” зорилгодоо хүрэхийн тулд дараах дөрвөн зорилтыг хэрэгжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлсэн болно:

Зорилт 1: Бичил уурхайн талаар ил тод болон шударга бодлого ба зохицуулалтын хүрээ боловсруулж хэрэгжүүлэх явдлыг сайжруулах.

Зорилт 2: Бичил уурхайн бүх түвшинд зохион байгуулалтын бүтэц, байгууллагуудыг бий болгож ажиллуулах явдлыг сайжруулах.

Зорилт 3: Үр ашигтай бөгөөд хариуцлагатай уул уурхайн ажиллагаа явуулах, ядуурлыг бууруулахад чиглэсэн хувиараа ашигт малтмал олборлогчдын чадварыг бэхжүүлэх.

Зорилт 4: Хувиараа ашигт малтмал олборлогчдыг болон байгалийн баялаг ашиглагч бусад иргэдийг байгаль орчны болон нийгмийн мөргөлдөөний асуудалд хариуцлагатай хандаж шийдвэрлэх чиглэлээр чадваржуулах.

Төслийн 2-р үе шатны үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засгийн макро, месо, микро шатанд мэдэгдэхүйц үр дүн гаргасан. Үүнд:

- 2006 оноос ТБУТ-ын санал болгож байсан Ашигт малтмалын хуулинд өөрчлөлт оруулсан хуулийн төслийг 2010 оны дундуур батлан бичил уурхайчдыг хууль эрх зүйн орчинтой болгож өгсөн. Үүнийг бичил уурхайд шууд болон шууд бусаар холбоотой 400,000 гаруй хүмүүст шинээр хөгжих боломж олгож байгаа гэдэг утгаар нь төслийн хамгийн том ололт амжилт гэж үзэж болно.
- ТБУТ хэрэгжиж буй сумдын бичил уурхайчид өөрсдийнхөө амьжиргаанд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан талаар илэрхийлж байсан. “Манай гэр бүл урьд нь гэрт амьдардаг байсан бол одоо тоосгон байшинд амьдарч байна. Өвөл хоолныхоо махыг бага багаар худалдаж авдаг байсан бол одоо 1 үхэр, 2 хонины махаар идэш бэлтгэдэг болсон. Урьд нь малгүй байсан бол одоо 90 толгой малтай болсон” гэж Борнуурын эмэгтэй бичил уурхайчин Г ярьсан.

Борнуурын БАСМА мэтийн бичил уурхайчдын байгууллагууд үүсэн байгуулагдсан нь орон нутгийн хэмжээний өөрчлөлт болно.

2009 оны 10 дугаар сард хийсэн дунд хугацааны үнэлгээ (ДХҮ)-нд тус төсөл нь Монголын бичил уурхайтай холбоотой ихэнхи асуудлуудыг зохих ёсоор шийдвэрлэсэн гэсэн. 1-3-р бүрэлдэхүүн хэсгүүдийн сэдвүүдийг хөндлөнгийн оролцооны харилцаанаас тусгаарласан нь 3 томоохон бие даасан асуудлуудыг шууд хэрэгжүүлэх утгаар төслийг удирдах явдлыг хялбар болгосон хэдий ч төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хооронд уялдаа холбоо алдагдаж, тухайлбал бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгдмэл чанарыг дутуу ашиглах, боломж алдахад хүргэсэн. Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгдмэл байдал, уялдаа холбоог сайжруулах үүднээс ДХҮ-нд төслийг Бичил уурхайн бодлогын болон

Бичил уурхайчдыг дэмжих гэсэн хоёр том бүрэлдэхүүн хэсэгтэйгээр хэрэгжүүлэхийг зөвлөмж болгосон.

Энэ зөвлөмжид тулгуурлан 2010 оны нэгдүгээр сараас эхлэн төслийг хоёр бүрэлдэхүүн хэсгээр өөрчлөн зохион байгуулж туршиж байна. Ийм хандлагын эхний нааштай дүнг төслийн гуравдугаар гол үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан болно.

3.2 Бололцоотой болон хүндрэлтэй асуудлууд

3.4.1. Хүндрэлтэй асуудлууд

2005 онд төслийн үйл ажиллагааны төлөвлөлтийг хийж байх үед тулгарч байсан гол хүндрэлтэй асуудлыг “хөдөөгийн тогтвортой хөгжилд бичил уурхайгаас оруулж байгаа хувь нэмрийг бүрэн үнэлэхгүй байна” гэж тодорхойлж байсан. Үүнд нөлөөлж байсан гол асуудлуудыг жагсаавал:

- i) Монгол Улсын засгийн газраас бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг үр дүнтэйгээр зохицуулах боломжгүй байсан;
- ii) Бичил уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлсэн ноцтой хохирол нийгмийн зөрчилдөөнтэй асуудлууд, бичил уурхайчид болон тэдний гэр бүлийн хүмүүсийн амьдралын хүнд нөхцөл;
- iii) Бичил уурхайгаас улс орны эдийн засагт оруулж болох хувь нэмрийг үл харгалзсан энэ үйл ажиллагааны талаарх олон нийтийн санал бодол⁵

Эдгээр нөхцөл байдлыг зохицуулах, зөв ойлголт төрүүлэх талаар төслийн дөрвөн жилийн үйл ажиллагаа чухал хувь нэмэр оруулсан боловч хөдөөгийн ажиллах хүчний 20%-ийг хамруулсан албан бус салбарыг үндсээр нь албан ёсны салбар болгож өөрчлөх ярвигтай асуудлыг хөндөж ажилласан цорын ганц хөгжлийн төсөл байсан учраас уг салбарт тулгарсан эдгээр хүндрэлтэй асуудлууд байсаар байгаа нь гайхах зүйл биш юм.

Бичил уурхайн салбар одоо болтол албан бус, зохион байгуулалт муутай, ядуу дорой байгаа учраас бичил уурхайчдын ажлын байр найдвартай бус, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөө зөв зохистой шийдвэрлэгдээгүй, орон нутгийн тогтвортой хөгжилд оруулж байгаа хувь нэмэр нь хязгаартай байна.

Үүнд нөлөөлж буй гол **шалтгаанууд** нь:

2010 оны дунд үе хүртэл бичил уурхайн хууль эрх зүйн орчин дутмаг байсан явдал: Бичил уурхайн салбарыг 10-аад жилийн турш зохицуулах боломжгүй байсан нь доор дурдсан хэд хэдэн шалтгаантай:

- i) Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа нь түр зуурын үзэгдэл учраас хуульчлах шаардлага байхгүй гэсэн андуу ташаа ойлголт;
- ii) Бичил уурхайн үйл ажиллагааг хууль бус үйл ажиллагаа байлгаснаар таслан зогсоож болно гэсэн буруу ойлголт. Үүнд байгаль орчныг хамгаалагчдын бодол санаа хамрагдна;
- iii) Уул уурхайн дунд зэргийн компаниудын бичил уурхайн үйл ажиллагааны эсрэг явуулдаг лобби;
- iv) Дээр дурдсан шалтгаануудыг дэмжин сул дорой бичил уурхайчдын олборлосон алтнаас орлого олох гэсэн эдийн засгийн сонирхол (албан бусаар алт худалдан авагчид г.м.);

Бичил уурхайн салбарын муу зохион байгуулалт. Бичил уурхайчид хоорондоо жижиг хэмжээний баг болж үйл ажиллагаагаа явуулдаг. Гэвч өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалах зорилгоор нилээд дээгүүр шатны хэлбэрээр зохион байгуулалтанд орох тухай ойлголт бага багаар хүлээн зөвшөөрөгдөж байна. Энэ талаар төслийн зүгээс

⁵ ШХА, АМГ, 2005: Бичил уурхайн төслийг дэмжих төслийн бичиг баримт.

оруулсан хувь нэмрээс өөрөөр бичил уурхайчдын үндэсний хэмжээний дээвэр байгууллага байгуулах санаачлагатай ажил одоохондоо хийгдээгүй байна.


Бичил уурхайчид ядуу дорой байна. Ядуурал нь голдуу учир шалтгаан байхаасаа илүү нөлөө байх нь элбэг байдаг хэдий ч бичил уурхайг тойрсон харгис хатуу үйл ажиллагаанаас болж ядуурал нь асуудлын шалтгаан болж байна. Монгол Улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин харьцангуй бага (2.8%)⁶ байдаг ч хөдөө орон нутагт мал маллахаас өөр бусад ажлын байр байдаггүй. Бэлчээр болон байгалийн гамшгаас сэргийлэх бэлтгэл ажиллагаа (жишээ нь: зудны эсрэг бэлтгэл) нь бичил уурхайн үйл ажиллагаанд илүү олон хүн оролцох хүчин зүйл болж байна. Эдгээр хүмүүсийн ядуу зүдүү байдал нь тэдний үйл ажиллагаагаа сайжруулах, бичил уурхайн үйл ажиллагааг хариуцлагатай байдлаар явуулах боломжийг нь хязгаарлаж байгаагаас гадна орон нутгийн хөгжилд шууд хувь нэмэр оруулах боломжийг нь хааж байгаа юм. Ихэнх бичил уурхай эрхлэгчдийн хувьд өөр бусад ажил эрхлэх боломж байх юм бол бичил уурхай эрхлэхгүй гэдэг нь үнэн юм. Мал маллах нь (хэдийгээр ихэнх бичил уурхай эрхлэгчид урьд нь малчин байсан боловч) бичил уурхай эрхлэгчдийн хувьд янз бүрийн учир шалтгааны улмаас мал сүргээ алдсаны дараа бичил уурхай эрхэлж эхэлсэн учраас орлогын эх үүсвэр байхаа больсон байна. Ядуурал нь зөвхөн ганц санхүүгийн байдал биш, бичил уурхай эрхэлж буй газрууд дахь хүнд хүчир амьжиргааны орчин, хөөгдөж туугдах, дахин бүх зүйлсээ алдахаас айх айдас зэрэг нь үүнд нэгэн адил нөлөөлж байна.

Гол **нөлөөлж** буй зүйлсүүд нь:

Ихэнх бичил уурхайн үйл ажиллагаанууд хууль бус. Бичил уурхайн үйл ажиллагаа явуулах зорилгоор ашигт малтмалын эрх олгодоггүй. Тэр ч байтугай саяхан батлагдсан Ашигт малтмалын хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хуулийн дагуу ч бичил уурхайчдын нөхөрлөлүүдэд ашигт малтмал олборлох зорилгоор түр хугацаанд газар эзэмших эрх (ямар ч эрхгүй байсан үеийг бодвол урагш давшсан маш том алхам болсон) олгогдож байгаа. Уг үйл ажиллагааны хууль бус гэсэн нөхцөл байдлын үр дагавараар бичил уурхайн үйл ажиллагаа албан ёсны хөрөнгө оруулалт/санхүүжилт авах ямар боломжгүй байсан ба дэвшилтэт технологи ашиглах боломж нь хязгаарлагдмал байсан. Бичил уурхайн үйл ажиллагаа “нинжа” гэсэн нэрийг зүүсэн хэвээр байгаа учраас нөхцөл байдлыг сайжруулах лобби хийх боломж багатай байна.

Бичил уурхайчдын байдал эмзэг, албан бус нийгмийн халамжийн сүлжээнээс хамааралтай байна. Зохион байгуулалт муу болон албан бус үйл ажиллагаа гэдэг статус хоёр нийлээд бичил уурхайн үйл ажиллагааг эмзэг, арга тасарсан байдалтай болгож байна. Эдгээр хориг саад, хязгаарлалтаас болж бичил уурхайн үйл ажиллагаанаас орон нутгийн хөгжилд оруулж болох боломж бүрнээр ашиглагдахгүй байна. Нийгмийн болон дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалт хийгдэхгүй үлдээд зогсохгүй (фоотнот **Error! Bookmark not defined.**-ийг үзнэ үү) бичил уурхайн үйл ажиллагаа ашигт малтмалын талаарх зөрчилдөөнд орж болзошгүй. Өөр нэгэн ноцтой дутагдал нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгал гэх мэтийн албан ёсны нийгмийн халамж хүртэх боломж дутуу байгаа явдал юм. Эдгээрийн үр дагавар болж бичил уурхайчид хариуцлагагүй “нинжа” гэдэг нэрнээс салж чадахгүй байна.

⁶ www.indexmundi.com



Зураг 1: Асуудлын мод

Бичил уурхайчид тохиромжтой технологи ашиглах боломж хязгаарлагдмал байна. Бичил уурхайчид ядуу байснаас хамгийн энгийн багаж төхөөрөмжийг хэрэглэх хэрэгтэй болдог (зарим тохиолдолд тэдний хэргэлж байгаа багаж төхөөрөмжийг технологи гэж нэрлэхэд ч хүндрэлтэй байдаг). Ийм төхөөрөмжүүд нь бүтээмж бага, алт барилтын хэмжээ нь муу учраас бичил уурхайчдын орлого бага байх үндэс болохоос гадна бичил уурхайн салбарыг тойрон хүрээлж байгаа ядуурлаас үүссэн хүндрэлтэй асуудлуудыг улам баталгаажуулж байна. Үүний үр дагавар нь баталгаатай бус (зарим тохиолдолд хэтэрхий баталгаатай бус) ажлын байр болж байгаа ба үүнийг зарим талаар бичил уурхайчид амин зуулгаа дөнгөж хангаж байгаа ийм нөхцөлд зохих журмын дагуу нөхөн сэргээлт хийх болон бусад төрлийн байгаль орчинтой холбоотой арга хэмжээнд хөрөнгө мөнгө зарцуулах боломж бага гэдэгийг нь ойлгож болох юм. Сайжруулсан технологи нь (аюулгүй ажиллагаа, байгаль орчны хариуцлагатай үйл ажиллагаа явуулах, болон үр ашигтай ажиллах) ерөнхийдөө зөвхөн хөрөнгийн боломж бүхий хамтарсан хэлбэрээр ажиллах нөхцөлд л ашиглах боломжтой байдаг. Бүтэц зохион

байгуулалтын хязгаарлалт болон албан бус үйл ажиллагаа нь үүнийг хэрэгжүүлэхэд саад тотгор болдог.

3.4.2. Бичил уурхайн боломжууд

Бичил уурхайчид амьжиргаагаа залгуулахын төлөө ажиллаж байх үедээ тулгардаг хүндрэлтэй асуудлууд болон саад тотгорын хажуугаар орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулж байгаа ба саяхан батлагдсан Ашигт малтмалын хуулинд бичил уурхайн асуудлаар оруулсан өөрчлөлтийн хуулийн үр дүнгээр цаашид улам их хэмжээгээр хувь нэмэр оруулах боломжтой юм.

Ажлын байр бий болгох

Бичил уурхайчдын тоо 38,000-аас (албан ёсны тоо) 100,000-ын (албан бус тоо) хооронд хэлбэлзэж байхад том уурхай салбарт 46,500 ажилчид ажилладаг байна. Өөртөө ажлын байр гаргадаг гэдэг утгаараа бичил уурхайн оруулж байгаа хувь нэмрийг дор хаяж том уурхайн салбарын оруулж буй хувь нэмэртэй адилтгаж үзүүштэй. Монгол Улсын уул уурхайн салбарт нэг ажлын байр бий болгоход 17,000 ам.доллар (Хавсралт 2: Үйлдвэрлэлийн уурхайн салбарын статистик тоо баримт) орчим байдгийг харгалзан үзвэл бичил уурхайгаас оруулж байгаа хувь нэмэр ч ойролцоо байгааг тэдний жилд олж байгаа 500 сая ам.доллараас харж болно. Хэрэв бичил уурхайн үйл ажиллагаа явуулах боломж байхгүй байсан бол ажилгүй болсон хөдөөгийн иргэд магадгүй бүгд хот суурин газарлуу шилжин суурьших байсан бизээ.

Орон нутагт орлого бий болгох

Бичил уурхайгаар олборлож байгаа алтны үнэ өртөг нь ойролцоогоор “100 сая ам.доллараас” давсан гэж тооцоологдож байгаа. Том уурхайн үйл ажиллагаатай харьцуулбал гол ялгаа нь энэ хэмжээний мөнгө тэр чигээрээ хөдөлмөрийн хөлс болж байгаа учраас зөвхөн улс дотроо үлдээд зогсохгүй мөн тухайн бүс нутагтаа үлддэг. Монгол Улсад том уурхайн компаниудын ажлын хөлсөнд зарцуулдаг мөнгөний (орон нутгийн гол өртөг) хэмжээ нь 15-20% байдгийг харгалзан үзвэл бичил уурхайгаас орон нутагт орлого бий болголт нь үүнээс 4-5 дахин илүү байна. Иймээс алтны бичил уурхайгаас олж байгаа орлогыг алтны том уурхайгаас олж байгаа орлоготой ижил хэмжээтэй гэж үзэх боломжтой юм.

Бичил уурхайгаас орж ирсэн орлого орон нутгийн түвшинд эргэлтэнд орж орон нутгийн эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болдог. Үүнийг Хэсэг 3.3-т өгүүлсэн Борнуурын эмэгтэй бичил уурхайчны ярьсан яриа гэх мэт орон нутгийн хүмүүсийн мэдэгдэлүүд бататгаж өгнө.

Албан ёсны бичил уурхайн үйл ажиллагаанаас улсад орох орлого

Бичил уурхайн үйл ажиллагааг албан бус хэлбэрээр байлгасанаас болж татвар түрээс төлдөггүй, улсын төсөвт хувь нэмэр оруулдаггүй гэж ерөнхийдөө буруутгадаг⁷ ба уг салбарыг албан ёсны салбар болгосноор бүх боломжуудыг нээж өгөх юм. Төлөвлөлтийн семинарын үед орлогын татварын талаарх бичил уурхайчдын хандлага, санаа бодлын талаарх тэмдэглэлийг эргэж харах нь чухал юм (**Error! Reference source not found.**): “Хэрэв биднээс “бичил уурхайгаар олборлосон алтнаас авах татвар” гэсэн тодорхой нэртэй татвар байдаг бол зүй ёсны асуудал юм. Тэгвэл энэ нь бидний үйл ажиллагааг үнэхээр нэр төртэй болгож өгнө”. Ер нь бол албан ёсоор үйл ажиллагаа явуулах (татвар, төлбөр) нь албан бусаар үйл ажиллагаа явуулахаас (хахууль) хамаагүй хямд байдаг.

⁷ Перугийн Уул уурхайн яам болон Сангийн яамны дотоод ажлын бичиг баримтанд (2003 он, хэвлэгдээгүй) Засгийн газрын БУ-аас олдог нийт орлого уг салбарыг албан ёсны болгосноор 30 орчим хувиар буусан нь албан ёсны бичил уурхайчид өөр бусад албан ёсны бизнесийн адилаар хангамж үйлчилгээний нэмүү өртгийн татвараас чөлөөлөгдсөнтэй холбоотой гэжээ.

Хувь хүний орлогыг нэмэгдүүлэх боломж

Албан ёсны бөгөөд хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагаа нь илүү машин техник, механикжуулалтай холбогдох (Борнуурын хүдэр баяжуулах цех, Жаргалантын эксковатор гэх мэт) ба үүний үр дүнд ажлын бүтээмж болон алт барилтын хэмжээ нэмэгдэх юм. Энэ нь бичил уурхайчдын орлогын байдалд эерэг нөлөө үзүүлэхээс гадна технологийн түвшинг дээшлүүлснээр ажлын байрны аюулгүй байдлыг нэмэгдүүлэх юм.

Орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх боломж

Орон нутагт орлого бий болгох болон хөгжилд хувь нэмэр оруулах боломжийн хажуугаар Монгол улсын бичил уурхайн салбар олон улсын Шудрага худалдааны зах зээлд оролцох боломжтой юм. Шудрага худалдааны үйл ажиллагаанд алтны бичил уурхайн үйл ажиллагааг хамруулах ажил амжилттай хийгдэж байгаа ба үүнээс ёс суртахуунтай гоёл чимэглэл хэргэлэх хүсэлт бүхий хүмүүсийн хэрэгцээ шаардлага хангагдах юм. Мөн шудрага худалдааны зах зээлээс олсон орлого нь голдуу орон нутгийг хөгжүүлэх зорилгоор ашиглагддаг.

3.4.3. Хүндрэлтэй асуудлууд

Монгол Улсын бичил уурхайн салбарын хөгжилд дараагийн хэдэн жил маш чухал байна.

Хэдийгээр бичил уурхайн талаарх олон нийтийн санаа бодол өөрчлөгдөж байгаа боловч бичил уурхайн үйл ажиллагааг “хариуцлагатай бичил уурхай”-н үйл ажиллагаанд шилжүүлэх боломжийн талаар бодлого боловсруулах түвшний хүмүүс бас л эргэлзэж байна. Гэвч бичил уурхайн талаарх санаа бодол өөрчлөгдсөний үр дүнд Ашигт малтмалын хуулинд оруулсан бичил уурхайн талаарх өөрчлөлтийн тухай хууль Их хурлын гишүүдийн олонхийн саналаар (80-аас дээш хувиар) батлагдсан.

Бичил уурхайн салбарт бий болсон энэ “нэр хүнд”-ийг бичил уурхайн үйл ажиллагаа нийгэм болон байгаль орчны хариуцлагатай эдийн засгийн албан ёсны салбар болж хөгжиж чадна гэдгийг харуулан баталгаажуулах хэрэгтэй. Энэ бол БУ-н салбарын өмнө тулгарч байгаа хамгийн чухал асуудал бөгөөд БУ-н салбар бүрэн зохион байгуулалтад орж энэ асуудлыг өөрөө шийдвэрлэж чадах хэмжээнд хараахан хүрээгүй байгаа учраас ТБУТ-ийн дэмжлэг хэзээ хэзээнээс илүүтэйгээр хэрэгтэй байна.

Төр засгийн зүгээс БУ-н салбарыг чухалчлан дэмжих шаардлагатай байна. БУ-н зориулалтаар ашиглах газрыг олгох эрх мэдэл сум/дүүргийн засаг захиргаанд олгогдож байна. Мөн уул уурхайн асуудал хариуцсан төрийн байгууллагууд (ЭБЭХЯ, АМГ) ашигт малтмалын талаарх шаардагдах эрх мэдэл, засаглалыг төвлөрөлийг бууруулах замаар олгох хэрэгтэй байна. Одоогийн байдлаар зөвхөн ШХА шаардагдах олон улсын туршлага, дадлага туршлагыг оруулж ирэн хүргэх боломжтой байгаа болохоор төв болон орон нутгийн засаг захиргаа ТБУТ-өөр дамжуулан энэ талын дэмжлэг авах нь чухал асуудал болж байна (Хавсралт 10: Хамтрагч талуудын талаар хийсэн дүн шинжилгээ/Хамтрагч талуудын дүн шинжилгээ).

Дараагийн 2-3 жилийн хугацаанд БУ-н үйл ажиллагааг албан ёсны, хариуцлагатай БУ-н салбар болгох ажиллагаа эхлэн, амжилттай явагдавал ТБУТ-ийн үйл ажиллагааны үр дүн баталгаажих юм.

3.5 Хөгжлийн стратегитай уялдаа холбоотой байдал

Төслийн үйл ажиллагаа нь “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого” –ын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн бодлогын талаарх стратегийн 2-р зорилт болох “албан бус салбарт ажиллагсадыг албан ёсны салбар болгож шилжүүлэхэд шаардлагатай эрх зүй, эдийн засаг болон зохион

байгуулалтын арга хэмжээнүүдийг авах”⁸, мөн Монгол Улсын Засгийн газрын “Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр”-тэй нийцэж байгаа юм. Дэд хөтөлбөр дараах 2 зорилготой. Үүнд: 1) Ашигт малтмалыг гар үйлдвэрлэлийн арга, бичил уурхайн хэлбэрээр ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлж, хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохицуулах, 2) Уулын үйлдвэрийн ашигласан болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн үйлдвэрлэлийн бус агуулгатай нөөц, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд, үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдсон орд илрэл дэх ашигт малтмалын нөөцийг бага оврын техник, тоног төхөөрөмж, дэвшилтэт технологи хэрэглэн осол аваагүй, эдийн засгийн үр ашигтайгаар олборлодог бичил уурхайн загварыг бий болгон үе шаттайгаар хөгжүүлэхэд оршино.

Төслийн үйл ажиллагаа нь 2007-2012 онд Монгол Улстай хэрэгжүүлэх Швейцарийн хамтын ажиллагааны стратегийн үр дүн 3 “Хөтөлбөрт хамрагдах бүс нутагт орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, малаас авах ашиг шимийг дээшлүүлснээр малчид, хөдөөгийн иргэдийн амьжиргааг сайжруулах”-д хүрэхэд шууд хувь нэмэр оруулна.

4. Төслийн загвар ба стратегийн чиг хандлага

4.1 Төслийн үндсэн стратеги

Төслийн үндсэн стратеги нь Төслийн 3-дахь үндсэн үе шатны үйл ажиллагааны төлөвлөлтийн төсөлд дурдсан ерөнхий ойлголтуудыг тусгасан.

4.1.1 Хөгжлийн зорилго

Төслийн 3-дахь үндсэн үе шатны үйл ажиллагааны хөгжлийн зорилго нь “Бичил уурхайн үйл ажиллагааг Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, албан ёсны дэд салбар гэж хүлээн зөвшөөрдөг болгоход дэмжлэг үзүүлэх” юм.

4.1.2 Зохион байгуулалтын цар хүрээ: Олон нийтэд тулгууралсан уул уурхайн үйл ажиллагаа

Бичил уурхайн үйл ажиллагааг ерөнхийд нь 4 төрөлд хувааж үздэг:

- Байнгын үйл ажиллагаа явуулдаг ХАМО иргэд: Жилийн 4 улиралд тогтмол үйл ажиллагаа явуулдаг. Энэ бүлгийн хүмүүст ашигт малтмал олборлох ажиллагаа нь тэдний хийдэг эдийн засгийн ганц ажиллагаа байдаг ба зарим тохиолдолд цөөн тооны мал маллах болон бага хэмжээний худалдаа үйлчилгээ явуулахтай хавсарсан байдаг.
- Улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг ХАМО иргэд: Иргэд орлогоо нэмэгдүүлэх зорилгоор үндсэн хийдэг ажлынхаа хажуугаар улирлын чанартай олборлолтын ажиллагаа явуулдаг. Эсвэл бичил уурхайн идэвхитэй үйл ажиллагаа явагдаж байгаа бүс нутагт улирлын чанартай шилжиж ажилладаг хүмүүс.
- Гэнэтийн цугларалтын байдлаар үйл ажиллагаа явуулдаг ХАМО иргэд: Ердийн орлогоос нь хамаагүй илүү орлого олох боломж бүхий шинээр гарч ирсэн, ашигт малтмалын нөөц ихтэй газарт хүмүүс ихээр нүүдэллэн ирж үйл ажиллагаа явуулах.
- Аргагүйн эрхэнд бичил уурхайн үйл ажиллагаанд шилжсэн ХАМО иргэд: Байгалийн гамшигт үзэгдэл болон бусад салбарт ажиллаж байгаад ажлын байр болон орлогын эх үүсвэрээ алдсан хүмүүс амьжиргаагаа залгуулах зорилгоор бичил уурхайн үйл ажиллагаанд шилжиж орох.

⁸ Мянганы хөгжлийн зорилт, Бүлэг 5.2.1.1. Геологи, уул уурхай, ашигт малтмал болон хүнд үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого. 2008 оны 1 сарын 31 нд Парламентын шийдвэр No 12.

Монгол улсын хувьд гар аргаар ашигт малтмал олборлох ажиллагаа 2000 оны эхэн үеээс аргагүйн эрхэнд бичил уурхай эрхлэлтээс үүдсэн хэлбэрээр бий болж эхэлсэн. Үүнээс олох орлого нь харьцангуй их байснаас болон алтны үнэ нэмэгдэж байсан зэрэг учир шалтгаануудаас болж энэ үйл ажиллагаа хурдан хугацаанд гэнэтийн цугларалтын байдлаар үйл ажиллагаа явуулдаг хэлбэрт шилжсэн. Эдгээр хэлбэрүүд нь хэдийгээр түр зуурын хугацаанд үргэлжилдэг боловч ашигт малтмалаас олох орлого нь амьжиргааг тогтвортой хангаж байгаа тохиолдолд байнгын болон улирлын чанартай үйл ажиллагаа болж хувирах магадлал өндөртэй байдаг.

Байнгын болон улирлын чанартай бичил уурхайн үйл ажиллагаа нь олон нийтэд суурилсан бичил уурхайн үйл ажиллагаа гэсэн нэр томъёогоор тодорхойлогддог. Энэ нэр томъёоны утга нь тухайн орон нутгийн ард иргэд ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа харъяаллынхаа газар нутагт байгаа нөөцтэй газар явуулан өөрсдийнхөө амьжиргааг залгуулдаг оршино.

Монгол улсын эдийн засгийн шилжилтийн үе бараг дуусах үе шатандаа орсонтой холбоотойгоор тус улс хөгжлийн идэвхитэй үе шатанд шилжинээс аргагүйн эрхэнд бичил уурхай эрхлэлтээс үүдсэн бичил уурхайн үйл ажиллагаа үндсэндээ зогсож бичил уурхайн үйл ажиллагаа явуулдаг олон газарт байнгын болон улирлын чанартай олборлолтын хэлбэрт шилжсэн. Харин хурдан хугацаанд сандралын байдалтай үйл ажиллагаа явуулдаг хэлбэр нь шинээр ашигт малтмалын гарц ихтэй газар илрэх болгонд дахин сэргэх учраас “дахин дахин давтагдах түр зуурын ажиллагаа” гэж нэрлэгдэх боломжтой юм.

ТБУТ-өөс 4 суманд (Жаргалант, Бөмбөгөр, Бигэр, Уянга сумд) хийсэн Нийгэм-эдийн засгийн суурь судалгаанаас гарсан үр дүн энэ хандлагыг бататгаж байна. Эдгээр сумдад үйл ажиллагаа явуулж байгаа бичил уурхайчдыг (68% шороон орд, 32% үндсэн орд) ямар ажилладаг талаар ангилахад дараах дүр зураг гарсан. Үүнд:

- 65% байнгын үйл ажиллагаа явуулдаг ХАМО иргэд (амьжиргаа залгуулах үндсэн ажил)
- 20% улирлын чанартай ажилладаг ХАМО иргэд (мөнгө хэрэгтэй болсон үед олборлолт хийдэг)
- 15% гэнэтийн цугларалтын байдлаар ажилладаг ХАМО иргэд (орлого олох зорилгоор илрэх ихтэй үед олборлолт хийдэг)

ТБУТ-ийн үзүүлэх нөлөөг оновчтой болгох зорилгоор төсөл (Швейцарь болон Монголын талууд) байнгын болон улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг БУ-ын дунд “манлайлагчид”-ыг төрүүлэн сум орон нутгийн төрийн болон ТББ-уудтай хамтран гэнэтийн цугларалтын болон аргагүйн эрхэнд БУ-н үйл ажиллагаа явуулж байгаа газруудад ажиллаж байгаа ХАМО иргэдийг тухайн орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг олон нийтэд тулгууралсан үйл ажиллагаа явуулдаг хүмүүс болж зохион байгуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах хэрэгтэй юм.

Төсөл 3-р үе шатандаа үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа газрынхаа иргэдийн тогтвортой амьжиргааг хангахад хувь нэмэр оруулах үүднээс тухайн нутгийн байнгын болон улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг ХАМО иргэдтэй ажиллана.

4.1.3. Үйл ажиллагаа явуулах хүрээ

ТБУТ өмнөх үе шатандаа 2005-2010 оны хооронд голчлон алт олборлогч ХАМО иргэдтэй зохион байгуулалт, чадвар дээшлүүлэх, технологийг нь сайжруулах, бүртгэлжүүлэх болон бичил уурхайн бодлого боловсруулах замаар тэднийг чадваржуулж, эрх мэдэлжүүлэх талаар ажиллаж ирсэн.


Монгол улсын бичил уурхайн 90 орчим %-ийг алтны бичил уурхайчид эзэлж байгаа боловч бусад ашигт малтмалын төрлүүд болох жонш, нүүрс олборлодог газруудад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа гэх мэт уул уурхайн салбарт тулгардаг нийтлэг асуудлууд газар авсан байна. Иймээс Монгол улсын бичил уурхайн салбарыг хариуцлагатай, тогтвортой эдийн засгийн үйл ажиллагаа явуулдаг хэлбэрт шилжүүлэхийн тулд бичил уурхайн салбарт тавих анхаарлыг цогц байдлаар хандуулах хэрэгтэй байна. Төсөл 3-р үе шатныхаа үйл ажиллагааг мөн жонш, нүүрс гэх мэт бусад

төрлийн ашигт малтмалыг байнгын болон улирлын чанартай олборлогч ХАМО иргэдэд хүрч ажиллахад чиглүүлэх болно.

2-р үндсэн үе шатны үйл ажиллагааны үед олж авсан сургамж дээр үндэслэн алтны бичил уурхайчдыг хөгжүүлэх болон технологийг сайжруулах ажиллагаагаа өргөжүүлэн жонш, нүүрс олборлодог газарт ижил стратеги бүхий үйл ажиллагаа явуулж туршина.

4.1.4 Үйл ажиллагааны таамаглал

Төслийн гол стратеги нь яг одоогийн төслийн төлөвлөлтийг хийж байгаа үеийн бичил уурхайн салбарыг тойрон хүрээлсэн хүндрэлтэй асуудлын тойргоос гарч бичил уурхайн орон нутгийн эдийн засагт оруулж байгаа хувь нэмэр нь энэ ажиллагааг албан ёсны хариуцлагатай бичил уурхай болж хөгжихөд гол хөшүүрэг болсон таатай нөхцөл үүсгэх улмаар энэ нь бусад харилцагч талуудад хариуцлагатай бичил уурхай нь хөгжих боломжтой гэсэн итгэл үнэмшил төрүүлэх, түүнийг харуулахад оршино.



Зураг 2: Олон нийтэд тулгуураласан бичил уурхайн тогтвортой хөгжлийн тойрог

Иймэрхүү таатай орчноор хүрээлүүлэх нөхцлийг бий болгохын тулд бодлогын төвшинд идэвхижүүлж чиглүүлэх ажил, харин бичил уурхайчдын төвшинд чадваржуулах, чадавхи дээшлүүлэх ажиллагааг зохион байгуулах шаардлагатай. Бичил уурхайг тойрсон таатай нөхцөл нь бодлого боловсруулагч болон уурхайчдын хоорондох хоёр талын хамтын ажиллагааны эерэг эргэх холбоо үүсгэснээр улам шаардагдах эрч хүчийг олгон өөртөө итгэлтэй үйл ажиллагаа явуулдаг болно.

4.1.5 Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд

Төслийн үйл ажиллагаа явуулахад дараах 2 үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байх нь тохиромжтой болох нь харагдаж байна:

Бичил уурхайн бодлогын бүрэлдэхүүн хэсэг

Бичил уурхайн бодлогын бүрэлдэхүүн хэсэг бичил уурхайд чиглэсэн бодлого эрх зүйн таатай орчин бий болгох ажлыг дэмжих, албан ёсны, хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагааг хөгжүүлэх тохиромжтой журмыг бий болгох ажилд идэвхжүүлэгчийн хэлбэрээр оролцох үүрэгтэй.

Энэ бүрэлдэхүүн хэсэг Монгол Улсын Засгийн газрын бичил уурхайн салбарыг зохицуулах, энэ салбарыг үндэсний эдийн засгийг бүрдүүлэгч идэвхитэй хэсэг болгож шилжүүлэх талаар явуулж байгаа арга хэмжээг дэмжинэ. Бусад орнуудын туршлага, түүний дундаас Перу улсад ШХА-ийн хэрэгжүүлсэн төслийн үр дүн нь бичил уурхай үйл

ажиллагаа нь орон нутагт албан ёсны жижиг бизнес болж хөгжих боломжтой юм гэдгийг баталсан.

Монгол Улсын Их хурлаас Засгийн газрын санаачилсан Ашигт малтмалын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай хуулийг батлах явдал нь бичил уурхайд түүний “төрсний гэрчилгээ”-г олгож байгаатай дүйцэхүйц анхны бөгөөд шийдвэртэй алхам болно. Цаашид маш олон хүндрэлтэй асуудлууд гарч ирнэ, ялангуяа энэ хуулиар зохицуулалт хийж эхлэхэд олборлолтын газар, олборлох эрхээс гадна бичил уурхайтай холбоотой янз бүрийн асуудлууд гарч ирнэ. Тухайлбал, нийгэм, эрүүл мэнд, байгаль орчин, санхүү, хөрөнгө мөнгөний асуудал гэх мэт.

Бичил уурхайн бодлогын бүрэлдэхүүн хэсгийн хувьд бичил уурхайн таатай эрх зүйн орчин бий болгох, бичил уурхайчдын болон олон улсын туршлагыг олон нийтийн сонорт хүргэх болон албан ёсны хариуцлагатай бичил уурхайчдын хүрч болох амжилтыг үзүүлэхэд идэвхжүүлэгчийн үүрэг гүйцэтгэнэ.

Бичил уурхайчдын хөгжлийн бүрэлдэхүүн хэсэг

Бичил уурхайчдын хөгжлийн бүрэлдэхүүн хэсэг нь аюулгүй, байгаль орчин болон нийгмийн хариуцлагатай, харъяалагдах орон нутагтаа эдийн засгийн үр ашигтай олборлолтын үйл ажиллагаа явуулахад орон нутгийн бичил уурхайчдыг чадавхижуулах мөн орон нутгийн бичил уурхайчдыг зохион байгуулалтад орох, тэдний үйл ажиллагааг албан ёсны болгоход нь дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй байна.

2-р үе шатанд нөхөрлөлийн төвшинд ажиллаж байсан нь энэ ажлын эхлэл байсан. Байнгын болон улирлын чанартай бичил уурхайчдын албан ёсоор байгуулагдсан байгууллагууд нь аюулгүй ажиллагаа, сайжирсан технологиор дамжуулан тухайн орон нутгийн бичил уурхайчдыг хөгжүүлэх болон олборлолтын үйл ажиллагаанд мэргэшүүлэх талаар манлайлах хэрэгтэй байна. Бичил уурхайчдын техникийн болон бизнесийн чадавхи нь сайжирснаар магадгүй хууль эрх зүйн дагуу лиценз авах эрхтэй бичил уурхайчдын компани болон хоршоолол болгох эсхүл ашиглалтын лиценз эзэмшдэг компанитай бие даан гэрээ хийж ажиллах боломжтой болгож болзошгүй юм.

Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааны хүрээнд төсөл ХАМО иргэдтэй нягт холбоотой ажиллан тэднийг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа хариуцлагатайгаар явуулахад шаардлагатай техникийн, зохион байгуулалтын болон нийгмийн талаарх ур чадвар олж авах гэсэн оролдлогыг нь дэмжиж ажиллах болно. Төсөл хэрэгжиж байгаа бичил уурхай эрхэлдэг газрууд энэ үйл ажиллагаанаас орон нутгийн хөгжилд оруулсан хувь нэмэр нь харагдахуйц байж цаашид хууль эрх зүйн орчныг сайжруулах үйл хэрэгт голлох түлхэц болох ёстой.

4.1.6 Төслийн арга барил

ТБУТ–н хоёр дахь үндсэн үе шатны төлөвлөгөөний үндэс боловсруулахдаа эрхэд тулгуурлан чадваржуулах талаарх ДХҮ-ний зөвлөмжийг баримталсан.



Зураг 3: Эрхэд тулгууралсан арга барил ба чадавхижуулах арга барил

Чадваржуулах гэдэг бол хувь хүн буюу бүлэг хүмүүсийг сонголт хийх болон сонголтлоо хүссэн ёсоор ажил хэрэг болгон үр дүнд хүрэх чадварыг нь дээшлүүлэх үйл явц юм. Энэ нь хүмүүсийг сургах замаар чадварыг нь бэхжүүлж, өөрсдийн болон хамт олны, нийгмийн амьдралд ашиглах үйл явц юм. Энэхүү үйл явц нь хүмүүст амьдралаа өөрөө хариуцан зохицуулахад болон тэдний чухалчилж байгаа асуудлууд дээр төвлөрөхөд тустай болно.

Чадваржуулах гэдэг бол таагүй байдалд байгаа хүмүүс эрхээ эдлэх чадвартай болох үйл явц мөн⁹.

Эрхийн өнцөгөөс асуудалд хандах нь хүмүүсийн чадвар, эрх, хариуцлагад нөлөө үзүүлдэг хүчний харилцааны гол асуудлуудыг шийдвэрлэх хүрээ болж өгдөг. Тэнцвэртэй хандлагад олон нийт, иргэний нийгэм болон хувь хүн аль аль нь эрх эдэлдэг, мөн үүрэг хүлээдэг гэсэн ойлголт байдаг.

Бичил уурхай эрхэлдэг иргэд арав гаруй жилийн хугацаанд үл тоомсорлох байдалд байж саяханаас л олон нийтийн болон улс төрийн санаа бодол өөрчлөгдөж, бичил уурхайг хөдөөгийн эдийн засгийг хөгжүүлэхэд тустай, хариуцлагатай аргаар явуулах шаардлагатай ажиллагаа хэмээн хүлээн зөвшөөрч эхэлсэн Монголд бичил уурхайн түүх, өнөөгийн байдлыг харгалзан эрхэд тулгуурлан чадваржуулах хандлага бол хөгжлийн зорилгод хүрэх хамгийн тохиромжтой хувилбар мөн.

4.2 ТБУТ төслийг хэрэгжүүлэх стратеги

ТБУТ-н гурав дахь гол үе шатны хэрэгжилтийн стратегид Монголын оролцогчдын нийтлэг ойлголтыг тусгасан болно. Энэ нь ярилцлага зохион явуулах, тухайн газар дээр очиж танилцах, гол үйл явдал болох 68 оролцогчдыг хамарсан төлөвлөлтийн семинар хийх замаар төв, аймаг, сумын Засгийн газар, Парламент, Иргэдийн Хурал, бичил уурхай эрхлэгчид болон тэдний байгууллагууд, иргэний нийгэм, эрдэмтэд, хувийн хэвшил, мөн түүнчлэн ижил үзэл баримтлагч донорууд зэрэг 250 гаруй гол оролцогчдыг хамарсан төлөвлөлтийн суурь тавих оролцооны аргаар хийгдсэн үйл явцын үр дүн мөн.

4.2.1. Хариуцлагатай бичил уурхайн талаарх оролцогчдын байр суурь

Төлөвлөлтийн семинарт оролцсон оролцогчид (**Error! Reference source not found.**) “хариуцлагатай бичил уурхай” гэсэн нэр томъёоны талаар нэгдсэн ойлголтод хүрэхийг хичээсэн болно. Бичил уурхай Монголд дараах нөхцөлд хөгжих боломжтой. Үүнд:

- Хууль тогтоомжийн дагуу албан ёсны эдийн засгийн ажиллагаа явуулж, хууль эрх зүйн хүрээгээр хамгаалагдсан байх,
- Зохион байгуулалтад орсон уурхайчид ажиллагаа явуулах,
- Нийгмийн хариуцлагаа илтгэн харуулах, бусдын эрхийг хүндэтгэх, уурхайчид болон тэдний гэр бүлийн нийгмийн хамгаалал болон аюулгүй ажиллагааны талаарх эрхийг хүндэтгэх,
- Байгаль орчны хариуцлагаа илтгэн харуулах, байгаль орчинд хал багатай технологи хэрэглэх, эрдэс баялгийг ашигласны дараа байгаль орчны нөхөн сэргээлт хийж дуусгах,
- Орон нутгийн хөгжил, тогтвортой амьжиргаа, орлого үйлдвэрлэлтэд тус дэм болох зэрэг болно.

4.2.2. Монголд хариуцлагатай бичил уурхайн салбар хөгжүүлэхтэй холбоотой гол асуудлууд

⁹ SDC (2004) Creating the Prospect of Living a Life in Dignity – Principles Guiding the SDC in its Commitment to Fighting Poverty, Berne: SDC. (www.deza.admin.ch/ressources/resource_en_24237.pdf)

Бичил уурхайд өргөн хүрээний асуудлууд хамааралтай байдаг учраас энэ талаарх төслүүд олон талт хандлага хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. Монголын оролцогчид албан бус байсан, одоо ч гол төлөв тийм байгаа “нинжа”-гийн уурхайг Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулагч хариуцлагатай бичил уурхайн ажиллагаа болгоход дараах 6 гол асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж тодорхойлсон:¹⁰

- Хууль эрх зүйн хүрээ ба албажуулалт
- Бичил уурхайн зохион байгуулалт ба түүний бэхжилт
- Нийгмийн хариуцлага, нийгмийн хамгаалал ба аюулгүй ажиллагаа
- Байгаль орчны хариуцлага, байгальд хал багатай технологи
- Сургалт ба мэдээллийн хүртээмж
- Орон нутгийн хөгжил ба орлого бий болгох

Хууль эрх зүйн хүрээ ба албажуулалт

Бичил уурхайн талаар хууль эрх зүйн хүрээ бий болгох үйл явц Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулснаар эхэлсэн. Энэ нь практикт хэрхэн хэрэгжиж ямар нөлөө үзүүлэх нь холбогдох журмаас ихээхэн шалтгаалах болно. Төслийн зүгээс энэ чиглэлээр цаашид ч идэвхтэй ажиллах шаардлагатай бөгөөд олон нийтэд явцыг мэдээлэх талаар ч үргэлжлэн ажиллах шаардлагатай. “Албан ёсны ажиллагаа” болгох нь газар болон ашигт малтмалтай холбоотой эрх, үүргээр хязгаарлагдахгүй тул санхүүгийн дэглэм, нийгмийн хамгаалал, г.м. эрх зүйн дагавар асуудлууд дээр үргэлжлэн ажиллах шаардлагатай болно.

Бичил уурхай эрхлэгчид өнөөгийн хууль тогтоомжийг мөрдөх, бүртгэгдээгүй нөхөрлөлүүдийн хувиар газрын эрх олж авах шаардлагатай байх бөгөөд үүний зэрэгцээ ТББ-ийн нэгэн адил илүү өндөр төвшний хуулийн этгээд болтол хөгжих, ашигт малтмалын эрх эдлэх боломжтой компани буюу хоршоолол болох чиглэлээр ажиллаж болох талтай. Өнөөгийн журам, үндэсний стандартыг бичил уурхай эрхлэгчдээр мөрдүүлэхийн тулд тэдгээрийн гол заалтууд нь бичил уурхайн салбарын сайн туршлага, албан ёсоор батлагдан нийтлэгдсэн бичил уурхайд тавих “наад захын шаардлагын” жагсаалтад тулгуурласан байх учиртай. Бичил уурхайн ийм стандартууд бол бичил уурхай эрхлэгчдийн хувьд удирдамж, хянагчдын хувьд бодит хэмжүүр болох юм.

Өнөөгийн саад бэрхшээлийг арилгах үүднээс ТБУТ нь уул уурхайн холбогдолтой болон бусад хууль зүйн асуудлуудыг зохицуулах тааламжтай эрх зүйн орчин бий болгох талаар үргэлжлэн ажиллах шаардлагатай. Бичил уурхай эрхлэгчдэд албажих үйл явцад нь дэмжлэг үзүүлэх бөгөөд бүртгэгдээгүй нөхөрлөлөөс шат ахин ашигт малтмал олборлох эрхтэй хуулийн этгээд болоход нь туслалцаа үзүүлнэ.

Бичил уурхайн зохион байгуулалт ба түүний бэхжилт

Зохион байгуулалт болон түүний бэхжилт нь уурхайчдыг уурхайн талбай, сум, аймаг болон үндэсний хэмжээнд чадваржуулахад чухал ач холбогдолтой. Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан бичил уурхайн салбартай болох (жишээлбэл, “Холбоо”) саналыг хамтран шаардлага, асуудлаа (жишээлбэл, эрх зүйн орчинг сайжруулах асуудал) тавих боломжтой байх үүднээс уурхайчдын зүгээс, мөн түүнчлэн “бичил уурхайн нийт салбар”-тай харилцаж, яриа хэлцээ хийх боломжтой байх үүднээс Засгийн газар (АМГ)-ын зүгээс тавьдаг.

Орон нутгийн төвшинд зохион байгуулалтыг бэхжүүлэх нь бичил уурхайн хууль ёсны нэгжийг байгуулах замаар орон нутгийн хөгжил, албажуулалтын үндсэн асуудалтай холбоотой. Ийм нэгжүүд байгуулах нь томоохон ордуудад (тухайлбал, Борнуурын хүдэр баяжуулах цех) хэрэглэдэг технологийг ашиглах, боловсронгуй болгох, эсвэл газрыг нөхөн сэргээх бага оврын машин техник болон уул уурхайн бусад техник ашиглах шаардлага гардаг юм. Ийм технологийг зөвхөн хувь хүн (хууль ёсны ажиллагаа

¹⁰ Хавсралт 9-г үзнэ үү: Төлөвлөлтийн семинар

явуулдаг нөхцөлд) буюу ТБУТ-н зохион байгуулалтын хүрээнд бичил уурхайн хууль ёсны нэгж гишүүний хувьд өмчлөх боломжтой.

Өнөөгийн саад бэрхшээлийг арилгах үүднээс ТБУТ нь бичил уурхай эрхлэгчдийн зохион байгуулалтын үйл явцыг бүсийн болон үндэсний төвшинд бэхжүүлж, уурхайчдад санаа бодлоо илэрхийлэх боломж, Засгийн газарт яриа хэлцээ хийх түнштэй болох боломж олгох хэрэгтэй. Орон нутгийн төвшинд зохион байгуулалтыг бэхжүүлэх нь орон нутгийг хөгжүүлэх болон технологийг боловсронгуй болгон технологийг хамтран ашиглах (жишээлбэл, боловсруулах үйлдвэр хэлбэрээр) үндсийг тавьж өгнө.

Нийгмийн хариуцлага, нийгмийн хамгаалал болон аюулгүй ажиллагаа

Хариуцлагатай бичил уурхай бол бусдын эрхийг хүндэтгэх, уурхайчид болон тэдний гэр бүлийн нийгмийн хамгаалал, аюулгүй ажиллагааны хувь хүний эрхийг хүндэтгэх замаар нийгмийн хариуцлагаа илтгэн харуулах учиртай. Бичил уурхай эрхлэгчдийн сэтгэл санааг хяналтгүй, эмх замбараагүй “нинжа”-гаас хариуцлагатай “хувиараа ашигт малтмал олборлодог иргэн” болгон өөрчлөх үйл явцыг үргэлжлүүлэн бэхжүүлэх шаардлагатай.¹¹ Төслийн зохион байгуулалтын хүрээнд уурхайчдын нөхөрлөлд оновчтой дэмжлэг үзүүлэх явдал ийм өөрчлөлт хийхэд тус дөхөм болно.

Нийт оролцогчид бичил уурхайн салбарт эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны нөхцлийг сайжруулах асуудалд тэргүүн зэргийн ач холбогдол өгч байна. Аюулгүй ажиллагааны талаарх мэдлэгийг дээшлүүлэх, уурхайчдын дунд аюулгүй тоног төхөөрөмж хэрэглэх явдлыг дэлгэрүүлэх, осол гарахад илүү бэлтгэлтэй байх замаар бичил уурхайн аюулгүй ажиллагааг нэн даруй хангах шаардлагатай гэсэн ерөнхий ойлголт байна. Элдэв осол ялангуяа нүүрс болон хайлуур жоншны уурхайд олонтаа тохиолддог. Бичил уурхайд тохиолддог осолууд тооны хувьд том уурхайнуудынхтай ойролцоо боловч үр дагавар нь илүү хүнд тусдаг бөгөөд аврагчдын үйлчилгээг алс хол орших бичил уурхайд хүргэх замаар шийдвэрлэх шаардлагатай. Албан бус ажиллагаа ямагт аюултай эрсдэлтэй байх тул аюулгүй ажиллагааны асуудал албажуулалтын асуудалтай мөн холбоотой болно.

Нийгмийн хариуцлага бол уурхайчдын гэр бүлийн буюу нөхөрлөлийн доторх эв санааны нэгдэлд тулгуурласан албан бус нийгмийн хамгааллын сүлжээнээс албан ёсны нийгмийн хамгааллын сүлжээ рүү шилжүүлэх асуудалтай мөн холбоотой. Зохион байгуулалтын хувьд сул бичил уурхайн тухайд эрх зүйн хүрээнд өөрчлөлт оруулж, бичил уурхайг мал аж ахуйн нэгэн адил хөдөөгийн бие даасан салбар хэмээн зөвшөөрүүлэх шаардлагатай. Зохион байгуулалтын хувьд илүү өндөр түвшинд байгаа бичил уурхай эрхлэгчдийг ТББ, хоршоолол буюу компаний ажилтан хэмээн үзэж нийгмийн хамгаалалд хамруулах нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай.

Бичил уурхайн нийгмийн хариуцлага бол орон нутгийн хөгжлийн асуудалтай мөн холбоотой. Уул уурхайн ажиллагаа нь эдийн засгийн бусад ажиллагаатай харьцуулбал илүү орлого олох боломжтой тул уурхайчид орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцох учиртай.

Өнөөгийн саад бэрхшээлийг арилгах үүднээс ТБУТ нь албан бус “нинжа”-гаас хариуцлагатай “хувиараа ашигт малтмал олборлодог иргэн” болгох сэтгэл санааг төлөвшүүлэх талаар үргэлжлэн ажиллах шаардлагатай. Энэ нь аюулгүй ажиллагааны асуудалд илүү ач холбогдол өгөх, уурхайчдыг болон тэдний гэр бүлийг нийгмийн хамгааллын тогтолцоонд хамруулах чиглэлд ахиц гаргахыг шаардаж байна.

Байгаль орчны хариуцлага, байгаль орчинд хал багатай технологи

¹¹ “Нинжа” гэсэн нэр томъёо Монголд алт олборлох эхний жилүүдэд гарч ирсэн бөгөөд албан бусаар бичил уурхайн ажиллагаа явуулж байгаа уурхайчдыг тодорхойлж байгаа юм. Энэ нэр томъёо алт угаахад ашигладаг ногоон хуванцар савыг уурхайчид нуруундаа зүүж явдагийг нинжа яст мэлхийтэй төстэй гэсэн утгаар үүссэн болно. Үүний зэрэгцээ энэ нэр томъёо мөн хуулийн гадуур явуулж байгаа ажиллагаа гэсэн утга агуулж байгаа ба анхны уурхайчид үүгээр ихэд бахархаж байсан. БУ-н түр журам гарснаас хойш ийм сэтгэл санаа өөрчлөгдөж байгаа бөгөөд албан ёсоор ажиллагаа явуулж буй уурхайчид одоо өөрсдийгөө “хувиараа ашигт малтмал олборлогчид” гэж нэрлүүлэх дуртай болсон.

Бичил уурхайн ажиллагааны, нэн ялангуяа алтны шороон ордны олборлолтын байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөө бүх нийтийн сэтгэл түгшээж байгаа бөгөөд олборлолтын газрыг нөхөн сэргээх шаардлагын асуудалд Засгийн газар болон олон нийт тэргүүн зэргийн ач холбогдол өгч байна.

Бичил уурхай эрхлэгчдэд тавих байгаль орчны талаарх шаардлага нь тодорхой бөгөөд хялбар, бодит байх хэрэгтэй. Холбогдох журам нь үйл ажиллагааны хүрээг сайтар харгалзан үзсэн байх ёстой бөгөөд хэргэжүүлж болохуйц байх ёстой. Тус төсөл нь сайн туршлагыг дэлгэн харуулах талаар гол үүрэг гүйцэтгэх бөгөөд, бичил уурхайчид том уурхайн орхигдсон болон нөхөн сэргээлт хийгээгүй талбайд нөхөн сэргээлт хийнэ гэх мэт явцгүй асуудлыг зогсоох талаар чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. Орон нутгийн иргэдээс байгаль орчны мониторинг хийх нь хариуцлагатай ажиллагаа явуулах явдлыг хангах чухал бүрэлдэхүүн хэсэг байж болох талтай бөгөөд дотоодын хяналт ихэнхи тохиолдолд хөндлөнгийн хяналтаас илүү үр дүнтэй байдаг болно.

Нөхөн сэргээх ажил уурхайчдын уялдаатай холбоотой үйл ажиллагаа болон хамтран эзэмшиж буй технологийг (тухайлбал, трактор, эксковатор) ашиглахыг шаарддаг тул ихэнх тохиолдолд нөхөн сэргээлт явуулах шаардлага зохион байгуулалтын ажилтай ихээхэн холбоотой байдаг. Хориотой мөнгөн усны оронд боловсруулах үйлдвэр байгуулах нь цорын ганц хувилбар болсон үндсэн ордуудын хувьд ч зохион байгуулалтын асуудал чухал ач холбогдолтой байдаг. Борнуурын баяжуулах цехийн загвар бичил уурхайн “албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн” технологи гэж эцэслэн батлагдах шаардлагатай ба цаашид үндсэн ордны олборлолтын үйл ажиллагаа явуулдаг өөр газруудад саадгүй ашиглах боломжтой болох хэрэгтэй. Хүдэр баяжуулах хангалттай хүчин чадалтай цехтэй байж л гэр орны нөхцөлд нууцаар мөнгөн ус ашиглаж буй явдлыг зогсоох боломжтой байх бөгөөд цехүүд сайн туршлага, ёс журмын дагуу үйл ажиллагаа явуулж байгааг баталж өгөх болно.¹²

Өнөөгийн саад бэрхшээлийг арилгах үүднээс ТБУТ нь байгаль орчны мониторингийг орон нутгийн иргэдээр хийлгэх асуудлыг оролцуулан бичил уурхайн ажиллагаанд тавих үндэслэлтэй болон заавал биелүүлэх байгаль орчны шаардлагын талаар оновчтой зөвшилцөлд хүрэхэд тус дөхөм үзүүлэх шаардлагатай. Олборлолтын талбайг нөхөн сэргээх явдал бүх нийтийн практик болох ёстой бөгөөд тус төсөл энэ чиглэлийн ажиллагааг техникийн болон зохион байгуулалтын хувьд тодорхойлж дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Мөнгөн усгүй баяжуулах технологийг боловсронгуй болгон дэлгэрүүлэх явдал нууцаар боловсруулалт хийж буй ажиллагааг устгахад хувь нэмэр болно.

Чадавхийг бэхжүүлэх болон мэдээллийн хүртээмж

Чадавхижуулах үйл ажиллагаанууд нь дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн байх шаардлагатай. Хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагаа явуулахын тулд уурхайчид хууль зүй, технологи, аюулгүй ажиллагаа, байгаль орчны талаар суурь мэдлэгтэй болон зохион байгуулалтын ба бизнесийн ур чадвартай байх ёстой. Ихэнхи ур чадварыг бичил уурхайн ажиллагааныхаа явцад хэсэгчлэн л эзэмших боломжтой байдаг. Бичил уурхайн ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулахын тулд мэргэжлийн сургалтад хамрагдах боломжийг бий болгох шаардлагатай. Мэргэжлийн сургалтын төвүүдэд албан ёсны сургалт хийх (бусад ихэнхи мэргэжлийн нэгэн адил), УУАА, мэргэжлийн сургалтын байгууллагууд (эхний үед ТБУТ-аас гэрээлэх, явцын дунд Засгийн газарт гэрээлэх үүрэг хариуцлагыг нь хүлээж авах замаар байгуулсан хөдөлгөөнт болон байнгын сургалт явуулдаг баг) гэх мэт мэргэжлийн газруудаас газар дээр нь сургалт явуулах, бичил уурхайн ТББ-дын хүрээнд бие биенээ сургах сургалт зохион явуулах зэрэг янз бүрийн хувилбаруудыг авч үзэж болно.

Монгол Улс нь сургалтын үндэсний хэмжээний бүтэц, үйл явц бий болгох сорилттой тулгарч байна. Тус төслийн сорилт бол ийм өргөн хүрээтэй үйл явцыг бэхжүүлэх болон дээд зэргийн сайн туршлагыг хэргэлэн төсөл хэрэгжүүлж байгаа газруудад сургалт явуулахын хооронд зохих тэнцвэр барьж байхад оршино (төсөл хэрэгжүүлж буй газрууд

¹² Борнуурын адил боловсруулах загвар үйлдвэрүүд маш энгийн бөгөөд олонхи орнуудад стандартын үйл ажиллагаа хэмээн үздэг. Уурхайчид янз бүрийн боловсруулах үйлдвэрийн үр ашгийг харьцуулан үзэж, хамгийн сайн үйлчилгээтэй, өртөг багатай алтны илэрц өндөр үйлдвэрийг ашигладаг.

дахь сургалтын туршлага нь ихэвчлэн хоцрогдмол байдалд байгаа бусад бичил уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа газруудад үлгэр жишээ болж байх ёстой).

Бичил уурхайн хувьд Монгол Улс саяханаас л туршлагатай болж байгаа бөгөөд ойролцоогоор 10 жилийн хугацаанд энэ ажиллагаа явагдаж байна. БУ-н үйл ажиллагаа явуулдаг ижил төстэй бусад орнууд (1980-аад оноос хойш) дор хаяж 30 гаруй жилийн туршлага хуримтлуулсан байдаг. Иймд мэдлэгээ хуваалцах, мэдээлэл хүртээмжтэй байх явдал саад бүрхшээлийг давахад чухал юм. Олон улсын туршлагыг ашиглах, үндэсний хэмжээнд хэрэглэж болох үйл явц, асуудлыг тодорхойлж, уурхайчдын нийгмийн сүлжээтэй холбож өгөх шаардлагатай.¹³

Чадавхижуулах ажиллагааны үед эрх эдлэгч болон үүрэг хүлээгчийн талаарх ойлголтыг адил тэнцүүгээр өгөх шаардлагатай. Саяхан батлагдсан Бичил уурхайн талаарх Ашигт малтмалын хуулинд нэмэлт өөрчлөлт оруулсан хуулинд төв, бүсийн болон орон нутгийн засаг захиргааг сайн зохион байгуулалттай болгоход хаанаас эхлэх нь зүйтэй байх талаарх нөхцлийг оруулсан байгаа.

Бүх сэдвийг урагшлуулахад сургалт гол хүчин зүйл учраас ТБУТ нь хоёр чиглэлээр ажиллах шаардлагатай: мэргэжлийн сургалтын замаар үндэсний хэмжээнд бичил уурхайн ажиллагааг мэргэжлийн болгох бүтэц, үйл явц бий болгох чиглэлээр ажиллах, нөгөөтэйгүүр, үлгэр жишээ болох дээд зэргийн сайн практикийг дэлгэрүүлэх чиглэлээр туршилтын төсөл дээр ажиллах шаардлагатай. Оролцогчид мэдээлэл хүртэх, мэдлэг хуваалцах боломжтой болох механизм байгуулах асуудал үүнд мөн хамрагдаж байгаа болно. Бичил уурхайн талаарх Ашигт малтмалын хуулинд нэмэлт өөрчлөлт оруулсан хууль батлагдсаны дараа бичил уурхайгаар ашиглах нөөцийг зохистойгоор зохицуулахад шаардлагатай чадваржуулах ажлууд хэрэгтэй байна.

Орон нутгийн хөгжил ба орлого бий болгох

Бичил уурхай нь Монголын хөдөө нутагт мал аж ахуйг орлох гол хөдөлмөр эрхлэлтийн хувьд чухал байр эзлэх болсон ба ихэнхи тохиолдолд илүү орлого олох боломж өгч байна. Олон нийтэд суурилсан бичил уурхайн ажиллагаа орон нутгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулах боломжтой бөгөөд олборлолтын ажиллагааны орлого нь орон нутгийн хэмжээнд эргэлдэж эхэлж байгаа ба төрөл бүрийн бизнес явуулах боломж олгож байна.

Бүсийн болон орон нутгийн захиргааны зүгээс бичил уурхайн ажиллагаанд зориулан ил тод болон шударга үндсэн дээр газар олгох явдал бичил уурхайн боломжийг орон нутгийн хөгжилд ашиглахад чухал үүрэгтэй болно. Бүсийн болон орон нутгийн захиргаа эрдэс баялгийн менежментийн талаар ихэвчлэн бага мэдлэгтэй байдаг ба төвлөрөлийг багасгах одоогийн үйл явцын хүрээнд хүлээх үүрэг гүйцэтгэхдээ дэмжлэг авах шаардлагатай.

Ашигт малтмалын баталгаатай эрх л уул уурхайн ажиллагаанд хөрөнгө оруулах боломжийг бичил уурхайчдад олгож байгаа тул орон нутгийн хөгжил БУ-н үйл ажиллагааг албан ёсны ажиллагаа болгох асуудалтай холбоотой болно. Эзэмшлийн эрх нь үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, орлогыг арвижуулах боломж олгож байна. Бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлснээр үнэ нэмэгдүүлэх асуудлыг нүүрс болон жоншны салбарт судалж үзэх шаардлагатай, харин алтны хувьд “уурхайгаас шууд зах зээлд” худалдааны сүлжээнд орсноор энэ нь хэрэгжих боломжтой.¹⁴

Орон нутгийн хөгжил болон орлого бий болгох асуудал нь орон нутгийн нийгмийн дэд бүтцэд хөрөнгө оруулснаар дамжин нийгмийн хариуцлагын асуудалд мөн холбоотой

¹³ Үүнийг хялбарчилсан маягаар илэрхийлэхдээ “ББОУ-н мэдээллийн сан” байгуулах шаардлага гэдэг. “Мэдээллийн сан” гэсэн нэр томъёог ерөнхий утгаар тоо баримтыг ашигтай мэдээлэл болгох, зохих шийдвэр гаргахад шаардлагатай мэдлэг өгөх хэрэгсэл буюу механизм гэж ойлгодог. “Мэдээллийн сан” гэсэн нэр томъёог компьютерын программ хэмээн буруу ойлголт байх болохгүй.

¹⁴ Жишээлвэл, шударга худалдаа болон шударга уурхайн баталгаатай бичил уурхайн алт “ёс зүйн” чанартай бөгөөд хэрэглэгчид үүний төлөө илүү өндөр үнэ төлөх урамшуулал өгөх хүсэлтэй байдаг. Шударга худалдааны урамшуулалын мөнгө орон нутгийн хөгжилд ашиглах зориулалттай.

юм. Засгийн газрын оролцоо орон нутгийн түвшинд сул байдаг бусад орон (жишээлбэл, Перу)-д хэрэгжүүлсэн ШХА-ийн төслүүдийн жишээ бичил уурхайн ажиллагаа тогтвортой амьжиргаа бий болгох боломжтой бөгөөд чадвартайг харуулж байна.¹⁵

Бичил уурхайчдыг орон нутгийн түвшинд тогтвортой хөгжүүлэх явдал ТБУТ-н гол үр дүн гэж үзэж болно. Бусад гол чиглэлийн үр дүнг орон нутгийн хөгжилд тустай болгохын тулд ТБУТ-н орон нутгийн хэмжээнд сайн засаглалыг хөгжүүлж дэмжих шаардлагатай. Үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх болон бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн төслийн ажил орлогыг нэмэгдүүлэх болон амьжиргааг сайжруулахад тус дэм болно.

4.2.3 Үйл ажиллагааны хандлага болон нийтлэг сэдвүүд

Шударга “ уурхайгаас зах зээлд” худалдааны сүлжээнүүд

Шударга худалдааны үзэл баримтлал¹⁶ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд хамааралтай 1960-аад онд гарч ирсэн ба хөгжлийн хэрэгцээг хэрэглэгчид ухамсарлан баталгаатай жижиг үйлдвэрлэгчдэд шууд ашиг өгөх шударга худалдааны урамшуулал төлөх замаар үйлдвэрлэгчдийг дэмжихэд чиглэсэн юм. Үүний хариуд үйлдвэрлэгчид хэд хэдэн стандартуудыг дагах шаардлагатай. Бие даасан гурав дахь талын баталгаа олгох систем нь тухайн бүтээгдэхүүн хариуцлагатай болон зүй ёсоор үйлдвэрлэгдсэн гэдгийг, тухайн бүтээгдэхүүний илүү өндөр үнэ нь орон нутгийн хөгжилд шууд хувь хэмэр оруулж байгааг хэрэглэгчдэд нотолж өгдөг. Саяхан шударга худалдааны зах зээл бичил уурхайчдын алтны хувьд нээлттэй болсон. Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 3-аас үзнэ үү.

Шударга худалдааны хандлага нь эрхийг эрхэмлэн чадваржуулах хандлага мөн бөгөөд үйлдвэрлэгчид шаардлагатай стандартыг мөрдөх үүрэг хүлээдэг ба шударга үнийн зэрэгцээ уг бүтээгдэхүүнийг шударга худалдааны системд оруулахын тулд гаргасан хүчин чармайлтынх нь төлөө нэмэлт урамшуулал хүртэх эрх эдэлдэг. Энэ нь үйлдвэрлэгчдийг өөрийн бүтээгдэхүүнд тавих хяналтаа нэмэгдүүлэх, олон улсын зах зээлд шууд оролцох, нэр хүндтэй болох зэргээр чадваржуулдаг болно.

Шударга худалдааны хандлага нь хариуцлагатай бичил уурхай хөгжүүлэхтэй холбоотой бүх сэдвүүдтэй нийцэж байгаа болно. Хууль эрх зүйн, зохион байгуулалтын, нийгмийн болон байгаль орчны хариуцлагууд нь шударга худалдааны үйлдвэрлэгчдэд тавигддаг шаардлага мөн бөгөөд энэ хандлага нь үйлдвэрлэгчийг дэмжих замаар чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн ба орон нутгийн хөгжил болон орлого үйлдвэрлэл нь шударга худалдааны гол ашиг өгөөж юм.

ТБУТ-н үр дүнг дээшлүүлэхийн тулд хоёр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд явуулах ажиллагаа болон 6 тэргүүн зэргийн ач холбогдолтой сэдвүүд нь “бичил уурхайн алтны шударга худалдаа болон шударга уурхайн стандартыг” мөрдүүлэхэд чиглэгдэх ба энэхүү стандарт нь дэлхийн хэмжээнд зөвшилцсон сайн туршлагыг тусгасан болно. Шударга худалдааны баталгаа болон ашгийг авах эрмэлзэл нь бичил уурхайн нөхөрлөлийн хувьд хүчтэй түлхэц болох бөгөөд уурхайчдын хариуцлагатай ажиллагааг үр ашигтай хувилбар болгох юм. Энэхүү стандарт нь сайн засаглал болон ил тод байдлаар үйл ажиллагаа явуулахад хувь нэмэр оруулах юм. Учир нь зөвхөн хууль ёсны дагуу олборлосон алтыг л Шударга худалдааны стандартын бүтээгдэхүүн гэж хүлээн зөвшөөрдөг.

¹⁵ Bobadillo et.al.: Nosotros construimos los pue

¹⁶ To distinguish between the concept and the label or organization, „Fair-trade“ is used for the generic concept of fair trading chains, and „Fairtrade“ (in one word) is used in reference to the label of Fairtrade Organizations International (FLO) and aspects related to FLO's Standards based trading scheme. E.g.: a „Fair-trade product“ is any product that is traded in a fair manner, while a „Fairtrade product“ describes a product covered by a Fairtrade Standard.

Тогтвортой амьжиргааны хандлага


Тогтвортой амьжиргааны хандлага нь холбогдох бүтэц, үйл явцыг өөрчлөх замаар айл өрхийн хөрөнгийг нэмэгдүүлэх, эмзэг байдлыг нь багасгахад чиглэгдэж байна.

Эрхийг эрхэмлэн чадваржуулах хандлага нь ТБУТ-н үйл ажиллагааг төлөвлөхөд хамгийн тохиромжтой бол тогтвортой амьжиргааны хандлага бол мониторинг хийхэд маш тустай байж болох юм. Амьжиргааны үнэлгээ бичил уурхайн нөхөрлөлийн хөрөнгийг (чанарын үзүүлэлт ашиглан) тоолох, тодорхой хугацаанд гарсан өөрчлөлтийг тодорхойлох боломжтой.

Үнэлгээ бүрийн үр дүнд гарах “амьжиргааны таван үзүүр” үзүүлэлт нь төслийн үр нөлөөг зөвхөн нэг үзүүлэлтээр бус хүний, нийгмийн, бодит, биет болон санхүүгийн хөрөнгийн өөрчлөлтөөр үнэлэх боломжийг өгдөг. Хавсралт 5 тус хандлагын хялбар шинжийг илтгэн харуулна.

ТБУТ-г хэрэгжүүлдэг газрын бичил уурхайчдын амьжиргааны түвшний

үнэлгээг үе үе хийх нь хяналтын хэрэгслийн хувьд тустай юм. Үүний онцгой давуу тал нь мониторингийн бие даасан байдал юм: эрхийг эрхэмлэн чадваржуулах хандлагын хүрээнд төлөвлөлт, хэрэгжилтийг хянах, ТА-ны хандлагын хүрээнд мониторинг хийх нь төслийн жинхэнэ үр нөлөөг гаргах боломжтой.



Жендерийн тэнцвэртэй хөгжил

Технологийн талаар болон олон нийтийн талаар оролцох оролцоо нь жендерийн тэнцвэртэй байдлын талаар чухал ажил болно. Жендерийн тэнцвэртэй байдал нь бусад зүйлсийн адилаар шийдвэр гаргах үйл явцад эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн адил тэнцүү оролцоог хангах, эмэгтэйчүүдийн үүрч байгаа давхар ачаа, мөн түүнчлэн хүйсийн онцлогтой эрүүл мэндийн асуудал зэрэгт илүү анхаарал тавьдаг. Төслийн хувьд жендерийн холбоотой асуудлууд болох эрэгтэйчүүд юм уу эмэгтэйчүүдийн орлого олох боломжийг нэмэгдүүлснээр гэр бүл доторх эрх мэдлийг тэнцвэржүүлэх талаар дүн шинжилгээ хийх чадвартай байх хэрэгтэй ба төсөл хэрэгжүүлэлтийн бүх асуудалд хүйсийн мэдрэмжтэй, хүйсийн тэнцвэртэй үйл ажиллагаа явуулах, ялангуяа БУ-ыг хөгжүүлэх, чадавхижуулах ажилд энэ талыг илүү анхаарах хэрэгтэй.

Төслийн зүгээс БУ-н үйл ажиллагаа гэр бүлийн бусад ажлуудыг мөрөн дээрээ үүрч байж болзошгүй нөхөрлөлийн гишүүн гэрлэсэн эмэгтэйчүүд, нөхөрлөлийн гишүүн биш боловч олборлолтын газар гэр бүлтэйгээ амьдарч тэднийг болон бусад хүмүүсийг асран тэтгэх ажил хийдэг эмэгтэйчүүд, нөхөрлөлд болон гэр бүлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжгүй ганц бие эмэгтэйчүүд, болон олон хүүхэдтэйн улмаас олборлолтын ажилд бүрэн оролцох боломжгүй ганц бие эхчүүдэд хэрхэн нөлөөлж байгааг судалж илрүүлэх хэрэгтэй юм. Иймэрхүү эмэгтэйчүүдэд зориулсан нэмэлт/зорилтот дэмжлэг хэрэгтэй байж болох юм.

Жендерийн тогтвортой хөгжлийн хүрээнд төслийн зүгээс дараах асуудлууд дээр төвлөрч ажиллана. Үүнд:

- (i) Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд, хөвгүүд болон охидын хоорондоо ялгаа бүхий хэрэгцээ шаардлага, хязгаарлалт болон боломжийн талаар
- (ii) Төрийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагааны талбар дахь ажил болон эрх мэдлийн талаар жендерийн дотоод харилцан холбоо

- (iii) Эмэгтэйчүүдийн хийж гүйцэтгэж байгаа үнэлгээгүй ажлыг (цэвэрлэгээ хийх, хоол хийх, угаалга хийх, хүүхдээ асрах г.м.) олборлолт гэх мэт бусад ажлын амжилттай салшгүй холбоотой юм гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх шаардлага
- (iv) Бүх шатанд шийдвэр гаргах үйл явцад эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн тэнцүү оролцоог хангах шаардлага зэрэгт төвлөрч ажиллана.

4.3 ТБУТ-н стратегийн оролцооны хэв маяг

Харилцан холбоотой бөгөөд эрхийг эрхэмлэн чадваржуулах хандлагад тулгуурласан хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй төслийн ерөнхий хэв загвар нь төслийн бэлтгэл болон эхний үе шатны явцад олсон сургамжийн үр дүнд гарч ирсэн юм.

Зургаан гол сэдэвт анхаарлаа төвлөрүүлсэн нь ТБУТ-н гурав дахь үндсэн үе шатны ажиллагааг төлөвлөх дороос дээш явагдсан өргөн хүрээний оролцоотой үйл явцын үр дүн юм. Зургаан гол сэдэв нь Монголын талын нийт оролцогчдын зөвшилцсөн асуудлууд бөгөөд ижил төрлийн төсөл болон доноруудын туршлагыг хийгээд ШХА-ийн өмнөх төслүүдийн сургамжийг харгалзан тодорхойлсон болно.

Үүний үр дүнд хөгжлийн гурван үндсэн хандлага (эрхийг эрхэмлэсэн хандлага, чадваржуулах хандлага, шударга худалдааны хандлага)-д бүрэн нийцсэн төслийн стратеги гарч ирсэн ба хөгжлийн дөрөв дэх хандлага (тогтвортой амьжиргааны хандлага)-аар баталгаажиж байна. Тэргүүн зэргийн зургаан сэдвүүд бүгд дөрвөн хандлагын аль алинд нь хамааралтай болно. Зураг 5-д стратегийн оролцооны матриксийг харуулсан.

Бүлэг 4.1.6-д харуулсан шалтгаануудын улмаас ТБУТ-ийн стратеги нь эрхэд тулгуурлан чадваржуулах арга барилын дагуу байна.

4.3 Эрсдэл, Таамаглал болон Эрсдлийг бууруулах стратеги

Төслийн өмнөх үе шатуудад бичил уурхайн асуудлыг олон нийтэд хүргэж үйл ажиллагааг зохицуулах, хамтын ажиллагааны бүтэц бий болгох, бичил уурхай эрхлэгч иргэдийг чадваржуулах ажлыг эхлүүлж ирсэн. Одоогийн байдлаар ТБУТ нь тус улсын хүн амын 15%-д боломж олгож буй асуудлыг хөгжүүлэх талаар ажиллаж байгаа анхны бөгөөд цорын ганц төсөл хэвээр байгаа учраас чухал ач холбогдолтой төсөл юм. Иймд төслийн дараагийн үе шатанд (3-р үе шат) эдгээр ажлын үр дүнг бататгах, гарч болох эрсдлийг бууруулахад чиглэж байна.

3-р үе шатны үйл ажиллагааны төлөвлөлтөөс гарсан гол **таамгууд**:

Саяхан батлагдсан бичил уурхайн хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх

Тус орны бодлого боловсруулагчид бичил уурхайн зохицуулалтын орчинг бүрдүүлэх талаар 5 орчим жил ярилцаж хэлэлцсний үр дүнд сая хуулийг хэлэлцэн олонхи (80%)-ийн саналаар батласан. ЭБЭХЯ энэ асуудлыг хариуцсан эрх мэдэлтэй байгууллагын хувьд энэ ажлын гол хөдөлгөгч хүч байсан ба урьд нь ч бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах түр журам батлуулсан байсан. Иймд ЭБЭХЯ, АМГ цаашид бичил уурхайн салбарыг зохицуулахад өөрсдийн бодлого, үйл ажиллагаагаа үргэлжлүүлнэ.

Төслийн төлөвлөлтийн уулзалт семинарын үеэр ч бичил уурхай эрхлэгчид албан ёсны үйл ажиллагаа эрхлэх чин эрмэлзэлтэй байсан нь харагдсан бөгөөд энэ байдал ч цаашид үргэлжилж бичил уурхай эрхлэгчид зохион байгуулалтанд орж олборлолт явуулах газар, эрхтэй болно гэдэг нь харагдаж байна.

Бичил уурхайн салбарт тохирсон журам боловсруулах

Ашигт малтмалын хуульд оруулсан бичил уурхайтай холбоотой өөрчлөлтийн тухай хуулийн хэрэгжүүлэлт нь уг асуудлыг хариуцдаг эрх мэдэл бүхий салбарын (ЭБЭХЯ) хариуцан зохицуулах ажил юм. Журмын төслийг боловсруулсан байгаа ба урьд нь

дагаж мөрдөж байсан түр журамын хэрэгжүүлэлтээс гарсан туршлага дээр үндэслэн энэ журам нь үйл ажиллагааг дэмжсэн шинж төрхөө хадгалах юм.

Орон нутгийн засаг захиргаа бичил уурхайгаар ашиглах газрын эрх олгох ажлыг хариуцна. Бичил уурхайтай холбоотой хууль болон түүнийг дагалдан гарах журам нь бичил уурхайчдыг хууль эрх зүйн таатай орчноор хангаж боловч эдгээрийн хэрэгжилт нь тухайн орон нутгийн засаг захиргаанаас ихээхэн хамаарах юм. БУ-н асуудлын талаарх орон нутгийн үзэл бодол эерэгээс сөрөг хүртэл янз бүр байна. Тиймээс уг салбарын талаар эерэг үзэл бодолтой хангалттай тооны орон нутгийн захиргаа хууль журмыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх байх гэж тооцоолж байгаа ба тэдний туршлага, үзүүлэх үлгэр жишээ нь энэ талаар эргэлзэж байгаа бусад хүмүүсийн үзэл бодлыг өөрчлөх гол хүчин зүйл болох юм.

БУ-н үйл ажиллагааг албан ёсны болгох үйл явц нь БУ-чдад зориулсан энгийн, ойлгомжтой заавар, удирдамж гаргах шаардлагатай болж байна. Жишээлбэл: Уурхайн аюулгүй ажиллагааны 10 гол асуудлын зааварчлага гэх мэт. Иймэрхүү заавар, удирдамжийг мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор нямбайлан бодож боловсруулах нь төслийн төлөвлөгөөт ажлын нэг хэсэг юм. Хэдийгээр баталгаатай биш боловч БУ-н асуудалтай холбоотой бүх эрх мэдэл бүхий байгууллагууд иймэрхүү богино хэмжээтэй, энгийн заавар удирдамжууд нь БУ-чдын хувьд дагаж мөрдөхөд үндэсний хэмжээний стандарт, журамнаас илүү үр дүнтэй байх болно гэдгийг ойлгож байгаа ба үүнийг хэдийгээр үндэсний хэмжээний стандарт, журамнаас бага зэрэг ялгаатай байсан ч батлан хэрэгжүүлэхэд идэвхитэй оролцож дэмжинэ байх гэж тооцоолж байгаа.

Бичил уурхайд цэвэр аюулгүй технологи хэрэглэх болно

ТБУТ-ийн техникийн саналууд (жишээ нь: Борнуурын хүдэр баяжуулах цех, хуурай баяжуулагч)-ыг бичил уурхай эрхлэгчид хүлээн авч өөрсдийн үйл ажиллагаандаа нэвтрүүлж, шороон ордын зарим багаж төхөөрөмж (жишээ нь: жижиг алт барих зориулалт бүхий шлюз)-ийг туршин хэрэглэж байна. Бичил уурхай эрхлэгчид байгаль орчинд халгүй, аюулгүй ажиллагааг хангасан, бүтээмж сайтай шинэ технологи хэрэглэх хүсэл эрмэлзэлтэй байдаг учраас цаашид ч өөр бусад технологийн шийдлүүдийг нэвтрүүлэх дэлгэрүүлэх болно.

Бичил уурхай зохион байгуулагдана

Бичил уурхай эрхлэгчид шүхэр байгууллагатай байх хэрэгтэй гэдгийг төслийн өмнөх үе шатуудад тогтоосон бөгөөд энэ нь бичил уурхай эрхлэгчид зохион байгуулалтанд орж, Төр засгийн байгууллагатай хамтран ажиллахад нэн чухал үүрэгтэй. Орон нутагт байгуулагдсан тэдний байгууллагууд нь ч гэсэн орон нутгийн Засаг захиргаатайгаа харилцан ярилцах, зөвшилцөх боломжтой болно. ТБУТ нь зөвхөн бичил уурхай эрхлэгчдийн байгууллагад зохион байгуулалтанд орох үндсэн ойлголт, чиглэл зөвлөмж өгч дэмжин ажиллана.

Арилжааны байгууллага байгуулах

Бичил уурхайгаар олборлосон алтны дэлхийн шудрага худалдааны зах зээлд Монгол орон нэгдэх боломжтой. Тус худалдааны зах зээлийн гол худалдан авагчид нь хувь хүмүүсээс бус харин тогтвортой үйл ажиллагаагаа явуулдаг бичил уурхай эрхлэгч иргэдийн байгууллагуудаас бүтээгдэхүүн худалдан авахыг эрмэлздэг. Иймд энэхүү шудрага худалдаанд нэгдэх хүсэлтэй бичил уурхай эрхлэгчдийн байгууллагууд нь өөрсдийн олборлолтын үйл ажиллагаандаа байнга хяналт тавьж, өөрсдийн бизнесийн үйл ажиллагааны арилжааны чадвараа дээшлүүлэхэд байнга анхаарлаа хандуулдаг. Шудрага худалдаанд хамрагдаггүй бичил уурхай эрхлэгчид (нүүрс, жонш олборлогч иргэд) ч өөрсдийн бизнесийн үйл ажиллагаагаа бэхжүүлж, орон нутгийн хэмжээнд орлого бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой. Иймд төсөл бичил уурхай эрхлэгчдийн байгууллагуудад дэмжлэг туслалцаа үзүүлэх бөгөөд энэ үйл ажиллагаанд хамрагдсанаар бичил уурхай эрхлэгчид орон нутгийн ченж, худалдаачдаас хараат бус байх болно.

Сэдэв	Төслийн бүрэлдэхүүн хэсэг			Хөгжлийн хандлага				Стратегийн ач холбогдол	
	Бичил уурхайчдыг дэмжих		Бичил уурхайн бодлого	Чадваржуулах хандлага	Эрхийг эрхэмлэсэн хандлага	Шударга худалдааны хандлага	Амьжиргааны хандлага	Бичил уурхайчдыг дэмжих	Бичил уурхайн бодлого
Эрх зүйн орчин ба албажуулалт	Бүртгэлгүй нөхөрлөлөөс олборлолт хийх эрх бүхий хууль ёсны нэгж болох чиглэлд ахиц гаргах	БУ-н үндэсний сайн практикийн стандарт, зааврыг боловсруулж албажуулах	Хууль зүйн болон зохицуулалтын хүрээний асуудлыг урагшлуулж зөвлөлгөө өгөх, БУ-н талаарх олон нийтийн санаа бодолыг сайжруулах	Оролцоо ба хамруулалт	ЗГ эрх эдлэгч, “нинжа” эрхгүй байгаа байдлыг өөрчилж БУ-г албажуулан эрх эдлэгч, ЗГ-ыг үүрэг хүлээгч болгох	Шаардлага	Бүтэц, үйл явцыг бий болгож бэхжүүлэх, эмзэг байдлыг багасгах	Үр дүнд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн	Үйлдвэрлэл нэмэгдүүлэх макро түвшинд хийх
Бичил уурхайн зохион байгуулалт ба түүний бэхжилт	Орон нутгийн ТББ, компани, хоршоолол, бүсийн болон үндэсний Төв байгууллага \Холбоо\	Хамтран эзэмшиж буй технологийг боловсронгуй болгож хөгжүүлэх \боловсруулах үйлдвэр\	БУ-н байгууллагуудыг эрх зүйн таатай хүрээний талаарх сурталчилгааны ажилдаа дэмжих	Орон нутгийн байгууллагууд	Албан ёсны БУ-н эрх эдлэгч болох, БУ-н байгууллагууд эрх эдлэгч бөгөөд хариуцлагатай үүрэг хүлээгч болох	Шаардлага	Бүтэц, үйл явцыг бий болгож, нийгмийн хөрөнгийг нэмэгдүүлэх, эмзэг байдлыг багасгах	Үр дүнд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн	Үр дүнд тустай болох бүтээгдэхүүн
Нийгмийн хариуцлага, нийгмийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа	БУ-н ТББ-ын нийгмийн хариуцлагын орон нутгийн хөтөлбөрүүд, албан бус нийгмийн аюулгүйн сүлжээнээс нийгмийн хамгаалалд шилжих	Аюулгүй ажиллагаа, ажлын байрны аюулгүй ажиллагааг хөгжүүлэх, уурхайн аврах албыг бэхжүүлэх	Албажуулалтын асуудлыг илүү өргөн утгаар авч үзэх, тухайлбал татвар төлөлт, нийгмийн хамгаалалд хамруулах г.м.	Тайлагнал	Нийгэм эрх эдлэгч болон БУ үүрэг хүлээгч \хариуцлага\, мөн эрх эдлэгч \нийгмийн хамгаалал\	Шаардлага	Нийгмийн болон хүний хөрөнгийг нэмэгдүүлэх, эмзэг байдлыг багасгах	Үр дүнд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн	Үр дүнд тустай болох бүтээгдэхүүн
Байгаль орчны хариуцлага, байгаль орчинд ээлтэй технологи	Байгаль орчны олон нийтийн мониторинг, хариуцлагатай ажиллагааны өөрийн хяналт	Нөхөн сэргэлтийн сайн туршлагыг илтгэн харуулах, байгальд ээлтэй ашиглалтыг хөгжүүлэх \хамгийн сайн нөхөн сэргээлт\	\Уурхайчдын боломжийг харгалзсан\ заавал биелүүлэх байгаль орчны журам, сайн туршлагын гарын авлага боловсруулах шаардлагыг ойлгуулах	Тайлагнал	Нийгэм эрх эдлэгч болон БУ үүрэг хүлээгч	Шаардлага	Байгалийн хөрөнгийг хамгаалах, биет хөрөнгийг нэмэгдүүлэх	Үр дүнд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн	Үр дүнд тустай болох бүтээгдэхүүн
Сургалт ба мэдээллийн хүртэмж	Бүх сэдэвт хамааралтай	Бүх сэдэвт хамааралтай	Бүх сэдэвт хамааралтай	Мэдээллийн хүртэмж	Сургагдсан уурхайчид ёс зүйн эрх эдлэгч \нэр хүнд\ бөгөөд үүрэг хүлээгч	Хэрэгсэл: Үйлдвэрлэгчийг дэмжих	Хүний хөрөнгийг нэмэгдүүлэх	Үр дүнд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн	Үр дүнд тустай болох микро түвшний оруулалт

Орон нутгийн хөгжил ба орлого бүрдүүлэлт	“Уурхайгаас зах зээлд” худалдааны сүлжээг ашиглан орон нутгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, БУ орон нутгийн хөгжлийн мотор болох	Үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах \баталгаажуулах г.м.\	Бүсийн болон орон нутгийн захиргаанаас БУ-д газрыг ил тод болон шударга үндсэн дээр олгох явдлыг хөгжүүлэх, төвлөрөлийг багасгах талаарх бүсийн болон орон нутгийн захиргааны хүч чармайлтыг дэмжих	Оролцоо ба хамруулалт Орон нутгийн байгууллагууд	БУ эрх эдлэгч	Шударга худалдааны ашиг	Санхүүгийн хөрөнгийг нэмэгдүүлэх, уурхайчдын амьжиргааны стратегийн үр дүн	Үр дүн
--	--	---	---	---	---------------	-------------------------	--	--------

Бичил уурхайгаар олборлосон алтны шудрага худалдааны дэлхийн зах зээлд Монгол орныг оруулах боломжтой

Монгол улсын бичил уурхайгаар олборлодог алт, түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг дэлхийн шудрага худалдааны зах зээлд оруулах боломжтой энэ талаар санал оруулж байсан ч өнөөг хүртэл тодорхой үнэлэлт дүгнэлт хийгдээгүй байсаар байна. Үндэсний гол харилцагч, хамтрагч байгууллагуудын нэг Монгол банк ч дэмжлэг тусалцаа үзүүлэх байр сууриа илэрхийлсэн бөгөөд энэ чиглэлээр хамтран ажиллах болон дэлхийн зах зээлд холбоо харилцаа тогтооход ТБУТ чухал үүрэгтэй ажиллана. Бичил уурхай бүхий бусад орнуудад энэхүү шудрага худалдаанд нэгдэн хэрхэн үйл ажиллагаагаа явуулж байгаа (бүтэц зохион байгуулалт, татвар хураамж, үйл ажиллагаагаа явуулах журам) –г судалж нэвтрүүлэх, нэгдэх боломж байсаар байна.

ТБУТ-ийн эрсдлийг бууруулах гол стратеги нь:

- Бичил уурхайн тухай хуулийг хэрэгжүүлэхэд улс төрийн хүсэл зориг дутмаг байсан тохиолдолд ТБУТ төслийн өмнөх үе шатны үед бий болгосон туршлага дээр үндэслэн үйл ажиллагааг урагшуулах шинэ боломжийг бүрдүүлж, идэвхижүүлэхэд чиглэх болно.
- Бичил уурхай эрхлэгчид албан ёсны болгох үйл ажиллагаанд нэгдэхийг эрмэлзэхгүй байх тохиолдолд ТБУТ нь хамтрагч талуудын хамт тулгарч буй саад, бэрхшээл тэдгээрийн хийдэл/цоорхой, даван туулах арга замыг тодорхойлж, төр-хувийн хэвшил, хожих-хожих хувилбаруудыг боловсруулах, хэрэгжүүлэх болно.

Дээрх хоёр тохиолдлуудын аль алинд ч ТБУТ нь үндэсний гол харилцагч талууд (бичил уурхай эрхлэгчид, Төр засгийн газар)-ын эрх, үүрэг хариуцлагын аль ч хэсгийг хүлээж ажиллахгүй!

- Хэрэв техник, технологийн саналуудыг бичил уурхай эрхлэгчид төдийлөн хүлээж авахгүй байх тохиолдолд ТБУТ гадаад эх үүсвэрээ ашиглан асуудалд дүн шинжилгээ хийж хамгийн нийцтэй зохистой хувилбаруудыг нэвтрүүлэхэд чиглэж ажиллана.
- Шудрага худалдааны шаардлагуудын зарим хэсэг нь тус орны нөхцөл байдалд үл нийцэх тохиолдол гарахад ТБУТ улс орны нөхцөл байдалд нийцсэн стандарт, хувилбаруудыг бий болгоход чиглэж ажиллана.

Бичил уурхайн асуудалд хандах олон нийт, улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдөх, эсрэг байр суурь гарах тохиолдолд ТБУТ нь эрхэд суурилсан ядуусыг дэмжих байр сууриа хадгалан төслийг үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дэмжлэг тусламжаа үзүүлэх болно. Хөгжил бол үндсэндээ “2 алхам урагш, нэг алхам хойш”-аас бүрддэг. ТБУТ нь хөгжлийн гол зорилгодоо чиглэн гол хамтрагч бичил уурхай эрхлэгчдэд чиглэх болно.

4.5. Төслийн үйл ажиллагааны тогтвортой байдал, хаалтын стратеги

Тогтвортой байдал

Хариуцлагатай бичил уурхайд чиглэсэн эрхэнд суурилсан чадваржуулах арга нь үндсэндээ үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн. Бичил уурхай эрхлэгчид эрхтэй болсноор нийгэм, байгаль орчны өмнө хүлээсэн үүргээ биелүүлдэг болно. Бичил уурхай эрхлэгчдийн байгууллага (жишээ нь Бичил уурхай эрхлэгчдийн шүхэр байгууллага)-ыг идэвхижүүлэх нь төслийн бичил уурхай эрхлэгчдийн өмнөөс бодлогын асуудлыг дэвшүүлэх үүргийг бичил уурхай эрхлэгчдэд шилжүүлж өгч тэднийг бодлогын асуудлаар холбогдох талуудад хандаж асуудлаа тавьж чаддаг чадвартай болгоход чиглэх болно.

АМГ түүний Бичил уурхайн тасагтай (Бүлэг **Error! Reference source not found.**) хамтран ажиллаж, түүний үүрэг хариуцлагыг тодорхой болгох нь үйл ажиллагааг тогтвортой явуулах үндэс бүрдүүлнэ. Төрийн байгууллага, нэгжийн хүлээх үүрэг

хариуцлагыг өмнөөс нь хүлээхгүйгээр харин төслийн үйл ажиллагааны туршлага, сургамжинд үндэслэн тулгарч буй бэрхшээл, сорилыг давах туулахад тэдний чадавхийг бэхжүүлж ажиллах нь төсөл дууссаны дараа үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад тустай байна.

Сум, аймгийн Засаг захиргаа, удирдлагуудтай ойр хамтран ажиллаж орон нутаг болон бүс нутгийн хэмжээнд чадавхийг бий болгоход чиглэнэ. Ажил үүргийн гүйцэтгэлийн төвлөрлийг сааруулах (бичил уурхай эрхлэгчдийн нөхөрлөлийг бүртгэх, нөхөрлөлд газар олгох) ажлын эхлэл Бичил уурхайн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр тавигдсан. Иймд энэ ажлыг цаашид үргэлжлүүлэн чадавхийг орон нутагт шилжүүлэх хэрэгцээ их байна. ТБУТ орон нутаг, бүс нутгийн Засаг захиргааны чадавхи бий болгох үйл явцыг дэмжин орон нутгийн хэмжээнд нөөцийн илүү сайн засаглалыг бий болгоход чиглэнэ. Энэ үйл ажиллагаанд зөвхөн ШХА-ийн төслийн баг дангаараа оролцох бус харин ЭБЭХЯ, АМГ-ын холбогдох ажилтнууд оролцох болно. Төр засгийн байгууллагын ажилтнуудыг бүс нутгийн хэмжээнд чадавхи бий болгох ажиллагаанд хамруулах нь төвлөрлийг сааруулах үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад тустай.

Бичил уурхайн салбарт үйлчилгээ үзүүлэх иргэний нийгэм, судалгаа шинжилгээний байгууллагуудыг тогтоосон боловч тэдгээрийн аль нь ч ТБУТ-ийн гадна үйлчилгээгээ хүргэх боломжгүй. Иймд тэдгээр нь цаашид бичил уурхай эрхлэгчдэд урт хугацааны үйлчилгээ үзүүлэгчид байхыг тулд тус төслийн үйл ажиллагаанд өргөнөөр оролцох болно.

Төслийн үйл ажиллагааны гол хэсэгт чадавхийг бий болгох асуудал чухлаар тавигдаж байна. Иймд төсөл энэ талаар өөрийн 2 бүрэлдэхүүн хэсгээр дамжуулан тогтвортой байдлыг хангахад голлон анхаарч байсан. Үүнд:

- Чадавхи бий болгох чиглэлээр төсөл мэргэжлийн сургалтуудыг явуулах, энэ хүрээнд бусад мэргэжлийн сургалтууд (жишээ нь оёдол, талх барих, засвар механикийн гм)-ыг явуулах, энэхүү сургалтын хүрээнд мэргэжлийн бичил уурхай эрхлэгчдийг бэлтгэх ажил хийгдэнэ.
- Чадавхи бий болгох ажлын гол хэсэгт төсөл шудрага худалдааны зах зээлд орох нь төслийн тогтвортой үйл ажиллагааг хангахад чухал ач холбогдолтой. Шудрага худалдааны сүлжээнд орох нь зөвхөн дэмжлэг тусалцаа авах бус хэрэглэгчдийн зүгээс бүтээгдэхүүний өндөр чанарын төлөө нэмэлт урамшуулал авах, үйлдвэрлэгчдийн өөрсдийн¹⁷ лизенцийн төлбөр хураамж зэргээр санхүүжигддэг. Монгол улсад шудрага худалдааны гэрчилгээ бүхий бичил уурхайн байгууллагуудыг бий болгох нь үйлдвэрлэгчдэд бизнесийн боломж олгохоос гадна тэднийг ТБУТ-өөс хамааралтай бус байхад туслана.

Төслийн явуулж буй үйл ажиллагааг цаашид тогтвортойгоор үргэлжлүүлэх гол элемент нь Шудрага худалдааны сүлжээнд орход оршиж байна. Шудрага худалдааны системийн гол утга санаа нь хэрэглэгчдээс төлсөн илүү (шагналын) төлбөрийг БУ-ын байгууллагууд захиран орон нутгийн хөгжилд зарцуулахад оршидог. Шудрага худалдаа, шудрага олборлолтын систем одоогийн байдлаар бичил уурхайгаар олборлосон алтанд 10% нэмэгдэл шагнал санал болгож байгаа ба уг алт байгаль орчны талаар тавьсан шаардлагыг хэрхэн гүйцэлдүүлж байгаагаас шалтгаалан нэмэгдэл шагналын хэмжээ 15% хүртэл өсөх боломжтой юм. Алтны үний тогтмол дундажаар бодож үзэхэд БУ-р олборлосон гэрчилгээ бүхий алтны килограмм бүрээс 3.000-4.500 Ам. Долларын нэмэгдэл шагнал олж болох юм. Үүнээс орон нутгийн хөгжилд зориулсан байнгын орлоготой болоход жилдээ бичил уурхайгаар олборлосон гэрчилгээ бүхий 250 кг алт (энэ нь нийт БУ-р жилд олборлодог алтны 10%-д ч хүрэхгүй ба Борнуурын баяжуулах цехийн хүчин чадлаас 3-4 дахин их хэмжээтэй тэнцүү юм) л хэрэгтэй ба үүнээс орох орлого нь Швейцарийн засгийн шазраас төсөлд зарцуулдаг жилийн төсөвтэй тэнцүү юм.

¹⁷ Латин америкийн орнуудын үйлдвэрлэгчийг дэмжигч байгууллага (одоогийн хэрэгжиж буй тогтолцоо) нь бичил уурхайчдын шүхэр байгууллагууд, үндэсний хэмжээний ТББ-ууд, судалгааны байгууллагууд; эдгээрийн аль нь ч дэмжлэг тусалцаа авдаг хөгжлийн төсөл биш.

Хаалтын стратеги

Төслийн 3-р үе шатыг 4 жилээр үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр Бичил уурхайн тухай хуулийг батлан гаргаснаас хойш төслийн ололт үр дүнг баталгаажуулах, бий болгосон чадавхи, сургамжийг үндэсний оролцогч талуудад шилжүүлэх, төсөл дууссаны дараа төслийн үйл ажиллагааг цаашид тогтвортой үргэлжлүүлэхэд чухал үүрэгтэй байна.

Шудрага худалдааны сүлжээнд нэгдэн орох нь бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх урт хугацааны дэмжлэг туслалцаа үзүүлэх болно.

Төслийн үйл ажиллагааг шилжүүлэх ба хаалтын үе шат 2 жилийн хугацаатай үргэлжлэнэ. Төслийн хаалтын стратегийн нэг хэсэг нь төслийн 3-р үе шатанд авч ажиллуулж байсан мэргэжилтэн, ажилтнуудын тоог багасган, харин үйлчилгээ үзүүлэгч гадны эх үүсвэрийг ашиглан тэдэнд шилжүүлэх болно. Энэ үйл явцад олж авсан сургамжаас хамааран хаалтын шатны үйл ажиллагааг төслийн ахлах мэргэжилтнүүдийн удирдлага дор гадны үйлчилгээ үзүүлэгчдийн оролцоотой хэрэгжүүлэх болно. Төслийн хаалтын шатны төлөвлөлтийг төслийн дунд шатны үнэлгээгээр тогтоолгож төслийн 3-р шатны хэрэгжилтийн гадаад үнэлгээний гол анхааралд тавих болно.

5. Дэвшүүлж байгаа үйл ажиллагааны хүрээ

5.1 Хөгжлийн зорилт

Төслийн гуравдахь шатны хөгжлийн зорилт нь **“Бичил уурхайн үйл ажиллагааг Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, албан ёсны дэд салбар гэж хүлээн зөвшөөрдөг болгоход дэмжлэг үзүүлэх”**-д оршино.

5.2 Үр дүн ба бүтээмж

Хүснэгтэнд төслийн 3-р үе шатны үйл ажиллагаанаас гарах үр дүн болон бүтээмж нь хамтрагч талуудын хамтран тодорхойлсон 6 нэн чухал асуудлын хүрээнд төслийн ба бүрэлдэхүүн хэсгийн түвшинд тодорхойлж харуулсан байгаа (Бүлэг **Error! Reference source not found.**).

Үйл ажиллагааг хэрэгжүүлэх таамаглалын дагуу болон төслийн хоёр бүрэлдэхүүн хэсгийн нягт хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор бүрэлдэхүүн хэсгүүдийн үйл ажиллагаанаас гарах үр дүн 1-4 нь харилцан уялдаа холбоотой байна. Үр дүн 5 –ийн хувьд (үр дүн 1-4-ийн тогтвортой байдлыг хангаж өгөх чадавхийг бэхжүүлэх бүтцийн тухай) бодлогын болон бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсгүүд аль болох олон хүмүүст хүрэхийг зорино. Үр дүн 6 нь орлого үүсгэх болон орон нутгийн хөгжилд бүх түвшинд хамааралтай байна.

Шалгуур үзүүлэлтүүдийг бүрэлдэхүүн хэсгүүдийн түвшинд биш төслийн түвшинд боловсруулан гаргасан. Төслийн зүгээс зөвхөн 2 бүрэлдэхүүн хэсэг нь хоорондоо харилцан уялдаатай үйл ажиллагаа явуулж амжилтанд хүрсэн тохиолдолд л хөгжлийн зорилгод ач холбогдолтой хувь нэмэр оруулж чадна. Үр дүн болон бүтээмжийг шалгах үзүүлэлтүүдийг 2 бүрэлдэхүүн хэсгийн хоорондын харилцан хамааралтай байдлыг харгалзан үзэхгүйгээр тус бүрээр хийсэн тохиолдолд гарах үр дүн нь үр ашигтай байж чадахгүй байх магадлалтай. Жишээлбэл, батлагдсан дүрэм журмын тоо өндөр гарч болох боловч БУ-д дагаж мөрдөхгүй, боломжгүй бол үр дүнтэй ажил байж чадахгүй.

Бичил уурхайн бодлогын бүрэлдэхүүн хэсэг	Бичил уурхайчдын хөгжлийн бүрэлдэхүүн хэсэг	Шалгуур үзүүлэлтүүд
Хөгжлийн зорилго		
Бичил уурхайн үйл ажиллагааг Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, албан ёсны дэд салбар гэж хүлээн зөвшөөрдөг болгох.		
Үр дүн		
Монгол Улс дах хариуцлагатай бичил уурхай баталгаатай ажлын байрыг бий болгоно.	Бичил уурхайчдын амьжиргааны төвшин, нийгмийн болон байгаль орчны хариуцлага болон хөдөлмөрийн аюулгүй байдал нь сайжирсан байна.	Шудрага худалдааны гэрчилгээ бүхий бичил уурхайн үйлдвэрлэгчид [тоо], шудрага худалдааны нэмэгдэл шагналыг хүртсэн хэмжээ [тоо] Амьжиргаа хөрөнгө үнэлгээ
Үр дүн		
Төслийн үр 1: Хууль, эрх зүй, зохицуулалтын тааламжтай орчинг бүрдүүлснээр бичил уурхай эрхлэх үйл ажиллагааг албан ёсны болгох боломж бүрдсэн байна.		Ашигт малтмалын нөөц олборлох эрх олгогдсон албан ёсны бичил уурхайн байгууллага/ этгээдийн тоо
Бүрэлдэхүүн хэсгийн үр дүн 1.1 Бичил уурхайн хууль эрх зүй, зохицуулалтын нөхцөл нь бичил уурхай эрхлэгч иргэдэд үйл ажиллагаагаа албан ёсоор явуулах боломж олгосон байна.	Бүрэлдэхүүн хэсгийн үр дүн 2.1 Хууль эрх зүй, зохицуулалтын хүрээний дагуу бичил уурхай эрхлэгчид үйл ажиллагаагаа албан ёсны болгосон байна	
Төслийн үр дүн 2: Бичил уурхайчдын байгууллагууд гишүүд болон хамтрагч талуудынхаа ашиг сонирхолыг илэрхийлдэг болно.		Бичил уурхай эрхлэгчдийн үндэсний холбоо байгуулагдан явуулсан үйл ажиллагаа,
Бүрэлдэхүүн хэсгийн үр дүн 1.2 Үндэсний, бүс нутаг, орон нутгийн хэмжээнд Төр засаг ба бусад хамтрагч талууд бичил уурхайн салбарыг хамтын ажиллагаа бүхий үйлдвэрлэгч байгууллагууд болгох чиглэлд хамтран ажилладаг болсон байна.	Бүрэлдэхүүн хэсгийн үр дүн 2.2 Бичил уурхай эрхлэгчид нь хамтын ажиллагаатай, үйлдвэрлэгч байгууллагууд болоход Төр засаг ба бусад хамтрагч талуудтай хамтран ажилладаг болсон байна.	Бүс нутгийн ба орон нутгийн бичил уурхай эрхлэгчдийн ТББ-уудын тоо
Төслийн үр дүн 3: Нийгмийн үүрэг хариуцлага бүхий бичил уурхай эрхлэгчид ажлын байрны аюулгүй байдлыг хангаж нийгмийн баталгаатай болсон байна.		Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой гардаг ослын тоо буурсан

Бичил уурхайн бодлогын бүрэлдэхүүн хэсэг	Бичил уурхайчдын хөгжлийн бүрэлдэхүүн хэсэг	Шалгуур үзүүлэлтүүд
Бүрэлдэхүүн хэсгийн үр дүн 1.3 Бичил уурхайн ажлын байрны аюулгүй байдал, нийгмийн баталгааг дээшлүүлэхэд чиглэсэн төрийн ба хувийн салбарын үйлчилгээ хариуцлагатай бичил уурхай эрхлэгчдэд хүртээмжтэй болсон байна.	Бүрэлдэхүүн хэсгийн үр дүн 2.3 Хариуцлагатай бичил уурхай эрхлэгчид нь ажлын байрны аюулгүй байдал, нийгмийн баталгааны тогтолцоог сайжруулахад чиглэсэн боломжийн үнэ/төлбөр бүхий үйлчилгээг авдаг болсон байна.	байдал¹⁸ Нийгэм, эрүүл мэндийн даатгалтай болсон бичил уурхай эрхлэгчдийн тоо
Төслийн үр дүн 4: Хариуцлагатай бичил уурхай эрхлэгчид байгаль орчинд халгүй олборлолт явуулж, технологи хэрэглэдэг болсон байна.		Бичил уурхай эрхлэгчдийн нөхөн сэргээсэн газрын тоо хэмжээ,
Бүрэлдэхүүн хэсгийн үр дүн 1.4 Хэрэгжүүлж, дагаж мөрдөж болохуйц байгаль орчны шаардлагууд нь бичил уурхай эрхлэгчдэд хариуцлагатай байгаль орчинд халгүй олборлолт явуулах чиглэл болж өгсөн байна.	Бүрэлдэхүүн хэсгийн үр дүн 2.4 Бичил уурхай эрхлэгчид нь байгаль орчны шаардлагуудыг мэддэг болж, хариуцлагатай, байгаль орчинд халгүй олборлолтыг явуулж, экологийн үр ашигтай технологийг хэрэгжүүлдэг болсон байна.	Мөнгөн усгүй баяжуулах цехүүдийн тоо
Төслийн үр дүн 5: Бичил уурхай эрхлэгчдийг чадавхижуулах бүтэц, үйл явц хэрэгжсэн байна		Чадавхи бий болгох чиглэлээр идэвхитэй ажилладаг байгууллагуудын тоо
Бүрэлдэхүүн хэсгийн үр дүн 1.5 Бичил уурхайг дэмжсэн чадавхи бий болгох бүтэц, үйл явц, байгууллагууд үндэсний хэмжээнд бий болсон байна.	Бүрэлдэхүүн хэсгийн үр дүн 2.5 Тодорхой чиглэлээр мэргэжүүлэх чадавхи бий болгох бүтэц, үйл явц орон нутгийн түвшинд бий болсон байна.	Ерөнхий оролцогч/ суралцагчдын тоо Мэргэжсэн/ тодорхой чиглэлээр/ бичил уурхай эрхлэгчдийн тоо

¹⁸ excludes eventual mayor accidents (single event disaster)

Бичил уурхайн бодлогын бүрэлдэхүүн хэсэг	Бичил уурхайчдын хөгжлийн бүрэлдэхүүн хэсэг	Шалгуур үзүүлэлтүүд
Төслийн үр дүн 6: Ашигт малтмалыг зохистой ашиглах талаар орон нутгийн засаг захиргаа болон бичил уурхайчдын чадавхи дээшилсэн байна.		Бичил уурхай эрхлэгчдийг дэмждэг байгууллагуудын тоо
Бүрэлдэхүүн хэсгийн үр дүн 1.6 Тусгай зөвшөөрөл олгох ил тод шудрага үйл явц төлөвшиж зөрчилдөөнийг бууруулах.	Бүрэлдэхүүн хэсгийн үр дүн 2.6 Бичил уурхайчдын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн болон бүтээгдэхүүний чанар дээшилсэн байна	Туршиж нэвтрүүлсэн технологийн шинэ санаачлагуудын тоо Жич:орон нутгийн хөгжлийн мониторинг гол төлөв урт хугацааны зорилтын түвшинд байна (дээр дурьдсан)

5.3 Үр дүн болон үйл ажиллагааны багц

Төслийн үйл ажиллагаанаас гарах үр дүн бүрт хувь нэмэр оруулах үйл ажиллагааны багцыг доор үзүүлсэн ба Хавсралт 7-д детальчилан оруулсан байгаа. Гэвч энэ үйл ажиллагааны багц төслийн хэрэгжилтэнд яг энэ хэвээр нь ашиглана гэсэн үг биш юм гэдгийг онцлох нь чухал юм. ДШҮ-ний дүгнэлтүүдийн нэг нь өнгөрсөн хугацаанд төслийн төлөвлөлтийг хэтэрхий чандлан барьж хэрэгжүүлснээр зарим боломжуудыг алдсан байна гэж гарсан учраас энэ мэтийн алдааг дахин давтаж болохгүй юм.

Төслийн удирдлагын нэг гол гүйцэтгэх ёстой ажил нь нөхцөл байдлыг хянан үзэж гарч ирсэн боломжуудыг идэвхитэйгээр төслийн үйл ажиллагаанд тохируулан хэрэгжүүлэх байдаг учраас “үйл ажиллагааны багц” гэсэн нэр томъёог зориудаар соносон болно. Үүний үр дүнд доор дурдсан үйл ажиллагаануудын зарим нь хэрэгжигдэхгүй байж харин оронд нь удирдлагын гаргасан шинэ санаачла бүхий ажлууд хэрэгжигдэх боломжтой юм. Холыг харсан идэвхитэй байдлаар төслийн үйл ажиллагааг зохицуулах нь бэлэн болсон жорын дагуу тогтсон үйл ажиллагаа явуулахаас хол давуу, мөн чадал сорьсон ажил учраас төслийн удирдлагын зүгээс их хэмжээний туршлага, бүтээлч байдал, мэдрэмжийг шаардана.¹⁹

Тиймээс үйл ажиллагааны багцын хамгийн чухал элемент нь Хавсралт 7 дахь “баримжаа ба заавар” гэсэн хэсэг юм. Хавсралт 7 дахь зарим үйл ажиллагаанууд нь “чухал үйл явдал” гэсэн тодруулгатай байгаа. Төслийн үйл ажиллагааг өөрийнх нь замаар явуулахад эдгээр “чухал үйл явдал”-д хүрэхэд хүндрэлтэй байж магадгүй гэж үзэж байгаа боловч ихэнх тохиолдолд зөвхөн төлөвлөсөн ажиллагаагаа хэрэгжүүлэх замаар юм уу эсвэл өөр хувилбараар (тухайн нөхцөл байдалд илүү зохимжтой) хэрэгжүүлснээр чухал үйл явдалд хүрэх боломжтой байдаг²⁰. Зарим үйл ажиллагаанууд Шудрага худалдаа, шудрага олборлолтын системд ороход чиглэсэн тусгай холбогдол бүхий ажлууд (FTFM багана) байгаа ба эдгээр нь үйлдвэрлэгчдийг дэмжихэд зориулсан нийтлэг үйл ажиллагаанууд юм.

¹⁹ Энэ зорилгоор ТБУТ-ын удирдлага нь өмнөх үе шатнаас илүү бат бэх байхаар төлөвлөгдсөн ба энэ нь өндөр зэрэглэлийн туршлага бүхий 2 хүн байна: Төслийн үндэсний захирал ба Төслийн олон улсын менежер (Бүлэг 7.3).

²⁰ Хавсралт 6-д зарим чухал үйл явдлууд хэд хэдэн үйл ажиллагаан дээр давхцаж байгаа ба эдгээр нь нэг болон хэд хэдэн үйл ажиллагааг хэрэгжүүлсний үр дүнд хүрч болно.

Доорх хүснэгтэд Хавсралт 7-д оруулсан үйл ажиллагаануудыг нэгтгэн багцалсан байхаас гадна үйл ажиллагаануудыг бүрэлдэхүүн хэсгээр нь ялгаж харуулсан байгаа. Энэ нь Хавсралт дахь төслийн үйл ажиллагаа болон бүрэлдэхүүн хэсгүүдийн үр дүнг нэгтгэсэн ба ингэснээр хоёр бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааны харилцан уялдаат ажиллагааг (жишээ нь 1.1-ийн үр дүн 2.1-ийнхтэй таарах) чухалчлан харуулахыг зорьсон. Чухал үйл явдалуудыг тусад нь хүснэгтэд нэгтгэсэн ба Хавсралтад үйл ажиллагаануудтай хамт оруулсан.

Бүрэлдэхүүн хэсэг 1: Бичил уурхайн бодлого

Үр дүн			
	..)	Үйл ажиллагаа	FTF M
Төслийн үр дүн 1:			
1.1		Хууль, эрх зүй, зохицуулалтын орчинг бүрдүүлснээр бичил уурхай эрхлэх үйл ажиллагааг албан ёсны болгох боломж бүрдсэн байна.	
	A)	Хууль, эрх зүй, зохицуулалтын асуудлаар идэвхижүүлэх, зөвлөх	
	B)	Бичил уурхайд хандах олон нийтийн хандлага, санал бодлыг дээшлүүлэх	
	C)	Шудрага худалдааны экспорт, ашиг тус хүртэхэд чиглэсэн үйл ажиллагааг идэвхижүүлэх	
Төслийн үр дүн 2:			
1.2		Бичил уурхайчдын байгууллагууд гишүүд болон хамтрагч талуудынхаа ашиг сонирхолыг илэрхийлдэг болно.	
	A)	Бичил уурхайн байгууллагуудыг олон нийтийн ба бодлогын асуудлаар ярилцлага, хэлэлцүүлэгт оролцдог чадавхи бий болох	
	B)	Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр асуудлаа тавих мэдээлэл, сурталчилгааны ажлаа явуулдаг болоход нь бичил уурхайн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх	
Төслийн үр дүн 3:			
1.3		Нийгмийн хариуцлагатай бичил уурхай эрхлэгчид ажлын байрны аюулгүй байдал, нийгмийн аюулгүй байдлыг хангаж ажилладаг болсон байна.	
	A)	Ажлын байрны аюулгүй байдал, нийгмийн баталгааг дээшлүүлэхэд чиглэсэн төрийн ба хувийн хэвшлийн үйлчилгээ хариуцлагатай бичил уурхай эрхлэгчдэд хүртээмжтэй болсон байна.	
	B)	Бичил уурхайн удирдамж албан ёсоор гаргах ажиллагааг идэвхижүүлэх	
	C)	Бичил уурхай эрхлэгчдийг нийгмийн баталгааны албан ёсны тогтолцоонд хамруулах энгийн механизмыг боловсруулах	
	C)	Бичил уурхайн үйл ажиллагаа бүхий газруудад хүргэдэг уурхайн аврах үйлчилгээг сайжруулах	
Төслийн үр дүн 4:			
1.4		Хариуцлагатай бичил уурхай эрхлэгчид нь байгаль орчинд халгүй олборлолтын үйл ажиллагаа, технологийг хэрэгжүүлдэг болсон байна.	
	A)	Хэрэгжүүлж, дагаж мөрдөж болохуйц байгаль орчны шаардлагууд нь бичил уурхай эрхлэгчдэд хариуцлагатай байгаль орчинд халгүй олборлолт явуулдаг боломж олгосон байна.	
	A)	Бичил уурхайд энгийн хэрэгжүүлж болохуйц байгаль орчны дүрэм, удирдамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих, идэвхижүүлэх	

Үр дүн	..)	Үйл ажиллагаа	FTF M
	B)	Бичил уурхайд хэрэглэж буй мөнгөн усгүй “батлагдсан” технологийн загварыг албажуулах	
Төслийн үр дүн 5:	Бичил уурхай эрхлэгчдийг чадавхижуулах бүтэц, үйл явц хэрэгжсэн байна		
1.5	Бичил уурхайг дэмжсэн чадавхи бий болгох бүтэц, үйл явц, байгууллагууд үндэсний хэмжээнд бий болсон байна.		
	A)	Бичил уурхайн үйл ажиллагаанд мэргэшүүлэх бүтцийг бий	
	B)	Бичил уурхайн үйл ажиллагаанд мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө, дэд бүтцийг бий болгох	
	C)	Бичил уурхайн мэдээллийн санг байгуулах	
	D)	Мэдээлэл хуваалцах замаар чадавхи бий болгох	
	E)	Бичил уурхайгаар олборлосон алтны шудрага худалдааны сүлжээнд орох албан ёсны харилцаа бий болгох	
Төслийн үр дүн 6:	Ашигт малтмалыг зохистой ашиглах талаар орон нутгийн засаг захиргаа болон бичил уурхайчдын чадавхи дээшилсэн байна.		
1.6	Тусгай зөвшөөрөл олгох ил тод шудрага үйл явц төлөвшиж зөрчилдөөнийг бууруулах.		
	A)	Бүс нутаг, орон нутгийн Засаг захиргаад бичил уурхайд газрыг ил тод, тэгш байдлаар олгох ажиллагааг дэмжих	
	B)	Орон нутаг, бүс нутгийн Засаг захиргаадыг төвлөрлийг сааруулах үйл ажиллагаагаар дэмжих	
	C)	Байгалийн нөөцийн ашиглалттай холбоотой гардаг зөрчлүүдийг зуучлагчийн оролцоотой шийдэх чадавхи бий болгох	
	D)	Бичил уурхай эрхлэгчдийн эрх, эрэлт хэрэгцээний талаар мэдээлэл сурталчилгаа явуулах/ уул уурхайн том компани	

Бүрэлдэхүүн хэсэг 2: Бичил уурхай эрхлэгчдийг дэмжих

Үр дүн	..)	Үйл ажиллагаа	FTF M
Төслийн үр дүн 1:	Хууль, эрх зүй, зохицуулалтын орчинг бүрдүүлснээр бичил уурхай эрхлэх үйл ажиллагааг албан ёсны болгох боломж бүрдсэн байна.		
2.1	Хууль эрх зүй, зохицуулалтын хүрээний дагуу бичил уурхай эрхлэгчид үйл ажиллагаагаа албан ёсны болгосон байна		
	A)	Албан бусаар олборлолт явуулдаг иргэдийг зохион байгуулалтанд оруулж албан ёсны үйл ажиллагаанд хамруулах ажлыг дэмжих	
	B)	Бүртгэгдээгүй нөхөрлөлүүдэд албан ёсны үйл ажиллагаанд орох талаар зөвлөх	
	C)	Бичил уурхайн албан ёсны үйл ажиллагаанд орохдоо хууль ёсны арилжааны этгээд болохыг зөвлөх	
	D)	Бичил уурхайн байгууллагуудыг худалдааны чадавхитай болгох	
Төслийн үр дүн 2:	Бичил уурхайчдын байгууллагууд гишүүд болон хамтрагч талуудынхаа ашиг сонирхолыг илэрхийлдэг болно.		
2.2	Бичил уурхай эрхлэгчид нь хамтын ажиллагаатай, үйлдвэрлэгч байгууллагууд болоход Төр засаг ба бусад хамтрагч талуудтай хамтран ажилладаг болсон байна.		
	A)	Орон нутаг, бүс нутаг, үндэсний хэмжээнд зохион байгуулалтыг бий болгох үйл явцыг дэмжих	

Үр дүн			
	..)	Үйл ажиллагаа	FTF M
	B)	Бичил уурхай эрхлэгчдийн байгууллагуудыг өөрсдийн гол ажиллагаагаа явуулахад чиглэл удирдамж өгөх	
	C)	Бичил уурхай эрхлэгчдийн байгууллагыг хамтран эзэмшдэг ба ажиллуулдаг технологи, үйлдвэрлэлийг эрхлэх боломж олгох ажлыг идэвхижүүлэх	
	D)	Бичил уурхайн байгууллагуудыг бичил уурхайгаас олборлосон алтны шудрага худалдааны сүлжээнд нэгдэх ороход бүтэц зохион байгуулалтын тодорхой дэмжлэг үзүүлэх	
Төслийн үр дүн 3:	Нийгмийн хариуцлага бүхий бичил уурхай эрхлэгчид аюулгүй ажлын байр, нийгмийн баталгааг хангаж ажилладаг болсон байна.		
2.3	Хариуцлагатай бичил уурхай эрхлэгчид нь ажлын байрны аюулгүй байдал, нийгмийн баталгааны тогтолцоог сайжруулахад чиглэсэн боломжийн үнэ/төлбөр бүхий үйлчилгээг авдаг болсон байна.		
	A)	Албан бус байдлаас албан ёсны нийгмийн баталгаа тогтолцоонд шилжүүлэх	
	B)	Бичил уурхайн удирдамж боловсруулах	
	C)	Уурхайд илүү аюулгүй технологи нэвтрүүлэх	
	D)	Ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар мэдлэг мэдээлэл, чадавхи бий болгох	
	E)	Орон нутгийн хэмжээнд аврах үйлчилгээг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх	
	F)	Шудрага худалдааны стандартын дагуу алтны туршилтын газарт ажлын байрны аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах	
	G)	Бичил уурхайн байгууллагуудын нийгмийн хариуцлагын орон нутгийн хөтөлбөрийг идэвхижүүлэх	
Төслийн үр дүн 4:	Хариуцлагатай бичил уурхай эрхлэгчид байгаль орчинд халгүй олборлолт, технологийг хэрэгжүүлдэг болсон байна.		
2.4	Бичил уурхай эрхлэгчид нь байгаль орчны шаардлагуудыг мэддэг болж, хариуцлагатай, байгаль орчинд халгүй олборлолтыг явуулж, экологийн үр ашигтай технологийг хэрэгжүүлдэг болсон байна.		
	A)	Энгийн хэрэгжүүлж болохуйц байгаль орчны дүрэм журам, удирдамжийг боловсруулж, дагаж мөрдөхөд дэмжлэг үзүүлэх	
	B)	Байгаль орчны мониторингийн ажилд нутгийн иргэдийг хамруулах замаар нөөцийн ашиглалттай холбоотой үүсдэг зөрчлийг бууруулах	
	C)	Мөнгөн усгүй баяжуулдаг Борнуурын цехийг хүчин чадлыг нэмэгдүүлэх, бусад газруудад дэлгэрүүлэх	
	D)	Байгаль орчинд ээлтэй, экологийн үр ашигтай техникийн шийдлийг алтны олборлолтонд нэвтрүүлэх, боловсруулах ажлыг үргэлжлүүлэх	
	E)	Шудрага худалдааны стандартын дагуу туршилтын газрын байгаль орчны талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулах	
Төслийн үр дүн 5:	Бичил уурхайд чадавхи бий болгох бүтэц, үйл явцыг хэрэгжүүлж нэвтрүүлсэн байна		
2.5	Тодорхой чиглэлээр мэргэжүүлэх чадавхи бий болгох, мэдээлэл солилцох бүтэц, үйл явц орон нутгийн түвшинд бий болсон байна.		
	A)	Бүх сэдвүүдтэй холбоотой үйл ажиллагаанууд	
	B)	Бичил уурхай эрхлэгчдийн байгууллагуудад өөрсдийн гишүүдийн чадавхи бий болгох бүтэцтэй болоход дэмжих	
	C)	Бичил уурхай эрхлэгчдийн байгууллагуудад бичил уурхай эрхлэгчдийн чадавхи бий болгох бүтэцтэй болоход дэмжих	

Үр дүн				
	..)	Үйл ажиллагаа	FTF	M
	D)	Бичил уурхайчдын багц сургалтын материалыг эмхтгэн гаргах		
	E)	Шудрага худалдааны тогтолцоо, алтны стандартын шаардлагын талаар туршилтын газруудын бичил уурхай эрхлэгчдийн байгууллагуудад мэргэжлийн сургалт явуулах		
Төслийн үр дүн 6: Ашигт малтмалыг зохистой ашиглах талаар орон нутгийн засаг захиргаа болон бичил уурхайчдын чадавхи дээшилсэн байна.				
2.6		Бичил уурхайчдын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн болон бүтээгдэхүүний чанар дээшилсэн байна		
	A)	Бүтээмжийг дээшлүүлэх замаар орлогыг нэмэгдүүлэх		
	B)	Бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх замаар орлогыг нэмэгдүүлэх		
	C)	Бичил уурхай эрхлэгчид ба тэдний байгууллагуудын мөнгөний менежмент, бизнесийн чадварыг дээшлүүлэх		
	D)	Бичил уурхай эрхлэгчдийн байгууллагуудад нутгийн иргэдийн хөгжлийн асуудалд хандан ажиллах чиглэл өгөх		

Чухал үйл явдлууд

Чухал үйл явдлууд	Expected in				FTF
	Year 1	Year 2	Year 3	Year 4	
Ашигт малтмалын тухай хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтийг үндэслэн бичил уурхайн журмыг батлуулах	◆				
Бичил уурхай эрхлэгч иргэд шүхэр байгууллагаа байгуулсан байх		◆			
Бичил уурхайн шүхэр байгууллага байгуулагдаж, олон нийтэд танигдсан байх		◆			
Баянхонгорын цех (2-р шатанд баригдаж эхэлсэн)-ийг байгуулж ажиллагаанд оруулсан байх	◆				
Боловсруулах цехийн технологийг “албан ёсоор батлуулсан байх”	◆				
Загвах цехүүдийг (жишээ нь: Өмнөговь, Мандал одоогоор төлөвлөж буй) –ийг байгуулж ажиллагаанд оруулсан байх		◆ ◆			
Бичил уурхайн анхны байгууллага арилжааны байгууллага (ашигт малтмал олборлох эрх бүхий) болсон байх			◆		
Бичил уурхайн удирдамжуудыг боловсруулж, батлуулж, хэвлүүлсэн байх	◆	◆			
“Бичил уурхайчдын багц” (ТБУТ-ийн бүх зөвлөмжийг багтаасан) хэвлэгдсэн байх				◆	
Жилд 1 явуулын аврах нэгж байгуулах (УУАА-ны үйл ажиллагаанаас хамааран 2, 3 дахь жилүүлд)	1◆	+1◆	+1◆		
Бичил уурхай эрхлэгчдэд нийгмийн баталгааны тогтолцоог нээлттэй, хүртээмжтэй болгох			◆		
Монгол улсын бичил уурхайн талаарх мэдээллийн судалгаа хийх (хэн юу мэддэг?)	◆				
Бичил уурхайн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн асуудлаар мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх үндэсний байгууллагуудын сүлжээ бий болсон байх		◆			

Чухал үйл явдлууд	Expected in				FTF M
	Year 1	Year 2	Year 3	Year 4	
Бичил уурхай эрхлэгчдэд албан ёсны мэргэжлийн сургалт явуулах төв бий болгох талаар шийдвэр гаргах		◆			
Анхны мэргэжлийн сургалтын төвийг буюу сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байх			◆		
Анхны мэргэжлийн бичил уурхайчид гэрчилгээг олгох				◆	
Бичил уурхайн байгууллагууд өөрсдийн гишүүддээ сургалт явуулах санаачлагыг гаргах (бичил уурхайн байгууллага бүрээр)		◆			
Бичил уурхайн салбарт үйлдвэрлэл эрхлэгчид алт экспортлох талаар тодорхой журамтай болох	◆				
Монгол улсад алтны шудрага худалдааны стандартыг хэрэглэх боломжийг тогтоосон байх		◆			
Бичил уурхайн салбар үйлдвэрлэл эрхлэгчдэд шудрага худалдааны гэрчилгээтэй болгох		1◆	2◆	3◆	
Бичил уурхайгаар олборлосон алтыг шудрага худалдаагаар экспортолдог болох			◆		
Бичил уурхайн байгууллагууд (шудрага худалдааны хороод) нутгийн иргэдийг хөгжүүлэх төслүүдийг удирдан зохион байгуулах				◆	

6. Сонирхогч талууд, хамтрагч талууд болон ашиг шим хүртэгсэд

6.1. Хамтрагч талуудын зураглал


Төслийн 3-р үе шатны үйл ажиллагаанд хамааралтай байх хамтрагч талуудын гүнзгийрүүлсэн дүн шинжилгээг дараах чиглэлүүдийг харгалзан үзэж хийсэн. Үүнд:

- (i) Төслийн өмнөх үе шатны ажиллагааны үед хийгдсэн хамтрагч талуудын дүн шинжилгээ
- (ii) ДШҮ-ээс хийсэн хамтрагч талуудын дүн шинжилгээ
- (iii) Төслийн багийнхан болон гадны зөвлөхийн үнэлгээ

Зураг 3-т хамтрагч талуудын төсөлд үзүүлэх хүлээгдэж байгаа хувь нэмрийг харуулав.

Аль ч хамтрагч талуудын дүн шинжилгээнд гардаг нийтлэг хязгаарлалт байдаг ба энэ нь тухайн субектийн шинж чанараас хамаардаг. Учир нь дүн шинжилгээ нь шинжээчийн хувийн ойлголт дээр тулгуурладаг ба байгууллагын байр суурь нь тухайн байгууллагыг хариуцаж байгаа хүний хувийн үзэл бодол дээр тулгуурласан байх нь олонтоо байдаг. Ялангуяа хожмын үйл явдал нь цаг хугацааны асуудал байдаг. Иймээс хязгаарлалт/дутагдалтай талын хажуугаар хамтрагч талуудын зураглал нь тодорхой ойлголт өгч байна²¹.

²¹ Өнгөөр ялгасан тойрог нь хамтрагч талуудын бүлгийг харуулна. + болон – тэмдэг нь тэдний БУ-д чиглэсэн ойлголтыг илэрхийлнэ. Тойргийн хэмжээ нь “төсөлд хамаатай байдлын индекс” ба үүнийг төсөлд оруулах хүлээж байгаа эрх мэдлийн хувь нэмэр, сонирхол болон нөлөөнөөс тооцоолсон (Зураг 3). the latter is intentionally recursive to the position of the stakeholder within the map, as it contributes to highlight key stakeholders. Coloured ovals without borders represent groups comprised of various not individually analyzed stakeholders; their size is not quantitative.




Зураг 4: Хамтрагч тал бүрээс төслийн үйл ажиллагаанд оруулах эрх мэдлийн хувь нэмэр

Гол хамтрагч талууд (Зураг 4 дэх бараан саарал хэсэг)

- БУ-д хамгийн их сонирхол бүхий хамтрагч тал нь бичил уурхайчид юм.
- ШХА-ийн хамтран хэрэгжүүлэгч, хамгийн ойрын хамтрагч тал нь ЭБЭХЯ болон түүний харъяа байгууллагуудаар төлөөлүүлсэн Монгол Улсын засгийн газрын уул уурхайн салбар юм. Орон нутгийн засаг захиргаа болон бичил уурхайчдын байгууллагууд мөн адил чухал үүрэг гүйцэтгэнэ. Зарим орон нутгийн захиргааг эс тооцвол эдгээр хамтрагч талуудын БУ-д чиглэсэн үзэл бодол нь маш эерэг байдаг.
- Албан ёсны хариуцлагатай бичил уурхайн салбарыг хөгжүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж саад тотгор болох талууд нь голдуу хяналтгүй, зохион байгуулалтгүй, албан бус, эрх мэдэлгүй бичил уурхайн үйл ажиллагаанаас ашиг олох гэсэн эдийн засгийн ашиг сонирголоос үүдэлтэй байдаг. Албан бусаар алт худалдаалдаг хар захын салбар нь БУ-н үйл ажиллагааг өнгөрсөн 10 жилийн хугацаанд албан бус үйл ажиллагаа байлгаж чадсан ба төслийн үйл ажиллагаа үүнд сөргөөр нөлөөлөх болно.

- Ижил хүсэл зорилго бүхий үйл ажиллагаа явуулдаг Дэлхийн банк, Азийн сан, Хариуцлагатай уул уурхайн холбоо гэх мэт олон улсын байгууллагууд янз бүрийн чиглэлээр ач холбогдол үзүүлэх болно.



Зураг 5: Хамтрагч талуудын зураглал (Хавсралт 10: Хамтрагч талуудын талаар хийсэн дүн шинжилгээ)

Үндсэн хамтрагч талууд (Зураг 4 дэх цайвар саарал хэсэг)

- Төрийн болон ТББ, хувийн хэвшлээс бүрдсэн олон тооны үндсэн хамтрагч талууд байна.
- Үндсэн хамтрагч талууд болох төв засгийн газрын байгууллагуудад БОАЖЯ, ХНХЯ, мөн БУ-н үйл ажиллагааг саяхан батлагдсан хууль эрх зүйн хүрээнд байгаль орчны болон нийгмийн хариуцлага бүхий мэргэжлийн үйл ажиллагаа болгоно гэсэн итгэл найдвартайгаар БСШУЯ зэрэг багтана. Монгол банкны зүгээс алтыг хууль ёсны дагуу худалдаалахад маш их сонирхолтой байгаа. УМХА БУ-н үйл ажиллагааг хянадаг утгаараа мөн чухал үүрэг гүйцэтгэнэ.
- Иргэний нийгмийн байгууллагууд (ТББ), судалгааны байгууллагууд болон хувийн хэвшлийнхэн (том уурхайн компаниуд) энэ талаар сонирхлоо бага илэрхийлж байгаа ба БУ-н үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө нь ч бага юм. ТББ-д нь ерөнхийдөө идэвхитэй өөрчлөлт хийгчид биш (БУ-г дэмжих эсвэл эсэргүүцэх


талаар үйл ажиллагаа явуулах) харин үйлчилгээ үзүүлэгчдийн байр суурьнаас хандаж байна. Хувийн хэвшил, уурхайн том компаниуд²² нь голдуу БУ-н үйл ажиллагаагаар ямар нэгэн нөлөө амсахгүй байхыг эрхэмлэж байгаа ба ихэнх тохиолдолд орон нутгийн засаг захиргаатай сайн харилцаатай байх болон...дагуу БУ-чидтай гэрээ хийж ажиллахыг зөвшөөрдөг.

Бусад хамтрагч талууд

- Энэ ангилалд зөвхөн цөөн тооны хамтрагч талууд дүн шинжилгээнд хамрагдсан. Учир нь тэдний төсөлтэй холбоотой байдал нь голдуу асуудал дээр эсвэл тухайн газарт суурилсан байдаг ба тэдний БУ-тай холбогдох нь бусад хөгжлийн асуудалтай холбоотой байдагт оршино.

6.2 Ашиг шим хүртэгсэд

Хөгжлийн зорилгод харуулсанчлан уг төслийн ашиг шимийг хүртэгсэд нь “хариуцлагатай бичил уурхайчид” юм. Төслийн 2-р шатны үйл ажиллагааны төгсгөл үед батлагдсан Ашигт малтмалын хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хууль нь олон нийтэд тулгууралсан уурхайн ажилтай ижил төстэй албан ёсны, байгаль орчны болон нийгмийн хариуцлагатай БУ-г бий болгох ажлыг улам хурцалж өгсөн. Төслийн үйл ажиллагаа нь байнгын болон улирлын чанартай олборлолт явуулдаг БУ-г хөгжүүлэхэд голчлон чиглэхээс гадна гэнэтийн цугларалтын байдлаар үйл ажиллагаа явуулдаг болон аргагүйн эрхэнд бичил уурхайн үйл ажиллагаанд шилжсэн иргэдийг тогтвортой, хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг болгож хөгжүүлэхэд чиглэнэ.



Зураг 6: БУ-н пирамид

БУ-чдыг “ашиг шим хүртэгсэд” гэж нэрлэхээсээ илүүтэйгээр “өөрчлөлт хийгсэд” гэж ойлгон төслийн хамтрагч тал гэж хүлээж авах хэрэгтэй юм. “Манлайлагчид” нь БУ-н хөгжлийн үйл явцыг төслийн хугацаа дууссаны дараа үргэлжлүүлэн удирдан явуулах боломжтой байна. Иймээс ТБУТ үйл ажиллагаагаа хэргэжүүлдэг газруудын зохион байгуулалтад орсон БУ-чдын бүлгүүдтэй нягт ажиллахыг чухалчлан үзэж тэднийг манлайлагчид болгох талаар сургах хэрэгтэй. Ийм манлайлагчдыг хөгжүүлэх нь БУ-чид болон бусад дотоодын хамтрагч байгууллагуудад суралцах дадлага туршлага болно.

Олон нийтэд тулгууралсан уурхайн үйл ажиллагаа нь яваандаа олон нийтийн гэсэн шинж чанараа хадгалан хувийн бизнесийн үйл ажиллагаа болж хөгжих ёстой ба төслийн зүгээс БУ-чдаас гарсан санаачлагыг дэмжин цаашид тогтвортой бизнес болоход нь туслах хэрэгтэй (тухайлбал Борнуурын туршлага).²³

Зохион байгуулалтад ороогүй БУ-чдыг зохион байгуулалтад оруулах, албажуулах ажил нь орон нутгийн түвшинд зохицуулах ажил учраас голдуу орон нутгийн засаг захиргаа

²² Үйл ажиллагаа явуулж байгаа бүх компаниудад энэ нь нийтлэг биү учраас Хавсралт 9-д оруулаагүй. Эдгээр компаниуд нь төсөл хэрэгжиж буй орон нутагт үйл ажиллагаа явуулж буй компаниуд юм.

²³ Regarding investment capital which ASM businesses might need, the Project must not substitute financial institutions through providing loans or rotational funds (this is not the task of the Project!) but shall facilitate access to sources of financing. Own capital of miners (e.g. accumulated through savings groups) is the most easily accessible money for miners, which creates the least dependencies.

төв засгийн газрын (АМГ БУ-н тасаг) дэмжлэгтэйгээр хийгдэх ёстой. Харин гэнэтийн цугларалтын байдлаар үйл ажиллагаа явуулдаг болон аргагүйн эрхэнд бичил уурхайн үйл ажиллагаанд шилжсэн иргэдийн үйл ажиллагаа явуулдаг газруудад төсөл голдуу хамтрагч талаараа дамжуулан үйл ажиллагаа явуулна.

Тооны хувьд ТБУТ дараагийн 4 жилийн хугацаанд 7,500 ($\pm$ 2,500) бичил уурхайчдыг “манлайлагч” болгож хөгжүүлэхээр, 15,000 ($\pm$ 5,000) бичил уурхайчдыг “ерөнхий сонсогч” байлгах аар хүрч ажиллах боломжтой юм. Энэ нь албан ёсоор хүлээн зөвшөөрсөн 38,000 бичил уурхайчдын 60% буюу албан бусаар тодорхойлсон 100,000 бичил уурхайчдын 20%-д хүрч ажиллана гэсэн үг юм.

6.3 Үндэсний хамтрагч тал

Төв засгийн газрын түвшний уул уурхайн салбарын (ЭБЭХЯ болон агентлагууд) гол үүрэг хариуцлага нь хамтрагч талуудын зураглал дээр тодорхой харагдаж байгаа. ЭБЭХЯ нь төслийн 2-р үе шатны хэрэгжилтэнд хамтрагч талаар оролцсон ба 3-р үе шатны төлөвлөлтийн ажиллагааны үед цаашид ШХА-тай БУ-н салбарыг зохицуулах, хөгжүүлэх зорилгоор хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.

Монгол улс нь ашигт малтмалаар баян орон бөгөөд уул уурхайн салбарын нэн тэргүүний асуудал нь төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар том уурхайн үйл ажиллагааг хөгжүүлэн олон нийтийн тогтвортой орлого бий болгохыг зорьж байгаа юм. Хэдий тийм боловч БУ-н үйл ажиллагаа нь үүнтэй холоотой 38,000 иргэдэд ажлын байр бий болгож байгаа гэдэг утгаараа том уурхайн үйл ажиллагаатай (46,000 ажилчид) ач холбогдолын хувьд бараг ижил тэнцүү байгаа юм. Үүний хөдөө орон нутагт ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгож байгаа чухал ач холбогдлыг харгалзан БУ-н үйл ажиллагаа нь ЭБЭХЯ-ны бас нэгэн нэн тэргүүний асуудал болсон юм.

БУ-н үйл ажиллагаа Могол Улсын хувьд эхлээд 10 гаруй жил болж байгаа шинэ салбар учраас 2010 онд батлагдсан Ашигт малтмалын хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хуулийн хэрэгжүүлэлттэй холбоотой олон олон ажлууд хийгдэх хэрэгтэй байгаа ба ЭБЭХЯ-наас ТБУТ-ийн шугамаар цаашид үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэхийг ШХА хүсч байна.

- ТБУТ-ийг хэрэгжүүлэх албан ёсны хамтрагч талууд нь Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Швейцарь Улсын Засгийн газрыг төлөөлж Швейцарийн элчин сайдын яам/ШХА нар байна.
- Үйл ажиллагааны төвшинд ТБУТ нь Ашигт малтмалын газартай (АМГ) нягт холбоотой ажиллана. АМГ нь ЭБЭХЯ-ны хэрэгжүүлэгч агентлаг ба геологи, уул уурхайн судалгаа, шинжилгээ болон уул уурхайн тусгай эрхийг олгох, бүртгэх зэрэг асуудлуудыг хариуцан ажилладаг.
- АМГ-аас БУ-н тасгийг дахин байгуулахаар төлөвлөж байгаа ба энэ нь урьд нь үйл ажиллагаа явуулж байсан БУ-н хэлтсийн үйл ажиллагааг залгуулан хариуцах юм. Энэ тасаг нь БУ-чдад хууль эрх зүйн, техникийн, байгаль орчны, бизнесийн болон олон нийтийн хөгжлийн талаар холбогдох дэмжлэгийг үзүүлэх үйл ажиллагаа явуулна.
- Хэрэгжүүлэх төвшинд ТБУТ-ийн бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсэг болон АМГ-ын БУ-н тасаг хоёр хоорондоо ихээхэн нягт холбоотой ажиллах болно. Төслийн үйл ажиллагаа нь голдуу АМГ болон үүний БУ-н тасгийг бэхжүүлэх, үүний ажилтангуудын БУ-н талаарх ойлголтыг гүнзгийрүүлэн чадавхижуулснаар уг салбарыг зохицуулах болон хөгжүүлэх бүрэн чадвартай болгоход чиглэнэ.

Төслийн бүтэц зохион байгуулалтын тухай илүү детальчилсан тайлбарыг **Error! Reference source not found.**, хэсэгт оруулсан. Ялангуяа Figure 7-д.

6.4 Харилцагч талууд

Харилцагч талуудтай хамтарч ажиллах нь ТБУТ-ийн хувьд чухал юм. Төслийг хэрэгжүүлэх хугацаанд төрийн байгууллагууд, орон нутгийн болон үндэсний ТББ, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын чадавхийг сайжруулах, төслийг хэрэгжүүлэх хугацаанд бий болгосон шийдлийн үндэсний эзэмшлийг бий болгох нь уг үйл ажиллагааг цаашид удаан хугацаагаар тогтвортой байлгахын үндэс болно.

Дотоодын гол хамтрагч талууд

БУ-н үйл ажиллагааг албан ёсны болгох болон орон нутгийн хөгжлийн талаарх гол хамтрагч тал нь **аймаг сумын засаг захиргаа** юм. Бүсийн болон орон нутгийн захиргаанаас БУ-н үйл ажиллагаа явуулах газрыг ил тод, тэгш эрхтэйгээр олгох явдал нь БУ-н хөгжлийн боломжуудыг гаргаж ирхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Гэвч бүсийн болон орон нутгийн захиргаа нь ашигт малтмалын менежментийн талаарх туршлагаар дутмаг байж одоо явагдаж байгаа төвлөрөлийг бууруулах үйл явцын хүрээнд оногдсон үүргээ биелүүлэхэд дэмжлэг хэрэгтэй байж болох юм.

Хэрэгжүүлэх төвшинд, ялангуяа орон нутагт ажиллах явцад бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсгийн хувьд орон нутгийн засаг захиргаа нь хамгийн чухал хамтрагч тал байх юм. Орон нутгийн засаг захиргааны ашигт малтмалын нөөцийн менежментийг сайжруулах оролдлогыг нь бэхжүүлэх үйл ажиллагаа нь БУ-н бодлогын бүрэлдэхүүн хэсгийн ажил байна.

Уул уурхайн аврах алба (УУАА) нь ЭБЭХЯ-нд харъяалагддаг ба уул уурхайн салбар дахь аюулгүй ажиллагааг мөрдүүлэх чиглэлийг хариуцаж ажилладаг. Уурхайд үзлэг шалгалт хийх, том уурхайн төлөвлөгөөг батлах зэргээс гадна УУАА нь аюулгүй ажиллагааны сургалт явуулах, уурхайн аврах ажлыг улсын хэмжээнд хийдэг. Үүнд БУ-н ажиллагаа мөн багтдаг. УУАА нь ТБУТ-тэй хамтран БУ-н үйл ажиллагаа явуулж байгаа газруудад явуулах аюулгүй ажиллагааны сургалтын хүрээг тэлэх, аврах ажиллагааг явуулах ихээхэн хүсэл эрмэлзэлтэй байгаа.

Дотоодын үндсэн хамтрагч талууд

БУ-н үйл ажиллагааг албан болгох нь ашигт малтмал олборлох эрх үүрэг, олборлолтын газар авах боломж зэргээс хамаагүй өргөн хүрээтэй үйл ажиллагаа юм. Байгаль орчны болон нийгмийн хариуцлагатай мэргэжсэн БУ-н үйл ажиллагаа нь **БОАЖЯ, НХХЯ, БСШУЯ, ЭМЯ** зэрэг бусад салбарын үйл ажиллагаатай давхцан хамаарч байна. ТБУТ-ийн үйл ажиллагаанд эдгээр яам, газрууд чиглэл чилэлээрээ оролцох хэрэгтэй байна. БОАЖЯ-тай хамтран байгаль орчинд хал багатай техникийн шийдэл гаргах, НХХЯ-тай хамтран БУ-чдыг албан ёсны даатгалын системд оруулах, БСШУЯ-тай хамтран БУ-н мэргэжлийн сургалтын хөтөлбөр, логикийг боловсруулах нь маш чухал юм.

Монгол банк болон **Үнэт металлын сорьц тогтоох лаборатори** зэрэг нь албан ёсны БУ-чдын байгууллагыг Шудрага худалдааны системд элсэн ороход чухал үүрэг гүйцэтгэнэ.

БУ-чдад зориулсан богино хэмжээтэй, энгийн, амархан ойлгогдох, мөн маш үр дүнтэй заавар зааварчлага боловсруулан гарагахад **УМХГ**, ялангуяа **аймаг, сумын МХ** болон **БО-ны байцаагчид** оролцох нь маш чухал. Тодорхой, ойлгомжтой зааварчлага нь зөвхөн БУ-чдад туслаад зогсохгүй байцаагчдад ч чухал ач холбогдолтой юм. Германы хөрөнгө оруулалттай BGR төсөлтэй хамтарвал илүү үр дүнтэй болох талтай.

Иргэний нийгмийг төлөөлж байгаа ихэнх ТББ, хувийн болон улсын **судалгаа шинжилгээний байгууллагууд** өөрийн орны онцлог бүхий БУ-н үйл ажиллагаатай болох талаар нэг их санаа тавьдаггүй байна. Тэдгээр нь ихэнхдээ хэрэгцээ шаардлагын дагуу үйлчилгээ үзүүлэгч маягаар оролцож байна. Тэгсэн ч гэсэн тэдний ихэнх нь БУ-н үйл ажиллагааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахуйц мэргэжсэн байгууллагууд байдаг учраас төслийн үйл ажиллагаанд татан оруулах нь зүйтэй юм. Төслийн чадавхийг эрчимтэйгээр тохируулах, зохицуулахад гадаадын үйлчилгээ үзүүлэгчдийн оролцоо тустай. Дотоодоос гарсан санал санаачлагыг дэмжүүштэй. Учир нь тэдгээр нь орон нутгийн нөхцөлд илүү ойр, хямд, олшруулж хэргэлэхэд амархан, ойлгомжтой байдаг. Судалгаа шинжилгээний байгууллагуудыг технологийг сайжруулах, олон нийтийг хөгжүүлэх, сурталчлах, нөлөөлөх, болон байгаль орчны менежментийн чиглэлээр оролцуулна.

БУ-р олборлоход тохиромжтой ихэнх нөөц (их , бага агуулгатай) бүхий газар нь **том уурхайн компаниудын** тусгай эрх бүхий газруудад байралдаг. Төслийн зүгээс БУ-чид, том компани болон орон нутгийн захиргааны хоорондын хамтын ажиллагааг үр дүнтэй, таатай байлгахад хувь нэмэр оруулж болно. Ялангуяа ICMM-ийн гишүүн компаниудыг CRS-ынхаа дагуу үүргээ хүлээхэд нь дэмжлэг болох хэрэгтэй.²⁴

Олон улсын үндсэн хамтрагчид

Хэдийгээр Монголд БУ-н тусгайлсан төсөл хэрэгжүүлээгүй боловч дэлхийн бичил уурхайчдыг нэгтгэж байдаг CASM-ыг санаачилсан байгууллага гэдэг утгаараа болон тусгай уул уурхайн мэргэжилтэн бүхий **Дэлхийн банкны** салбар оффис нь ТБУТ-ийн хамгийн чухал хамтрагч юм. Дэлхийн банк Монгол банктай Шудрага худалдааны системийн дагуу алт экспортлох талаар ярилцахад дэмжлэг үзүүлнэ гэдгээ илэрхийлсэн.

Азийн сангаас ESEC (Байгаль орчныг хамгаалахад олон талын оролцоог хангах нь) төслийг Голландын хөрөнгө оруулалттайгаар хэрэгжүүлэхээр бэлтгэж байна. Энэ төсөл нь ашигт малтмалын салбарыг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах найдвартай туршлага Монгол Улсад бий болгох талаар ажиллах юм. Энэ төслийн 4 бүрэлдэхүүн хэсэгтэй (Хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг амьдралд үйл хэрэг болгох/төлөвшүүлэх, орон нутгийн түвшинд байгалийн нөөцийг ашиглахад олон талуудын оролцоог хангах, Байгаль орчныг хамгаалах нөлөөлөх чадавхийг сайжруулах, Байгаль орчин болон усны чанарыг хянах үйл ажиллагааг институтчилах) хамтарч ажиллах боломж байна. Хэрэв энэ төсөл хариуцлагатай бичил уурхайн болон үүний Монгол улсын хөгжилд хувь нэмэр оруулах боломжуудын талаар олон нийт болон улс төрийн (ялангуяа ESEC төслийн хамтрагч талуудын дунд) үзэл бодолд зөв ойлголт өгөхөд нэмэр болвол ТБУТ-ийн хөгжлийн зорилгодоо хүрэхэд нь маш чухал хувь нэмэр болох юм. ESEC-ийн зүгээс ашигт малтмалтай холбоотой гарах зөрчлүүдийг бууруулах тал дээр чухалчлан БУ-чид байгаль орчны хариуцлагыг өөрсдөө хянах/зохицуулах дээр төвлөрч ажиллаж болох юм. ESEC төслөөс ШХА-д хандаж үйл ажиллагаандаа БУ-д чиглэсэн хэсэг оруулах талаар бичиг баримт боловсруулж байна.

2010 оны 3-р сард **Хариуцлагатай уул уурхайн холбоо** (ARM) болон **Шудрага худалдааны олон улсын байгууллагаас** (FLO) **Шудрага худалдаа, шудрага олборлолтын холбоог** (FT&FM) зарласан ба “Бичил уурхайгаар олборлосон алтны шудрага худалдаа, шудрага олборлолтын стандарт”-ыг хэвлүүлсэн. Энэ стандарт нь одоогийн байдлаар Өмнөд Америкд хэрэгжиж эхлээд байгаа ба Африкт чиглэсэн үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд үүний дараагийн алхам нь Азид хүрэх үйл ажиллагаа байх юм. Эдгээр байгууллагууд ШХА-д Монгол улсыг үйл ажиллагааныхаа хүрээнд урьдчилан оруулах боломжтой гэдгээ илэрхийлээд байна.

Бусад хамтрагч талууд болон ерөнхий сүлжээ

Ижил хүсэл бодолтой үйл ажиллагаа явуулдаг дотоод, гадаадын байгууллагууд болон санаачлагуудтай хамтарч ажиллах хэрэгтэй юм. Төслийн дараагийн 4 жилийн үйл ажиллагааны явцад хамтарч ажиллах боломжит бусад байгууллагууд гарч ирж болох ба төслийн зүгээс тэдэнтэй зүй ёсны дагуу хамтарч ажиллах шаардлагатай.

Ерөнхийдөө төсөл хэрэгжиж эхэлсэн эхний жилүүд буюу CASM-ыг зохион байгуулж байх үедээ байгуулсан харилцаа холбооны сүлжээг дахин сэргээх шаардлагатай юм. Ийм сүлжээ нь олон улсын туршлагаас сурах, түүнийг нутагшуулах хамгийн үр дүнтэй бөгөөд хамгийн хямд арга зам юм. Төслийн удирдлагын зүгээс дотоод гадаад харилцаа холбооны сүлжээг адил тэнцүү чухалчилж үзэх хэрэгтэй бөгөөд төслийн нийт багийг энэ талаар идэвхитэй ажиллахад нь дэмжих болно. Мэдлэг хуваалцах сүлжээ нь “нийгмийн хөрөнгө” юм. Энэ нь хэргэлэхийн хэрээр өсдөг цорын ганц хөрөнгө юм!

7. Төслийн зохион байгуулалт ба менежмент

²⁴ ICMM Publication „Working together: How large-scale mining can engage with artisanal and small-scale miners“, <http://www.icmm.com/document/789> accessible from <http://www.icmm.com/page/236>

Error! Bookmark not defined.-р хуудсанд байгаа Figure 7-д ТБУТ-ийн байгууллагын болон менежментийн бүтцийг харуулсан.

7.1 Төслийн бүтэц

Төслийн гэрээ

ТБУТ нь Швейцарь болон Монгол Улсын Засгийн газруудын хамтран хэрэгжүүлдэг төсөл юм. Төслийн гэрээнд хоёр талаас хариуцсан эрх мэдэлтэнгүүд гарын үсэг зурна.

- **Монгол Улсын Засгийн газрыг** төлөөлж Эрдэс баялаг, эрчим хүчний яам
- **Швейцарийн Засгийн газрыг** төлөөлж Монгол дахь Швейцарийн элчин сайдын яамны дэргэдэх Швейцарийн хамтын ажиллагааны газар

Үйл ажиллагааны төвшинд

- Монгол Улс

Ашигт малтмалын газар (АМГ) нь ЭБЭХЯ-ны хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд уул уурхай болон ашигт малтмалын салбарыг хариуцаж ажилладаг. АМГ нь ТБУТ-д Монгол улсын талаас оруулах хувь нэмрийг хэрэгжүүлэгч байна.

- Швейцарь Улс

Швейцарийн хөрөнгө оруулалттай хөгжлийн төслүүдийн хүрээнд төсөл хэрэгжүүлэх хэд хэдэн хэлбэр байдаг. Эдгээр нь “гэрээлсэн” (төслийн үйл ажиллагааг гадна дотны хэрэгжүүлэгч нэгжүүдэд гэрээлэн хийлгэх) төсөл, “өөрөө хэрэгжүүлэгч” төсөл буюу ШХА төслийн үйл ажиллагааг өөрөө хэрэгжүүлэх хэлбэрээр явуулах зэрэг болно. Төслийн төлөвлөлтийн үйл явцын үед хэрэгжүүлэлтийн янз бүрийн хэлбэрүүдэд дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

- (i) Төслийн хэрэгжүүлэлтийг олон улсын хэмжээний мэргэжлийн байгууллагад гэрээлэн хэрэгжүүлэх хэлбэр нь уг хэлбэрээр хэрэгжүүлсэн төслийн бэлтгэл үе шатны үйл ажиллагааны үед гарсан ойлголт болон туршлагаас шалтгаалж боломжгүй гэж дүгнэгдсэн
- (ii) Төслийн хэрэгжүүлэлтийг дотоодын гүйцэтгэгч нэгжид гэрээлэн хэрэгжүүлэх хэлбэр нь БУ-тай холбоотой туршлага бүхий мэргэжсэн байгууллага байхгүй гэсэн шалтгаанаас болж мөн боломжгүй гэж дүгнэгдсэн
- (iii) Төслийн үе шат 2-ыг өөрөө хэрэгжүүлсэн ба энэ нь хэдийгээр ямар ч саад тотгоргүй явагдаагүй боловч хангалттай хэмжээний үр дүн гаргасан ба хамгийн чухал нь ШХА-ийн ажилтангууд шаардлагатай дадлага туршлагыг бүрэлдүүлсэн нь дараагийн үе шатны үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх найдвар төрүүлж байна.

Тиймээс **Швейцарийн хөгжлийн агентлаг** (ШХА) нь Швейцарийн талаас ТБУТ-д оруулах хувь нэмрийг өөрөө хэрэгжүүлнэ. Энэ зорилгоор ШХА ТБУТ-ийн багийг өмнөх үе шатны нэгэн адилаар бүрдүүлнэ.

7.2 Төслийн зохион байгуулалт

Төслийн бүтэц

Швейцарийн хөрөнгө оруулалттай хөгжлийн төслүүдийн хүрээнд төслийн бүтцийн талаар хэд хэдэн хувилбар байдаг. Эдгээр нь төслийн шинж чанараас хамааран түүнийг хэрэгжүүлэх бүрэн бие даасан нэгжээс хамтрагч талын бүтцэд бүрэн болон материаллаг хэлбэрээр нэгдэх хүртэл янз бүр байна. Төслийн төлөвлөлтийн явцад эдгээр хувилбаруудад дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

- (i) БУ-н үйл ажиллагаа нь түр зуурын асуудал биш учраас хамтрагч талууд болон харилцагч байгууллагуудад энэ талын чадавхийг суулгаж өгөх нь цаашид тогтвортой хөгжүүлэхийн нэгэн үндэс юм. Иймээс төслийн баг

зөвхөн дотроо бүрэн бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулж болохгүй.

- (ii) Төсөл хамтрагч талын бүтцэд бүрэн нэгдэж болохгүй. Учир нь бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөхтэй холбоотойгоор уусан алга болж болзошгүй юм. Жишээ нь: урьд нь байсан АМГ-ын БУ-н хэлтсийн үйл ажиллагаа саарсан ба одоо дахин БУ-н тасгийг байгуулах талаар төлөвлөж байна.
- (iii) АМГ-ын байгуулахаар төлөвлөсөн БУ-н тасагтай төслийн багийг нэгтгэх нь уг тасгийн үүрэг хариуцлагыг орлож хийх эсвэл уг тасгийн үйл ажиллагааг байнгын үйл ажиллагаатай бүтэц болгохоосоо илүүтэйгээр тодорхой хугацааны хооронд хэрэгжидэг төсөл мэт болгох эрсдэлтэй.
- (iv) Ихэнх бичил уурхайчдын албан бус байдлаар үйл ажиллагаагаа явуулж байгаа нөхцөл нь тэдэнд сэтгэхүйн талаар гүн нөлөөлж Төрийн байгууллагатай харьцах талаар арга барилаа олоход нь саад болж байна.
- (v) Биет (тусдаа ажлын байр/оффис) болон логик (АМГ-н хянах ажиллагаа VS. ТБУТ-ийн дэмжих ажиллагаа) талаасаа тусдаа байгаа бүтцээ цаашид хадгалан үлдээн, харин маш нягт холбоотойгоор (шаардлагатай газар нь хамтарч үйл ажиллагаа явуулах, хамтарч томилолтоор ажиллах) нь төслийн хамгийн тохиромжтой зохион байгуулалтын хэлбэр болж байна.

Үүний үр дүнд ТБУТ-ийн баг АМГ-тай болон үүний БУ-н тасагтай нягт хамтын ажиллагаа явуулах бүтцээр төслийг хэрэгжүүлэхээр сонгосон.

Энэ бүтэц нь төслийн өмнөх үе шатны бүтэц зохион байгуулалттай зарчмын хувьд ижил төстэй бөгөөд энэ шатанд явуулсан үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжийг бий болгохоос гадна үйл ажиллагааны түвшинд хамтран ажиллах талууд болох ШХА ба АМГ-ын илүү нягт үйл ажиллагааг чухалчилсан. Энэ нь АМГ БУ-н тасгаа байгуулсаны дараа илүү боломжтой болох юм.

- **ТБУТ** АМГ-ыг байгууллагын хувьд үндэс суурь гэж үзэн АМГ-ын БУ-н тасгийн үйл ажиллагаа болон даалгаварыг сайжруулж дэмжих тодорхой зорилго болон үйл ажиллагаа бүхий нэгэн хэсэг/өргөтгөл гэж тооцох хэрэгтэй. Чадавхийг сайжруулах болон мэдлэг дамжуулах замаар АМГ болон үүний БУ-н тасаг БУ-н асуудлыг зохицуулж чадах илүү чадвартай болсон байх хэрэгтэй. Төслийн баг төсөл дууссаны дараа хоосон зай үлдээхээс болгоомжлох үүднээс АМГ-ын гүйцэтгэх ёстой ажлыг орлож хийхээс зайлсхийх хэрэгтэй.
- **АМГ БУ тасаг** (АМГ, ЭБЭХЯ-ны бусад хэсгүүд) ТБУТ-ыг тэдний өөрсдөө бие даан хийх боломжгүй байгаа ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа түр зуурын нэмэгдэл хүч гэж үзэх хэрэгтэй. ТБУТ-ийн үйл ажиллагаанаас олсон туршлага болон сургамжуудыг АМГ-ын БУ тасгийн үүрэг, зорилготой нийцэж байгаа тохиолдолд АМГ үйл ажиллагаандаа аажмаар нэгтгэн тусгахаас гадна бусад хамтрагч талуудад ч үүнээс суралцах, ашиглах боломжийг нь олгоно. ТБУТ-ийн туршлагыг өвлөн авснаар төсөл дууссанаас хойш АМГ-ын БУ-н үйл ажиллагааг зохицуулах чадавхи нь илүү сайн болох юм.

Энэ зорилгоор ШХА болон ТБУТ доорх чиглэлээр нягт харилцаагаа үргэлжлүүлнэ:

- Бодлогын түвшинд ЭБЭХЯ-тай
- Үйл ажиллагааны түвшинд АМГ-тай

Хэрэгжүүлэлтийн болон өдөр тутмын үйл ажиллагааны түвшинд АМГ-ын БУ-н тасагтай нягт харилцаатай ажиллана.

Төслийн удирдах хороо

Төслийн үйл ажиллагааны хүрээнд ажиллах асуудлууд болох “*Бичил уурхайн үйл ажиллагааг Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, албан ёсны дэд салбар гэж хүлээн зөвшөөрдөг болгоход дэмжлэг үзүүлэх*” болон БУ-н асуудлыг зохицуулах АМГ-ын нөхцлийг сайжруулах нь хамтрагч байгууллагууд хоорондын

хамтын ажиллагаа шаардагдаж байна. Төслийн эрхэд тулгуурлаж чадавхижуулах арга барил нь төслийн стратегийг бичил уурхайчдыг хөгжүүлэх хэтийн төлөвтэй уялдуулахыг шаардаж байна.

Төслийн Удирдах хороо стратегийн шийдвэр гаргах, төлөвлөгөө тайлан батлах, хамрагч талуудын дотоод зохицуулалтын асуудлуудыг хариуцаж ажиллана.

Төслийн удирдах хороонд бүх хамтрагч талуудын төлөөллийг оролцуулах хэрэгтэй. Удирдах хорооны гол гишүүд нь хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан талууд байх ёстой ба төслийн удирдлагаас гадна дараах талуудын **төлөөлөгчид** орсон байх ёстой. Үүнд:

- о Өөр салбарыг хариуцсан төрийн захиргааны байгууллагыг (яам, агентлагууд) төлөөлж дор хаяж нэг гишүүн
- о Бүсийн болон орон нутгийн засаг захиргааг төлөөлж дор хаяж нэг гишүүн
- о БУ-ын байгууллагуудыг (ТББ, олон нийтэд суурилсан компаниуд) төлөөлж дор хаяж хоёр гишүүн (3 байвал илүү сайн)
- о ТББ-ын салбарыг төлөөлж (иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагууд, уул уурхайн компаниуд) дор хаяж нэг гишүүн байна.

Нийт бичил уурхайчдыг нэгтгэсэн дээвэр байгууллага байгуулагдмагц БУ-н салбараас нэг гишүүнийг ардчилсан байдлаар сонгох буюу дэвшүүлэх хэрэгтэй.

Удирдах хорооны гишүүдийн тоог хаягаарлахгүй ба уг хороо дор хаяж жилд нэг удаа хуралдах ёстой. Удирдах хороо хурлын ирцийн хүчинтэй байдал болон хуралдах тоог өөрсдөө шийдэх ба удирдах хорооны ажлын удирдамжийг боловсруулж батална.

7.3 Төслийн удирдлагын бүтэц

ТБУТ-ийн менежмент

Төслийн үйл ажиллагааны төлөвлөлтийн явцад янз бүрийн менежментийн бүтцэд дүн шинжилгээ хийсэн. Хамгийн тохиромжтой хэлбэр нь **Төслийн үндэсний захирлаар** (ТЗ) удирдуулсан бүтэц юм. ТЗ нь гадны хамтрагч талуудтай тулж ажиллан олон нийтийн дунд төслийн нүүр царай болон олон нийт болон бодлогын түвшинд хэлэлцэх чухал байр суурьтай хүн байна. ТЗ-ийг төслийн багийг удирдан, олон улсын туршлагыг нэвтрүүлэн төслийн хэрэгжүүлэлт, удирдах, төлөвлөх болон хянах ажлыг хариуцан ажиллах **Төслийн олон улсын менежер** (ТМ) дэмжиж ажиллана.


ТЗ болон ТМ нар “ТБУТ-ийн менежмент”-ийн өмнөөс хамтарч тайлагнахаас гадна тус тусдаа ШХА болон Төслийн удирдах хороонд тайлан хийнэ.

Төслийн баг

Төслийн багийг төслийн хоёр бүрэлдэхүүн хэсгийн ахлах мэргэжилтнүүдийн дэмжлэг бүхий Төслийн менежер удирдана. Хавсралт 8-д бүх ахлах ажилтангуудын ажлын тодорхойлолтыг хураангуйлан оруулсан байгаа.

Бичил уурхайн бодлого, албажуулалтын ахлах мэргэжилтэн нь БУ-н бодлогын бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааг хариуцаж ажиллахаас гадна Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсгийн ажлын хүрээнд бичил уурхайчдад хууль эрх зүйн талаар зөвлөгөө өгөх ажлыг хариуцна. БУ-н бодлогын бүрэлдэхүүн хэсгийн ажлын хүрээнд ахлах мэргэжилтэн олон нийт болон бодлогын түвшинд төслийг төлөөлөх ТЗ-тай хамтын ажиллагааг чухалчилна. Энэ зорилгоор ахлах мэргэжилтэн ТЗ-ийн доор ажиллах Бодлого ба харилцааны зөвлөхтэй баг болж ажиллана.

Бичил уурхайчдын хөгжлийн ахлах мэргэжилтэн нь Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсгийн ажлыг хариуцахаас гадна БУ-н бодлогын бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааны хүрээнд техникийн болон нийгэм-соёлын талын зөвлөгөөгөөр ТМ-ийг дэмжинэ.²⁵



Зураг 1: ТБҮТ-ийн бүтэц зохион байгуулалт, менежмент

Бичил уурхайн бодлого, албажуулалтын ахлах мэргэжилтэнд тавигдаж байгаа хэрэгжүүлэлтэд чиглэсэн ур чадварын шаардлага нь хагас цагаар ТЗ-тай шууд холбоотой ажиллах **Бодлого ба харилцааны зөвлөхийн** оруулах хувь нэмэртэй дэмжин бүрэлдүүлэх юм.

Хоёр бүрэлдэхүүн хэсэгт туршлагажсан хэрэгжүүлэлтийн **мэргэжилтнүүдийг** Төслийн хэрэгцээ шаардлага дээр үндэслэн авч ажиллуулах шаардлагатай. Үйл ажиллагааг **хэрэгжүүлэх баг** нь ШХА-тай гэрээ бүхий 4 мэргэжилтэн болон АМГ-аас **төслийн үйл ажиллагаанд оролцуулахаар томилсон 2 мэргэжилтнээс** бүтнэ. ШХА-ийн гэрээт

²⁵ “Community mining experts” are not easy to identify, as this qualification is the outcome of years of practical field experience with artisanal miners, which results in interdisciplinary technical and social expertise. The Project needs therefore the flexibility either to contract one high-level Senior Community Mining Expert, or to join the expertise of a Community development- and a Mining and environment expert.

ажилтангуудын мэргэжил чадвар нь АМГ-аас томилсон мэргэжилтэнгүүдийн дадлага туршлагыг дэмжин бүрэлдүүлэх хэмжээнд байх ёстой.

АМГ-ын БУ-н тасгаас ашигт малтмалын зохицуулалтын талаар бүсийн болон орон нутгийн засаг захиргаанд үзүүлж байгаа дэмжлэгийн түвшинээс хамаарч албажуулалт болон эрх зүйн асуудлаар 1-2 мэргэжилтэн хэрэг болно. Тэдний гол үүрэг нь БУ-н үйл ажиллагааг албажуулах үйл явцад БУ-чид болон орон нутгийн засаг захиргаанд дэмжлэг үзүүлэх явдал юм. 4-5 мэргэжилтэнгүүд бичил уурхайчдын болон тэдний байгууллагуудын техникийн, байгаль орчны, болон нийгэм-зохион байгуулалтын талаарх чадавхийг бий болгох, сайжруулах ажлуудыг хариуцаж ажиллах шаардлагатай болно. Энэ хувиарлалт нь зөвхөн чиглүүлэх зориулалттай ба төслийн зүгээс тухайн үеийн хэрэгцээ шаардлагаас хамаарч багийн бүрэлдэхүүнийг жил жилээр тохируулж ажиллах талаар уян хатан байх хэрэгтэй. Саяхан батлагдсан хуулийг дагалдан албажуулалтын үйл явцын эхний үе шатны үед хууль эрх зүй болон техникийн хэрэгжүүлэлтэд илүү хүн хүч хэрэгтэй байж болох ба хэсэг хугацааны дараа зохион байгуулалтад орсон БУ-чдын байгууллагуудад орон нутгийн хөгжлийн талаар илүү дэмжлэг хэрэгтэй байж болох юм.

Үйл ажиллагааг хэрэгжүүлэгч баг **гадаад нөөц бололцоог ашиглах** замаар өргөжинө. Төлөвлөсөн ажлыг хэрэгжүүлэх зорилгоор үр дүнд чиглэсэн богино хугацааны уян хатан чанартай гэрээг үйл ажиллагааны шаардлагын дагуу шаардлагатай мэргэжлийн хүмүүс болон байгууллагатай хийнэ. Үүнд:

- **Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд** (иргэний нийгмийн салбарын дотоодын ТББ, хувийн болон улсын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, зөвлөгөө өгөх байгууллагууд гэх мэт): Хэдийгээр эдгээр байгууллагуудын мэргэжил, ур чадвар, асуудалд хандах хандлага нь хамтрагч талуудын дүн шинжилгээгээр дунджаар сул гэж дүгнэгдсэн боловч эдгээрийн зарим байгууллагууд нь үндэсний чанартай нов-хау болон мэргэшсэн үйлчилгээг үзүүлж чадна²⁶. Тэдний төсөлтэй үйл ажиллагаагаар холбогдох нь гүйцэтгэх явцад суралцах замаар чадавхийг сайжруулах явдал гэж үзэж болох ба энэ нь БУ-н талаар үндэсний бат бөх эзэмшилтэй болоход чиглэсэн чухал алхам юм.
- **Зөвлөх:** Бусад олон төслүүдэд бие даасан зөвлөхүүд нь бичил уурхайчдад чиглэсэн чанартай үйлчилгээ үзүүлэх боломжтой гэдгийг харуулсан. Зөвлөхүүд нь голдуу “хүрч болохуйц” үр дүнд чиглэн ажилладаг. БУ-н асуудал нь бие даасан зөвлөхүүдийн анхаарлыг татахуйц зах зээлийн нэг хэсэг юм. Хэрэв үйлчилгээний гэрээнүүд нь БУ-ийн байгууллагуудын шугамаар хийгдсэн бол бие даасан зөвлөхтэй ажиллах нь бичил уурхайчдын чадавхийг бэхжүүлэх, эрх мэдэлжүүлэх ажилтай бүтээлчээр нэгдэх боломжтой юм. Харин ажлын удирдамж боловсруулах, зөвлөхийг сонгох, гэрээ хийх, гарах үр дүнг тодорхойлох, төлбөр хийх зэрэг ажлуудыг БУ-ын байгууллагууд өөрсдөө төслийн зааварчлага, дэмжлэгтэйгээр хийх хэрэгтэй. Иймэрхүү ашиг тус хүртэгсэдийн шууд хэрэгжүүлэлт нь үүнд суралцах хосгүй боломж юм.

Төлөвлөгөөт ажлыг бие даасан зөвлөхөд гэрээлүүлэн гүйцэтгүүлэх нь төслийн 1,2-р үе шатны хэрэгжүүлэлтийн үед ажиллаж байсан хүмүүсийн олж авсан чадавхийг татан оруулах боломжийг бий болгоно. Ямар ч нөхцөлд төслийн хуучин ажилтангууд нөхцөл байдал болон төслийн хэрэгжүүлдэг газрууд дахь хамтрагч талуудыг мэддэг, танил байдаг. Энэ мэтийн харьцангуй давуу талуудыг “хувийн ашиг сонирхол” гэж үзэхээсээ илүүтэйгээр эдгээр шаардлага хангасан мэргэжилтэнгүүдийг БУ-н салбарт хадгалан үлдээх боломж гэж хандууштай.

- **Үе тэнгийхний сургалт:** БУ-н салбарын хүн амын байдал нь маш их ялгаатай. Хэдийгээр БУ-чдын ихэнх нь урьд нь малчин байсан иргэд байдаг боловч тэдний дунд эдийн засагч, иженер, хуульч болон бусад мэргэжлийн хүмүүс байх нь элбэг тохиолддог. Тэр ч байтугай жирийн бичил уурхайчин мөртлөө гайхмаар өргөн мэдлэг туршлагатай хүн байх нь тохиолддог. Иймээс боломжтой

²⁶ See outcomes of the planning workshop in **Error! Reference source not found.**: “Offers” from the NGO and Academics group.

тохиолдолд төсөл тэдний мэдлэг туршлагыг бусдад зааж сургах чиглэлд ашиглах хэрэгтэй. Иймэрхүү сургагчид нь голдуу өөрсдийн мэдлэг туршлагаа үндэслэн сургадаг учраас хамгийн үр дүнтэй байдаг.

Захиргааны ажигтангууд нь нарийн бичиг, нягтлан бодох, ерөнхий үйлчилгээ үзүүлэгч жолооч болон туслах ажилтангаас бүрдэнэ.

Орчуулагч нь хоёр чиглэлийн үүрэгтэй. Энэ нь захиргааны ажилтны байр суурьнаас гадаад харилцаа холбоо болон ШХА-ийн удирдлагатай холбох үүргүүдийг гүйцэтгэхээс гадна үйл ажиллагааны багийн нэг хэсэг болж олон улсын туршлагыг хүргэх үүргийг гүйцэтгэнэ.

Зөвлөх үйлчилгээ

ТБУТ-ийн багийнхны хийх үүрэгт ажлаас бусад онцгой ажлыг хийж гүйцэтгэхэд төслийн менежмент **үндэсний болон олон улсын мэргэжилтэнтэй богино хугацааны гэрээ** хийж ажиллуулж болно.

Богино хугацааны үндэсний зөвлөхийн хийж гүйцэтгэх ажил болон ур чадвар нь дээр дурдсан гадаад нөөц бололцоог ашиглаж хэд хэдэн хэлбэрээс бүрэн ялгаатай байх хэрэгтэй. Учир нь гадаад нөөц бололцоог ашиглах нь хэрэгжүүлэлтийн хүчин чадлыг нэмэгдүүлэх (аерэг нөлөө үзүүлэх нэмэгдэл хүч, туршлага) асуудал байдаг бол мэргэжлийн дэмжлэг нь тусгайлсан мэргэшил, чадвар, туршлага буюу өөрсдийн хүчээр гүйцэтгэх боломжгүй нүх цоорхойг бөглөхөд чиглэсэн байдаг. Үндэсний зөвлөхийн гэрээг төслийн менежмент хийнэ.

Олон улсын тусгай зөвлөхийг төслийн менежмент болон ахлах мэргэжилтэнгүүдэд дэмжлэг хэрэг болсон цагт төслийн менежментийн хүсэлтээр юмуу эсвэл ШХА-ийн санаачлагаар ШХА-р дамжуулан урьж ажиллуулна. Уригдаж ирсэн олон улсын зөвлөх зөвхөн төслийн багийнханд дэмжлэг үзүүлээд зогсохгүй өөрсдийн мэргэжлийн чиглэлийн дагуу бусад хамтрагч талууд, ашиг шим хүртэгсэд, ЭБЭХЯ, АМГ болон бүсийн болон орон нутгийн засаг захиргааны холбогдох хүмүүстэй нягт холбоотой ажиллаж тэдний чадавхийг бэхжүүлэх, сэтгэхүйд БУ-н асуудлын талаар зөв ойлголт суулгахад чиглэж ажилласнаар тодорхой үр дүнд хүрэх ёстой.

Хамтран хэрэгжүүлэгч талын ажилтангууд

Үйл ажиллагааны түвшинд АМГ-аас ТБУТ-д томилогдож ажиллах мэргэжилтэнгүүдээс гадна ЭБЭХЯ, АМГ зэрэг **хамтрагч талын ажилтангууд** төслийн үйл ажиллагаанд нягт холбогдож ажиллана. Мөн түүнчлэн аймаг, сумын холбогдох ажилтангууд, УУАА, бусад салбар яамдын холбогдох ажилтангууд болон бусад төсөл хөтөлбөрүүд, хамтрагчид болон санаачлагчид төслийн үйл ажиллагаатай холбоотой ажиллана.²⁷ Зарим тохиолдолд эдгээр мэргэжилтэнгүүдийг ТБУТ-д томилож ажиллуулж болох юм.

- АМГ-ын **БУ-н тасгийн** ажилтангуудын ажил үүрэг нь бичил уурхайчдад хууль эрх зүйн, техникийн, байгаль орчны, бизнесийн, болон олон нийтийг хөгжүүлэхтэй холбоотой дэмжлэг туслалцаа үзүүлэх зэрэг болно. Төслийн зүгээс БУ-н тасгийн үйл ажиллагааг БУ-чдын байгууллагаар дамжуулан оролцох замаар дэмжих ба харин тасгийн үүрэг хариуцлагыг хүлээн гүйцэтгэх ажлыг нь орлож хийхээс зайлсхийх хэрэгтэй. Хамтрагч талын чадавхийг бэхжүүлэх замаар төсөл үйл ажиллагаагаа цагт нь хүлээлгэж өгөх боломжтой болно гэж тооцоолж байгаа.
- **УУАА** нь уул уурхайн аюулгүй ажиллагаа, аврах чиглэлээр мэргэжсэн байгууллага юм. УУАА-тай хамтын ажиллагаа нь мөн нэмэлт, дэмжлэгийн зарчмыг баримтална. Төслийн тэдэнд хандсан чадавхийг бэхжүүлэх хувь нэмэр нь тус байгууллагын үйл ажиллагааны БУ-д холбоотой нүх, цорхойг нөхөх болон түүнийг даван туулахад чиглэнэ.
- Бичил уурхайтай холбоотой хуулийн төсөл батлагдсанаас хойш **сум, аймгийн засаг захиргаа** хууль ёсны БУ-р ашиглах ашигт малтмалын шууд хариуцах нэгж

²⁷ Counterpart staff from MRAM, MRS and local and regional Government was already tightly integrated in the planning of Phase 3, accompanying and supporting all fieldwork of the external consultant.

болж байна. Үүрэг хариуцлагын төвлөрөлийг бууруулах (БУ-чдын нөхөрлөлийг бүртгэх, нөхөрлөлүүдэд газар хувиарлах г.м.) үйл явц эхэлсэн ба чадавхийг дамжуулах үйл ажиллагаа хийгдэх хэрэгтэй байна. ТБУТ бүсийн болон орон нутгийн захиргааны албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэн эрдэс баялагийг зохистой ашиглахад хувь нэмэр оруулна. Энэ ажлыг нэмэгдэл буюу орлох зарчмын дагуу төслийн зүгээс дэмжих ба төслийн ажилтангууд үүнийг дангаараа хийлгүй яам болон АМГ-ыг албан ёсоор эрх мэдлийнх нь дагуу татаж оролцуулах ёстой.

Бусад яам, тусгай газруудтай ажиллах арга барил, хэлбэр нь тухайн ажлын онцлогт үндэслэн төлсийн менежментийн зүгээс тохируулах ёстой. Тэдний байгууллагын эрх мэдлийн хүрэн дэх үйл ажиллагаанд идэвхитэй оролцох нь уг асуудалд бат бэх үндэсний эзэмшилтэй болох чухал алхам болно²⁸.

Харилцаа холбоо

Хамтран хэрэгжүүлэгч талтай нягт холбоотой ажиллах талаар бидний хүсэн хүлээж байгаа хэмжээнд хүрэхэд зөвхөн төслийн менежмент болон ажилтангууд харилцагч талуудтай чөлөөтэй харьцдаг байгаад зогсохгүй таатай байдлаар дэмжсэн, тэдний бүтээлч хамтын ажиллагаа, харилцаа холбоог үнэлсэн нөхцөл байдлыг бүрдүүлэх хэрэгтэй.

- Төслийн захрал ЭБЭХЯ, АМГ-ын бодлогын болон үйл ажиллагааны түвшний бүх албан тушаалтангуудтай чөлөөтэй харьцдаг байх (Тухайлбал, салбарын сайд болон түүнээс доод албаны хүмүүс)
- Төслийн менежер ЭБЭХЯ, АМГ-ын бүх өндөр албан тушаалтангуудтай чөлөөтэй харьцдаг байх (Тухайлбал, АМГ-ын дарга ба түүнээс доод албаны хүмүүс)
- Ахлах мэргэжилтэнгүүд ЭБЭХЯ, АМГ-ын бүх ахлах мэргэжилтэнгүүдтэй чөлөөтэй харьцдаг байх (Тухайлбал, АМГ-ын БУ-н тасгийн болон бусад тасгуудын дарга ба түүнээс доод албаны хүмүүс)
- Мэргэжилтэнгүүд ЭБЭХЯ, АМГ-ын бүх мэргэжилтэнгүүдтэй чөлөөтэй харьцдаг байх (Тухайлбал, АМГ-ын БУ-н тасаг болон бусад тасгуудын мэргэжилтэнгүүд)

7.4 Ижил хүсэл зорилго бүхий байгууллагуудтай хамтарч ажиллах

ESEC-Азийн сан

2010 оны 8-р сараас эхлэн Азийн сангаас 3 жилийн хугацаатай байгаль хамгаалах болон байгалийн баялагийг хариуцлагатай ашиглахад чиглэсэн “Байгаль орчныг хамгаалахад олон талын оролцоог хангах нь” төслийг хэрэгжүүлж эхэлнэ. Энэ төсөл нь засаглал болон иргэдийн үйл ажиллагаа нь Монгол улсын урт хугацааны өргөн хүрээтэй хөгжилд чухал үүрэг гүйцэтгэнэ гэсэн ухагдахуунд суурьлаж зохиогдсон төсөл юм. Эн төслийн хөтөлбөр нь хоорондоо холбоо бүхий 4 бүрэлдэхүүн хэсэгт хуваагдсан. Үүнд: 1. Хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг амьдралд үйл хэрэг болгох/төлөвшүүлэх, 2. Орон нутгийн түвшинд байгалийн нөөцийг ашиглахад олон талуудын оролцоог хангах, 3. Байгаль орчныг хамгаалах нөлөөлөл чадавхийг сайжруулах, 4. Байгаль орчин болон усны чанарыг хянах үйл ажиллагааг институтчилах.

Азийн сан болон ШХА ESEC болон ТБУТ-ийн хооронд хэд хэдэн нийтлэг шинж чанар байна гэдгийг олж харж байна. Жишээлбэл, ESEC хөтөлбөр орон нутгийн түвшинд олон талуудын оролцоог ханган хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг амьдралд хэрэгжүүлэхээс гадна байгаль орчныг хамгаалахад нөлөөлөл үзүүлэх талаар ажиллана. Энэ нь ТБУТ-ийн хариуцлагатай бичл уурхайг хөгжүүлж байгаль орчинд үзүүлэх хор нөлөө болон зөрчлийг багасгах, орон нутгийн түвшинд байгалийн баялагийн

²⁸ Жишээлбэл: “ногоон технологи” хэрэглэхийг чухалчилж шаарддаг БОАЖЯ технологийн талын асуудлуудад идэвхитэй оролцох шаардлагатай юм. Хэрэв тус яамны зүгээс одоо байгаа технологийг хангалттай “ногоон” биш байна гэж үзэж байгаа тохиолдолд яг хэрхэн яаж сайжруулах талаар бодитоор харуулах боломжтой байх хэрэгтэй.

ашиглалтыг оролцооны аргаар хянах хэрэгсэл нэвтрүүлэх гэсэн санаачлагуудтай нийцэж байгаа юм.

ESEC-тэй хамтран ажилласнаар **ТБУТ-ийн үйл ажиллагааны нэг хэсгийг** хэрэгжүүлж байгаа гэж үзэж болох юм. Азийн сангаас нарийвчилсан саналын төсөл боловсруулж ШХА-д хүргэнэ.

Мэргэжлийн сургалтын төсөл (МС)-ШХА

2010 оны 10-р сараас ШХА-аас мэргэжлийн сургалтын төслийн төлөвлөлтийн ажлыг эхлэх ба энэ төсөл нь хөдөөгийн залуучуудад мал маллахаас өөр чиглэлээр ажиллах боломж олгоход чиглэсэн. ТБУТ албан ёсны мэргэжлийн сургалт нь БУ-н үйл ажиллагааг мэргэшүүлэх замаар чадавхи бий болгох үндсэн элемент гэж үзэж байгаа бөгөөд БУ-н үйл ажиллагаа нь хөдөөгийн залуучуудад хамгийн ойр дөт, бэлэн байгаа ажлын байр юм.

ТБУТ болон Мэргэжлийн сургалтын төсөл хоёрын ирээдүйн хамтын ажиллагааг уг төслийн төлөвлөлтийн явцад илүү нарийвчлан гаргах болно. ТБУТ БУ-н мэргэжлийн сургалтын төлөвлөгөө гаргахад тодорхой хувь нэмэр үзүүлэх туршлагатай учраас МС-н төсөл нь энэ мэргэжлийг Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд хэрэгжүүлэх илүү боломжтой байж болох юм. МС-ийн хамтрагч талууд нь уурхайн ажил нь малчдад хамгийн чухал ажлын байрны гэсэн ойлголттой болох ба ТБУТ-ийн зарим хамтрагч талууд нь бичил уурхайчдад хамгийн тохиромжтой ажлын боломж нь мал маллах юм гэж тогтохоос зайлсхийх зорилгоор хоёр төсөл хамтран нийтлэг бодлого боловсруулан баримтлах шаардлагатай. Хэрэв нэгэн хэсэг хүмүүсийг будилуулан урагш хойш нь гүйлгээд байвал үр дүн хэзээ ч гарахгүй билээ.

Бичил уурхайн алтны шудрага худалаа ба шудрага олборлолт-ARM ба FLO

Шудрага худалдааны системд нэгдэх нь ТБУТ-ийн оролцооны стратегийн хамгийн гол хэсэг юм. ARM ба FLO-ийн Бичил уурхайн алтны шудрага худалаа ба шудрага олборлолтын холбооноос өөрсдийнхөө үйл ажиллагааны газар зүйн хүрээнд Монгол улсыг урьдчилан оролцуулах талаар хүсэл эрмэлзэлтэй байгаа гэдгээ илэрхийлсэн (Хавсралт 3).

Үйлдвэрлэгчдийн дэмжлэгийн сүлжээнд орсноор ТБУТ энэ системд элсэн орж үйл ажиллагаагаа эхлүүлсэн орнууд болох Өмнөд Америкийн Колумби, Эквадар, Перу, Волив (гэрчилгээ авах үе шатандаа хэдийнэ хүрсэн); Африкийн Танзани, Уганда, Гана (одоогийн байдлаар стандартыг туршиж хэрэгжүүлэн үйлдвэрлэгчдийн эхний дэмжлэгийг авах шатанд байна) зэрэг орнуудын туршлагаас суралцаж болно. Үйлдвэрлэгчдийн дэмжлэгийн сүлжээнд орох гэдэг нь ерөнхийдөө хамтран ажиллах ба харилцаа холбоо тогтоох асуудал юм. Үүний гишүүнчлэлийн татвар төлөхгүй. Үүнтэй адилаар ARM ба FLO-ийн холбооноос Монголд явуулах үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжгүй ба Шудрага худалдааны системтэй холбоотой бүх үйл ажиллагаанууд ТБУТ-ийн санхүүжилтанд орох ёстой. Хэрэв Монгол улсад Бичил уурхайн алтны шудрага худалаа ба шудрага олборлолтын холбооноос болон бие даасан нэгжээс тодорхой дэмжлэг хэрэгтэй болсон тохиолдолд ТБУТ-тэй гэрээ хийх ёстой.

Бусад холбогдох төслийн үйл ажиллагааны хүрээнд төр болон хувийн хэвшлийн түншлэлийн арга боломжтой юм. Яваандаа Перугийн Амазонкд *Terre des Hommes Suisse* болон гоёл чимэглэлийн *Transparence SA* компанитай хамтран ШХА-ийн хэрэгжүүлдэг “projet-pilote d'or йthique” (зүй ёсны алт төсөл)-ийн тушлагыг авчирч нэвтрүүлж болох юм. *Transparence SA* компани нь зарим бүтээгдэхүүнийхээ түүхий эд болох алтыг яг одоо Шудрага худалдааны гэрчилгээ авах үйл явцад байгаа Колумбийн (Oro Verde®) БУ-аас авч байна.

8. Хяналт ба үнэлгээ

Мониторинг

Төслийн үйл ажиллагааны хөгжил дэвшлийг үйл ажиллагааны шатанд төлөвлөгөөний дагуу гарах үр дүн, бүтээмжид онцгой анхаарсан хагас жилийн тайлангаар бичиг

баримтжуулж Удирдах хороонд хүргэнэ. Харин илүү тодорхой илтгэсэн жилийн тайланг төслийн Удирдах хороо батлана.

Мониторинг хийх зорилгоор тоо баримт цуглуулах үйл явцыг хэтэрхий хүнд, их ажил, санхүүжилт шаардсан байдлаар явуулах шаардлагагүй юм. Харин голдуу гарсан онцгой үйл явдлаар монитор хийх нь зүйтэй юм. Энэ нь энгийн хэлбэрээр “хүрсэн” ба “хүрээгүй” гэж дүгнэх боломж олгоно. Үүнтэй адилаар энэ нь төслийн үр дүнг амархан үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтоож утга учиртай ойлголт өгөх юм.

Мониторингийн үр дүнг үйл ажиллагаанд хүргэх шаардлагатай төслийн үйл ажиллагаа хэргэждэг газруудад (Борнуур, Бөмбөгөр, Жаргалант, Мандал) дээр дурдсан энгийн мониторингийн арга барилыг хэрэглэхгүй байвал зохино. Учир нь төслийн тулж ажилладаг газруудад гарсан өөрчлөлтүүд нь үр дүнгийн шатанд бодит, харагдахуйц байх ёстой гэж үзэх нь зүй ёсны асуудал юм. Иймээс гарсан өөрчлөлтийг хэмжиж хянахдаа суурь судалгаанд тулгуурлах, бүх газруудад ижил аргачлал хэргэлэн хяналтыг байнга хийх нь чухал юм. Иймэрхүү суурь судалгааг хийхэд хэрэг болохуйц аргыг “амьжиргааны орлогын үнэлгээ”-ээс харж болно. 3-р үе шатны үйл ажиллагаа эхлэхэд төслийн бүх сайтууд дээр суурь судалгаа хийх хэрэгтэй ба төсөл үйл ажиллагаагаа өргөсгөж шинэ сайтанд орох болгондоо суурь судалгааг явуулах нь чухал юм. Амьжиргааны орлогын үнэлгээг жил бүр төлөвлөгөөндөө оруулж хийх шаардлагатай ба энэ нь тухайн газар цаашид үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулах эсэхийг шийдэхэд үндэслэл болж өгнө.

Шудрага худалдааны системтэй бичил уурхайчдыг холбох, энэ талаар явуулах төслийн үйл ажиллагаа үүнтэй зохицсон мониторингийн чиглэлийг шаардаж үнэлгээнд хязгаарлалт тавьж байна. Бичил уурхайн алтны шудрага худалаа ба шудрага олборлолтын стандарт нь дэлхийн хэмжээний стандарт ба Монголын бичил уурхайчдын үйл ажиллагаа болон төслийн ололт амжилтыг дэлхийн бусад орнуудын тэргүүн туршлагаудтай харьцуулж үзэх боломжийг олгоно. Стандартыг гэрчилгээжүүлэх нь бие даасан мэргэжлийн гуравдагч этгээдээр хийгдэнэ (FLO-CERT GmbH, an ISO 65 accredited certifier). ARM ба FLO-ийн БУ-чдын байгууллагуудын үйлдвэрлэгчдийг дэмжиж гэрчилгээжүүлэхэд зориулан боловсруулсан бусад хэрэгсэлүүдийг мониторинг хийхэд оруулж болно.

Үнэлгээ

Төслийн үйл ажиллагааны 2 дахь жилийн төгсгөлд (2013 он) дотоодын дунд шатны үнэлгээ хийх хэрэгтэй ба энэ нь үйл ажиллагааны цаашдын төлөвлөгөөнд тохируулга хийх боломж бүрдүүлнэ.

Гадны үнэлгээг төслийг дуусгах, гарах болон 2014 оноос хойш хүлээлгэн өгөх төлөвлөгөөнд оруулах хэрэгтэй юм.

9. Төсөв ба нөөц бололцоо

Төслийн үйл ажиллагаанд оруулах Монгол улсын хувь нэмрийг Монгол талын хамтрагч талууд захиран зарцуулах ба Швейцарийн хувь нэмрийг ШХА захиран зарцуулна. Бүх талууд оруулсан хувь нэмрээ өөрсдийнхөө дотоод зарчмын дагуу зарцуулна.

9.1 Швейцарийн оруулах хувь нэмэр

3-р үе шатны үйл ажиллагааны үргэлжлэх 4 жилийн хугацаанд ШХА-аас 4.5 сая Швейцарь франкийн (ШФ) хувь нэмэр оруулна.

Төсөл голдуу ашиг шим хүртэгчид, хамтрагч талууд, харилцагч талуудад чиглэсэн зөвлөгөө өгөх, чадавхи бэхжүүлэх чиглэлийн үйл ажиллагааг явуулна. Тоног төхөөрөмж гэх мэт материаллаг зүйлээр дэмжлэг үзүүлэх нь төслийн чухалчлан үзэх асуудал биш ба зөвхөн Монголын хамтрагч талуудад чадавхийг сайжруулахад чухал хэрэгтэй тохиолдолд төсөвт оруулна.

Энэ төсөв нь Швейцарийн оруулах нийт хувь нэмэр юм. Бүрэлдэхүүн хэсгүүдэд хувиарласан хувиарлалт нь зөвхөн баримжаагаар²⁹ хийгдсэн ба энэ нь хоёр бүрэлдэхүүн хэсгийн нягт хамтын ажиллагааг бэхжүүлнэ. Нарийвчилсан төсвийг хавсралтад оруулсан. Швейцарь дахь ШХА-ийн төвийн болон Улаанбаатар дахь ШХА-ны захиргааны зардлыг бэлэн бусаар оруулсан ба төслийн төсөвт тусгаагүй болно.

Нийт төсөв, хувиарлалт – Бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр

	Тодорхойлолт		Нийт	БХ1	БХ2	Захиргаа
1.1	Төслийн ажлтангуудын цалин хөлс		1'326'000	527'800	675'480	122'720
1.2	Олон улсын + дотоодын зөвлөх		552'200	220'880	331'320	-
1.3	Захиргааны ажлтангуудын цалин		244'400	-	-	244'400
1.4	Ажилтангууд + зөвлөхийн томилолт		643'000	165'180	267'520	210'300
1.5	Төслийн тоног төхөөрөмж худалдан авах		458'800	26'000	405'000	27'800
1.6	Төслийн үйл ажллагаа явуулах зардал		975'600	257'500	542'000	176'100
2.1	Үйл ажиллагааны хэсэг 3-ын зардал		300'000	150'000	150'000	-
		Нийт	4'500'000	30%	53%	17%

Төсвийг жил тус бүрээр гаргасан байдал

Pos	Тодорхойлолт		жил 1	жил 2	жил 3	жил 4	Нийт
1.1	Төслийн ажлтангуудын цалин хөлс		325'455	329'485	333'515	337'545	1'326'000
1.2	Олон улсын + дотоодын зөвлөх		110'440	165'660	165'660	110'440	552'200
1.3	Захиргааны ажлтангуудын цалин		59'267	60'489	61'711	62'933	244'400
1.4	Ажилтангууд + зөвлөхийн томилолт		143'900	179'400	180'000	139'700	643'000
1.5	Төслийн тоног төхөөрөмж худалдан авах		133'460	144'720	109'320	71'300	458'800
1.6	Төслийн үйл ажллагаа явуулах зардал		285'133	223'311	234'489	232'667	975'600

²⁹ Most cost items serve both components and some even cover administrative components. E.g.: the Project Manager oversees both components and the Project administration. In consequence, the attribution of budget items in percentages to components is subject to subjective criteria and therefore not binding.

2.1	Үйл ажиллагааны хэсэг 3-ын зардал		100'000	100'000	100'000	-	300'000
		Нийт	1'157'655	1'203'065	1'184'695	954'585	4'500'000
			26%	27%	26%	21%	100%

9.2 Монголын талын оруулах хувь нэмэр

ЭБЭХЯ ба үүний агентлагийн оруулах хувь нэмэр

Төлөвлөлтийн семинарын (**Error! Reference source not found.**) үед Монголын төрийн байгууллагуудыг төлөөлж оролцсон оролцогсодоос гарсан санал болгох зүйлс болон шаардлага, ЭБЭХЯ-аас ШХА-д илэрхийлсэн санал хүсэлтэнд ТБУТ хариулж байна.

Монголын талын оруулах хувь нэмэр нь 700,800 Ам. Доллартай тэнцүү ба бэлэн бус хэлбэрээр хийгдэнэ. Үүнээс төв засгийн газрын оруулах хувь нэмэр нь 200,000 Ам.Доллар, бүсийн болон орон нутгийн захиргаанаас 100,800 Ам.Доллар, ашиг тус хүртэгчдээс 400,000 Ам.Долларын хувь нэмэр оруулна. Хамтрагч талууд өөрсдийн оруулж буй хувь нэмрийг тухайн байгууллагын дүрэм журмын дагуу захиран зарцуулна. Үүн дээр нэмэгдээд төсөл нь БУ-д Шудрага зах зээлийн орлого болох 1 сая Ам. Долларыг жил бүр нэмж оруулах боломжтой юм.

Тэмдэглэл: (₮-Монгол Улсын мөнгөний нэгж-Төгрөг)

Тодорхойлолт	2011	2012	2013	2014	Total
Ажилтангуудын цалин	19,000,000	19,500,000	20,000,000	20,500,000	79,000,000
Хөрөнгө/хогшил	46,415,000	22,000,000	5,650,000	0	74,065,000
Томилолтын зардал	9,000,000	9,500,000	10,000,000	10,500,000	39,000,000
Байрны түрээс	35,000,000	38,500,000	42,435,000	46,500,000	162,435,000
Хямдрал/чөлөөлөлт	10,000,000	11,000,000	12,000,000	12,500,000	45,500,000
Монголын талын нийт хувь нэмрийн хэмжээ	119,415,000	100,500,000	90,085,000	90,000,000	400,000,000 ₮ (equal to 300,800 USD by the date)
Швейцарийн оруулах нийт хувь нэмэр					4.5 Mio CHF

Ерөнхий үнэлгээ

ЭБЭХЯ-с АМГ БУ-н тасаг болон УУАА-нд хувиарлах төсвийн хэмжээ төсөл хэрэгжиж дуусах үед багасахгүй гэдэгт баталгаа өгч байна.

Тиймээс ЭБЭХЯ-наас оруулж буй хувь нэмэр нь 200,000 Ам. Долларын хүрээнд байна. Яам болон агентлагийн захиргааны зардлыг бэлэн бусаар оруулсан тул төслийн төсөвт суулгаагүй болно.

Бүсийн болон орон нутгийн засаг захиргаанаас оруулах хувь нэмэр

ТБУТ бат бөх үндэсний эзэмшил бий болгож байна. Сум, аймгийн засаг захиргаа нь үндсэн хамтрагч талууд ба төслийн хэрэгжилтэнд нягт холбоотойгоор оролцдог. Орон нутгийн засаг захиргаа нь ШХА болон ЭБЭХЯ-ны хооронд байгуулах төслийн гэрээний тал биш учир тэдний оруулах хувь нэмэр нь зарчмын хувьд зөвхөн үзүүлэлт юм.

Хэдий тийм боловч орон нутгийн засаг захиргаа нь төслийн үндсэн хамтрагч тал ба ТБУТ-өөр дамжуулсан хамтын ажиллагаа болон дэмжлэг нь энэ хувь нэмрийг (бэлэн

бус хэлбэрээр боловч) тооцох нөхцлийг бүрдүүлж байна. Төсөл хэрэгжүүлж байгаа аймаг сум болгон төслийн үйл ажиллагаа явуулах байр болон чадавхи бий болгох үйл ажиллагааг орон нутагт зохицуулах үүрэгтэй хагас цагаар ажиллах идэвхижүүлэгч/холбогчоор хангах хэрэгтэй юм.

Иймээс орон нутгийн захиргаанаас оруулах нийт хувь нэмэр нь 100,800 Ам. Доллар байна байх гэж тооцоолсон. (Жилд 25,200 Ам.Доллар)

Орон нутгийн засаг захиргаа	Жилийн зардал (USD)	Жилийн дүн (USD)	Нийт (USD)
Борнуур		5,040	20,160
Оффис	3,040		
Идэвхижүүлэгч	2,000		
Баянхонгор		5,040	20,160
Оффис	3,040		
Идэвхижүүлэгч	2,000		
Жаргалант		5,040	20,160
Оффис	3,040		
Идэвхижүүлэгч	2,000		
Айраг/Налайх		5,040	20,160
Оффис	3,040		
Идэвхижүүлэгч	2,000		
Gov 5		5,040	20,160
Оффис	3,040		
Идэвхижүүлэгч	2,000		
Дүн (USD)			100,800

Ашиг тус хүртэгсэдээс оруулах хувь нэмэр

Төлөвлөлтийн семинарын (**Error! Reference source not found.**) үед ашиг тус хүртэгсэдийг төлөөлж оролцсон оролцогсодоос гарсан “хэрэгцээнд тулгууралсан шаардлага” болон хариуд нь санал болгох зүйлсэд ТБУТ хариулж байна. Тэдний оруулах хувь нэмэр нь бэлэн бус хэлбэртэй байна.

Орон нутгийн төвшинд БУ-чидын зөвхөн зарим хэсэг нь л зохион байгуулалтад орсон учраас тэдний хүсэл эрмэлзэлийг албан ёсоор илэрхийлэх дээвэр байгууллага байхгүй байна. Хариуцлагатай БУ-н байгууллагаас орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр нь тэдний үйлдвэрлэлийн өртгийн 1%-тай, төслийн үйл ажиллагаанд нэг ХАМО-ийн оролцох хугацаа нь жилд 2.5 өдөртэй тэнцүү буюу ажиллах цагийнх нь 1%-тай тэнцүү байна гэж тооцоологдсон³⁰. Хэрвээ ТБУТ бүх ХАМО иргэдийн зөвхөн 5% болох 5,000 ХАМО иргэдэд “манлайлагч”-ийн түвшинд хүрч ажиллаж чадсан тохиолдолд тэдний оруулах хувь нэмэр нь **400,000 Ам.доллар** байна гэж үнэлэгдэж болох юм.

³⁰ Participation in Project activities benefits artisanal miners, but is at the same time their in-kind contribution, to be valued as the opportunity cost of not dedicating this time to minerals extraction. The resulting opportunity cost of 4 USD/day is based on the very conservative estimation of an ASM gold production value of 100 million USD; the real cost is probably considerably higher (Footnote **Error! Bookmark not defined.**).

БУ-н алтны үйлдвэрлэлийн үнэ цэнэ	Хүрч ажиллах	Орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр	Жилийн үнэ өртөг USD	4 жилийн нийт дүн
USD 100 сая	БУ-н алтны үйлдвэрлэлийн 5%	1%	50,000	USD 200,000
БУ-н алтны үйлдвэрлэлийн үнэ цэнэ	ХАМО иргэдийн нийт тоо ба хүрч ажиллах	1 ажлын өдрийн үнэ цэн/Жил 250 хоног ажиллана	5000 ХАМО иргэдийн 2.5 өдрийг USD шилжүүлбэл (5%-д хүрэх)	
USD 100 сая	100,000 бичил уурхайчид; 5% нь хүрвэл	4 USD / day	50,000	USD 200,000
TOTAL				USD 400,000

Иймээс ТБУТ-д Монгол Улсын зүгээс үзүүлэх нийт хувь нэмэр нь 700,800 Ам.доллар байна.

Бусад шууд бишээр оруулах хувь нэмрүүд

БУ-н байгууллагуудын орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр нь Шудрага худалдааны системээс болж огцом өсөх боломжтой. Хэсэг 4.5-д тайлбаласанчлан зөвхөн бичил уурхайгаар олборлосон гэрчилгээтэй 250 кг алтыг жилд үйлдвэрлэснээр төсөл оруулж байгаа Швейцарийн жилийн хувь нэмэртэй тэнцүү хэмжээний тогтмол орлогыг урамшууллаас олж орон нутгийн хөгжилд зориулах боломжтой.

ТБУТ, түүний хамтрагч талууд ARM/FLO-ийн үйлдвэрлэгчидийг дэмжих сүлжээгээр дамжуулан олон улсын хэмжээний мэдлэг дамжуулах болон хуваалцахаас ашиг шим хүртэхээс гадна БУ-н алтны шудрага худалдаа, шудрага олборлолтын холбоог дэмжиж болохуйц мэдлэг туршлагаас ашиг олох боломжтой юм. ТБУТ-ийг олон улсын хэмжээнд зөвшилцөж хүлээн зөвшөөрсөн стандартад тулгуурлан байгуулж болно.

Шудрага худалдаа нь зүй ёсны бизнест тулгуурласан ухагдахуун учраас энэ талаар сонирхосон компаниуд БУ-чидтай бизнесийн холбоо тогтоох давуу сонирхолтой байдаг. Олон улсын зах зээлтэй тогтоох ийм шууд холбоо нь бүх хамтрагч талуудад ашиг тус хүртээх шинэ дадлага туршлагыг авч ирдэг.

Эдгээр шууд бус хувь нэмрүүд нь бүгд бэлэн бус хэлбэртэй учраас тооцоолох боломжгүй юм.

Төслийн бичиг баримт
Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ)
Үе шат 3, 2011 - 2014





ХАВСРАЛТ

Хавсралт 1: Товчилсон үг болон өнгөний кодны жагсаалт

Аймаг	Аймаг
ХУУХ	Хариуцлагатай уул уурхайн холбоо
БУ	Бичил уурхай
БУХ	Борнуур сумын Бичил уурхайчдын холбоо
CASM	Бичил уурхайн олон улсын нийгэмлэг
CHF	Швейцарь франк
CSR	Нийгмийн хариуцлагын нэгдэл
ESEC	Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь
FLO	Олон улсын шударга худалдааны шошго олгох байгууллага
FT	Шударга худалдаа
FT&FM	Шударга худалдаа-шударга олборлолт
HAMO	Хувиараа ашигт малтмал олборлогч- “ХАМО”
Hg	Мөнгөн ус
ILO	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
LSM	Том уул уурхай
MCTIC	Монголын хоршоодын мэдээлэл, сургалтын төв
MDG	Мянганы хөгжлийн зорилт
MMRE	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
MRAM	Ашигт малтмалын газар
MRS	Уул уурхайн аврах алба
MTR	Дунд шатны үнэлгээ
NGO	Төрийн бус байгууллага
NSO	Үндэсний статистикийн хороо
OSH	Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуй
PD	Төслийн захирал
PM	Төслийн менежер
PIU	Төсөл хэрэгжүүлэгч нэгж
SAM	Тогтвортой бичил уурхай төсөл
SDC	Швейцарийн хөгжлийн агентлаг
SCO	Швейцарийн хамтын ажиллагааны газар
SCS	Швейцарийн хамтын ажиллагааны стратеги
Soum	Засаг захиргааны нэгж
TOR	Ажлын удирдамж
USD	Америк доллар
VET	Мэргэжлийн боловсрол сургалтын төсөл
WB	Дэлхийн банк

Зураг болон хүснэгтэд үзүүлсэн өнгөний код:

<u>Байгууллагууд:</u>		<u>Бүрэлдэхүүн хэсгүүд:</u>	
	Төрийн байгууллагууд		Бичил уурхайн бодлогын бүрэлдэхүүн хэсэг
	Бичил уурхайчид		Бичил уурхайчдын хөгжлийн бүрэлдэхүүн хэсэг
	ТББ-д, иргэний нийгэм, судалгааны байгууллагууд		
	Олон улсын байгууллагууд		ТБУТ

Хавсралт 2: Үйлдвэрлэлийн уурхайн салбарын статистик тоо баримт

Эх үүсвэр: Канадын Торонто хотод болсон Олон улсын уул уурхайн конференсэд Монголын уул уурхайн үйлдвэрлэлийн талаар хийсэн танилцуулга, ЭБЭХЯ 2008

Ажиллах хүч 2001: 15,100
 Ажиллах хүч 2008: 45,900
 Бий болсон ажлын байр 2001 – 2008: **30,800**

Хөрөнгө оруулалт 2001 – 2008: $41.6 + 33.2 + 33 + 53 + 82 + 72 + 95 + 133 =$
542.8 Mio USD

Ажлын байр бүрт оруулсан хөрөнгө оруулалт $= 543 \text{ Mio} / 30,800 =$ **17,600 USD**

Хавсралт 3. “Шудрага худалдаа болон бичил уурхайн шудрагаар олборлосон алт”-ын тухай

2010 оны 3 дугаар сард хариуцлагатай уул уурхайн холбоо (ХУУХ) болон Олон улсын шудрага худалдааны тэмдэгтийн байгууллага (ШХТБ) өөрсдийн Шудрага худалдаа болон Шудрага олборлолтын холбоог (ШХ ба ШО) зарлаж, “Бичил уурхайгаар олборлосон алтны Шудрага худалдаа ба Шудрага олборлолтын стандарт” –ыг хэвлэн гаргасан (ШХ ба ШО-ын стандарт). Энэхүү ШХ ба ШО-ын стандарт нь зөвхөн ХАМО иргэдэд зориулсан ба дунд болон том хэмжээний үйл ажиллагаанд хамааралгүй юм.

Шудрага худалдааны концепци нь 1960-аад онд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд зориулан гарсан ба энэ нь зөвшөөрөл бүхий жижиг үйлдвэрлэгчид үр шимийг нь хүртэх Шудрага худалдааны нэмүү үнээр төлбөрийг хийх замаар хөгжлийг дэмжихийн чухлыг хэрэглэгчдэд хүргэх зорилго агуулж байсан. Шудрага худалдааны баталгаа нь жижиг үйлдвэрлэгчид болон ажиллагсадыг өөрсдийн үйл ажиллагаа, нөхөрлөлөө ядуурлаас гаргах, байгаль орчныг хамгаалах, дэлхийн зах зээлд өрсөлдөхөд шаардлагатай бизнесийн ур чадварыг эзэмших боломжийг олгодог. Шудрага худалдааны зарчмуудад:

- Шудрага үнэ: Үйлдвэрлэгчдийн ардчилсан байдлаар зохион байгуулагдсан хэсгүүд нь доод суурь үнийг батлагаатай авах ба нэмэлт үнийг батламжлагдсан бүтээгдэхүүнд нэмж олгодог. Үйлдвэрлэгчдийн байгууллага нь урьдчилсан санхүүжилт авах эрхтэй.
- Шудрага ажлын нөхцөл: Шудрага худалдааны ажиллагсад нь эвсэн нэгдэх, нийгмийн хамгаалал, аюулгүй ажиллах нөхцөл, амьжиргааны хөлс авах эрх эдэлдэг. Хүүхдийн хөдөлмөрийг хатуу хориглодог.
- Шууд худалдаа: Шудрага худалдааг зөвхөн худалдааны албан ёсны харилцаагаар дамжин хийх ба ил тод байдал болон гарал үүслийг тогтоох боломжтой нөхцөл хангагдсан байх шаардлагатай. Импортлогчид нь Шудрага худалдааны үйлдвэрлэгчдээс аль болох шууд худалдан авах ба дэлхийн зах зээлд өрсөлдөх бизнесийн чадавхийг хөгжүүлнэ.
- Ардчилсан, ил тод байгууллагууд: Шудрага худалдааны үйлдвэрлэгчид болон ажиллагсад Шудрага худалдааны орлогыг хэрхэн хөрөнгө оруулалтад оруулах асуудлыг ардчилсан замаар шийднэ.
- Бичил уурхайчдын хөгжил: Шудрага худалдааны үйлдвэрлэгчид болон ажиллагсад нь Шудрага худалдааны нэмэлт үнийг орон нутгийн нийгэм, бизнесийн хөгжлийн төслүүдэд хөрөнгө оруулна.
- Байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангах: Шудрага худалдааны үйлдвэрлэгчид нь хүний эрүүл мэндийг хамгаалах, үнэлж баршгүй эко системийг хойч ирээдүйдээ хамгаалан үлдээх байгаль орчны тэнцвэрийг хангах үйлдвэрлэлийн арга ажиллагаа явуулна.

Шудрага худалдаа нь үйлдвэрлэгч байгууллагуудад үндэсний хууль тогтоомжийг ягштал сахин мөрдөх шаардлага тавьдаг ба харин үндэсний хууль тогтоомжийн стандарт нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт болон конвенцийн заалтаас доогуур түвшинд тавигдаж байгаа бол олон улсын стандартыг баримтлана. Алтны ХАМО нарт зориулсан ШХ ба ШО –ын стандарт нь хариуцлагатай бичил уурхайн ARM-ын зарчмуудыг нэмэлт шаардлага болгон тавьдаг ба энд дурдсан бүх лавлах материалуудыг **Error! Reference source not found.** оруулсан болно. Хэрэв

үндэсний хууль тогтоомж зарим нэг тодорхой асуудлаар ШХ ба ШҮ-гийн стандартаас дээгүүр шаардлага тавьж байгаа бол үндэсний хууль тогтоомжийг баримтлана.

Шудрага худалдаа нь FLO-CERT мандат бүхий хөндлөнгийн ISO батламжтай гуравдахь талын батламжийн тогтолцоотой байна. Аудитийн шалгалтыг тогтмол хийж, хэрэглэгч нарт бүтээгдэхүүний чанарын баталгаа гаргаж өгсөнөөр хэрэглэгч нар нэмүү үнэ төлөхөд бэлэн байх болно.

ТБУТ-ын хүрээнд Шудрага худалдаа ба Шудрагаар олборлох асуудлыг авч үзэх

ШХ ба ШО-ын стандарт нь ТБУТ –ийн хөгжлийн зорилттой холбоо бүхий бүх асуудлыг хамарч байгаа бөгөөд *“Бичил уурхайн үйл ажиллагааг Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, албан ёсны дэд салбар гэж хүлээн зөвшөөрдөг болгоход дэмжлэг үзүүлэх”* гэсэн хөгжлийн зорилгод дөхөм үзүүлнэ. Олон нийтэд суурилсан БУ-чид нь тэд олборлолтыг зохион байгуулалттай, аюулгүй нөхцөлд, байгаль орчин ба эрүүл мэндийн хувьд хариуцлагатай явуулж, үндэсний хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн бүх заалтыг сахин мөрдөж байгаа бол “FAIRTRADE® and FAIRMINED™” гэсэн батламж олгоно.

Шудрага худалдааны тогтолцооны хүрээнд олгож байгаа нэмүү үнэ нь хүчтэй урамшуулалын хэлбэр бөгөөд БУ-чид хариуцлагатай олборлолт хийх бодит хүчин чармайлтын нөхцөл нь болдог юм. Импортлогч нараас төлж байгаа ШХ –ны нэмүү үнийг ШХ/ТБУ стандартын хорооноос ердийн алтанд Лондонгийн биржийн алтны үний 10%, мөнгөн усгүй технологиор боловсруулсан бол 15% -д тогтоодог (Монголд хамааралтай) ба орон нутгийн эко системийг бүрэн нөхөн сэргээлт хийх шаардлагыг хатуу тавьж байна.

Нэмүү үнээс авах илүү шагнал бол зөвхөн үндэсний хууль тогтоомжийг сахин мөрдсөнөөр БУ-чид нийгмийн дотор нэр хүнд олоод зогсохгүй олон улсын хэмжээнд тэргүүн стандартыг хэрэгжүүлж байгаа нь хүлээн зөвшөөрдөгдөх явдал юм.

ТБУТ нь эрх зүйн болон зохицуулалтын орчныг бүрэлдүүлж, олон нийтэд суурилсан бичил уурхайчдын чадавхийг бэхжүүлэх нөхцлийг бүрэлдүүлнэ. Монголын БУ-ыг стандартыг мөрдөж ажиллахад чиглэгдсэн төслийн арга хэмжээ нь ТБУТ-ийн Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсгийн БУ-ын чадавхийг бэхжүүлэх зорилттой яв цав нийцэж байгаа болно. БУ-чдыг албан ёсны болгох, батламж авах эрхтэй болгох эрх зүйн орчныг бүрэлдүүлэх чиглэлээр төсөл үйл ажиллагаа явуулна. Улс төрийн түвшинд, хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагааг хөндлөнгийн бөгөөд ISO – ын шаардлагыг хангасан гуравдахь талын батламжид хамруулах асуудал үнэхээр хурцаар тавигдаж байгаа тал талаас хэлэлцэх асуудал бөгөөд сонирхогч талуудын нэр хүндийн асуудал юм.

ШХ ба ШО-ын стандарт нь ТБУТ төслийн хариуцлагатай хувиараа алт олборлолтод тавих тодорхой бөгөөд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шалгуур юм. Эквадор, Перу, Боливи-д БУ-чид нь ШХА-аас дэмжин хэрэгжүүлж ирсэн төслийн түнш болон хамтран ажиллагсад байсан ба одоо батламж авахаар өргөдөл гаргаад байгаа болно.

Монгол банк зөвхөн 300 gram³¹-аас дээш хэмжээний алтны арилжаанд орж байгаа юм. Ихэнх хамтрагч талуудын дунд байгаа ойлголтоор бол зөвхөн Монгол банк л албан ёсоор алт худалдаалах эрхтэй гэж үздэг. Гэвч Монгол банкны зүгээс уг банк зөвхөн алтыг дамжуулах/худалдах ажиллагаа явуулдаг ба 2002 оноос эхлэн дотоод алтны зах зээлийг чөлөөтэй болсон гэж мэдэгдсэн. Монгол банкнаас авсан мэдээллийн дагуу

³¹ Information obtained from Mongol Bank. Sellers report that sometimes quantities above 1 kg are put as threshold.

хууль ёсоор алт эзэмшигчид (тухайлбал, алт үйлдвэрлэгчид) холбогдох татвар хураамжийг төлсөн цагт алтыг экспортлож болно гэсэн. Хэдий тийм боловч илүү гүнзгийрүүлсэн судалгаа хийх шаардлагатай юм. Худалдаа хийх болон ил тод байх тухай Шудрага худалдааны заавал биелүүлэх шаардлага нөхцөлүүд нь Монгол банкны зарчимтай нийцэх юм шиг байна.

FLO болон ARM холбоо Монголын БУ-ын байгууллагуудын уг холбоонд элсэн орох боломж болон төслийн талаар мэдэж байгаа бөгөөд ШХ ба ШО-ын стандартыг Монголд нэвтэрүүлэх чиглэлээр ажиллах эрмэлзэл дүүрэн байгаа болно. Хэрэв ШХА-аас энэ үйл ажиллагаанд нэгдэн орох талаар шийдвэр гаргавал холбооны зүгээс Монгол улсыг газар зүйн байрлалын хувьд хөтөлбөртөө урьдчилан оруулахад бэлэн байгаа юм.³²

Салбаруудын хүрээний хувьд гэвэл, Шудрага худалдааны талаар ТБУТ нь зөвхөн алт олборлогч хамо нарын 90%-г хамруулах боломжтой бөгөөд ШХ ба ШО-ын стандартыг бусад бүтээгдэхүүний хувьд хэрэгжүүлэх талаар одоогийн байдлаар ямар нэг бэлтгэл хийгдээгүй болно. ШХ ба ШО-ын стандартын зарим нэг шалгуур болон зарчмуудыг хамо нарын бусад бүтээгдэхүүнд авч хэрэглэх боломж уг нь байгаа юм.

Тогтвортой байдалд оруулах Шудрага худалдааны хувь нэмэр

Шудрага худалдаа нь жижиг үйлдвэрлэгчдийн бизнесийн загвар бөгөөд 50 гаруй жилийн түүхтэй бөгөөд Шудрага худалдааны зах зээл хурдацтай өсөж байна. Бичил уурхайн үйлдвэрлэгчдийн Шудрага худалдааны бизнесийн загвар (ШХ-ны худалдан авагч нартай худалдааны харилцаа тогтоох) бөгөөд байгуулагдсанаас хойш ТБУТ-өөс ангид байх ба төсөл хэрэгжиж дууссанаас хойш урт удаан хугацаанд үйл ажиллагаа нь үргэлжлэн явагдах болно. Үйлдвэрлэгчдийг дэмжих байнгын байгууллага шаардлагатай бөгөөд зарим аудитын шалгалтын үеэр батламж бүхий үйлдвэрлэгчдийн зүгээс зөрчил гаргасан нь илрэх тохиолдол байдаг. Иймэрхүү (өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг) үндэсний болон бүс нутгийн үйлдвэрлэгчдийг дэмжих байгууллагууд ШХ-ны бусад бүтээгдэхүүний хувьд үйл ажиллагаа явуулж байдаг ба ТБУТ-ын хүрээнд нь хувийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын хэлбэрээр байгуулах шаардлагатай байна.

ШХ-ны тогтолцоо бий болж, үр дүнгээ үзүүлж эхлэх үед бичил уурхайн үйлдвэрлэгчид хувийн хэвшлийн туслах байгууллагаас багахан дэмжлэг авч, энэ үүнд нэгдэн орно гэж үзэж байгаа бөгөөд энэ нь бусад салбарын жишээнээс харагдаж байгаа болно.

ШХ-ны нэмүү үнэ нь Бичил уурхайн үйлдвэрлэгчид Стандартыг даган мөрдөж байгаа нөхцөлд үргэлжлэн өгөгдсөөр байх юм. Энэ нэмүү үнээс орох орлогыг орон нутгийн нийгэм, бизнесийн хөгжлийн төслүүдэд оруулах ба зарцуулалтыг бичил уурхайн үйлдвэрлэгчид хариуцана. Алтны үнийг хамгийн доод хэмжээгээр авч үзсэн тооцоогоор, бичил уурхайн нөхөрлөлүүдэд хөгжлийн зориулалтын байнгын орлогын урсгалыг хангахын тулд 250 кг/жил батламжтай алт үйлдвэрлэх шаардлагатай бөгөөд энэ нь ТБУТ-ийн жилийн төсвийн хэмжээнд очих юм.³³

³² Source: FLO/ARM ASM Gold Partnership communication from June 04.

³³ 1000 дол\унц \ойролцоогоор 32,000 дол\кг\ гэж тооцоолоход нэг кг батламжлагдсан алт нь 3200-аас 4800 ам. долларын үнэд хүрнэ. Хамгийн доод үнээр бодоход ердийн алтны 50%, экологийн алтны \мөнгөн усгүй технологиор цэвэршүүлсэн\ 50% батламжлагдсан алт дундачаар 4000 дол\унц нэмүү үнийг босгох ба батламжлагдсан жилийн бүтээгдэхүүн 250 кг байх ба үүнээс болосх мөнгө нь ТБУТ-ийн жилийн төсөвийн жишигт очих юм.

ХАВСРАЛТ 4: Хариуцлагатай бичил уурхайн зарчмууд

“ШХ ба ШО-ын хамо болон жижиг үйлдвэрлэгчдийн алт болон дагалдах үнэт металлын олборлолтын стандарт” нь хариуцлагатай ТБУ –н зарчмууд болон ТБУ-н хэвлэн гаргасан энд дурдсан бусад зарчмуудыг дагаж мөрдөнө. Үүнд:

(Эх сурвалж: Алтан судал: хариуцлагатай БУ гарын авлага. Хариуцлагатай бичил уурхайн асуудлаархи ХУУХ-ны цувралууд, 2008)

1. Мянганы хөгжлийн зорилтууд ба Тогтвортой хөгжлийн тунхаглал

Бид Мянганы хөгжлийн зорилтууд болон Жонхансбургын Тогтвортой хөгжлийн Тунхаглалын зарчмуудыг удирдлага болгон, хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагаанд дараахь зарчмуудыг мөрдлөгөө болгохоо тунхаглаж байна:

2. Хууль тогтоомж

Хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагаа нь үндэсний хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. Олон нийтэд суурилсан бичил уурхайг үндэсний хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрөөгүй байгаа бөгөөд тэд өөрсдөө үйл ажилагаагаа хуульчилах гэсэн хууль ёсны хүчин чармайлт гаргаж байгаа нөхцөлд бид боломжийн хэмжээнд тэдгээр зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгчидтэй болон засгийн газартай хамтран ажиллаж, эдгээр зарчмуудыг даган мөрдөх шийдвэр төгс байгаа бичил уурхайчдын байгууллагуудын талаар төрийн бодлогыг сайжруулахын тулд лоббийн ажиллагаа явуулна. СТАНДАРТ нь зэвсэгт мөргөлдөөнд оролцсон болон мөргөлдөөнийг санхүүжүүлсэн эсвэл орлогоо зэвсэг худалдан авахад зарцуулах замаар мөргөлдөөнд оролцсон байгуулагыг дэмжин туслахгүй.

3. Хүний эрх

Хариуцлагатай бичил уурхай нь хүний эрхийн түгээмэл тунхаглал болон НҮБ-ын хувь хүний соёл, нийгэм, эдийн засагийн эрхийн тухай тунхаглалд тулгуурласан болно. Бичил уурхай эхлэгчдийн эрхийг хүндэтгэх ёстой бөгөөд энэ эрхийг зөрчих явдлыг эрс буруушаах болно. Олон нийтэд суурилсан хариуцлагатай бичил уурхай эрхлэгчдийн байгууллага нь хүний эрх болон иргэн бүрийн нийгэм, эдийн засаг, соёл ёс заншилд, хөдөлмөрлөх эрхийг хүндэтгэдэг. Эмэгтэйчүүд, эмзэг бүлэг, хувь хүмүүс, шилжин ирж ажиллагсадын эрхийн талаар зориуд тодорхойлон оруулсан байдаг.

4. Зохистой ажил эрхлэлт

Хариуцлагатай бичил уурхайн эрхлэлт бол ОУХБ-ын конвенцийн агуулагатай нийцэж байгаа бөгөөд хариуцлагатай бичил уурхайн ажил эрхлэлт нь эрх чөлөө, тэгш эрх, аюулгүй байдал, хүний эрхэм чанар, хүүхдийн хөдөлмөөрөөс ангид, бага хэмжээний ашигт малтмал олборлогчдийн оролцоог зөвшөөрсөн, ажиллагсад болон тэдний гэр бүлийг амьжиргааг зохих стандартын түвшинд байлгах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа юм.

5. Бичил уурхайн нөхөрлөлийн амьжиргааны чанар болон хүний тогтвортой хөгжлийг хангах

Хариуцлагатай бичил уурхайн эрхлэлт нь өөрийн нөхөрлөлийн гишүүдийн тогтвортой хөгжлийг хангахад хувь нэмэр оруулдаг юм. Хариуцлагатай бичил болон бага олборлолтын уурхайн эрхлэлт нь эмэгтэй, эрэгтэй уурхайчид, тэдний гэр бүл болон нөхөрлөлийн амьжиргааны чанарыг

дээшлүүлэх, хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагааны концепцийг хүндэтгэн үзэж, нөхөрлөл бүрийн эрх ашгийг дээдэлдэг юм.

6. Байгаль орчныг хамгаалах удирдлага

Хариуцлагатай бичил уурхайн эрхлэлт нь үйлдвэрлэлийн хариуцлагатай арга хэлбэрийг ашиглаж, байгаль орчинд хохирол учруулахаас урьчилан сэргийлэх болон нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулдаг. Хариуцлагатай уурхайчид нь тухайн улс оронд мөрдөгдөж байгаа байгаль орчны тухай хууль тогтоомжуудыг сахин ажилладаг ба байгаль орчныг хамгаалах үйлсэд тус дөхөм үзүүлж, үйл ажиллагаандаа хүний эрүүл мэндийг хамгаалах, экологийн нөхөн сэргээлтийг хийх, түүнчилэн нөхөрлөл, шилжин ирсэн ажиллагсадад ямар нэг сөрөг нөлөөгүй байх зарчмыг баримталж ажилладаг. Дархан цаазат газруудын статусыг хүндэтгэж, нэн чухал байгалийн тогтолцоонд хохирол учруулахгүй байх, уул уурхайн экологийн ул мөрийг аль болохоор багасгах, боломжтой газруудад байгалийн унаган төрхийн тогтолцоог сэргээх, боломжгүй газарт нь учирсан хохиролын нөхөн төлбөр олгох зэрэг нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр баримтлах зарчмууд юм.

7. Хүйсийн тэгш байдал

Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг зохих ёсоор үнэлж, цалин хөлсийг нь олгодог. Хариуцлагатай бичил уурхайн эрхлэлийн зохион байгуулалт, санаачилга нь эмэгтэй болон эрэгтэй ажиллагсадын хувьд эрх тэгш байх зарчмыг бүх үйл ажиллагаандаа баримтлах ба үүнд баялагийн нөөцийг эзэмших, орлогоо зарцуулах, шийдвэр гаргах үйл явцад оролцох болон нөлөөлөх эрхүүд хамрагдаж байгаа юм. Эмэгтэйчүүд нь үйлдвэрлэлд оруулсан хувь нэмрийнхээ дагуу хөлс авах ба өөрсдийн байгууллагын хүрээнд зохих эрхээ эдлэнэ. Уурхайчдын байгууллага нь адил хөдөлмөрт ижил хөлсийг хүйс харгалзахгүйгээр олгох асуудлыг батлхаатай хангана. Эмэгтэйчүүдийн хувьд ямар нэг жич хэмжээ хязгаарыг байгууллагын хүрээнд тавьж байгаа бол үүнийг засаж залруулж, тэгш байдлыг хангах арга хэмжээг авна.

8. Олон үндэстэн, ястаны бүтэц

Хариуцлагатай бичил уурхайд ажиллагсад нь ихэвчлэн олон янзын ястан болон янз бүрийн ёс заншил бүхий хүмүүс байдаг. Орон нутгийн хүмүүс буюу бусад этник бүлгүүд нь тухайн олборлолтын талбайг эзэмшиж байгаа бөгөөд уурхайчдаас өөр этник бүлгийн хүмүүс байгаа бол хариуцлагатай бичил уурхайн байгууллагууд нь ОУХБ-ын 169 дугаар конвенцийн үндсэн дээр зөвлөлгөө авч, орон нутгийн уугуул иргэдийн ёс заншлыг хүндэтгэх талаар зөвшицөлд хүрэх ба уурхайн үйл ажиллагааг хэвийн явуулах, худалдааг эрхлэх боломжийг тухайн талбайд бий болгох үүргийг хүлээнэ.


9. Зэвсэгт мөргөлдөөн


Дотоодын зэвсэгт мөргөлдөөний хүнд бөгөөд аюултай нөхцөлд ажиллаж байгаа хариуцлагатай бичил уурхайн эрх болон үйл ажиллагааг СТАНДАРТ дэмжин бэхжүүлнэ. Хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагааг мөргөлдөөний газар явуулж байгаа ажиллагсад, тэдний гэр бүлийн ажлын болон амьдарх нөхцлийг сайжруулах зорилгоор СТАНДАРТ нь зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд байгаа энгийн иргэдийн дунд зохиох ажлын хүрээг тэлэх, зэвсэгт талуудын үйл ажиллагааг хязгаарладаг Олон улсын Хүмүүнлэгийн тухай хуулийн үзэл санаанд суурилсан болно. Олон нийтэд суурилсан хариуцлагатай бичил уурхайн байгууллагууд нь жижиг хэмжээний олборлолт эрхэлдэг уурхайчдыг нийгмийн эмзэг бүлэг хэмээн тооцож, зэвсэглэсэн бүлгийхний зүгээс айлган сүрдүүлэх,

хүчээр үйл ажиллагаандаа нэгдэн оролцуулах эсвэл шууд бусаар (санхүүгийн дэмжлэг авах, мэдээлэл түгээх зэрэг) мөргөлдөөнд татан оруулахгүй байх нөхцлийг бэхжүүлэх талаар ажиллана.

ХАВСРАЛТ 4: Тогтвортой амьжиргааны үзүүлэлтийг мониторингийн хэрэгсэл болгон ашиглах

Бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй газрууд амьжиргааны байдалд хийсэн үнэлгээгээр тодорхойлогдож болох болон нөлөөллүүдийг (эдгээр тохиолдолд нөөц байхгүйгээс болж эмзэг байдал үүсэх) хэрхэн графикчилан харуулж болохыг доорх зургууд харуулна. Иймэрхүү байдлаар эерэг нөлөөнүүдийг (төслийн үр дүнгээс гарсан) мониторинг хийх зорлгоор баримтжуулж болно.





Example: Community mining (e.g. Huacaschuque)


Possible scenario if deposit gets depleted or if community loses the right to mine

Low vulnerability: Community still has agriculture and solid social structures; income will be reduced but community will continue

Example: Rush type ASM (e.g. Serra Pelada)

Possible scenario if deposit gets depleted or if community loses the right to mine

High vulnerability: No mining = no income
Community will be abandoned



Хавсралт 5: ШХА-гийн логфреаме хийх зааврын дагуу боловсруулсан логфреаме

Зорилгуудын шатлал Оролцох стратеги	Гол шалгуур үзүүлэлтүүд [Суурь]	Мэдээллийн эх үүсвэр Means of Verification	
Нөлөө (Ерөнхий зорилт)	Нөлөөний шалгуур үзүүлэлтүүд		
Бичил уурхайн үйл ажиллагааг Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, албан ёсны дэд салбар гэж хүлээн зөвшөөрөх	БУ-ш хөгжих боломжтой гэдэг талаарх хамтрагч талуудын итгэлтэй байдал [2010: Их хурал дээр уг салбарыг албан ёсны болгох талаар олонхи санал өгсөн; олон нийтийн санаа бодол тийм ч таатай бус байгаа] БУ-аас GDP-д оруулах эдийн засгийн хувь нэмэр [2010: 0 USD; Борнуур дунджаар 3 сая USD]	Хэвлэл мэдээлэл, экспртүүд, төрийн байгууллагуудтай гол мэдээлэгч зөвлөгөөн, ярилцлага хийх Тоо баримт, барагцаа	
Үр дүн	Үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд		Гадаад нөхцөл (Таамаглал & Эрсдэл)
Үр дүн 1: Хариуцлагатай бичил уурхай Монгол Улсад хууль ёсны, баталгаатай ажлын байрыг бий болгоно	Хууль ёсны, баталгаатай ажлын байр бүхий 10'000 эрэгтэй, эмэгтэй хүмүүс [2010 онд зөвхөн ТБУТ-ын үйл ажиллагаа хэрэгжүүлэдэг газруудад л 2000 эрэгтэй, 1000 эмэгитэй бичил уурхайчид баталгаатай ажлын байртай байсан] Гэрчилгээ бүхий бичил уурхайн үйлдвэрлэгч байгууллагуудын тоо ба тэдний ШХШО-ын системээс авсан нэмэгдэл шагналын хэмжээ [2010: 0/0] Хууль эрх зүйн таатай орчин [2010: Ашигт малтмалын болон Газрын хуулинд оруулсан]	Статистикийн тоо баримт Бие даасан ISO 65-аас ШХШО-ын стандартын байгууллагад гуравдагч талын баталгаа олгох эрх олгосон Хууль, журмууд батлагдсан	Саяхан батлагдсан бичил уурхайн журам үр дүнтэй, тохиромжтой болсон нь батлагдаж байна БУ-н секторт зориулсан тохиромжтой дүрэм, журмууд батлагдана. Монгол улсыг алтны ШХШО-ын системд хамруулах боломжтой

Зорилгуудын шатлал Оролцох стратеги	Гол шалгуур үзүүлэлтүүд [Суурь]	Мэдээллийн эх үүсвэр Means of Verification	
Үр дүн 2: Нийгмийн үүрэг хариуцлага бүхий бичил уурхай эрхлэгчид ажлын байрны аюулгүй байдлыг хангаж нийгмийн баталгаатай болсон байна.	өөрчлөлтийн хууль] Өрхийн орлого нэмэгдсэн байна [2011: судалгааны үр дүнгээр тогтоох] БУ-ын өрхийн орлого нэмэгдэх [2009: зорилтот бүс нутагт сард 250 USD байх] БУ-д бага насны хүүхдийн хөдөлмөр ашиглалт буурсан байх [2011-ны байдлаар суурь хэмжээг авах] Нийгмийн анхан шатны үйлчилгээ хүртэж байгаа эрэгтэй хүн, эмэгтэй хүн, хүүхдийн тооны харьцаа (боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж) [2009: зорилтот бүс нутгийн бичил уурхайчдын 62% нь эрүүл мэндийн үйлчилгээ авах, сургууль завсардалтын хэмжээ 5%] Гэмт хэрэг, хүчирхийлэл, архидан согтуурахтай холбоотой хэрэг зөрчил гарсан хэмжээ [2011-ны байдлаар суурь хэмжээг авах] Бичил уурхайчдын гүйцэтгэсэн нөхөн сэргээлтийн ажил [2009: 2 га газар] Мөнгөн усгүй технологи бүхий баяжуулах цехийн тоо	Сонгож авсан газруудад орлогын хүртээмжтэй байдлын талаарх судалгааг жил бүр явуулах Сонгож судалгаа хийх Сонгож судалгаа хийх Сонгож судалгаа хийх Бүлгээр ярилцах, хэвлэл мэдээллээр таниулах дээр төвлөрч ажиллах Төслөөс тэмдэглэл хийж баримтжуулах	БУ-салбарт шинэ, цэвэр, аюул осол багатай технологи нэвтрүүлэх БУ-н салбар зохион байгуулалтанд орно Худалдаа арилжааны байгууллага болох чиглэлээр хийдэг ажлууд саатахгүй байх Алтны үнийг хянах

Зорилгуудын шатлал Оролцох стратеги		Гол шалгуур үзүүлэлтүүд [Суурь]	Мэдээллийн эх үүсвэр Means of Verification	
		[2010: зөвшөөрөл авсан газар 3, үйл ажиллагаа явуулж байгаа 1]		
Бүтээгдэхүүн (үр дүн бүрээр) ба үнэ өртөг		Бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлтүүд		
Үр дүн 1 ба үр дүн 2: (Жич: Үр дүн 1, үр дүн 2 –ын хувьд төслийн бүрэлдэхүүн хэсгүүд нягт холбоотой ажиллана)				
Бүтээгдэхүүн 1	Хууль, эрх зүй, зохицуулалтын орчинг бүрдүүлснээр бичил уурхай эрхлэх үйл ажиллагааг албан ёсны болгох боломж бүрдүүлнэ ➤ БХ 1: Бичил уурхайн хууль эрх зүй, зохицуулалтын нөхцөл нь бичил уурхай эрхлэгч иргэдэд үйл ажиллагаагаа албан ёсоор явуулах боломж олгоно ➤ БХ 2: Хууль эрх зүй, зохицуулалтын хүрээний дагуу бичил уурхай эрхлэгчид үйл ажиллагаагаа албан ёсны болгоно	Орон нутагт ашигт малтмал олборлох эрх авсан бичил уурхайчдын албан ёсны байгууллагын тоо дор хаяж 5 байна. [2010: 3 ТББ-ын гишүүд орон нутгийн төвшинд олборлолт явуулах эрхтэй байсан]	АМГ болон орон нутгийн төрийн үйлчилгээний байгууллагуудын статистик тоо баримт	Яг ямар байгууллага нь ашигт малтмал олборлох эрх авах вэ гэдэг нь одоогийн байдлаар тодорхой биш байна (ТББ эсвэл бүртгэгдээгүй нөхөрлөл)
Бүтээгдэхүүн 2	БУ-чдын байгууллагууд нь гишүүд, дэмжигч, хамтран ажиллагч талуудын хүсэл сонирхолыг илэрхийлдэг болсон байна ➤ БХ 1: Үндэсний болон орон нутгийн төвшинд төр, засгийн болон бусад субъектүүд бичил уурхайн салбарыг хамтран ажиллагч, үйлдвэрлэгч болгох талаар хамтран ажилладаг болсон байна. ➤ БХ 2: Бичил уурхай эрхлэгчид хамтын ажиллагаатай, үйлдвэрлэгч байгууллагуудтай болоход төр, засаг, бусад хамтрагч талуудтай хамтран ажилладаг болсон байна.	Дор хаяж БУ-н үндэсний хэмжээний 1 байгууллага байгуулагдаж үйл ажиллагаа явуулдаг болсон байна. [2010: 0] Бүсийн болон орон нутгийн ТББ-ын тоо болон гишүүдийн тоо нэмэгдсэн байна [2010: БУ-ын 7 ТББ; 2000 гишүүд]	БУ-ын ТББ-аас тоо баримт авах	
Бүтээгдэхүүн 3	Нийгмийн хариуцлагатай бичил уурхай эрхлэгчид ажлын байрны аюулгүй байдлыг хангаж нийгмийн баталгаатай болсон байна. ➤ БХ 1: Бичил уурхайн ажлын байрны аюулгүй байдал, нийгмийн баталгааг дээшлүүлэхэд чиглэсэн төрийн ба хувийн салбарын үйлчилгээ хариуцлагатай бичил уурхай эрхлэгчдэд	Ажлын байрны аюулгүй байдалтай холбоотой гарсан осол аваарийн тоо (Ажлын байрны аюулгүй байдлын талаар хайхрамжгүй байман) [2009: Судалгаанд хамрагдсан БУ-ын 63.3% нь ямар нэгэн байдлаар	Government statistics by MRS (Mine rescue Service) and Ministry of Social Welfare	

Зорилгуудын шатлал Оролцох стратеги		Гол шалгуур үзүүлэлтүүд [Суурь]	Мэдээллийн эх үүсвэр Means of Verification	
	хүртээмжтэй болсон байна. ➤ БХ 2: Хариуцлагатай бичил уурхай эрхлэгчид нь ажлын байрны аюулгүй байдал, нийгмийн баталгааны тогтолцоог сайжруулахад чиглэсэн боломжийн үнэ/төлбөр бүхий үйлчилгээг авдаг болсон байна	осол аваарт өртөж байман] Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын системд хамрагдсан БУ-ын тоо өсөн [2009: Эрүүл мэндийн даатгалтай БУ-68% , Нийгмийн даатгалтай БУ- 45%]		
Бүтээгдэхүүн 4	Хариуцлагатай бичил уурхай эрхлэгчид байгаль орчинд хал багатай технологи хэрэглэж олборлолт явуулдаг болсон байна ➤ БХ 1: Хэрэгжүүлж, дагаж мөрдөж болохуйц байгаль орчны шаардлагууд нь бичил уурхай эрхлэгчдэд хариуцлагатай, байгаль орчинд хал багатай олборлолт явуулах чиглэл болж өгсөн байна. ➤ БХ 2: Бичил уурхай эрхлэгчид нь байгаль орчны тавигдаж буй шаардлагуудыг мэддэг, хариуцлагатай, байгаль орчинд хал бага арга, технологи ашиглаж олборлолт хийдэг болсон байна.	Байгаль орчны зааварчлагыг хэрэгжүүлэх [2010: Зааварчлага гараагүй байсан] Байгаль орчны стандартыг хэрэгжүүлэх зааварчлага Мөнгөн усгүй технологи бүхий баяжуулах цехийн загварыг албан ёсоор хүлээн зөвшөөрөх	АМГ болон орон нутгийн захиргаанаас хийсэн статистикийн мэдээ баримт (tbd) Төслөөс хийсэн тэмдэглэл Төслөөс хийсэн тэмдэглэл	
Бүтээгдэхүүн 5	Бичил уурхайн дэд салбарыг дэмжих хүрээнд бичил уурхай эрхлэгчдийг чадавхижуулах бүтцийг бий болгох үйл явц эхэлсэн байна. ➤ БХ 1: Бичил уурхайд ерөнхий оролцогчдод чиглэсэн чадавхи бий болгох бүтэц, үйл явц үндэсний хэмжээнд хэрэгжсэн байна ➤ БХ 2: Тодорхой чиглэлээр мэргэжлүүлэх чадавхи бий болгох бүтэц, үйл явц орон нутгийн түвшинд бий болсон байна	БУ-тай холбоотой чадавхи бий болгох болон дэмжигч байгууллагуудын тоо (үүн дээр нэмээд дор хаяж 1 их сургууль, 1 МСҮТ) [2010: 2 – АМГ 3 мэргэжилтэн, УУАА] Гишүүддээ үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллаж буй БУ-ын байгууллагуудын тоо. [2010: 3] ШХШО-ын үйлдвэрлэгчдийг дэмжих үндэсний байгууллага бий болсон байх	Төслөөс хийсэн тэмдэглэл Сургалтын байгууллагуудын тэмдэглэл, тооцоо ШХШО-ын холбоо болон ХУУХ-ын тайлан	

Зорилгуудын шатлал Оролцох стратеги		Гол шалгуур үзүүлэлтүүд [Суурь]	Мэдээллийн эх үүсвэр Means of Verification	
		Алтны ШХШО-ын холбоо болон ХУУХ-тай албан ёсны харилцаа холбоо тогтоосон байх	ШХШО-ын холбоо болон ХУУХ-ын тайлан	
Бүтээгдэхүүн 6	Орон нутгийн засаг захиргаа болон бичил уурхай эрхлэгчдийн ашигт малтмалын менежментийн чадавхи дээшилсэн байна ➤ БХ 1: Зөвшөөрөл олгох үйл явц ил тод, шударга явагдаж, зөрчлийг бууруулах ➤ БХ 2: БУ-чдын үйлдвэрлэлийн бүтээмж дээшилж бүрээгдэхүүний чанар сайжирсан байна	БУ-н хөгжлийг дэмжиж ажилладаг орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд болон энэ талаар ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн тоо [2010: 0] Дор хаяж техникийн талын 3 шинэлэг зүйлс тушигдаж нэвтрүүлэгдсэн байх	Төслөөс хийсэн тэмдэглэл Амьжиргааны үнэлгээ Үйлдвэрлэгчдийн гэрчилгээ батламж авсан байдал Төслөөс хийсэн тэмдэглэл	
Үр дүн 1, үр дүн 2-оос гарах бүтээгдэхүүний зардал: 4,500,000 ШФ (Тэмдэглэл: Үр дүн 1, үр дүн 2-ыг хэрэгжүүлэхэд төслийн БХ-д нягт холбоотойгоор ажиллана)				

Үйл ажиллагаа (Үр дүн бүрээр)	Inputs		
Үр дүн 1-ийн хүрээнд хийх ажлын жагсаалт: ➤ Хууль эрх зүйн зохицуулалтын орчны талаар идэвхижүүлэх, зөвлөгөө өгөх ➤ Бичил уурхай талаарх олон нийтийн үзэл бодлыг сайжруулах ➤ Бүртгэгдээгүй нөхөрлөлөөс ашигт малтмалын эрх авах эрх бүхий хууль ёсны аж ахуйн нэгж болж хөгжүүлэх чиглэлээр ажиллах ➤ Бичил уурхайн талаар гаргасан дотоодын сайн туршлагын стандарт болон зааварчлагуудыг боловсруулж албан ёсны болгох	Төслийн бичиг баримтанд тусгасан үйл ажиллагааны багцаас харах. Төслийн удирдлагын үүрэг нь гарч ирж буй боломжуудыг ашиглах зорилгоор нөхцөл байдлыг ерөнхийд нь хянаж байх ба төлөвлөсөн ажлуудыг тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх юм.	Төслийн тайлангууд	
Үр дүн 2-ын хүрээнд хийх ажлын жагсаалт: ➤ Бичил уурхайчдын байгууллагуудыг хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэхэд үзүүлэх нөлөөллийн ажилд нь дэмжлэг үзүүлэх ➤ Орон нутгийн бичил уурхайчдын ТББ-д, компаниуд, хоршооллуудыг дэмжих; Бүсийн болон үндэсний дээвэр байгууллага байгуулахад нь дэмжлэг үзүүлэх (холбоо	Төслийн бичиг баримтанд тусгасан үйл ажиллагааны багцаас харах. Төслийн удирдлагын үүрэг нь гарч ирж буй боломжуудыг ашиглах зорилгоор нөхцөл байдлыг ерөнхийд нь хянаж байх ба төлөвлөсөн ажлуудыг тухайн нөхцөл байдалд тохируулан	Төслийн тайлангууд	

байгуулах) ➤ Баяжуулах цехгэх мэт олон нийтээрээ зохион байгуулж ажиллуулах технологи ашиглах, байгуулах ажиллагааг дэмжих, өргөжүүлэх	хэрэгжүүлэх юм.		
Үр дүн 3-ын хүрээнд хийх ажлын жагсаалт: ➤ Албажуулах үйл ажиллагааг арай өргөн хүрээнд авч үзэх. Жишээлбэл: татвар төлөх, нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулах гэх мэт. ➤ Бичил уурхайчдын ТББ-ын дотоодын нийгмийн хариуцлагын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх; Албан бус нийгмийн баталгаатай байдлын сүлжээнээс албан ёсны нийгмийн даатгалын системд шилжүүлэх ➤ Ажлын байрны аюулгүй ажиллагаа болон ерөнхий хөдөлмөр хамгаалал, эрүүл мэндийн талаарх ажиллагаануудыг дэмжих ➤ Уул уурхайн аврах албыг бэхжүүлэх	Төслийн бичиг баримтанд тусгасан үйл ажиллагааны багцаас харах. Төслийн удирдлагын үүрэг нь гарч ирж буй боломжуудыг ашиглах зорилгоор нөхцөл байдлыг ерөнхийд нь хянаж байх ба төлөвлөсөн ажлуудыг тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх юм.	Төслийн тайлангууд	
Үр дүн 4-ийн хүрээнд хийх ажлын жагсаалт: ➤ Бодлого боловсруулагчид, эрх мэдэлтэнгүүдэд бичил уурхайчдын дагаж мөрдөж хэрэгжүүлж болохуйц байгаль орчны зааварчлага, сайн туршлага дээр тулгуурлаж боловсруулсан дүрэм журмын ашиг тустай талыг ойлгуулж, итгүүлэх ➤ Бичил уурхайчид байгаль орчны хяналтыг өөрсдөө хийдэг болоход нь дэмжлэг үзүүлэх; хариуцлагатай үйл ажиллагааны дотоод хяналт ➤ Нөхөн сэргээлтийн сайн туршлагуудыг үзүүлэх; Байгаль орчинд хал багатай аргаар ашигт малтмал ашиглах ажиллагааг дэмжих (металл барилтыг хамгийн сайн болгох)	Төслийн бичиг баримтанд тусгасан үйл ажиллагааны багцаас харах. Төслийн удирдлагын үүрэг нь гарч ирж буй боломжуудыг ашиглах зорилгоор нөхцөл байдлыг ерөнхийд нь хянаж байх ба төлөвлөсөн ажлуудыг тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх юм.	Төслийн тайлангууд	
Үр дүн 5-ын хүрээнд хийх ажлын жагсаалт: ➤ Бичил уурхайд ерөнхий оролцогчдод чиглэсэн чадавхи бий болгох бүтэц, үйл явц (мэргэжлийн сургалт явуулах гэх мэт) үндэсний хэмжээнд бий болгох ➤ Бичил уурхайчдын байгуулага, хамт олны дундаас “манлайлагчид” болох боломжтой хэсгийг нь чадавхи бий болгох тусгайлсан бүтэц болон үйл явцаар дамжуулан (жишээлбэл: Шудрага худалдааны гэрчилгээ авах шаардлага хангасан) дэмжих	Төслийн бичиг баримтанд тусгасан үйл ажиллагааны багцаас харах. Төслийн удирдлагын үүрэг нь гарч ирж буй боломжуудыг ашиглах зорилгоор нөхцөл байдлыг ерөнхийд нь хянаж байх ба төлөвлөсөн ажлуудыг тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх юм.	Төслийн тайлангууд	

Үр дүн 6-гийн хүрээнд хийх ажлын жагсаалт:: ➤ Бүсийн болон орон нутгийн захиргаанаас ил тод, шударга хэлбэрээр газар олгох ажиллагааг дэмжих; ➤ <i>Орон нутгийн болон бүсийн засаг захиргааг төвлөрлийг бууруулах талаар хийж байгаа ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх</i> ➤ <i>Орон нутгийн орлогын эх үүсвэрийг “олборлолтоос зах зээлд” сүлжээний дагуу нэмэгдүүлэх;</i> ➤ <i>Орон нутгийн хөгжлийн хөдөлгөөгч хүч гэдэг утгаар нь бичил уурхайд анхаарлаа хандуулах</i> ➤ <i>Үйлдвэрлэлийн бүтээмж болон бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх (жишээлбэл: гэрчилгээ авах)</i>	Төслийн бичиг баримтанд тусгасан үйл ажиллагааны багцаас харах. Төслийн удирдлагын үүрэг нь гарч ирж буй боломжуудыг ашиглах зорилгоор нөхцөл байдлыг ерөнхийд нь хянаж байх ба төлөвлөсөн ажлуудыг тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх юм	Төслийн тайлангууд	
---	---	--------------------	--

Хавсралт 7: Үйл ажиллагааны багц

Төслийн үр дүн 1:

Хууль, эрх зүй, зохицуулалтын орчинг бүрдүүлснээр бичил уурхай эрхлэх үйл ажиллагааг албан ёсны болгох боломж бүрдсэн байна.

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
БУ-н бодлогын бүрэлдэхүүн хэсэг 1.1 Бичил уурхайн хууль эрх зүй, зохицуулалтын таатай нөхцөл нь бичил уурхай эрхлэгч иргэдэд үйл ажиллагаагаа албан ёсоор явуулах боломж олгосон байна.	
<i>Бичил уурхайн хууль эрх зүй, зохицуулалтын таатай нөхцөлийн гол цөм нь тухайн орон нутгийн бичил уурхай эрхлэгч иргэд өөрийн оршин суугаа нутаг дэвсгэрт олборлолтын ажиллагаа явуулах эрхтэй гэдгийг нь хүлээн зөвшөөрөх явдал юм. Монгол улсын засгийн газрын Журманд тодорхой асуудлуудыг тусгана.</i> <i>Хууль, журам батлагдсаны дараа хууль эрх зүйн орчны талаар олон ажил хийх хэрэгтэй болно. БУ-н үйл ажиллагааг албажуулах нь ашигт малтмалын олборлолын асуудлаас хамаагүй өргөн хүрээтэй асуудал юм. Энд нийгэм, хүний хөдөлмөр, байгаль орчин, алба гувчуур гэх мэт илүү олон асуудлыг багтаадаг.</i>	
А) Хууль эрх зүйн орчны талаар идэвхижүүлэх, зөвлөх ажиллагаа зохион байгуулах Хамаа бүхий албаны хүмүүст хууль, журмыг хэрхэн үр дүнтэйгээр хэрэгжүүлэх, даган мөрдүүлэх, үүний нөлөөний талаар дотоодын сайтууд дээрх туршлагууд болон гадаад орнуудын туршлага дээр үндэслэн зөвлөгөө өгөх. ☒ <u>Чухал үйл явдал:</u> БУ-н журам батлагдсан байна	Төсөл болон албаны хүмүүсийн хоорондын хамтын ажиллагааг доорх зарчмын дагуу чиглүүлэх хэрэгтэй: 1. Монгол улсын эрх мэдэл, тусгаар тогтнолыг хүндэтгэн үзэх: ШХА-ын үүрэг роль нь олон улсын туршлагаар хувь нэмэр оруулахаар хязгаарлагдана. 2. Бүтээлч байдал болон боломж хоёрын хоорондын тэнцвэртэй байдал: ТБУТ-ын үүрэг бол практик дээр гарч байгаа тулгамдсан асуудлуудыг тодорхойлох, бодож эрэгцүүлэх болон шинэ соргог шийдвэрлэх арга замуудыг санал болгох ба эрх бүхий хүмүүсийн үүрэг роль нь үүний улс төрийн талаарх боломжийг шийдвэрлэхэд оршино. 3. Хараат бус итгэлцэл: Төсөл болон бусад холбогдох албаны хүмүүсийн хоорондын хамтын ажиллагаа нь хоорондын итгэлцэл дээр тулгуурлана.
01B) Бичил уурхайн талаарх олон нийтийн бодлыг сайжруулах БУ-н талаар ядуурлаас зайлсхийх боломж, бичил уурхайчдын зүгээс орон нутгийн хөгжилд оруулах нөөц бололцоо гэх мэт талаас нь харж бодитоор мэдээлэх (байнгын болон улирлын чанартай үйл ажиллагаа	БУ-н үйл ажиллагааны талаар олон нийтийн санаа бодол нийлээд эерэг талруугаа өөрчлөгдөж байгаа боловч БУ-ын талаарх “зэрлэг нинжа” гэсэн дүр төрх одоо болтол байсан хэвээр байна. Энэ нь бичил уурхайчдын үйл ажиллагааны янз бүрийн хэв маягийг тодорхойлж тохирсон шийдвэр гаргаж хөгжүүлэхэд саад болон бодлогын талаар хэлэлцүүлэг хийхэд саад

	Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
	явуулдаг бичил уурхайчид). Аргагүйн эрхэнд (байгалийн гамшгаас шалтгаалсан хэт ядуурал) болон гэнэтийн цугларалтын (богино хугацаанд орлого олох гэнэтийн боломж) байдлаар БУ-н үйл ажиллагаа явуулахад хүргэж байгаа учир шалтгаануудын талаар хөгжлийн асуудлын байр суурьнаас хандаж бодитоор мэдээлэх	тотгор болдог. <i>Олон нийтэд суурилсан (байнгын болон улирлын чанартай) бичил уурхайн үйл ажиллагаа нь орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, тогтвортой амьжиргааг бий болгодог урт хугацааны эдийн засгийн үйл ажиллагаа юм.</i> <i>Аргагүйн эрхэнд хийгдэж байгаа бичил уурхайн үйл ажиллагаа нь үүнд оролцож байгаа бичил уурхайчдын ядуурлын түвшин маш өндөр байгаагийн шинж тэмдэг юм. Үүнийг нөлөөнд автсан салбарт нь үндсээр нь авч үзэх хэрэгтэй юм (жишээлбэл: зуднаас мал сүргийг хамгаалах арга хэмжээ г.м.).</i> <i>Гэнэтийн цугларалтын байдалтай бичил уурхайн үйл ажиллагаа нь түр зуурын шинж чанартай боловч байнгын тогтвортой орлогын эх үүсвэр болох зүйл байсан цагт л энэ ажиллагаа багасах, зогсох боломжтой юм.</i> <i>ТБУТ-ийн зүгээс олон нийтэд тулгууралсан бичил уурхайчдын хөгжлийг амьжиргаагаа дээшлүүлэх байнгын боломж гэдэг талаас нь дэмжиж болох юм. Бусад салбартай холбоотой орлогын эх үүсвэр болгох боломж бий болгох нь эдгээр салбарт төвлөрсөн төслүүдийн хийх ажил юм.</i>
С) 	Шудрага худалдааны экспортын талаарх асуудлыг идэвхижүүлж үүнээс гарах ашиг тусыг таниулах Бичил уурхайчдын байгууллагаас гэрчилгээ бүхий алтыг экспортлох бололцооны талаар судалж боломжтой болгох ☒ <u>Онцгой үйл явдал 1:</u> Бичил уурхайчдын үйлдвэрлэсэн алтыг экспортлох бололцоо болон үүний процесс тодорхой болсон байна ☒ <u>Онцгой үйл явдал 2:</u> Бичил уурхайчдын үйлдвэрлэсэн алт шудрага худалдааны шугамаар экспортлогдсон байна	Шудрага худалдааны зах зээлийг Монголын нөхцөлд нээж өгөх үйл ажиллагаа татварын болон алт экспортлох асуудал хариуцсан эрх мэдэлтэнгүүдтэй нягт холбоотой, хамтын ажиллагааг шаардна.³⁴ Хууль ёсны дагуу олборлосон, ил тод, гарал үүсэл нь тодорхой алтыг экспортлох явдал нь улс төрийн болон олон нийтийн дунд хийх ярилцлагуудад хүчтэй хэрэгсэл болж нөлөө үзүүлнэ.

³⁴ Exploratory conversations with the Central Bank of Mongolia have taken place during project planning and the Bank's opinion has been very favourable.

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
Бичил уурхайчдын дэмжих бүрэлдэхүүн хэсэг	
2.1 Хууль эрх зүй, зохицуулалтын хүрээнд бичил уурхай эрхлэгчид үйл ажиллагаагаа албан ёсны болгосон байна.	
Бичил уурхайчид хууль эрх зүйн заалтуудыг даган мөрдөж бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж олборлолт явуулах газрын зөвшөөрөл авах хүсэлт гаргах, авах шаардлагатай. Тэдгээр байгууллагуудын хамгийн сайн нь ашигт малтмалын эрх авах (олборлолтын тусгай эрх) дээд шатны хууль ёсны бизнесийн нэгж болох нөөц бололцоотой байгаа.	
А) Албан бус бичил уурхайчдын дунд үйл ажиллагаагаа албан ёсны болгоход нь дэмжих Гэнэтийн цугларалтын байдлаар олборлолт хийдэг бичил уурхайчдын үйл ажиллагааг албан ёсны болгоход хамгийн тохиромжтой сайн туршлагыг хэрэгжүүлэх, тодорхойлоход төрийн байгууллагын эрх бүхий хүмүүст дэмжлэг үзүүлэх (төв, орон нутаг, бүсийн захиргаа). Үйл ажиллагааг албан ёсны болгох талаар амжилт гаргасан оролдлогуудыг дэмжин дэлгэрүүлэх (жишээлбэл: бичил уурхайчид болон орон нутгийн захиргаанд зориулж гарын авлага, зааварчилга хэвлүүлэх, тараах гэх мэт)	“Зэрлэг нинжа” гэсэн нэр албан бус, гэнэтийн цугларалтын байдлаар үйл ажиллагаа явуулдаг бичил уурхайчдаас гаралтай. Харин одоо Ашигт малтмалын хуульд оруулсан өөрчлөлтийн тухай хууль батлагдсанаар бичил уурхайчдыг үйл ажиллагаагаа албан ёсны болгох боломжийг олгож байна. Төсөл тогтвортой ба хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг бичил уурхайчдыг дэмждэг учраас төрийн байгууллагын эрх мэдэлтэнгүүдийн гэнэтийн цугларалтын байдлаар үйл ажиллагаа явуулдаг бичил уурхайчдыг зохицуулах оролдлогыг нь дэмжих хэрэгтэй. Сайн туршлагауудыг тодорхойлж, дэмжин дэлгэрүүлэх хэрэгтэй. Жич: Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх бичил уурхайчдыг зохион байгуулах нь төслийн үүрэг биш харин Засгийн газрын хийх ажил юм. Харин төслийн зүгээс энэ ажилд дэмжлэг үзүүлэх, нийтлэг асуудлуудыг шийдвэрлэх, бий болсон туршлагыг системчлэх, сурсан сургамжийг дэмжин дэлгэрүүлэх зэрэгт хамтарч ажиллан, дэмжлэг үзүүлэх болно.
В) Бүртгэгдээгүй нөхөрлөлүүдэд албан ёсны болох үйл явцад зөвлөгөө өгөх Ялангуяа эхний үеээс чадавхи бэхжүүлэх, бий болгох бүтэц болон үүний үйл явц хэвийн байдлаар явагддаг болсон үе хүртэлх хугацаанд хууль эрх зүйн зөвлөгөө өгөх талаарх нүх цоорхойг бөглөж бичил уурхайчдын нөхөрлөлүүдийг сургаж дадлагажуулах талаар төсөл санаа тавьж ажиллана.	Ашигт малтмалын хуульд оруулсан өөрчлөлтийн тухай хууль болон бичил уурхайн журам батлагдсанаар бичил уурхайчдыг шинээр бий болсон хууль эрх зүйн орчинг дагаж мөрдөх шаардлага тавина.
С) Бичил уурхайчдын хууль ёсны арилжааны нэгжүүдэд албажуулах	Зохион байгуулалтын хувьд харьцангуй дэвшилттэй яваа бичил уурхайчдын бүлгүүд цаашид хууль

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
үйл явцын талаар зөвлөгөө өгөх Бичил уурхайчдын байгууллагуудыг хууль ёсны арилжааны нэгж болж хөгжих оролдлогыг нь зөвлөгөө өгөх үйлчилгээ өгөх замаар дэмжих. ☑ <u>Онцгой үйл явдал:</u> Арилжааны байгууллага болж хөгжсөн бичил уурхайчдын анхны байгууллага бий болох (ашигт малтмалын эрх авах боломж бүхий)	ёсны арилжааны нэгж болж хайгуулын болон ашиглалтын тусгай эрх авах хүсэлт гаргах сонирхолтой байгаагаа илэрхийлж (төлөвлөлтийн семинарийн үеэр) байсан. Эдгээр оролдлогууд нь бичил уурхайн салбарт энэ талын асуудлаар хамгийн анхны туршлага болж байгаа учраас ТБУТ иймэрхүү саналуудыг дэмжих шаардлагатай юм. Гэвч эдгээр дэмжлэгийг бичил уурхайчдын гишүүнчлэл дээр тулгууралсан байгууллагууд авах боломжтой ба <u>Жич:</u> Бичил уурхайчдын байгууллагууд арилжааны байгууллага болж өөрчлөгдөхөд тэд бичил уурхайн журмын дагуу үйл ажиллагаа явуулахаа больж Ашигт малтмалын ерөнхий журмыг дагаж мөрдөх хэрэгтэй болдог. Монгол Улсын хууль эрх зүйн орчны дагуу бичил уурхайчдын байгууллагууд илүү дээд төвшиний компани болон бүртгэлтэй нөхөрлөл хэлбэрт шилжих нь нээлттэй байдаг. Иймээс төсөл цаашид хөгжиж дэвжихийг хүссэн, ашигт малтмалын эрх авах хүсэл эрмэлзэл бүхий бичил уурхайчдын олон нийтэд суурилсан байгууллагуудыг дэмжиж ажиллана.
С) Бичил уурхайчдын байгууллагуудын зах зээлийн талаарх чадавхи боломжийг бий болгох Бичил уурхайчдын байгууллагуудыг өөрсдийнхөө бүтээгдэхүүнийг хууль ёсны дагуу арилжаалах талаар хийж байгаа оролдлогуудыг нь дэмжих, бизнесийн ур чадварыг нь бэхжүүлэх, ялангуяа анхны үүсгэл санаачлагууд дээр хууль эрх зүйн талаар зөвлөгөө өгөх.	Зөвхөн хууль ёсны, бичил уурхайчдын гишүүнчлэл дээд суурилсан байгууллагууд Шудрага худалдааны системд орж болно. Үүнд алт худалдаалах ажиллагаа явуулах эрхтэй байх, үнийн нэхэмжлэл явуулах, төлбөр хүлээж авах, татвар төлөх гэх мэт бүхий л үйл ажиллагаанууд хамрагдана. Зөвхөн тодорхой нөхцөлд эдгээр үйл ажиллагаануудыг хийх эрх олгогдно. Монгол улсын хууль эрх зүйн орчинд хамгийн нийцтэй хэлбэрийг тодорхойлох хэрэгтэй.

Төслийн үр дүн 2:

Бичил уурхайчдын байгууллагууд гишүүд, дэмжигч, хамтран ажиллагч талуудын хүсэл сонирхолыг илэрхийлдэг болно.

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
Бичил уурхайн бодлогын бүрэлдэхүүн хэсэг 1.2 Үндэсний болон орон нутгийн хэмжээнд төр, засгийн болон бусад субъектүүд бичил уурхайн салбарыг хамтран ажиллагч, баялагийг бүтээгч болгох талаар	

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
тэдэнтэй хамтран ажилладаг болсон байна	
Зохион байгуулалтад ороогүй бичил уурхайчид дуу хоолой хүсэл бодлоо хүргэх чадваргүй байх ба хэрэв бичил уурхайчдыг төлөөлсөн байгууллага байхгүй бол Засгийн газар болон бусад харилцагч талууд хэлэлцүүлэг хийхэд хамтрах тал байхгүй болно. Орон нутгийн болон үндэсний төвшинд бичил уурхайчдын байгууллага байгуулах нь маш чухал юм.	
А) Олон нийтийн болон бодлогын хэлэлцүүлэгт оролцох талаарх бичил уурхайчдын байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх Үндэсний болон аймаг сумын түвшинд бодлого боловсруулагчид болон бусад холбогдох хүмүүст бичил уурхайчдын үндэсний хэмжээний дээвэр байгууллагын талаар бичил уурхайчдын манлайлагчдыг бодлогоор дэмжих, хэлэлцэх болон хэвлэл мэдээлэлийн байгууллагатай харьцах талаар сургах замаар илэрхийлэх/ойлголт өгөх. ☒ Онцгой үйл явдал: Бичил уурхайчдын дээвэр байгууллага олон нийтийн дунд гарч ирэх	Засгийн газрыг бичил уурхайн салбартай хэлэлцүүлэг хийхэд бичил уурхайчдын үндэсний хэмжээний дээвэр байгууллага байгуулагдсан байх шаардлагатай. Бичил уурхайчдын дээвэр байгууллага (бичил уурхайчдын нэгдсэн холбоо) Засгийн газартай хэлэлцэж тохиролцох чадавхитай байх ёстой. Төсөл Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсгээр дамжуулан бичил уурхайчдын үндэсний хэмжээний дээвэр байгууллага байгуулах хэрэгцээ шаардлага, ач холбогдолын талаарх ойлголтыг бэхжүүлэх, суулгах; Бичил уурхайн бодлогын бүрэлдэхүүн хэсгээр дамжуулан дээвэр байгууллагыг бодлогын хэлэлцүүлэг хийхэд итгэл найдвар хүлээсэн, нэр хүнд бүхий байгууллага болоход сургаж дадлагажуулах.
В) Бичил уурхайчдын байгууллагыг хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэхэд нөлөө үзүүлэх ажилд нь дэмжлэг үзүүлэх Үндэсний төвшинд бичил уурхайчдын байгууллагыг хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэхэд нөлөө үзүүлэхэд нь дэмжих, бүсийн болон орон нутгийн төвшинд хууль эрх зүйн тогтвортой байдлын талаар дэмжих	Бичил уурхайчдын байгууллагууд (тухайлбал, бичил уурхайчдын холбоо) бичил уурхайчдын дуу хоолой болдог. Бичил уурхайчдыг нөлөөлөл үзүүлэх тал дээр алхам алхамаар сургах шаардлагатай. Гол асуудлууд нь зохион байгуулалт ба дайчлан ажиллуулах, хэлэлцээ, удирдлагыг тодорхойлох, бичгийн болон аман харилцааны чадвар, улс төрийн удирдагчидтай харилцаа холбоо тогтоох, сэтгэл зүйн талаар бэлтгэх гэх мэт чиглэлтэй байна. Энэ бүх ажлуудыг хийх гол зорилго нь бичил уурхайчдын дунд цаашид үйл ажиллагаа явуулах, хэлэлцээр, зөвшилцөөн хийх, бодлого боловсруулахад голлох үүрэг гүйцэтгэх гол хүмүүсийг төрүүлж бий болгоход оршино.
Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсэг	
2.2 Бичил уурхай эрхлэгчид нь хамтын ажиллагаатай, үйлдвэрлэгч байгууллагууд болоход төр, засаг, бусад хамтрагч талуудтай хамтран ажилладаг болсон байна	
Зохион байгуулалтанд ороогүй, бие даасан бичил уурхайчид том хэмжээтэй “бух” алт олно гэж мөрөөдөж болох боловч ингэх боломж нь тун бага юм. Бичил уурхайчдын хөгжиж дэвших боломжийг гаргаж нээж өгөхийн тулд бичил уурхайчид	

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
зохион байгуулалтанд орох ёстой. Зөвхөн зохион байгуулалтанд орсон бичил уурхайчид л олборлолтын ажлаа албан ёсны болгож, хэрэгцээ шаардлагаа бусад харилцагч талуудтай зөвшилцөх замаар илэрхийлж, ажлын байр болон бүтээмжийг сайжруулах зорилгоор сайжруулсан үр бүтээл өндөртэй техник технологи ашиглаж чадна. Орон нутгийн бичил уурхайчдын байгууллагууд (ТББ) олборлолтын үйл ажиллагаа болон газрыг захирах, зохицуулах ажилд гол үүрэг гүйцэтгэх шаардлагатай. Бичил уурхайчдын байгууллагууд бичил уурхайчдын үндэсний дээвэр байгууллага байгуулж нэгдэх хэрэгцээ шаардлагыг ойлгож ухаарсан байх хэрэгтэй.	
А) Орон нутгийн, бүсийн болон үндэсний төвшинд байгууллага байгуулах үйл явцыг дэмжих <u>Орон нутгийн төвшинд (үйлдвэрлэгч байгууллагууд):</u> • Бие даасан бичил уурхайчнаас нөхөрлөл байгуулах чиглэлд • Нөхөрлөлөөс бичил уурхайчдын ТББ байгуулах чиглэлд • Бичил уурхайчдын ТББ-аас олон нийтэд суурилсан арилжааны нэгж байгуулах чиглэлд <u>Бүсийн болон үндэсний төвшинд (холбоо/нэгтгэсэн байгууллагууд):</u> • Бичил уурхайчдын ТББ, арилжааны нэгжээс аймгийн төвшинд бүсийн байгууллага байгуулах чиглэлд • Орон нутгийн болон аймгийн төвшинөөс бүх бичил уурхайчдыг төлөөлсөн үндэсний дээвэр байгууллага байгуулах чиглэлд ☒ <u>Чухал үйл явдал:</u> Бичил уурхайчид дээвэр байгууллага байгуулсан байх.	Бичил уурхайчдын байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, сайжруулах шаардлагатай бөгөөд бичил уурхайчид санхүүгийн хувьд боломжтой, хэтийн зорилгод хүргэх удирдагчидтай, үүнд хүрэхийн төлөө хийх ажил нь тодорхой бат бөх, тогтвортой институцтай байх хэрэгтэй. ТБУТ үндэсний дээвэр байгууллага байгуулж болохгүй ба энэ нь бичил уурхайчдын өөрсдийнх нь санал санаачлага байх ёстой. ТБУТ-ын зүгээс үүнийг бичил уурхайчдыг ийм үйл ажиллагаанд оролцох боломжоор хангах, манлайлагчдыг чадваржуулах, нийтлэг үйл ажиллагааг дэмжих замаар идэвхижүүлж болно.
В) Бичил уурхайчдын байгууллагуудыг үндсэн үйл ажиллагаагаа явуулахад нь чиг баримжаагаар хангах Орон нутгийн бичил уурхайчдын байгууллагуудыг гишүүддээ үйлчилгээ үзүүлэгч байгууллага болоход нь дэмжлэг үзүүлэх.	Орон нутгийн төвшиний бичил уурхайчдын байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа нь гишүүддээ <u>уурхайтай</u> холбоотой үйлчилгээ (засаглал, төлөвлөх, хянах, олборлолт, санхүүгийн менежмент, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа ба эрүүл мэнд, нөлөөлөл, олон нийтийн хөгжил, байгаль орчны менежмент гэх мэт) үзүүлж дэмжих явдал юм. Олон нийтэд тулгууралсан бичил уурхайчдын байгууллагууд нь мөн олон нийтийг хөгжүүлэх ерөнхий чиглэлтэй уул уурхайнтай холбоогүй үйл ажиллагаанд хамрагдаж болно. Энэ нь тэдний эрхийн асуудал учраас ийм үйл ажиллагаа явуулахдаа ТБУТ-ын үйл дэмжлэгийн хүрээнд явуулж болохгүй юм. ТБУД нь уурхайтай холбоотой асуудлуудыг дэмжихэд төвлөрөх ёстой.

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
С) Бичил уурхайчдын байгууллагуудыг хамтран эзэмшиж ашиглах технологийг болон бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх авахад идэвхижүүлэх Олдож болох хамгийн дэвшилтэт технологийг хамтарч эзэмшин ашиглах боломжтой бичил уурхайчдын байгууллагуудыг тодорхойлох (технологийн хувьд тэргүүлэх боломжтой байгууллага болон “манлайлагчдыг” тодорхойлох) Хамтран эзэмших технологийг худалдаж авах, эзэмших болон ажиллуулахад хамгийн тохиромжтой зохион байгуулалтын хэлбэрийн талаар зөвлөх, дэмжих	Мөнгөн усгүй хүдэр баяжуулах цех, нөхөн сэргээлтэд ашиглах трактор, механикжуулсан уурхайн ам, агааржуулалтын систем гэх мэт өндөр үнэ өртөг бүхий дэвшилтэт технологийн эзэмшил нь ихэнх тохиолдолд хамтын эзэмшлийх байдаг. ТБУТ-ийн зүгээс зохион байгуулалтанд орж ашигт малтмалын эрх авах талаар тодорхой амжилтанд хүрсэн бичил уурхайчидтай (“манлайлагчид”) ажиллан олдож болох хамгийн дэвшилтэт технологийг өөр өөр ашигт малтмал (алт, нүүрс, жонш г.м.) олборлодог газруудад танилцуулна. Иймэрхүү олборлолтын болон баяжуулалтын технологийг ашиглах чадвартай бичил уурхайчдын байгууллагууд байгуулагдсан байх ёстой. Бие даасан хөрөнгө оруулагчидтай ажиллахдаа ТБУТ болгоомжтой байх хэрэгтэй. Төслийн зорилго нь бичил уурхайчдыг хөрөнгө оруулагч болгож хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх явдал учраас энэ ухагдахууныг эсэргээр хэрэгжүүлэхээс болгоомжлох хэрэгтэй.³⁵
D) Бичил уурхайчдын байгууллагуудад Шудрага худалдааны алт үйлдвэрлэгч болох асуудал дээр онцолсон зохион байгуулалтын тусгай дэмжлэг үзүүлэх Бусад орны баталгаатай үйлдвэрлэгч байгууллагуудаас заавар зөвлөгөө авч туршлагаас нь суралцах Бичил уурхайн алтны стандартын шаардлагыг Монголын нөхцөлд биелүүлэх боломжийн талаар ХУУХ болон ШХТБ-тай хамтран ажиллах Бичил уурхайчдын байгууллагуудад ШХ үйлдвэрлэгчдийн дэмжлэгийг хүртэх боломж өгөх ☒ <u>Чухал үйл явдал:</u> Монгол Улсад Шудрага худалдаа-шудрага олборлолтын стандартыг хэрэгжүүлэх	Шудрага худалдааны стандартын байгууллага нь үйлдвэрлэгч байгууллагуудын ардчилсан засаглалтай гишүүнчлэл дээр тулгуурласан статуст тусгайлан ач холбогдол өгдөг. Тусгай худалдааны тэмдэгт бүхий үйлдвэрлэгч байгууллагууд (бичил уурхайчдын байгууллагууд) хууль ёсны олборлолтын газарт явагдаж байгаа үйл ажиллагааг хянах үүрэгтэй ба гишүүдээ төлөөлж бүтээгдэхүүнээ борлуулах үйл ажиллагаанд оролцох боломжтой байх ёстой. ТБУТ “үйлдвэрлэгчдийг дэмжих” талаар зааварчлага авч болох ба Шудрага худалдаа-шудрага олборлолтын гэрчилгээнд хамрагдсан бусад орнуудын туршлагаас суралцаж санаа авах боломжтой юм.

³⁵ The difference may be gradual and drawing the line may be difficult in some cases. The Project needs a clear understanding regarding the “business case” of ASM, which is an income generating (therefore „for profit”) activity and requires investment! Even in pure community based ASM, each individual member “invests” in the mining operation and the level of financial commitment may differ among members. The project needs to be able to distinguish such ASM investors who intent to “exploit the mine” (and who deserve the support of SAM) from investors who intent to “exploit the miners”.

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
үүд хаалга нээгдсэн байна	

Төслийн үр дүн 3:

Нийгмийн хариуцлагатай бичил уурхай эрхлэгчид ажлын байрны аюулгүй байдлыг хангаж нийгмийн баталгаатай болсон байна

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
Бичил уурхайн бодлогын бүрэлдэхүүн хэсэг 1.3 Бичил уурхайн ажлын байрны аюулгүй байдал, нийгмийн баталгааг дээшлүүлэхэд чиглэсэн төрийн ба хувийн салбарын үйлчилгээ хариуцлагатай бичил уурхай эрхлэгчдэд хүртээмжтэй болсон байна Бичил уурхайн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн нөхцлийг сайжруулах нь чухалчилж үзэх асуудал гэдэг дээр бүх хамтрагч талууд санал нэгтэй байгаа. Бичил уурхайн үйл ажиллагаа явуулдаг газруудад осол аваар олон гардаг ба аврах үйлчилгээг тэдэнд хүргэх шаардлагатай байна. Мөн нийгмийн хариуцлагатай байдал бичил уурхайчдыг нийгмийн хамгааллын системд нэгтгэх зорилгоор албан бус нийгмийн хамгааллын сүлжээнээс шлжих явдалтай холбоотой юм.	
А) Бичил уурхайтай холбоотой зааварчлагуудыг албан ёсоор баталгаажуулж гаргах ажлыг идэвхижүүлэх Бичил уурхайд зориулсан энгийн, ойлгомжтой аюулгүй ажиллагааны болон бусад зааварчлага стандартуудыг боловсруулж гаргах, албан ёсоор батлуулах боломжийг эрж хайх. ☒ <u>Чухал үйл явдлууд:</u> Нягт нямбай бодож боловсруулсан бичил уурхайн зааварчлагууд батлагдаж, хэвлэгдсэн байх	Төрийн захиргааны байгууллагуудын гүйцэтгэгч мэргэжилтнүүдийн (байцаагчид, уул уурхайнаврах албаныхан г.м.) дунд техник технологи муутай, боловсрол нимгэн бичил уурхайчдад энгийн бөгөөд хялбаршуулсан техникийн заарчлагууд яаралтай хэрэгтэй байна гэсэн ойлголт маш өргөн байна. Мөн үүнээс гадна ийм зааварчлага, стандарт нь орон нутгийн байцаагчдад үйл ажиллагаагаа явуулахад шалгуур үзүүлэлт болох юм. Үүнийг хийж гүйцэтгэхэд энэ талын асуудал хариуцсан албан тушаалтнуудтай нягт холбоотой ажиллах шаардлагатай.
В) Бичил уурхайчдыг нийгмийн хамгааллын албан ёсны системд хамруулах энгийн механизмыг нягт нямбай бодож боловсруулан санал болгох Бичил уурхайчдыг эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгалын багцууд, ялангуяа тэтгэвэр тэтгэмжийг багтаасан нийгмийн даатгалын системд хамруулах ажиллагааг идэвхижүүлэх, энэ талаар материал боловсруулж санал болгох ☒ <u>Чухал үйл явдал:</u> Бичил уурхайчдад нийгмийн хамгааллын системд	Бичил уурхайн үйл ажиллагаа нь хүнд хэцүү ажил учраас ихэнх бичил уурхайчид энэ ажлыг зөвхөн тодорхой хугацааны турш л хийж чадна. Одоогийн байдлаар эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамаргдсан бичил уурхайчдын тоо маш цөөн байна. НХХЯ-наас малчид болон өөрөө өөртөө ажлын байр бий болгосон иргэдийг нийгмийн хамгааллын системд харуулах тухай төсөл боловруулж байна. ТБУТ-ийн зүгээс бичил уурхайчдыг энэ системд албан ёсоор хамруулах боломжийг алдаж болохгүй юм.

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
хамрагдах явдал нээлттэй болох	Нийгмийн даатгалд хамруулах механизм болон бусад үйлчилгээгээр хангах ажилд аймаг, сумын холбоо бүхий албаны хүмүүсийг идэвхитэйгээр оролцуулах хэрэгтэй юм.
С) Бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй газруудад УУАА-аас үзүүлэх үйлчилгээг сайжруулах Сонгож авсан газруудад хөдөлгөөнт аврах баг байгуулж бичил уурхайчдад үр дүнтэй үйлчилгээ хүргэхэд нь УУАА-д дэмжлэг үзүүлэх. ☒ Жил бүрийн чухал үйл явдал: УУАА-ны гүйцэтгэлийн байдлаас хамаарч жилд нэг хөдөлгөөнт аврах хэсэг байгуулах (хэрэв байгуулсан аврах багуудыг УУАА-ны зүгээс зохицуулж ажиллуулсаар байх боломжтой бол жил бүр нэг ийм багийг нэмж байгуулж болох юм)	Бичил уурхайн аюулгүй ажиллагааг сайжруулах нь бүх хамтрагч талуудын хамгийн чухалчлан үзэх асуудал юм. Хэдийгээр бичил уурхайд гарсан ослоос хүний амь хохирсон тоог том уурхайн осолтой харьцуулж үзвэл бараг ижил мэт байгаа боловч бичил уурхайчдын өсгөсөн тоотой харьцуулбал энэ тоо нь үнэхээр сэтгэл түгшээж байгаа юм. УУАА-ны зүгээс үйлчилгээнийхээ хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор 3 газарт аврах баг байгуулах санал тавьж байгаа. УУАА-ны бичил уурхайн газруудад үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх гэсэн оролдлыг нь дэмжих хэрэгтэй боловч УУАА-ны зүгээс эдгээр аврах багуудыг ямар нэгэн гадны дэмжлэг тусалцаагүйгээр тогтвортой байлгаж, үйл ажиллагааг нь явуулж чадна гэдгээ практик дээр батлах хэрэгтэй юм.
Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсэг 2.3 Хариуцлагатай бичил уурхайчид нийгмийн хамгааллын системд хамрагдаж ажлын байрныхаа аюулгүй байдал, нөхцлийг сайжруулан орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулна. Бичил уурхайчдын сэтгэхүйг хяналтгүй, хянах боломжгүй “нинжа”-гаас хариуцлагатай хувиараа ашигт малтмал олборлогч иргэн болгож өөрчлөх үйл явц үргэлжлэх шаардлагатайгаас гадна улам эрчимжүүлэх хэрэгтэй юм. Бичил уурхайчдын ажлын байрыг аюулгүй ажиллагааны талаарх мэдлэгийг дээшлүүлэх болон бичил уурхайчдын аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмж ашиглахыг дэмжих замаар аюул осол багатай болгох хэрэгтэйгээс гадна бичил уурхайчдыг ослоос урьдчилан хамгаалж бэлтгэл хангадаг болгох хэрэгтэй. Бичил уурхайг орон нутагт өөрөө өөртөө ажлын байр бий болгож байгаа гэдэг талаас нь нийгмийн хамгааллын системд оруулах хэрэгтэй бөгөөд бичил уурхайчдыг нийгмийн даатгалы системд нэгдэн орох талаар ойлгуулж, ухамсарлуулах хэрэгтэй.	
А) Албан бус нийгмийн хамгааллын сүлжээг албан ёсны нийгмийн даатгалын системд шилжүүлэх Бичил уурхайчдад одоогийн байгаа албан ёсны нийгмийн хамгааллын системийн талаар мэдээлэл хүргэж эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдах асуудлыг дэмжих. ☒ Чухал үүйл явдал 1: Бичил	Бичил уурхайчид голдуу урьд нь малчин байсан үеийнхтэйгээ нэгэн адилаар гэр бүл болон хэсэг бүлгээрээ харилцан дэмжиж амьдардаг албан бус нийгмийн хамгааллын сүлжээндээ найдаж амьдардаг. Бодлогын түвшинд бичил уурхайчдыг албан ёсны нийгмийн даатгалын системд хамруулах сонирхол татахуйц мөн ашглаж болохуйц даатгалын хэлбэрүүдийг бий болгох хэрэгтэй. Одоо ашиглагдаж байгаа болон шинээр

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
уурхайчдад нийгмийн хамгааллын систем нээлттэй болж нэвтрүүлсэн байна	бий болгосон албан ёсны даатгалын багцуудын үнэ, үүнээс гарах ач тус гэх мэт мэдээллүүдийг бичил уурхайчдад хүргэх хэрэгтэй.
В) Бичил уурхайн холбоотой зааварчлагуудыг боловсруулах нарийвчлан Бичил уурхайчдад зориулж энгийн бөгөөд тодорхой аюулгүй ажиллагаа болон үйл ажиллагааны зааварчлагуудыг нарийвчлан боловсруулах. Боломжит сэдвүүд: • Аюулгүй ажиллагааны төхөөрөмжүүдийг ашиглах • Уурхайн ерөнхий агааржуулалт ба агаарын найрлага шалгах • Нүүрсний уурхайн агааржуулалт ба агаарын найрлага шалгах • Нуралт ба уурхайн найдвартай байдал • Өргөгч (лебодка) ба амны бэхэлгээ • Нөхөн сэргээлт • Ашигт малтмалыг баяжуулах зааварчлага • Бусад ☒ <u>Чухал үйл явдал:</u> Зааварчлагуудыг нарийвчлан боловсруулж батлуулан хэвлүүлсэн байх	Боловсрол нимгэнтэй, энгийн технологи хэрэглэдэг бичил уурхайчид голдуу унших, ойлгох болон том уурхайнуудад зориулж инженерийн төвшинд боловсруулсан үндэсний стандартыг дагаж мөрдөх талаар чадвар муутай байдаг. Тиймээс тэдэнд энгийн бөгөөд тодорхой дүрэм журам хэрэгтэй болдог (Жишээлбэл: нэг сэдэв хамгийн ихдээ 10 заалттай байх гэх мэт. Богино байх тусмаа л сайн). Иймээс бичил уурхайн стандартууд бичил уурхайчдад тодорхой заавар өгдөг байх ёстой. Ялангуяа албан ёсоор батлагдаж гарсан тохиолдолд энгийн дүрэм журамнууд нь хэрэгжүүлэхэд илүү боломжтой байдаг.
С) Аюул осол багатай уурхайн технологи нэвтрүүлэх Олборлолтын үйл ажиллагааг илүү үр дүнтэй, аюул осол багатай байхаар зохион байгуулах, тохиромжтой технологийг механикийн хувьд боломжтой төвшинд хэрэглэхийг дэмжих. Илүү аюул осол багатай, нэвтрүүлж болохуйц олборлолтын технологи болон аргачлалыг танилцуулах	Уурхайн аюулгүй ажиллагаа сайн биш байх нь технологийн талаарх мэдлэг дутмаг байдагтай салшгүй холбоотой. Жижиг нөхөрлөлийн хэлбэртэй байгууллага болон зохион байгуулалтгүй нөхөрлөлүүд нь осол гамшиг гарах нэмэлт шалтгаан болдог. Монгол Улсын бичил уурхайн салбар үүсч бий болоод 10-аадхан жил болж байгаагаас гадна нилээд тусгаарлагдмал байдалд үүсч хөгжсөн. Технологийн шийдлүүд нь голдуу “гар аргаар” хийгдсэн бичил уурхайд хэрэглэдэг хамгийн сайн технологийн туршлагаас жишээ санаа аваагүй байдаг. Шинэ содон төхөөрөмжүүд (тухайлбал, хуурай баяжуулагч) нь бичил уурхайчд технологийн шинэчлэл хийхэд бэлэн байгааг харуулж байна.

	Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
		Илүү тохиромжтой төхөөрөмжийг нэвтрүүлэх сал санаачлага дороосоо гарах ёстой: бичил уурхайчдаас үйл ажиллагаагаа сайжруулах талаар гаргасан хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэх ёстой ба тэд өөрсдөө тенологийн шинэчлэлд биечлэн оролцож, хувь нэмэр оруулах ёстой.
D)	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл мэндийн талаар чадваржуулах ерөнхий үйл ажиллагаа ба мэдэгдэхүүн олгох Бичил уурхайн үйл ажиллагаа явагддаг газруудад хүрч ажиллах орон нутгийн ХХЭМ-ийн сургагчдыг бэлтгэх сүлжээний бүтэц бий болгох ХХЭМ-ийн сүлжээнд бүх хамаа бүхий байгууллагуудыг оролцуулах (Ийм байгууллагууд нь нөхцөл байдлыг сайжруулах талаар үүрэг хариуцлага хүлээсэн байдаг) ХХЭМ-ийн сүлжээг энгийн байдлаар зааварчилсан сургалтын материалаар дэмжих ☒ <u>Чухал үйл явдал:</u> ХХЭМ-ийн талаар ажилладаг байгууллагуудын сүлжээ байгуулагдсан байна	Бичил уурхайн аюулгүй ажиллагааг дээшлүүлэх асуудалд энэ асуудлыг хариуцдаг байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа, бичил уурхайчид, хувийн болон төрийн байгууллагуудын оролцоо чухал шаардлагатай. ХХЭМ-ийн талаарх одоогийн байгаа хүчин чадал нь олон тооны бичил уурхайчдад хүрч ажиллах боломжгүй юм. Иймээс одоогийн байгаа бүтцийг сургагчдыг бэлтгэн орон нутагт бичил уурхайчдын байгууллагууд болон төрийн үйлчилгээний байгууллагуудын чадавхи бэхжүүлэх чадавхийг бий болгох хэрэгтэй. Бичил уурхайн ХХЭМ хамгийн их санаа зовоосон асуудал болж байна гэдгийг бүх төрийн байгууллагууд хүлээн зөвшөөрч илэрхийлж байсан. ТБУТ-ийн хувьд эдгээр хэрэгцээ шаардлагыг тодруулж үйл ажиллагаа болгоход нь анхаарал хандуулах хэрэгтэй.
E)	Орон нутагт аврах үйлчилгээ байгуулах Бичил уурхайчдын байгууллагуудыг УУАА-ны хөдөлгөөнт аврах багуудтай холбогдож орон нутаг дахь салбарын үйлчилгээ хүргэхэд нь дэмжлэг үзүүлэх Аймгийн Онцгой байдлын албанд уул уурхайн аврах чиглэлээр чадавхийг бэхжүүлэх, дэмжих.	УУАА-ны зүгээс бичил уурхайчдад үзүүлэх үйлчилгээгээ өргөтгөх зорилгоор тодорхой стратегийн дагуу том уурхайн компаниудыг түшиглэн аврах баг байгуулах төлөвлөгөөтэй байна. Энэ хөдөлгөөнт аврах анги бичил уурхайн үйл ажиллагаа явагддаг газруудад хүрч ажиллах хэрэгтэй. Аймгийн онцгой байдлын албууд ерөнхий болон аврах дэд бүтэцтэй байдаг ба зарим тохиолдолд уурхайн аврах ажилд оролцдог. УУАА мөн аймгийн Онцгой байдлын газартай чадавхи бэхжүүлэх талаар хамтарч ажиллах төлөвлөгөөтэй байгаа ба шаардлага гарсан үед дэмжлэг үзүүлэх болно. Хөдөлгөөнт аврах багийн үйл ажиллагааны болон урсгал засварын зардлыг УУАА хариуцах ёстой. ТБУТ бичил уурхайн байгууллагууд болон аймгийн онцгой байдлын газрыг УУАА-тай холбоотой ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
F)  Шудрага худалдаа-шудрага олборлолтын стандартын дагуу ажлын байрны аюулгүй ажиллагаа болон нөхцлийг сайжруулах Алтны туршилтын сайтууд дахь бичил уурхайчдын байгууллагуудтай Шудрага худалдаа-шудрага олборлолтын стандартын дагуу ажлын байрны аюулгүй ажиллагаа болон нөхцлийн шаардлагыг хангах талаар ажиллах ☒ Чухал үйл явдал: Бичил уурхайчдын байгууллага шудрага худалдаа-шудрага олборлолтын гэрчилгээ авах	Шудрага худалдаа-шудрага олборлолтын стандартын гол шаардлага нь ажлын байрны аюулгүй ажиллагаа хөдөлмөрийн нөхцөл байдаг. Төслийн үйл ажиллагаа хэрэгждэг алтны бичил уурхайчдын газрууд бичил уурхайн олон улсын сайн туршлагын дагуу үйл ажиллагаа явуулж харуулах хэрэгтэй. Үүний тулд олон улсын стандартын шаардлагыг хангахын төлөө ажиллах ёстой. Бичил уурхайчдын байгууллагын үйл ажиллагааны хэрэгжлтийг дэмжсэнээр ТБУТ нь тэдгээр байгууллагуудын энэ гэрчилгээг авах оролдлогод нь дэмжлэг үзүүлж байна гэсэн үг юм. Ингэж ажилласнаар ажлын байрны нөхцлийг сайжруулахын хажуугаар Шудрага худалдааны системээс орж ирэх ашиг тусыг мөн хүртэх нь бичил уурхайчдын байгууллагуудад том урамшуулал болох юм. Өөр төрлийн ашигт малтмал олборлодог (иймээс шудрага худалдааны системд нэгдэх боломжгүй) төсөл хэрэгждэг сайтууд дээр аюулгүй ажиллагааны хамгийн наад захын шаардлагуудыг дор хаяж хангаж ажилладаг болгох хэрэгтэй.
G) Бичил уурхайчдын байгууллагуудын орон нутгийн нийгмийн хариуцлагын талаарх хөтөлбөрүүдийг өрнүүлэх Бичил уурхайчдын байгууллагуудад олон нийтийн хөгжлийн талаарх үйл ажиллагааг чухалчилж үзэхийг зөвлөх	Олон нийтэд тулгууралсан олборлолтын ажиллагаа гэдэг нь тухайн орон нутгийн оршин суугчид ашигт малтмал олборлонгоо орон нутгийнхаа хөгжилд хувь нэмэр оруулахыг хэлнэ. Шудрага худалдаа-шудрага олборлолтын системийн гишүүн байгууллагуудад шудрага худалдааны нэмэгдэл шагналынхаа тодорхой хэсгийг орон нутгийн хөгжилд зориулах шаардлага тавигддаг. Ер нь энэ системд нэгдэн ороогүй байсан ч гэсэн олон нийтэд тулгууралсан бичил уурхайчдын байгууллагуудаас орон нутгийнхаа хөгжилд хувьнэмэр оруулах хүлээлттэй байдаг. ТБУТ-ийн зүгээс бичил уурхайчдын байгууллагуудын явуулах олон нийтийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагаануудыг дэмжиж, зөвлөгөө өгөх. Гэвч бичил уурхайн холбогдолгүй үйл ажиллагаануудыг дэмжих, санхүүжүүлэх, болон явуулах нь ТБУТ-ийн үүрэгт ажил биш юм гэдгийг анхаарах хэрэгтэй!

Төслийн үр дүн 4:

Хариуцлагатай бичил уурхай эрхлэгчид байгаль орчинд хал багатай технологи хэрэглэж олборлолт явуулдаг болсон байна

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
Бичил уурхайн бодлогын бүрэлдэхүүн хэсэг	
1.4 Хэрэгжүүлж, дагаж мөрдөж болохуйц байгаль орчны шаардлагууд нь бичил уурхай эрхлэгчдэд хариуцлагатай байгаль орчинд халгүй олборлолт явуулах чиглэл болж өгсөн байна.	
Бичил уурхайгаас, ялангуяа шороон ордын бичил уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж байгаа нөлөө нь уг үйл ажиллагааны талаарх хамгийн гол асуудал болж байна. Энэ талаар холбогдох талууд зөвхөн асуудал үүсгэдэг байхын оронд мөн энэ байдлыг залруулах практикийг тодорхойлох, нэвтрүүлэхэд хувь нэмэр оруулдаг байх хэрэгтэй. Дүрэм журам нь үйл ажиллагааны хэмжээг сайтар анхаарсан байхаас гадна хэрэгжүүлэх боломжтой байх ёстой.	
А) Бичил уурхайд зориулсан байгаль орчны энгийн бөгөөд тодорхой заавар журмыг батлуулахад дэмжлэг үзүүлэх, идэвхижүүлэх Бичил уурхайд зориулсан байгаль орчны энгийн бөгөөд тодорхой заавар журмыг албан ёсоор батлуулах, гаргах арга замыг эрж хайх. ☒ <u>Чухал үйл явдал:</u> Бичил уурхайн заавар журмуудыг нарийвчлан боловсруулж батлуулан хэвлэсэн байна	Байгаль орчинд үзүүлсэн нөлөөнөөсөө шалтгаалж уул уурхайн ажиллагаа ерөнхийдөө, ялангуяа бичил уурхайн үйл ажиллагаа шүүмжлэлийн гол нөхцөл болдог. Гэвч бичил уурхайгаас экологид үзүүлж байгаа ул мөр нь маш бага (m3 хүдэр/гр алт), хүлэмжний хийн бохирдол бүр байхгүй, нөхөн сэргээлтийн ажил үргэлж дутмаг байдаг болон ерөнхийдөө байхгүй байдаг. Бичил уурхайчид энгийн бөгөөд ойлгомжтой байгаль орчны зааварчилгаа яаралтай шаардлагатай байгаа бөгөөд энэ нь олборлолт хийсэн газрыг нөхөн сэргээхэд болон байгаль орчинд нөлөөлж байгаа бусад нөлөөг хэрхэн бууруулах талаар яг ямар ажил хийж гүйцэтгэх талаар тодорхой дүрслэж зааварласан байх хэрэгтэй. Иймэрхүү зааварчилга нь мөн орон нутгийн байцаагчдад бичил уурхайчдын үйл ажиллагааг дүгнэх бодит шалгуур үзүүлэлт болж өгнө. Дотоодын эрх бүхий байгууллагуудтай нягт хамтран ажиллах шаардлагатай.
В) Мөнгөн усгүй технологи бүхий баяжуулах цехийн загварыг бичил уурхайд хэрэглэх “батлагдсан” технологи болгож баталгаажуулах ТБУТ-ийн боловсруулсан мөнгөн усгүй технологи бүхий баяжуулах цехийн загварыг бичил баримтжуулж, “нийтийн хүртээл” болгох (Жич: <i>in any case, the plant design consists of known components in usual</i>)	For processing of hard rock gold ores from ASM, the design of the Bornuur plant has proven to be efficient and is widely accepted by artisanal miners. The Засгийн газрын 28-р тогтоолоор баяжуулах цех байгуулах тоо хязгаарлагдмал байдаг ба энэ нь одоогийн байгаа хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байгаа юм. Үүний үр дагавараар нуугдмал байдлаар мөнгөн усыг алт бариулахад хэрэглэх явдал байсаар байгаа юм.

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
<i>combination</i>) Уг цехийн загварыг ижил төстэй үйл ажиллагаа явуулах эрх бүхий хэн бүхэн ашиглаж болох журам бий болгох хчиглэлээр ажиллах Уг цехийн загварыг авч ашиглах эрх авах ил тод, нээлттэй шаардлага бүхий журам гаргах чиглэлээр ажиллах ☒ <u>Чухал үйл явдал:</u> Баяжуулах цехийн технологийг “албан ёсоор” баталгаажуулсан байна	Үндсэн ордны хүдрийг баяжуулах хууль ёсны хангалттай хүчин чадал бий болгохын тулд уг цехийн загварыг албан ёсоор баталгаажуулж, бусад газруудад байгуулах баяжуулах цехүүдэд ашиглах боломжтой болгох хэрэгтэй байна. Харин баяжуулах цех барих тоог хязгаарлахгүйгээр байгуулах (мэдээж шаардлагатай бүх зөвшөөрлийг авсан тохиолдолд) талаар журамлах хэрэгтэй ба монопольчилон эзэмших аливаа оролдлогоос урьдчилан сэргийлэх талаар анхаарч ажиллах. <u>Жич:</u> Түр журмын дагуу байгуулах баяжуулах цехийн тоо хязгаарлагдмал байгаад барьсан цехийн үйл ажиллагааг “туршилтын” гэсэн тодорхойлолттой хэвээр байсан цагт ТБУТ-ийнүүнд оруулсан санхүүгийн дэмжлэг зөвхөн энэ загварыг ашиглаж болно гэдгийг батлах гэсэн оролдлого гэж тооцогдоно (Баянхонгорын ажиллагаа). Харин загвар батлагдсан цагт санхүүгийн болон тоног төхөөрөмжийн талаар оруулсан дэмжлэг, хувь нэмрийг бичил уурхайчдын байгууллагуудыг бэхжүүлэх, тогтворжуулах чиглэлд нягт холбоотойгоор зохицуулах хэрэгтэй юм.
Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсэгнт 2.4 Бичил уурхай эрхлэгчид нь байгаль орчны тавигдаж буй шаардлагуудыг мэддэг, хариуцлагатай, байгаль орчинд хал бага арга, технологи ашиглаж олборлолт хийдэг болсон байна Бичил уурхайд зориулсан байгаль орчны тодорхой, энгийн, бодит шаардлагуудыг яаралтай бий болгох хэрэгтэй байна. Байгаль орчинд хал багатай бичил уурхайн технологи байдаг боловч бичил уурхайчдад хүртээмжтэй болгох хэрэгтэй юм. Зарим нэгэн байгаль орчинд хал багатай боловсронгуй технологийг (системтэй төлөвлөсний дагуу ашиглах баяжуулах цех, трактор/эксковатор гэх мэт) зөвхөн зохион байгуулалтанд орсон бичил уурхайчид л худалдаж авах болон ашиглах боломжтой юм.	
А) Бичил уурхайчдад зориулсан энгийн бөгөөд хэрэгжүүлж болохуйц байгаль орчны зааварчлагуудыг нарийвчлан боловсруулж, дагаж мөрдөх ажиллагааг дэмжих Нөхөн сэргээлтийн ажил хийх талаар бичил уурхайчдын гаргасан амжилттай оролдлогуудыг системчилж хэрэгжүүлж болохуйц ерөнхий зааварчилга зохиох	Бичил уурхайчид энгийн бөгөөд ойлгомжтой байгаль орчны зааварчилгаа яаралтай шаардлагатай байгаа бөгөөд энэ нь олборлолт хийсэн газрыг нөхөн сэргээхэд болон байгаль орчинд нөлөөлж байгаа бусад нөлөөг хэрхэн бууруулах талаар яг ямар ажил хийж гүйцэтгэх талаар тодорхой дүрслэж зааварласан байх хэрэгтэй. Хэрэгжүүлэх боломжтой зааварчлага

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг сааруулах талаар доорх чиглэлийн зааварчлагуудыг боловсруулах. Үүнд: • Waste rock and tailings dumps • Хүчлийг Acid mine drainage • Урсгал болон гүний усыг хамгаалах • Хог хаягдалыг зохицуулах • Бусад. Бичил уурхайн байгаль орчны журмыг дагаж мөрдүүлэх талаар сумын байгаль орчны байцаагчидтай хамтарч ажиллах ☒ Чухал үйл явдал: Бичил уурхайн зааварчлагууд боловсруулагдаж, батлагдаж, хэвлэгдсэн байх	боловсруулахад үүний заалтнууд нь амьдрал дээр хэрэгжүүлж болох талаар батлагдсан байх хэрэгтэй ба бичил уурхайн технологийг аугилож хэрэгжүүлж болохуйц байх ёстой.
В) Байгаль орчны мониторинги хийхэд орон нутгийн оршин суугчдыг хамруулах замаар зөрчлийг бууруулах БОХТОХ төсөлтэй хамтран олон нийтэд тулгууралсан мониторинг хийх шугамаар зөрчлийг бууруулах, өөрөө зохицуулах ажлуудыг хэрэгжүүлнэ.	Бичил уурхайн үйл ажиллагаа нь уламжлалт мал аж ахуй болон бусад газар ашиглалтын төрлүүдтэй зэрэгцэж, зохицож оршин тогтнох хэрэгтэй. Олборлолтын үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголт дутмаг байх, үл итгэлцэл зэрэг нь орон нутагт гарч байгаа зөрчлийн гол хүчин зүйл болдог. Голландийн хөгжлийн байгууллагын хөрөнгө оруулалттай Азийн сангийн БОХТОХ төсөл нь уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчны мониторингийг олон нийтийг тулгуурлан хийх асуудал дээр анхаарч ажилладаг. Төслийн зүгээс том уурхайн талаар нөлөөллийн арга барилыг хэрэглэхийн зэрэгцээгээр олон нийтэд тулгууралсан бичил уурхайн чиглэлд зөрчлийг бууруулах арга барил барьж ажиллана. Хоёр төсөл хоорондоо нягт хаммтын ажиллагаатай байх боломжтой. Ер нь олон нийтийн сайн дурын үндсэн дээр хяналт шалгалт тавьж ажиллах нь ямар нэгэн шаардлага журмыг албан хүчээр даган мөрдүүлэх гэж оролдохоос илүү үр дүнтэй юм.
С) Борнуурын мөнгөн усгүй технологитой хүдэр баяжуулах цехийн загварыг түгээн дэлгэрүүлэх, өргөтгөх Борнуурын баяжуулах цехийн загвараар баяжуулах цех байгуулах сонирхолтой талуудыг зөвлөгөө өгөх (хөрөнгө оруулагчид) эсвэл шууд дэмжих (бичил уурхайчдын байгууллагуудыг) замаар дэмжих.	Хэдийгээр мөнгөн усны хэрэглээг алт баяжуулахад хэрэглэхийг хориглосон боловч үүнийг нууцаар хэрэглэх явдал нилээдгүй байгаа ба зөвхөн мөнгөн усгүй технологиор алт баяжуулдаг цех хангалттай хэмжээгээр байгуулж, үйлчилгээг хүргэснээр л үүнийг зогсоох боломжтой юм. Борнуурын баяжуулах цех бол бусад маш олон орны хувьд ч “урлагийн бүтээл” мэт ажил болсон ба Монгол Улсад энэ технологийг албан ёсоор баталгаажуулсны дараа өөр

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
☒ <u>Чухал үйл явдал:</u> Баянхонгорын баяжуулах цех баригдаж дуусаад үйл ажиллагаа явуулж эхэлсэн байх (одоогоор бүтээн босголт хийгдэж байгаа) Цаашид дахин өөр газар цех барих (ж.нь: Өмнөговь, Мандал, одоогоор төлөвлөж байгаа), үйл ажиллагаа явуулж байх	газруудад нэврүүлж байгуулах боломжтой юм. Баяжуулах цехийг ажиллуулах нь хувийн хөрөнгө оруулагчдын хувьд бизнесийн боломж болох ба бичил уурхайчдын байгууллагуудад олон нийтийг хөгжүүлэх боломж болж болно. Ер нь чөлөөт зах зээлийн орчинд баяжуулах цехүүд хаягдалаасаа үйл ажиллагааныхаа зардлыг нөхөх боломжтой байдгаас бичил уурхайчдын хувьд баяжуулалтын үнэ маш доогуур байх боломжтой байдаг. ТБУТ энэ цехийн загвараар баяжуулах цех байгуулах сонирхолтой хөрөнгө оруулагчдыг техникийн талын зөвлөгөө өгөх (үйлчилгээний чанарыг баталгаажуулах) эсвэл өөрсдөө баяжуулах цех байгуулах төлөвлөгөөтэй бичил уурхайчдын байгууллагуудыг шууд дэмжих хэрэгтэй. Олон нийтийн эзэмшил бүхий баяжуулах цехийн үйл ажиллагааг бичил уурхайчдын байгууллагад тавигддаг шаардлагыг хангах ажиллагааны нэг хэсэг болох Шудрага худалдаа-шудрага олборлолтын стандартын шаардлагуудад нийцүүлэн байгуулж ажиллуулах хэрэгтэй юм.
D) Алтны бичил уурхайн байгаль орчинд хал багатай, экологийн хувьд үр дүнтэй технологийн шийдэл боловсруулах ажлыг үргэлжлүүлэх Бичил уурхайчидтай хамтарч шороон ордын нойтон болон хуурай баяжуулалтын алт барилтыг сайжруулах чиглэлээр ажиллахад дотоодын болон олон улсын ноу-хау шийдлүүдийг ашиглах. Янз бүрийн нөхцөл байдал бүхий газруудад техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх ажлыг дэмжих, сайжруулах.	Шороон ордын хүдрийг баяжуулах явцад нарийн ширхэгтэй алт алдах явдал нийлээд өргөн байна гэж үзэж байгаа. Төслийн 2 дахь үе шатны үед боловсруулсан зарим шийдлүүд шороон ордын үйл ажиллагаа голчлон явагддаг улирлын байдлаас болж тийм ч өргөнөөр хэрэглэгдээгүй юм. Учир шороон ордын олборлолт голдуу өвөл газар хөлдсөн үед явагддаг бол шлюзийг ашиглахад ус ихээр шаардагддаг учраас зун хэрэглэхэд илүү тохиромжтой байдаг. Хүдэр дэх алтыг бүрэн авч чадахгүй байгаа нь ашигт малтмалыг зохистой ашиглахгүй байгаагийн нэг хэлбэр болохоос гадна нөхөн сэргээлт хийсэн газар дахин орох нөхцөл болдог. Техникийн сайжруулалт хийж болох өөр нэг хэсэг бол шороон ордын хуурай баяжуулагчийг томруулж сайжруулан алт барилтын хэмжээг нэмэгдүүлэх, улмаар тархай бутархай олборлолтын ажиллагааг төвлөрүүлэх явдал юм.

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
	Янз бүрийн нөхцөл байдал бүхий газруудад бичил уурхайн техник технологиор техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх, сайжруулах талаар судлах шаардлага гарч магадгүй юм.
Е)  Алтны олборлолт явуулдаг туршилтын сайтууд дээрх үйл ажиллагааг ШХ&ШО-ын стандартын дагуу явуулах талаар чиглүүлэх Алт олборлодог туршилтын сайтууд дахь бичил уурхайчдын байгууллагуудтай Алтны ШХ&ШО-ын стандартын шаардлагад нийцэж ажиллах чиглэлээр хамтарч ажиллах ☒ <u>Чухал үйл явдал:</u> Бичил уурхайн үйлдвэрлэгч байгууллага ШХ&ШО-ын гэрчилгээ авсан байх	Алтны ШХ&ШО-ын стандартын гол шаардлага нь байгаль орчны хариуцлагатай байдал юм. ТБУТ-ийн үйл ажиллагаа хэрэгжүүлдэг алтны сайтууд олон улсын сайн туршлагуудыг хэрэгжүүлж үзүүлэх хэрэгтэй ба ингэснээрээ олон улсын стандартыг дагаж мөрдөх юм. Бичил уурхайчдын байгууллагуудын үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулснаар төсөл уг байгууллагуудыг энэ гэрчилгээг авахад чиглэсэн оролдлогыг нь дэмжиж байна гэсэн үг юм. Байгаль орчныг хамгаалах, Шудрага худалдааны нэмэлт шагнал авах (Монголын бичил уурхайн үйл ажиллагаанд мөнгөн усны хэрэглээг зогсоох талаар дорвитой арга хэмжээ авч байгаа болон цианидийг бүү хэргэлдэггүй) ялах-ялах хэлбэр нь бичил уурхайчдын байгууллагуудад маш их түлхэц болж өгнө.

Төслийн үр дүн 5:

Бичил уурхайн дэд салбарыг дэмжих хүрээнд бичил уурхай эрхлэгчдийг чадавхижуулах бүтцийг бий болгох үйл явц эхэлсэн байна

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
Бичил уурхайн бодлогын бүрэлдэхүүн хэсэг 1.5 Бичил уурхайд ерөнхий оролцогчдод чиглэсэн чадавхи бий болгох бүтэц, үйл явц үндэсний хэмжээнд хэрэгжсэн байна Чадавхи бий болгох нь дээр дурдсан 4 сэдвийн нэгэн салашгүй хэсэг юм. Гэвч бичил уурхайг мэргэжлийн болгох гэх мэт тогтвортой чадавхи бий болгох бүтцийн талаар тусгайлан авч үзэх хэрэгтэй юм. Мөн үүнийг Монголын бичил уурхайчдад бүгдэд нь хүргэх талаар анхааруштай.	

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
А) Бичил уурхайн үйл ажиллагааг мэргэжлийн болгох талаар бүтэц, тогтолцоо бий болгох БСШУЯ-тай хамтран хөтөлбөр боловсруулах, мэргэжлийн сургалтын ерөнхий хөтөлбөрт бичил уурхайн сургалтын програмыг нэвтрүүлэх ☒ <u>Чухал үйл явдал:</u> Бичил уурхайчдад зориулж бичил уурхайн албан ёсны мэргэжил бий болгох шийдвэр гарсан байх	Бичил уурхай нь олон нийтийн дунд болон нилээд олон хамтрагч талуудын хувьд түр зуурын үйл ажиллагаа гэж үзэгдэж ирсэн. Зарим талууд тэр ч байтугай бичил уурхайчдыг “ажилгүй хүмүүс” гэж үздэг. Хэдий тимй боловч бичил уурхай нь олборлолт хийх газрыг эрж хайхаас эхлээд олборлох, баяжуулах, тэндээсээ борлуулах хүртлээ бүх үе шатандаа тодорхой нэгэн ур чадвар, мэргэжил шаарддаг. Монгол улсад байнгын, тогтвортой үйл ажиллагаа болж хөгжсөн олон нийтэд тулгууралсан уурхайн ажиллагаа нь энэ ажлыг хийж гүйцэтгэж байгаа бичил уурхайчдыг мэргэжил эзэмшүүлж, албан ёсны мэргэжил хэмээн хүлээн зөвшөөрүүлэн (мэргэжилтэн) энэ талаар тодорхой мэдлэгтэй болгохыг шаардаж байна. Иймээс бичил уурхайн үйл ажиллагааг мэргэжил гэдэг утгаар нь одоогийн байгаа мэргэжлийн сургалтын системийн бүтцэд оруулж өгөх хэрэгтэй байна.
В) Бичил уурхайг мэргэжлийн болгох хөтөлбөр болон дэд бүтцийг бий болгох БСШУЯ-тай хамтран хөтөлбөр боловсруулах, МСҮТ-эд чадавхи бий болгох талаар ажиллах <i>Оруулах шаардлагатай сэдвүүд: Ерөнхий геологи, далд ба ил уурхай, ашигт малтмалыг баяжуулах, уурхайн аюулгүй байдал ба эрүүл мэнд, байгаль орчин, албан ёсны бичил уурхайчны эрх ба үүрэг гэх мэт.</i> МСҮТ-тэй хамтран хамгийн үр дүнтэй байх сургалтын модулийг тогтоох. Үүнд: Тусгай сургалтын төвүүд дээр сургах, ерөнхий сургалтын төвүүдээр сургах, хөдөлгөөнт сургалтын цэгээр сургах, хувьчилах, мөн сургах эрх мэдлийг бичил уурхайчдын байгууллагуудад хариуцуулах гэх мэт. ☒ <u>Чухал үйл явдал:</u> Анхны МСҮТ эсвэл сургалтын хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байна ☒ <u>Чухал үйл явдал:</u> Анхны бичил уурхайчид мэргэжлийн үнэмлэх авсан байх	Бичил уурхай нь мэргэжил гэдэг утгаараа Монгол улсад анх удаа л яригдах гэж байна. Сургалтын хөтөлбөрүүд боловсруулагдах хэрэгтэй байгаа ба МСҮТ-д дээр сургагчдыг бэлтгэх сургалтууд хийгдэх хэрэгтэй байна. Хамгийн тохиромжтой хэлбэр нь дадлага туршлагатай ахмад бичил уурхайчид сургагчид болох явдал юм. Мөн дээд сургууль төгссөн бичил уурхайчид байгаа гэдгийг тооцоолж үзэх нь чухал юм. Харин бичил уурхайн хичээл заах багш нарыг тусгайлан бэлтгэх нь үндсээрээ буруу ба бичил уурхайчид сургагчид болж бэлтгэгдэх хэрэгтэй. Практик ажиллагааны туршлага нь анхааралд авууштай нэгэн хүчин зүйл юм! Бэлтгэгдсэн бичил уурхайчдад мэргэжлийн үнэмлэх олгох хэрэгтэй ба энэ нь тэднийг мэргэжилтэн гэж баталсан баталгаа болох юм.
С) Бичил уурхайн “мэдээллийн сан”	Бичил уурхайчид, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд тэдэнд хэрэгтэй мэдээлэл олж авч чадна гэсэн

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
байгуулах Ямар байгууллага ямар мэдээлэлтэй байгаа талаар судалгаа хийх эсвэл байгаа судалгааг баяжуулах, үүний үр дүнгийн талаарх мэдээллийг бүх хамрагдах талуудад хүргэх. Байгууллагуудын хоорондын харилцаа холбооны үүргийг (сүлжээн дэх байгууллагуудын дунд мэдээлэл солилцох) байгуулах, мөн уг мэдээллийг гадны байгууллагууд болон хувь хүмүүс хэрхэн хэрэглэж ашиглаж болох дээр тохиролцох. Хамгийн эцсийн (хамгийн шалгарсан) алхам: мэдээлэл цуглуулах, мэдлэг хуваалцах ажлыг зохицуулах үүрэгтэй байгууллагууд дундын ажлын хэсэг байгуулах. Байгууллага тус бүрт хадгалагдаж байгаа мэдээллүүдийг интернэт ашиглан олон нийтийн мэдлэг дээшлүүлэх чиглэлээр ашиглуулах. ☒ Чухал үйл явдал: Монгол Улсын бичил уурхайн талаар байгаа мэдээллийн судалгаа (хэн юу мэдэж байна?)	итгэл найдварын доор “Бичил уурхайн мэдээллийн сан” байгуулах хэрэгцээ шаардлага байна гэж илэрхийлцгээж байна. Гэвч байгууллага бүрт, хувь хүн бүрт өөр өөр төрлийн мэдээлэл хэрэгтэй байдаг ба ямар ч “мэдээллийн сан” бүх хэрэгцээтэй мэдээллээр хангах боломжгүй байдаг. Ийм учраас “мэдээллийн сан” гэдэг нэр томъёог зохион байгуулалттай болон зохион байгуулалтгүй тоо баримт, мэдээллийг цуглуулж тэднийг мэдээлэл болгож хувирган шийдвэр гаргахад шаардагдах мэдээлэл, мэдлэг бий болгодог ерөнхий систем гэж ойлгох ёстой. Маш олон төрлийн, өргөн хүрээтэй мэдээлэл цуглуулах болон шийдвэр гаргах хэрэгтэй учраас ийм систем нь зөвхөн янз бүрийн байгууллагуудад хадгалагдаж байгаа электрон болон цаасан дээр байгаа тоо баримт, мэдээллүүдийг хооронд нь сүлжээ үүсгэх замаар хийх боломжтой юм. Ийм “мэдээллийн сан” нь хаанаас ямар тодорхой мэдээллийг авч болох талаар заасан байгууллага дотоодын мэдлэгийн менежментийн систем юм.
D) Мэдлэг хуваалцах замаар чадавхи бэхжүүлэх Хамтрагч талуудад дотоодын болон олон улсын сайн туршлагаудыг хүргэх бичил уурхайн талаар мэдээлэл, мэдлэг солилцох үйл ажиллагаануудыг зохион байгуулах. Энэ талаар CASM гэх мэт олон улсын хэмжээний мэдлэг дээшлүүлэх үйл ажиллагаануудад оролцох.	Бичил уурхайн төрөл бүрийн асуудлуудаар сайн туршлага нэвтрүүлэх, байгаа туршлагаа бэхжүүлэх замаар олон улсын сайн туршлагаудыг авчирж нутагшуулах болно. Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, бичил уурхайчдын зохион байгуулалт, тэдэнд хүргэх үйлчилгээ, технологийн сайн туршлага, шудрага худалдаа болон байгаль орчны менежментийн талаар төрийн болон бичил уурхайчдын байгууллагуудад аль болох их мэдээлэл хүргэж, танилцуулах хэрэгтэй.
E)  Шудрага худалдааны тэмдэгтийн байгууллагын Алтны шудрага худалдаа, шудрага олборлолтын холбоо, Хариуцлагатай уул уурхайн холбоо зэрэг байгууллагуудтай албан ёсны харилцаа холбоо тогтоох Шудрага худалдааны тэмдэгтийн байгууллага, Хариуцлагатай уул уурхайн холбоо зэрэг байгууллагуудтай албан ёсны харилцаа холбоо тогтоон чадавхи бэхжүүлэх хамтарсан үйл	The Fairtrade and Fairmined Gold Partnership of FLO (Fairtrade Labelling Organization) and ARM (Alliance for Responsible Mining) was formally established in 2009. ASM producers in all countries currently covered by the Үйлдвэрлэгчдийг дэмжих байгууллагуудад газар зүйн байрлал, цар хүрээ чухал ач холбогдолтой. Бүх үйлдвэрлэгчдийг дэмжих байгууллагууд ХУУХ-ы байгууллагуудын сүлжээгээр холбогддог.

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
ажиллагаануудад оролцох. (<i>үйлдвэрлэгчдийг дэмжихэд голдуу ХУУХ дэмжигч байгууллагуудын сүлжээ, гэрчилгээ авах болон шудрага худалдааны талаар голдуу ШХТБ-тэй хамтран ажиллах</i>). Шудрага худалдааны систем хэрхэн ажилладаг талаар сурах. ☒ Чухал үйл явдал: Монгол улсад Алтны шудрага худалдаа, шудрага олборлолтын стандартын үйл явц хэрэгжүүлэгдэж эхэлсэн байх	Энэ холбоо Монгол Улсыг өөрийнхөө үйл ажиллагааны газар зүйн байрлалын хүрээнд багтаах боломжтой гэдгээ илэрхийлсэн. Иймээс энэ байгууллагатай албан ёсны харилцаа холбоо тогтоон сүлжжээнд багтаж, туршлагаас нь хэрэгжүүлэх нь төслөөс шалтгаалах юм.
Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсэг 2.5 Тодорхой чиглэлээр мэргэжүүлэх чадавхи бий болгох бүтэц, үйл явц орон нутгийн түвшинд бий болсон байна Чадавхи бий болгох нь дээр дурдсан 4 сэдвийн нэгэн салашгүй хэсэг юм. Гэвч нийт бичил уурхайчдад дагаж дууриах үлгэр жишээ болж чадахуйц, бичил уурхайн үйл ажиллагаа хариуцлагатайбайж болдог юм гэдгийг харуулах бодит үр дүн гаргахуйц “манлайлагчид”-ыг төрүүлэх, бий болгоход тусгайлан анхаарал хандуулах шаардлагатай.	
А) Бүх сэдвүүдтэй холбоотой үйл ажиллагаанууд	Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд төслийн шугамаар явуулж байгаа чадавхи бий болгох бүх ажлууд нийт сэдвүүдтэй холбоотой юм.
В) Гишүүдийн чадавхийг бий болгох бүтцийн дагуу явуулж байгаа бичил уурхайчдын байгууллагуудын чадавхи бэхжүүлэх Бичил уурхайчдын байгууллагуудыг гишүүд болон гишүүн нөхөрлөлүүддээ чадавхи бий болгох үүрэг хариуцлага хүлээсэн байгууллага болгох чиглэлээр чадваржуулах. ☒ Чухал үйл явдал: Бичил уурхайчдын байгууллагууд гишүүддээ сургалт явуулах талаар санал санаачлагыг гаргана (Бичил уурхайчдын байгууллага бүрт хамаатай)	Бичил уурхайчдын байгууллагууд гишүүддээ анхан шатны үйлчилгээ хүргэгчидтэй холбогдох хэрэгтэй. Гишүүддээ хүргэж байгаа хууль эрх зүйн, зохион байгуулалтын болон техник технологийн (аюулгүй ажиллагаа, байгаль орчин) талаарх үйлчилгээний дагуу бичил уурхайчдын байгууллагууд нь гишүүдийнхээ дунд чадавхи бий болгодог гол бүтэц болох юм. Бичил уурхайчдын байгууллагууд сургалт зохион байгуулан мэдлэгийг дээшлүүлэн гишүүдийнхээ чадавхийг бэхжүүлэх нь тэдний байгууллагын байгууллага болсоны гол үүрэг хариуцлагын нэг юм гэдгийг ойлгох хэрэгтэй юм. Бичил уурхайчдын байгууллагууд нь гишүүддээ зориулж өөрсдөө болон гадны сургагч нараар дамжуулж сургалт явуулах үүрэгтэй.
С) Бичил уурхайчдын чадавхийг бий болгох бүтцийн дагуу явуулж байгаа	Сум, аймгийн захиргаа, орон нутгийн бусад мэргэжлийн байгууллагууд (мэргэжлийн хяналтын байгууллага

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
орон нутгийн байгууллагуудын чадавхи бэхжүүлэх Орон нутгийн бичил уурхайчдын чадавхийг бий болгох үүрэг хариуцлага хүлээсэн гэдэг талаас нь орон нутгийн эрх баригчид, төрийн байгууллагууд, бусад агентлагуудад ойлголт төрүүлэх. Орон нутгийн эрх баригчид, байгууллагуудыг сургалт семинар, газар дээрх сургалт зэргээр бичил уурхайчдын чадавхийг бэхжүүлэх үүрэг хариуцлагаа гүйцэлдүүлэх боломжтой болгох. <i>(Орон нутгийн эрх баригчдыг сургах ажиллагаа нь голдуу хамтрагч талаар хийгдвэл зохимжтой)</i>	г.м.) нь бичил уурхайчдад газар олгох, татвар төлбөр авах гэх мэт эрхтэй байхын хажуугаар бичил уурхайчдыг чадавхижуулах үүрэг хариуцлага хүлээсэн байдаг. Бичил уурхайчдын дагаж мөрдөж хэрэгжүүлэх ёстой заавар журмууд, шаардлагуудыг орон нутгийн эрх баригчид тайлбарлаж өгдөг байх шаардлагатай. Тиймээс орон нутгийн эдгээр эрх баригчид чанартай үйлчилгээ үзүүлэх үүднээс өөрсдийнхөө мэдлэгийг дээшлүүлж эхлэх шаардлагатай. <u>Жич:</u> АМГ-аас орон нутгийн төрийн байгууллагуудын ашигт малтмалыг зохистой ашиглах асуудлаар бичил уурхайн үйл ажиллагаа болон чадавхи бэхжүүлэх талаар хариуцаж ажиллах Бичил уурхайн тасгийгбайгуулахаар төлөвлөж байна. Төслийн зүгээс энэ тасгийг мэргэжилтэнгүүдээр сургагчдыг бэлтгэх сургалт зохион байгуулуулах замаар дэмжиж болно.
D) Сургалтын материалуудыг “бичил уурхайчдын хэрэгсэл” болгож нэгтгэх ТБУТ-ын хүрээнд хийгдсэн сургалтын болон мэдээллийн материалуудыг хэвлэх болон боломжтой бол интернетээр нэгтгэж “бичил уурхайчдын цаашид ашиглах хэрэгсэл болгох. ☒ <u>Чухал үйл явдал:</u> “бичил уурхайчдын хэрэгсэл” (ТБУТ-ын бүх зөвлөмжийн эмхэтгэл) хэвлэгдсэн байна.	ТБУТ-ын хүрээнд хийгдсэн сургалтын болон мэдээллийн материалуудыг эмхэтгэж бичил уурхайчдад цаашдын үйл ажиллагаандаа хэрэглэхэд нь хүртээмжтэй болгох. Энэ нь бичил уурхайд холбоотой бүх сэдвүүдийг багтаасан байх хэрэгтэй. Үүнд: хууль эрх зүй, ашиглалт, баяжуулалт, менежмент, хөрөнгө оруулалт, олон нийтийн хөгжил гэх мэт бүх сэдэв орох хэрэгтэй. Үүнийг ном хэлбэрээр хэвлэх болон интернэтээр ашиглаж болохуйцаар хийж болох юм. Энэ “хэрэгсэл” төслийн хугацаа дууссаны дараа цаашид удаан хугацаагаар ашиглагдах ба бичил уурхайн үйл ажиллагааны талаарх мэдлэгийн гол суурь болж өгөх юм. Энэ хэрэгсэлийн интернетийн хэлбэр нь бичил уурхайн мэдээллийн сантай хавсрагасан хэлбэртэй байж болох ба бичил уурхайчдыг хооронд нь холбох, харилцан мэдээлэл солилцох, бичил уурхайн тухайн үеийн чиг хандлагын талаарх мэдээлэл солилцох, ашигт малтмалын үнэ ханш, бусад оронд хүрсэн амжилт, бичил уурхайчдыг чадавхижуулах, тэднийг дотоодын болон гадаадын бусад ижил хүсэл зорилго бүхий байгууллагуудтай

	Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчилга
		холбоход хэрэглэгдэж болно. Төсөл хэрэгжүүлэгч Монгол талын хамтрагч талтай нягт холбоотойгоор тэдний байнгын website-ын нэг хэсэг болгож интернетийн хувилбарыг боловсруулах тал дээр тусгайлан анхаарах хэрэгтэй. Тусгайлан байгуулсан web хуудас нь төсөл хэрэгжээд дууссан үед хүлээлгэж өгснөөс хойш түүнийг тогтвортойгоор зохицуулж ажиллуулахад асуудал үүсдэгийг урьд өмнө ийм төрлийн ажил хийсэн газруудын туршлагаас харагдсан.
Е) 	Шудрага худалдааны систем болон Алтны стандартын шаардлагын талаар төсөл хэрэгждэг газруудын бичил уурхайчдын байгууллагуудад тусгайлан сургалт явуулах Шудрага худалдааны системийн талаарх мэдлэг мэдээллийг ТБУТ-ийн Алтны ШХШО-ын үйлдвэрлэгчдийг дэмжих холбооны сүлжээнд оролцох шугамаар олж авах. Гэрчилгээ авах боломж бүхий бичил уурхайн алт үйлдвэрлэгч байгууллагуудад ШХ-ны системийн талаар мэдээлэл түгээх. Онгол улсад Алтны ШХШО-ын стандартыг хэрэгжүүлэх боломжийн талаар туршилт хийж Алтны ШХШО-ын холбоонд үр дүнгийн талаар мэдээлэх³⁶. Бичил уурхайчдын байгууллагуудад үйлдвэрлэгчдийн дэмжлэг үзүүлж тэднийг стандартын шаардлагад нийцүүлж үйл ажиллагаа явуулах, гарал үүсэл нь тодорхой худалдааны сүлжээ байгуулахад нь дэмжлэг үзүүлэх. ☒ Чухал үйл явдал: Бичил уурхайчдын үйлдвэрлэгч байгууллага ШХШО-ын гэрчилгээ авсан байх	Бичил уурхайчдын байгууллагад Шудрага худалдааны системийн талаар мэдлэг, мэдэгдэхүүн бий болгох замаар бичил уурхайчдын байгууллагуудын ШХШО-ын гэрчилгээ авах талаар хийж байгаа оролдлогыг дэмжих хэрэгтэй. Гэрчилгээ олгох явдал нь бие даасан гуравдагч талын хариуцаж шалгасны үндсэн дээр олгогддог ажил учраас энэ системийн талаар баттай ойлголттой байх нь маш чухал юм. Үүнд нэгдэн орох анхны байгууллага энэ системийг Монголын нөхцөлд хэр үр дүнтэй байх вэ гэдэг талаар туршилт болох учраас их анхаарал тавьж, чухалчилсан дэмжлэг хэрэгтэй юм. Монгол Улсын хувьд ШХ-ны систем нь шинэ үйл явдал (ШХ-ны замаар хийгддэг ихэнх бүтээгдэхүүнүүд Монголд үйлдвэрлэгддэггүй) учраас ТБУТ эхний үед голдуу ШХТБ болон ХУУХ-ны хариуцдаг ажлыг орлон гүйцэтгэх хэрэгтэй. Үйлдвэрлэгчдийг дэмжих нь ямар нэгэн байдлаар ШХ-ны систем дэх байнгын үйл ажиллагаа бөгөөд голдуу дээвэр байгууллага, ТББ, эсвэл хувийн зөвлөхүүд хийдэг учраас үүнийг хэрхэн хийх талаар төсөл эхний үед хариуцаж ажиллаж байгаад дараа нь шилжүүлэх юмуу эсвэл эхнээс нь гадны байгууллагаар хийлгэж болох юм.

³⁶ Contextualization of the Standard can be proposed to the ARM-FLO Standards Sub-Committee. As long as the required modifications do not affect fundamental Fairtrade and Fairmined principles, adaptations are likely.

Төслийн үр дүн 6:

Орон нутгийн засаг захиргаа болон бичил уурхай эрхлэгчдийн ашигт малтмалын менежментийн чадавхи дээшилсэн байна

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчлага
Бичил уурхайн бодлогын бүрэлдэхүүн хэсэг	
1.6 Зөвшөөрөл олгох үйл явц ил тод, шудрага явагдаж, зөрчлийг бууруулах Бүсийн болон орон нутгийн захиргаанаас газар олгох ил тод, шудрага үйл явц нь орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах чухал үүрэг гүйцэтгэдэг боловч голдуу үүнийг зохистойгоор зохицуулах талаар маш бага туршлагатай байдаг тул төвлөрөлийг бууруулах үйл явцад тэдний үүрэг ролийг таниулах талаар дэмжлэг хэрэгтэй байдаг.	
А) Бүсийн болон орон нутгийн захиргаанаас бичил уурхайчдад газар олгох ил тод, шудрага үйл явцыг дэмжих Бичил уурхайчдын байгууллагад хууль ёсны дагуу тогтвортой ажиллах боломжоор хангасан газар олгох бодит шалгуур үзүүлэлтийг нарийвчлан боловсруулах, дэмжих Орон нутгийн захиргаанаас бичил уурхайчдад олборлолтын газар олгох ил тод үйл явцын хэрэгжүүлэлтийг идэвхижүүлэх	Бичил уурхайн үйл ажиллагааг албан ёсны болгох нь орон нутгийн засаг захиргааны эрх мэдлийн дагуу газар ашиглах эрхийг нөхөрлөлүүдэд олгоход суурилдаг. Орон нутгийн захиргаанаас субектив шалгуур үзүүлэлтийн дагуу газар олгох нь орон нутгийн нөхцөл байдлыг тусгасан байхаар уян хатан байх хэрэгтэй. Харин бодит шалгуур үзүүлэлтүүд нь ил тод, шудрага, ялгаварлан гадуурхах үзэлгүйгээр газар олгохыг баталгаажуулах хэрэгтэй болдог. Нөхөрлөлүд болон бичил уурхайчдын байгууллагуудад тодорхой шалгуур үзүүлэлтүүд нь хууль ёсны тогтвортой байдлыг олгоод зогсохгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулах, баталгаатай ажлын байр бий болгох болон байгаль орчны тогтвортой байдлыг хангах боломжийг олгодог.
В) Төвлөрөлийг бууруулах оролдлогод орон нутгийн болон бүсийн засаг захиргааг дэмжих Орон нутгийн болон бүсийн засаг захиргаанд төвлөрөлийг бууруулах тулд юу хэрэгтэй байгааг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх. Орон нутгийн болон бүсийн засаг захиргаанд бичил уурхайгаас ирэх ашиг тусыг орон нутгийн хөгжилд хэрхэн шилжүүлж ашиглах талаар зөвлөх. Орон нутгийн болон бүсийн засаг захиргааг бичил уурхайн талаар мастер төлөвлөгөө гаргахад дэмжих (байгаа геологийн тоо баримт дээр тулгуурлан бичил уурхайгаар олборлоход тохиромжтой орд газрыг тогтоох, олборлолтын газрын урт хугацааны	Олборлолтын газар олгох болон энэ талаар хяналт шалгалт хийгдэх газар болох орон нутгийн төвшинд бичил уурхайн үйл ажиллагаа зохицуулагддаг. Бичил уурхайг захиран, зохион байгуулах үүргийг биелүүлэхийн тулд эрхийг орон нутагт шилжүүлэх шаардлага гардаг. ТБУТ-ийн Монгол талын хамтран хэрэгжүүлэгч байгууллага нь төв үасгийн газар, мөн ТБУТ нь бичил уурхайн үйл ажиллагаа явагддаг газруудын бүсийн болон орон нутгийн захиргаатай хамтарч ажиллах учраас төсөл төвлөрөлийг сааруулахад чухам юу хэрэгтэй байгааг тодорхойлох, төв болон бүс, орон нутгийн засаг захиргааны хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэх тохиромжтой байр сууринд байгаа юм.

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчлага
төлөвлөгөө, нөхөн сэргээлт хийх дэс дараалал, бичил уурхайчдад хүргэх үйлчилгээ болон шаардлагатай нөөцүүд гэх мэт).	
С) Байгалийн нөөцийн талаарх зөрчилдөөнийг шийдвэрлэх чадавхийг бий болгох Зуучлагчдыг сургах хэрэгтэй. Зуучлагчдыг сургах сургагчдыг бэлтгэх талаар тусгайлан анхаарал хандуулах хэрэгтэй.	Бичил уурхайчд, орон нутгийн захиргаа, болон нутгийн ард иргэд бичил уурхайгаас олдог ашиг тусын талаар нэгдсэн санаа бодолтой байж төв засгийн газар болон том уурхайн компаниудтай хэлэлцээ, тохиролцоо хийхэд сайтар бэлтгэгдсэн, нэгдсэн нэг үзэл бодолтой байх хэрэгтэй. Энэ талаар хийх ТБУТ-ын үүрэг функц маш чухал юм. Учир нь иймэрхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын хувьд шинэ бөгөөд ийм төрлийн зөрчилдөөнийг зохицуулах ажилд түрүүлж оролцох талуудын дунд уг төсөл багтдаг.
Д) Бичил уурхайчдын эрх болон хэрэгцээ шаардлагыг уул уурхайн том компаниудын зүгээс CSR-ийн үүрэг хариуцлагынхаа дагуу хүндэтгэж үзэх талаар нөлөөллийн ажил хийх Бичил уурхайчдын байгууллагууд болон орон нутгийн захиргааг уул уурхайн том компаниудтай зохицож ажиллах, хэлэлцэх талаар дэмжлэг үзүүлэх. Уул уурхайн том компаниудын CSR-ын сайн туршлагыг дагаж мөрдөх, бичил уурхайчдын ажиллах эрхийг хүндэтгэж үзэх талаар нөлөөлөх. Уул уурхайн том компаниуд болон бичил уурхайчдын дунд гарч болзошгүй зөрчилдөөнийг зохицуулахад зуучлах.	Бичил уурхайн үйл ажиллагаанд тохиромжтой ихэнх газрууд голдуу хайгуулын болон ашиглалтын тусгай эрх бүхий газарт байдаг. Бичил уурхай болон уул уурхайн том компаниудын хамтран үйл ажиллагаа явуулах CSR (нийгмийн хариуцлагын нэгдэл)-ын шаардлагад чиглэсэн олон улсын чиг хандлагын биелүүлэлт нь бичил уурхайчдад газар олгохыг шаардахаас эхэлвэл зохилтой. Олон улсын уул уурхайн том компаниудын хувьд энэ үүрэг хариуцлагыг дагаж мөрдөхгүй бол нэр хүндэд нь сөргөөр нөлөөлөх эрсдэл бий болгох талтай. Хариуцлагатай бичил уурхайчдыг дэмжих ТБУТ-ын үүрэг нь том уурхайн компаниудыг бичил уурхайчдын эрхийг CSR-ын сайн туршлагын дагуу хүндэтгэж үзэх талаар нөлөөлөлийн ажлыг хийлгэхэд оршино.
Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсэг 2.6 БУ-чдын үйлдвэрлэлийн бүтээмж дээшилж бүрээгдэхүүний чанар сайжирсан байна Олон нийтэд тулгууралсан бичил уурхайн үйл ажиллагаа нь орон нутгийн хөгжилд үр дүнтэйгээр хувь нэмэр оруулах боломжтой байдаг. Учир нь олборлолтын үйл ажиллагаанаас орсон орлого орон нутгийн эдийн засгийн эргэлтэд орж орлогы хоёрдогч эх үүсвэр бий болгох боломж бүрдүүлдэг.	
А) Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх замаар орлогыг өсгөх Төслийн зүгээс өгөх техникийн зөвлөгөө,	Хэдийгээр бичил уурхайчдын орлого нь хөдөө орон нутагт бусад төрлийн бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүсээс арай өндөр байдаг

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчлага
эсвэл төслийн удирдлага дор гадны үйлчилгээ үзүүлэгч байгууллагаар дамжуулж ашиглаж байгаа олборлолтын амнуудыг сайжруулах. Олборлолтын багаж төхөөрөмжийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг сайжруулах зорилготой бичил зээлийн нөхцөл боломж бүрдүүлж өгөх <i>(Иймэрхүү бичил уурхайн бичил зээлийн сан нь орон нутгийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хөрөнгө санхүүгийн байгууллагаар дамжуулж юмуу эсвэл ийм байгууллагатай хамтарч байгуулагдвал тохиромжтой. Мөн үүний өөр нэг хэлбэр нь бичил уурхайчдын дундын хадгаламжийн сан байгуулах хэлбэр юм)</i>	боловч бичил уурхайчид ихэнхдээ ядуу байдаг. Энэ байдал нь алтны бичил уурхайчдыг бодвол нүүрс болон жоншны бичил уурхайчдад илүү элбэг тохиолддог. Орлого багатай байна гэдэг нь үйл ажиллагаандаа хөрөнгө оруулах боломжгүй болгож байгаа ба хуучирсан багаж төхөөрөмж, технологи хэргэлснээс болж ажлын байрны аюул осол ихсэх нөхцөл шалтгаан болж өгдөг. Мөн үүнээс гадна орлого багатай байснаас орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр бага байна гэсэн үг юм. Иймээс үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг өсгөх нь орлогыг нэмэгдүүлэх хамгийн дөт зам юм.
В) Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах замаар орлогыг өсгөх Ажиллаж байгаа уурхайнуудыг сайжруулах, төслөөс үзүүлэх техник, эдийн засгийн зөвлөгөө болон төслийн удирдлага доор гадны үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйлчилгээний дагуу бүтээгдэхүүний чанарыг сайжруулсанаар орлогыг нэмэгдүүлэх. ШХШО-ын гэрчилгээ авах боломж бүхий бичил уурхайчдын байгууллагыг дэмжиж хууль ёсны, гарал үүсэл нь тодорхой, гэрчилгээ бүхий худалдааны сүлжээ байгуулах, улмаар бүтээгдэхүүнийг экспортлох. <i>Одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн алт худалдан авагчид (ченжүүд) бичил уурхайчдад үнэхээр үйлчилгээ үзүүлэх сонирхолтой, хууль эрх зүйн дагуу гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүнийг борлуулах гэрчилгээ бүхий ажилтан болход бэлтгэлтэй байгаа бол уг системд оролцож болох юм.</i>	Нүүрс, жонш мэтийн их хэмжээгээр олборлодог ашигт малтмалын хувьд <u>бүтээгдэхүүний бодит чанарт</u> хяналт тависанаар олох орлогыг нэмэгдүүлэх боломжтой юм. Бүтээгдэхүүний чанараас бүтээгдэхүүний үнэ хамаардаг ба бичил уурхайчид хамгийн үнээр борлуулж болохуйц чанар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх шаардлагатай юм. <u>Харин бүтээгдэхүүний ёс зүйн чанар</u> гэдэг нь алтны бичил уурхайд хамаатай чанарын нэгэн шинэ зэрэглэл юм. “Ёс зүйн гоёл чимэглэл” худалдан авах хэрэгцээ шаардлага ихсэж байгаа ба бичил уурхайчид ШХШО-ын гэрчилгээ авснаар энэ зах зээлд өөрсдийнхөө бүтээгдэхүүнийг нийлүүлж болно. Бичил уурхайчдын хувьд ерөнхийдөө бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлийн үнийн 70-80%-тай тэнцүү үнээр худалддаг бол ШХШО-ын гэрчилгээ бүхий бичил уурхайчид баталгаатай 95%-иархудалдахаас гадна шудрага худалдааны нэмэгдэл шагнал болох 10-15%-ийг орон нутгийн хөгжилд зориулах боломжтой юм. Бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх энэ 2 арга замын аль аль нь бичил уурхайчдаас маш их оролдлого, хүчин чармайлт шаардах бөгөөд гадны дэмжлэгч чухал шаардлагатай.
С) Бичил уурхайчид болон тэдний байгууллагуудын хөрөнгийн	Бичил уурхайчид болон тэдний байгууллагуудын хөрөнгийн менежмент хийх зөв зохистой ур чадвартай байх нь

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчлага
менежмент, бизнесийн ур чадварыг дээшлүүлэх Бичил уурхайчид болон тэдний байгууллагуудын хөрөнгийн менежмент, бизнесийн ур чадварыг дээшлүүлэх талаар онолын болон практикийн сургалтаар дэмжлэг үзүүлэх. Бичил уурхайчдын хадгаламжийн бүлгүүд байгуулахыг дэмжих. Бичил уурхайчдын байгууллагыг урт хугацааны төлөвлөгөө боловсруулах, техникийн сонголын эдийн засгийн үнэлгээ хийхэл нь дэмжлэг үзүүлэх Эдийн засгийн талаарх мэдлэгийг нь дээшлүүлэх замаар бичил уурхайчдын хэлэлцэх, тохиролцох ур чадварыг бэхжүүлэх <i>Практикийн сургалтуудыг бичил уурхайчдыг өөрсдийнхөө сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах гэх мэт бусад сэдвүүдтэй хамтатгаж болно.</i>	маш чухал юм. Бичил уурхайчид орлого ашиг хоёрыг хооронд нь ялгахгүй будилах, үнэ болон хөрөнгө оруулалт хоёрын ялгааг ойлгохгүй байх үзэгдэл элбэг тохиолддог. Үүний үр дагавараар орлого бүгдийг нь зарцуулж дуусаад үйл ажиллагаагаа сайжруулах хөрөнгө оруулалт хийх боломжгүй болдог. Орон нутгийн тогтвортой эдийн засгийг төлөвшүүлэхэд мөнгөний менежмент, бизнесийн ур чадварыг сайжруулах талаар чадавхижуулах шаардлагатай.
D) Бичил уурхайчдын байгууллагуудын орон нутгийн нийгмийн хөгжлийн үйл ажиллагаанд зөвлөмж өгөх Бичил уурхайчдын байгууллагуудад өөрсдөө санхүүжүүлэх олон нийтийн хөгжилд чиглэсэн төсөл сонгох болон хэрэгжүүлэхэд нь зөвлөгөө үзүүлэх. ШХШО-ын гэрчилгээ бүхий бичил уурхайчдын байгууллагуудад ШХ-ны нэмэгдэл шагналыг зохицуулах зөвлөл байгуулах, үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэх. Энэ орлого нь орон нутгийн хөгжилд зарцуулагддаг. ☒ <u>Чухал үйл явдал:</u> ШХ-ны шагналын зөвлөл байгуулагдаж олон нийтийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохицуулдаг болох	Олон нийтэд тулгууралсан бичил уурхайн үйл ажиллагаа нь орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг. Энэ нь бичил уурхайгаас орсон орлого тухайн орон нутгийн эдийн засагт эргэлдэж эхэлснээр “санаандгүй” үүсэж эхэлдэг. Мөн бичил уурхайчдын байгууллагууд олон нийтийг хөгжүүлэх үйл ажиллагааг тусгайлан зохион байгуулсанаар “санаатайгаар” бий болдог. Харин орон нутгийг хөгжүүлэх ажлуудын үүнд үзүүлэх үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор төслийн зүгээс бичил уурхайчдын байгууллагуудад зөвлөгөө, заавар өгч чиглүүлэх шаардлагатай юм. Мөн үүнээс гадна бичил уурхайчдын байгууллагуудын хийж байгаа орон нутгийн хөгжилд чиглэсэн ажлууд нь орлогын хоёрдогч эх үүсвэр үүсгэх чиглэлд хийгдэж болох юм. Гэвч ихэнх тохиолдолд нийгмийн дэд бүтэц болон боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн ажлын төслүүд нь илүү их үр нөлөө үзүүлдэг. Орон нутгийн олон нийтэд чиглэсэн ажлуудын талаар бичил уурхайн ШХШО-ын гэрчилгээ бүхий байгууллагатай газруудад илүү анхаарал хандуулах шаардлагатай. Ийм байгууллагууд нь ШХ-ны нэмэгдэл

Үйл ажиллагааны багц, чухал үйл явдлууд	Танилцуулга ба зааварчлага
	шагнал болох нилээд их хэмжээний мөнгө авдаг ба үүнийг олон нийтийн хөгжилд зарцуулах шаардлагатай юм. <i>Жич: Орлогын хоёрдогч эхүүсвэр бий болгох төслүүдэд ТБУТ хөрөнгө оруулах ёсгүй юм. Энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг бусад төслүүд хийх хэрэгтэй!</i>

Хавсралт 8. Төслийн ажилтангуудын ажил үүргийн тодорхойлолт

Албан тушаал	Ажил үүргийн тодорхойлолт
Төслийн захирал (ТЗ)	Төслийн захирал нь Төслийн баримт бичиг, Төслийн удирдах хорооны шийдвэр, ШХА-аас өгсөн заавар зөвлөгөөний дагуу төслийн стратегийн хэрэгжүүлэлтийг хариуцаж ажиллана. Төслийн захирал төв, бүсийн болон орон нутгийн төвшинд дотоодын хамтрагч талуудын бүх талын дадлага туршлагыг авч ирэн гадны хамтрагч талуудтай тулж ажиллан олон нийтийн дунд төслийн нүүр царай болон бичил уурхайн бодлого болон харилцаа холбооны чиглэлээр хошуучлан ажиллана. ТЗ нь байгууллагуудын хоорондын харилцаа холбоо болон бодлогын түвшинд хэлэлцэх чухал байр суурьтай, өндөр мэдлэг боловсролтой байх ёстой.
Төслийн менежер (ТМ)	Төслийн менежер нь Төслийн баримт бичиг, Төслийн удирдах хорооны шийдвэр, ШХА-аас өгсөн заавар зөвлөгөөний дагуу төслийн менежмент болон үйл ажиллагааны хэрэгжүүлэлтийг хариуцаж ажиллана. Төслийн менежер нь төслийн багийг удирдах, дайчлах, нэгтгэх үүрэгтэй бөгөөд олон улсын туршлагыг нэвтрүүлэн төслийн хэрэгжүүлэлт, удирдлага/захиргаа, төлөвлөлт болон хяналтын ажлыг хариуцан ажиллана. ТМ-ийн удирдлага, асуудлын талаар өргөн мэдлэг болон олон нийтэд тулгууралсан бичил уурхайн талаарх дадлага туршлага нь түүний бичил уурхайн бодлогын дагуу удирдах чадварыг нь улам бүрдүүлж өгнө. ТМ нь төслийг үр дүнтэй, үр ашигтай удирдах, төслийн зорилго, зорилт, чухал үйл явдлуудад хүрэх, ажилтангууд болон байгууллагыг чадавхижуулах өндөр ур чадвар, мэдлэг боовсролтой байх ёстой.
Бичил уурхайн бодлого, албажуулалтын ахлах мэргэжилтэн (АМ)	Ахлах мэргэжилтэн нь БУ-н бодлогын бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааг хариуцаж ажиллахаас гадна Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсгийн ажлын хүрээнд бичил уурхайчдад хууль эрх зүйн талаар зөвлөгөө өгөх ажлыг хариуцна. БУ-н бодлогын бүрэлдэхүүн хэсгийн ажлын хүрээнд ахлах мэргэжилтэн олон нийт болон бодлогын түвшинд төслийг төлөөлөх ТЗ-тай хамтын ажиллагааг чухалчилна. Энэ зорилгоор ахлах мэргэжилтэн ТЗ-ийн доор ажиллах Бодлого ба харилцааны зөвлөхтэй баг болж ажиллана. АМ нь бичил уурхайн бодлого болон уул уурхайд холбоотой хууль эрх зүйн талаар өндөр мэдлэгтэй байж бодлогын хэлэлцээр хийхэд дэмжлэг үзүүлэх чадвартай байх ёстой. АМ-ний хууль эрх зүйн талаарх дадлага туршлага нь төслийн зүгээс бичил уурхайчид болон орон нутгийн засаг захиргааг чадавхижуулах, дэмжих замаар бичил уурхайн үйл ажиллагааг зохион байгуулалтанд оруулах, албажуулах оролдлогыг дэмжих ажилд чухал ач холбогдол үзүүлэх ёстой.
Бичил уурхайчдын олон нийтийн ахлах мэргэжилтэн (АМ)	Бичил уурхайчдын олон нийтийн ахлах мэргэжилтэн нь Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсгийн ажлыг хариуцахаас гадна БУ-н бодлогын бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааг

Жич: шаардлагатай бүх ур чадвар эзэмшсэн мэргэжилтэн байгаа эсэхээс хамааран АМ-ийг 2 мэргэжилтний баг байхаар авч ажиллуулж болно. (АМд).	техникийн болон нийгэм-соёлын талын зөвлөгөөгөөр дэмжинэ. АМ нь бичил уурхайн далд ба ил уурхайн аюулгүй ажиллагаа, экологийн үр ашигтай олборлолт, баяжуулалт, нөхөн сэргээлтийн технологийн талаар мэргэжил турлагатай байх ёстой ба бусад мэргэжилтэнгүүдийг чадавхи бэхжүүлэх талаар төвлөрж үйл ажиллагааг нь чиглүүлэх чадвартай байх ёстой. Мөн олон нийтийг хөгжүүлэх, орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх, мэдлэг дамжуулах, болон чадваржуулах талаар мэргэжсэн байх ёстой. АМ нь бичил уурхайчдыг хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаагаа хариуцлагатай явуулахад нь дэмжиж тэднийг өсөж хөгжин албан ёсны уурхайн байгууллагын бүрэн эрх болон үүргийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бизнесийн байгууллага болоход нь дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. . БУ-ын байгууллагуудыг ШХШО-ын стандартын шаардлагыг хангаж ажиллахад нь техникийн болон зохион байгуулалтын талаар чадавхижуулах үйл явцыг дэмжинэ.
Бодлого ба харилцааны зөвлөх (БХЗ)	Бодлого ба харилцааны зөвлөх нь ТЗ-ыг бодлого идэвхижүүлэх болон бичил уурхайн талаар олон нийтийн санал бодлыг сайжруулахад чиглэсэн стратеги боловсруулахад нь зөвлөж ажиллана (харилцаа холбоо). Бичил уурхайн бодлого, албажуулалтын ахлах мэргэжилтэнд тавигдаж байгаа хэрэгжүүлэлтэд чиглэсэн ур чадварын шаардлага нь Бодлого ба харилцааны зөвлөхийн оруулах хувь нэмэртэй дэмжин бүрэлдүүлэх юм. БХЗ бичил уурхайчдыг чадваржуулах, эрх мэдэлжүүлэх ажлыг дээшлүүлэх зорилгоор хэзээ, хэрхэн, хаана төслийн үйл ажиллагааг харилцаж, холбох талаар ур чадвар гаргаж ажиллах юм.
Мэргэжилтэнгүүд	Хоёр бүрэлдэхүүн хэсэгт туршлагажсан хэрэгжүүлэлтийн мэргэжилтнүүдийг Төслийн хэрэгцээ шаардлага дээр үндэслэн авч ажиллуулах шаардлагатай. Үйл ажиллагааг хэрэгжүүлэх баг нь ШХА-тай гэрээ бүхий 4 мэргэжилтэн болон АМГ-аас төслийн үйл ажиллагаанд оролцуулахаар томилсон 2 мэргэжилтнээс бүтнэ. ШХА-ийн гэрээт ажилтангуудын мэргэжил чадвар нь АМГ-аас томилсон мэргэжилтэнгүүдийн дадлага туршлагыг дэмжин бүрэлдүүлэх хэмжээнд байх ёстой. Төсөл доорх чиглэлээр мэргэжсэн мэргэжилтэнгүүдтэй байх ёстой. Үүнд: • Олон нийтийг зохион байгуулах ба байгууллага бүрэлдүүлэх • Байгууллагыг бэхжүүлэх • Бичил уурхайн үйл ажиллагааг албажуулах • Ашигт малтмалыг зохицуулах, бүсийн болон орон нутгийн захиргаанд зөвлөгөө өгөх • Бичил уурхайчдад хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх • Хэлэлцээр, зохицуулалт • Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, уул уурхайн аюулгүй ажиллагаа

	• Ил болон далд уурхай • Ашигт малтмалын баяжуулалт • Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт • Чадавхижуулах • Орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжил • Шудрага худалдааны сүлжээ
--	--

Хавсралт 9: Нарийвчилсан төсөв**Нийт төсөв, хувиарлалт – Бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр**

	Тодорхойлолт		Нийт	БХ1	БХ2	Захиргаа
1.1	Төслийн ажилтангуудын цалин хөлс		1'326'000	527'800	675'480	122'720
1.2	Олон улсын + дотоодын зөвлөх		552'200	220'880	331'320	-
1.3	Захиргааны ажилтангуудын цалин		244'400	-	-	244'400
1.4	Ажилтангууд + зөвлөхийн томилолт		643'000	165'180	267'520	210'300
1.5	Төслийн тоног төхөөрөмж худалдан авах		458'800	26'000	405'000	27'800
1.6	Төслийн үйл ажиллагаа явуулах зардал		975'600	257'500	542'000	176'100
2.1	Үйл ажиллагааны хэсэг 3-ын зардал		300'000	150'000	150'000	-
		Нийт	4'500'000	30%	53%	17%

Нийт төсөв – Жил бүрээр гаргасан байдал

Pos	Тодорхойлолт		жил 1	жил 2	жил 3	жил 4	Нийт
1.1	Төслийн ажилтангуудын цалин хөлс		325'455	329'485	333'515	337'545	1'326'000
1.2	Олон улсын + дотоодын зөвлөх		110'440	165'660	165'660	110'440	552'200
1.3	Захиргааны ажилтангуудын цалин		59'267	60'489	61'711	62'933	244'400
1.4	Ажилтангууд + зөвлөхийн томилолт		143'900	179'400	180'000	139'700	643'000
1.5	Төслийн тоног төхөөрөмж худалдан авах		133'460	144'720	109'320	71'300	458'800
1.6	Төслийн үйл						975'600

	ажллагаа явуулах зардал		285'133	223'311	234'489	232'667	
2.1	Үйл ажиллагааны хэсэг 3-ын зардал		100'000	100'000	100'000	-	300'000
		Нийт	1'157'655	1'203'065	1'184'695	954'585	4'500'000
			26%	27%	26%	21%	100%

Монгол Улсын талаас оруулах хувь нэмэр (тооцоо)

Тэмдэглэл: (₮-Монгол Улсын мөнгөний нэгж-Төгрөг)

Тодорхойлолт	2011	2012	2013	2014	Total
Ажилтангуудын цалин	19,000,000	19,500,000	20,000,000	20,500,000	79,000,000
Хөрөнгө/хогшил	46,415,000	22,000,000	5,650,000	0	74,065,000
Томилолтын зардал	9,000,000	9,500,000	10,000,000	10,500,000	39,000,000
Байрны түрээс	35,000,000	38,500,000	42,435,000	46,500,000	162,435,000
Хямдрал/чөлөөлөлт	10,000,000	11,000,000	12,000,000	12,500,000	45,500,000
Монголын талын нийт хувь нэмрийн хэмжээ	119,415,000	100,500,000	90,085,000	90,000,000	400,000,000 ₮ (equal to 300,800 USD by the date)
Швейцарийн оруулах нийт хувь нэмэр					4.5 Mio CHF

